



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 03-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

# ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
**2023 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр, Баасан гараг**

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2-5
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	6-110
<hr/>	
<i>1.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.11.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, нэн яаралтай/</i>	9-79
<i>2.Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэл /Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалах, оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны талаар/</i>	79-110

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы  
11 дүгээр сарын 03-ны өдөр /Баасан гараг/-ийн нэгдсэн  
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 72 гишүүнээс 38 гишүүн хүрэлцэн ирж, 52.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 21 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Батжаргал, Д.Батлут, Х.Болорчулуун, Г.Ганболд, Б.Дэлгэрсайхан, Ц.Идэрбат, Г.Мөнхцэцэг, С.Одонтуяа, Ц.Туваан, Ч.Ундрэм, Б.Чойжилсүрэн, Б.Энх-Амгалан, Л.Энх-Амгалан, Т.Энхтүвшин;

Чөлөөтэй: Ё.Баатарбилэг, Л.Оюун-Эрдэнэ;

Эмнэлгийн чөлөөтэй: Ц.Мөнхцэцэг, Б.Саранчимэг;

Тасалсан: Ц.Анандбазар, Ж.Батсуурь, Ш.Раднаасэд, Ж.Сүхбаатар;

Хоцорсон: С.Амарсайхан -1 цаг 04 минут, Т.Аубакир -1 цаг 43 минут, С.Батболд - 1 цаг 39 минут, Х.Булгантуяа -04 минут, С.Ганбаатар -04 минут, Д.Ганбат -32 минут, Б.Жавхлан -33 минут, М.Оюунчимэг -11 минут, Д.Өнөрболор -18 минут, Ц.Сэргэлэн -19 минут, Б.Энхбаяр -20 минут, Ж.Эрдэнэбат -40 минут.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Улсын Их Хурлын гишүүдийн ирцийг танилцуулав./10:18-10:21/

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг, Б.Пүрэвдорж нараас ирүүлсэн албан бичгийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг, Б.Пүрэвдорж нар үг хэлэв.

**Нэг.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.11.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, нэн яаралтай/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч П.Сайнзориг, Нийслэлийн Засаг даргын Хууль, эрх зүйн асуудал хариуцсан ахлах зөвлөх Д.Цолмон, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Ж.Бямбадулам, Нийслэлийн Орон сууцны бодлогын газрын дарга Г.Ганхүү, Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны дарга Г.Батзориг, “Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэгч нэгж” улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал Ч.Батзориг, мөн үйлдвэрийн газрын мэргэжилтэн М.Уранбилэг, Хот байгуулалт, хөгжлийн газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга Д.Хан-Уул, “Нийслэлийн орон сууцны корпорац” хувьцаат компанийн гүйцэтгэх захирал М.Говьсайхан, “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төслийн зохицуулагч Д.Авирмэд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, Л.Батмөнх, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн

референт А.Наранцэцэг, Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа нар танилцуулав.

*Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар 11 цаг 18 минутаас хуралдааныг даргалав.*

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Ц.Сандаг-Очир, Г.Тэмүүлэн, Ц.Цэрэнпунцаг, С.Ганбаатар, С.Бямбацогт, Н.Учрал, А.Адъяасүрэн, Ж.Бат-Эрдэнэ, Б.Баттөмөр, О.Цогтгэрэл, Н.Ганибал, Б.Баярсайхан, М.Оюунчимэг, Т.Доржханд, Б.Пүрэвдорж, Д.Сарангэрэл, Ш.Адьяа, Д.Өнөрболор, Д.Цогтбаатар, Г.Дамдинням нарын тавьсан асуултад Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны дарга Г.Батзориг, “Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэгч нэгж” улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал Ч.Батзориг, Хот байгуулалт, хөгжлийн газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга Д.Хан-Уул нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, С.Амарсайхан нар үг хэлэв.

**Л.Мөнхбаатар:** Байнгын хорооны саналаар Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжжэ гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 30  
Татгалзсан: 11  
Бүгд: 41  
73.2 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 15 цаг 04 минутад хэлэлцэж дуусав.*

**Хоёр.Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэл /Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалах, оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны талаар/**

Ерөнхий сайдын мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Э.Ганхүү, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга А.Хишигбаяр, Хүн амын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга С.Тунгалагтамир, Нийгмийн халамжийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга

Б.Ундрал, Хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг дэмжих хэлтсийн дарга Б.Алтантулга, Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэн, мөн яамны Тэгш хамран сургах боловсролын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Саранхүү, Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газрын дарга А.Өнөржаргал, Барилга, хот байгуулалтын яамны Барилга, инженерийн дэд бүтцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Гантулга, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Нямсүрэн, Гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албаны дарга Л.Нямгэрэл, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал В.Баярмаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга С.Ганболд, мөн газрын Хяналт шалгалтын хэлтсийн ахлах зөвлөх Ч.Онончимэг, референт Ж.Лхагвасүрэн нар байлцав.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалах, оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны талаар мэдээлэл хийв.

Мэдээлэлтэй холбогдуулан цөөнхийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн А.Адьяасүрэн үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.13-т заасны дагуу Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибал нарын тавьсан асуултад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга С.Тунгалагтамир, мөн яамны Нийгмийн халамжийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Ундрал, Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газрын дарга А.Өнөржаргал нар хариулж, тайлбар хийв.

Чуулганы нэгдсэн хуралдаанд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалах, оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны талаар мэдээлэл хийлээ.

*Уг асуудлыг 16 цаг 42 минутад хэлэлцэж дуусав.*

### **Өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийг танилцуулах**

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар Монгол Улсын Засгийн газраас 2023.10.23-ны өдөр өргөн мэдүүлсэн “Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогыг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд;

Монгол Улсын Засгийн газраас 2023.10.24-ний өдөр мэдүүлсэн Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Төсвийн байнгын хороонд;

Монгол Улсын Засгийн газраас 2023.10.31-ний өдөр өргөн мэдүүлсэн Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Төрийн байгуулалтын байнгын хороонд тус тус хуваарилсныг танилцуулав./16:43/

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./16:44/

**Бусад.** Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа, Ж.Ганбаатар, Х.Ганхуяг, С.Одонтуяа нарын урилгаар Ховд аймгийн Бизнес эрхлэгч залуу эмэгтэйчүүд, Нийслэлийн Баянгол дүүргийн 16, 17 дугаар хорооны иргэдийн төлөөлөл, Дорнод аймгийн ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийг 1993 онд төгссөн төгсөгчид, Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн, Л.Мөнхбаатар, Л.Энх-Амгалан нарын урилгаар Хөвсгөл аймгийн сумдын Монгол Ардын намын хорооны дарга, тэргүүлэгч, гишүүд, Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар, Х.Ганхуяг, С.Одонтуяа нарын урилгаар “Бэст Инглиш” академийн сурагчид, Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн, Л.Мөнхбаатар, Л.Энх-Амгалан нарын урилгаар Хөвсгөл аймгийн Рашаант сумын Засаг даргын Тамгын газрын албан хаагчид, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сэргэлэнгийн урилгаар Нийгмийг аюулаас хамгаалах яамны Цэргийн дээд сургуулийн Команд ба улс төрийн ангийг 1989 онд төгссөн төгсөгчид Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцож, С.Энхзаяа нар хариуцан ажиллав.

*Хуралдаан 6 цаг 23 минут үргэлжилж, 72 гишүүнээс 50 гишүүн хүрэлцэн ирж, 69.4 хувийн ирцтэйгээр 16 цаг 44 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ЕРӨНХИЙ НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр,  
Баасан гараг  
Төрийн ордон “Их хуралдай” танхим  
10 цаг 21 минут.

### НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Г.Занданшатар:** Бат-Амгалан гишүүн 9.58, Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн 9.49, Ж.Бат-Эрдэнэ 9.57, яагаад энэ ирцийг байхгүй болгоод байна вэ. Нямаагийн Энхболд 10.14, Содномын Чинзориг 9.56, Жигжидсүрэнгийн Чинбүрэн 10.02, Ням-Осорын Учрал 10.05, Ч.Хүрэлбаатар 9.53, Д.Цогтбаатар 10.09, Д.Тогтохсүрэн 9.24, Г.Тэмүүлэн 9.55, Д.Сарангэрэл 10.05, Ц.Сандаг-Очир 10.02, Пүрэвдорж 9.55, Жаргалмаа 10.00, Мөнхбаатар 10.00, Ц.Мөнх-Оргил 9.55, Нанзадын Наранбаатар 9.57, Тогмидын Доржханд 10.19, 10 цаг, 19 минут хоцорсон байна. Гонгорын Дамдинням 10 цаг 05, 5 минут хоцорсон байна. Цэрэнпилийн Даваасүрэн 10.00, Хассуурийн Ганхуяг 10.03, Наянтайн Ганибал 9.58, Ж.Бат-Эрдэнэ 9.57, Д.Баярсайхан 10.12, Бейсен 9.57, С.Бямбацогт 9.36, Жамбалын Ганбаатар 10.18, Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ 9.49. Бусад нь түрүүн дуудсан гишүүд байна. Ирц бүрдсэн байна.

Тасалсан одоогийн ирцэд ороогүй тасалсан гишүүд Сайнбуянгийн Амарсайхан, Анандбазар, Аубакир, С.Батболд, Болдын Жавхлан, Дамбын Батлут, Жамбын Батсуурь, Хаянгаагийн Болорчулуун сайд гадаадад яваа. С.Ганбаатар, Б.Дэлгэрсайхан, Болдын Жавхлан, Ц.Идэрбат, Ц.Мөнхцэцэг, Одонтуяа, Оюунчимэг, Раднаасэд, Саранчимэг, Ж.Сүхбаатар, Сэргэлэн, Туваан, Ч.Ундрал, Чойжилсүрэн чөлөөтэй, Б.Энх-Амгалан Туваан гишүүн чинь гадаадад айлчлалтай байгаа. Одонтуяа гишүүн гадаадад яваа, Л.Энх-

Амгалан, Энхтүвшин гишүүн чөлөөтэй, Ж.Эрдэнэбат байхгүй байна.

Ингээд ирц бүрдсэн тул чуулганы нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье. Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 11 дүгээр сарын 3-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 1.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгэжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ. Монгол Улсын Засгийн газраас нэн яаралтай горимоор өргөн мэдүүлсэн. Үдээс хойших нэгдсэн хуралдаанаар Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалах, оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны талаар Ерөнхий сайдын мэдээллийг сонсоно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13.4-д гишүүн энэ хуулийн 9.5-д заасан нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхээр тогтсон асуудлын тов дарааллыг өөрчлөх, хойшлуулах, асуудал нэмэх горимын санал гаргах бол Улсын Их Хурлын даргад нэгдсэн хуралдаанаас өмнөх өдрийн 17 цагаас өмнө үндэслэл бүхий саналаа бичгээр ирүүлнэ гэж заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Норовын Алтанхуяг, Бөхчулууны Пүрэвдорж нараас албан бичиг ирүүлсэн байна. Норовын Алтанхуяг гишүүн үг хэлнэ.

**Н.Алтанхуяг:** Өглөөний амгаланг айлтгая. Би өнөөдөр утааны тухай нэг хэдэн юм хэлэхгүй бол болохгүй байна. Энэ өвөл энэ Улаанбаатарчууд маань, энэ хүүхдүүд маань яаж өвөлжих юм бол доо. Олон иргэд янз бүрийн байдлаар ингээд санал хэлээд байна л даа. Энэ Улаанбаатарын утааг энэ өвөл ер нь ямар түлшээр, яаж өнгөрүүлэх гэж байгаа, энийгээ олон нийтэд тайлбарлаж хэлж болохгүй юм уу? Ядаж сайн тайлбарлаад хэлчихвэл хувь хүмүүс өөрснийгөө хамгаалах арга хэрэгслээ, хэрэгслийг нь ч

гэсэн заагаад өгвөл бас болмоор байна гээд ингээд байх юм. Тэгэхээр Занданшатар даргад би санал хэлэх гэсэн юм. Заавал хэн нэгэн гишүүн ингэж ярих биш, энэ Улсын Их Хурал дээр энэ өвлийн утаа, утааны түлшний асуудлыг ер нь яаж шийдэх гээд байгаа юм бэ? Энэ Чойжилсүрэн гээд сайд нь болохоор нэг кокс яриад ингээд алга болсон. Тэр өнгөрсөн хэдэн жилд болбол мидлинг гэдэг нэг юм гаргаж ирээд угаачихсан нүүрсний үлдэгдлийг авчраад шатаагаад, тэгээд сүүлдээ хүхрээ дийлэхээ байгаад одоо тэрнийгээ хаяж байгаа юм уу л гэж би ойлгож байгаа юм. Ингээд ойлгогдохгүй байна. Тэгэхээр энэ иргэдийн хэлээд байгаа асуудлыг хэдүүлээ нэг ярья. Би энэ танхимд ярья л гээд байгаа юм. Тэрнийг хариуцсан хүмүүс нь сууж байгаа.

Энэтэй холбоотой би нэг юм хэлэх гэж байгаа юм. Одоо дандаа ингээд нэг ийм би Их Хурал дээр нэг ийм цаас харуулж ярьж байхгүй болбол худал ярьдаг, гүтгэдэг хүмүүс их бий болчихоод байгаа юм. Энэ онолын хувьд би нэг юм хэлье гишүүдээ. Утааны асуудлыг шийдэхэд урт хугацаанд болбол орон сууцжуулах, ойрын хугацаанд болбол ерөөсөө л хагас коксоор хангах гэдэг ийм л 2 юм огт ойлгомжтой томъёолол, маш ойлгомжтой томъёологдсон юм. Би энийг хэний 2010 оны 7 сарын 9-ний өдрийн энэ гэрээг та нарт үзүүлэх гэж байгаа юм. Энэ дээр юу гэж бичсэн юм гэхээр ДЦС 2-ыг түшиглэж 210 мянган тонн хагас коксожсон түлш үйлдвэрлэх ийм цогцолбор байгуулна гээд тендер зарласан юм уу, үгүй юү мэдэхгүй. Амори интернэйшнл гэдэг компанитай ингээд гэрээ хийгээд, тэгээд энэ үйлдвэрийг хэзээ ашиглалтад оруулна гэсэн юм гэхээр 2012 оны 9 сарын 30-нд. Одоо тэгээд хэдэн жил болж байна вэ? Өнөөдөр 23 он болж байдаг. 11 жилийн өмнө Монголд хагас коксын үйлдвэр ашиглалтад ороод, Монголчууд Улаанбаатарчууд утаанаас салах байсан ийм боломж байсан юм. Энэ компани нь болбол 17 тэрбум төгрөгөө аваад юмаа хийчихсэн.

Манай ЗГ дээр юу ирсэн юм гэхээр юмаа хийсэн гэж юмаа хийж чадаагүй. Манай ЗГ 14 оны 5 сарын 21-ний өдөр тогтоол гаргасан юм. Яагаад гэхээр нөгөө хагас коксын үйлдвэр чинь ашиглалтад орох ёстой байсан. Ашиглалтад ороогүй. Ганхуяг сайд болбол ЗГ дээр оруулж ирээд гаргасан тогтоолыг би та нарт харуулж байна. Энэ дээр юу гэсэн гэхээр 1 дүгээрт энэ компани болбол ажлаа хийж чадаагүй байна. 2 дугаарт тэр нэг байшин бариад хаячихсан байна, тэрнийг дуудлага худалдаагаар худалдаалахыг Төрийн өмчийн хороонд даалгасан. 3 дугаарт нь болбол ДЦС 2-ын технологийн горимыг өөрчлөөд 5 дугаар зуухыг нь аваачаад технологийн горимыг өөрчилчихсөн. Тэгэхээр энийг нь буцаагаад тэр Амори интернэйшнл компанийг хөрөнгөөр эрчим хүчний горимд шилжүүл, дараа нь одоо энэ компаниас мөнгөө нөхөн төлүүлэх арга хэмжээ ав гэж ийм л ЗГ-ын тогтоол гарсан.

Харамсалтай нь хэдэн сарын дараа манай ЗГ-ыг огцруулсан, тэгээд тэрнээс хойш 11 жил өнгөрөхөд энэ асуудал шийдэгдээгүй байна. Энийг бас Улсын Их Хурлын гишүүд анхаарч, энэ хагас коксоос өөр шийдэл байхгүй байна. Тэгэхээр энэ хагас коксоор шийдэх байсан 11 жилийн өмнө ашиглалтад орох байсан тэр үйлдвэр 17 тэрбум төгрөгөө аваад ДЦС-ын зуухыг буруу горимтой болгож хаяад, хагас кокс ч байхгүй, хагас коксыгоо буталдаг, барьцалдуулдаг, хэлбэржүүлдэг нэг байшин барьсан байгаа юм. Ингээд би бас нэг юм хэлэх гэж байгаа юм. Энэ Монголд ер нь эзэн байна уу, энэ гэмт хэрэг үйлдээд, энэ Улаанбаатарчууд энэ олон хүүхдүүдийг энэ утаан дунд нь 11 жил болгосны хариуцлагыг нь хүлээлгэдэг хүн байхгүй юм уу? Засаг төр байхгүй юм уу? Сайд нар чинь ээлжлээд л солигдоод л, шинэ шинэ сайд нар гарч ирээд л тэгээд ажлаа мэдэхгүй ингээд яваад байна.

Би Занданшатар даргад их тодорхой санал хэллээ. Ойрын үед



хэдүүлээ энэ төсвөөс гадна энэ утааны асуудлыг Улсын Их Хурал дээр заавал авч ярьж. Худал, үнэн гүтгэлгийн шинжтэй юм ярьж байсан дорвол баримттай, нотолгоотой, мэддэг, чаддаг хүмүүс нь тойрч суугаад ард иргэдийнхээ төлөө нэг юу санаа тавиад.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Норовын Алтанхуяг гишүүний гаргасан утааны асуудлаар жич мэдээлэл асуудал сонсох асуудлыг ЗГ-ын мэдээлэл сонсох эсвэл гишүүний асуулгад хариулах 2 хэлбэрийн аль нэгээр 5 дахь өдөр сонсдог, ийм хэлбэрээр зохион байгуулахаар холбогдох Байнгын хороо, Тамгын газар, сайд дарга нарт үүрэг чиглэл өгье. Энэ асуудлаар тэгэхдээ энэ хэлэлцүүлгийн явцад бас сайд нар тодорхой мэдээлэл хийх байх. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

**Б.Пүрэвдорж:** Хөдөө малчдаар явж уулзалт хийж байхад бол бүх хүмүүс тэтгэврийн нэмэгдэлд гомдолтой байсан. Өөрөөр хэлбэл бол тэтгэврийг хамгийн багадаа 126 мянгаар нэмэгдүүлнэ гэхээд 50 мянгаар нэмчихлээ. Тэгээд ерөөсөө хөдөөгийн малчин болгон толгой дараалан 50 мянган төгрөгөөр тэтгэвэр нэмэгдсэн юм байна лээ. Тэгээд тэрэнд гомдолтой байгаад байдаг. Тэгээд би энэ тэгээд энэ тэтгэврийн асуудлаар яриад байхаар надад бас олон ахмадууд хандаж байгаа. Тэгээд ер нь бол хот, аймаг, сумын төвийн тэр иргэдийн ахмадуудын энэ ахмадууд 7 сарын 1-нд нэмэгдсэн тэр тэтгэвэрт бол маш тийм сэтгэл дундуур байна. Ялангуяа 600 мянгаас 800 мянган хооронд тэтгэвэр авч байгаа хүмүүс тэтгэврийн нэмэгдэл зөв болсонгүй гэдэгт маш их гомдолтой байгаад байгаа юм байна. Тэгээд энэ хүмүүс юу гэж үзэж байгаа юм гэхээр 2022 оны 2 сарын 1-ний өдрийн тэр төсвийн тодотголоор хийсэн нэмэгдэл дээр л гомдолтой байгаад байгаа юм байна. Өөрөөр хэлбэл тэр хүмүүс 350 мянгаас 42 хувиар нэмэгдүүлээд 500 мянга болсонд бол хөөрхий тэр бага тэтгэвэртэй хүмүүс зөв гэж ярьж байна. Тэгтэл бусад нөгөө тоо хамгийн бага тэтгэвэр авдгаас бусад хүмүүсийн

тэтгэврийг бүгдийг нь тэгшитгээд 15 хувь нэмснээс болоод өндөр нь өндөр аваад, бага авсан нь бага аваад ингээд бид нар хохирчихлоо л гэж энэ хүмүүс үзээд байгаа юм байна л даа.

Тэгээд ер нь бол тухайн үед сүйхээтэйхэн Ардын намын гишүүн байсан болбол 1 сая хүртлийг нь 20 хувиар, 2 сая хүртлийг сая хүртлийг нь 10 хувиар, 2 саяас дээшээг нь 5 хувиар нэмчихсэн болбол энэ тэтгэврийн зөрөө тийм айхтар зөрөөтэй болж явахгүй байсан юм байна л гэдэг нь энэ харагдаж байгаа юм. Тэгэхээр би энэ өчигдөр над дээр Тэтгэврийн шинэчлэлт хохирогчид гээд нэг олон ахмадууд 5 ахмадууд ирсэн, 4 ахмад ирсэн. Тэгээд энэ групп тэтгэврийн шинэчлэлд хохирогчид гээд групп 7 сарын 14-ний өдөр нээгдсэн байгаа юм. Тэгээд өнөөдрийн байдлаар өчигдөр 29 мянга байсан, өнөөдрийн байдлаар 30200 хүн нэгдчихсэн энэ тэтгэвэрт чинь гомдчихсон хүмүүс ингээд дарга нарт асуудлаа тавья гэхээр хаана ч уулзаж хүлээж авдаггүй ийм нөхцөл байдалтай байгаад байна. Тэгээд энэ хүмүүсийн тэтгэвэрт хохирсон, тэтгэврийн шинэчлэлээс хохирогчдын группт энэ группийн Авирмэд эгч СБД-ийн 17 дугаар хороо, Дагва-Очир ах БЗД-ийн 27 дугаар хороо, Сувдням эгч БГД-ийн 24 дүгээр хороо, Цэнгэл эгч Хан-Уул дүүргийн 14 дүгээр хороо, бас Энэбиш гээд хүн орж ирэх ёстой байсан, орж ирсэнгүй. Тэгээд энэ хүмүүс орж ирээд асуудлаа ярьж байна.

Тэгээд Сувдням гэдэг эгч эрчим хүчний салбарт ажиллаж байсан, хамгийн өндөр цалин тухайн үедээ авч байсан байна. Тэгээд 1996 онд тэтгэвэрт гараад 38 мянган төгрөгийн тэтгэвэртэй болсон юм байна. Тухайн үедээ хамгийн өндөр. Тэгээд 2 сарын тэтгэврийнхээ мөнгөөр СУИС-д сурдаг хүүхдийнхээ мөнгийг төлж байсан байна шүү дээ. Тэгээд энэ хүмүүс яагаад ингээд 800 мянга дээр мянган төгрөг дээр хамгийн бага тэтгэвэр ер нь бол өөрсдийнхөө хувьд хамгийн бага тэтгэвэртэй болчихлоо гэж

үзээд байгаа юм бэ гэхээр энэ хуулийн хэрэгжилтээр буюу ЗГ-ын гаргасан тогтоол 238 дугаар тогтоол гарсан юм байна. Тэр 238-ын дугаар тогтоолын 3 дугаар заалтаар нь бүгдийг нь тэгшитгээд тайралт хийчихсэн. Өөрөөр хэлбэл 2013 онд тэр цалингийн дээд хэмжээ сая 400 мянга байсан. Тэр сая 400 мянгаас тооцно гээд 13, 10 жилийн өмнөх тэр цалингийн дээд хэмжээнээс бодоод тэтгэврийг нь бодохоор бага гараад байгаа юм байна л даа. Тэгээд дээрээс нь зүгээр байхгүй тухайн саруудад хамгийн бага байсан нэг тухайн 120 мянга, 100 мянган төгрөгөөс нь хэргээр нөгөө нэг бага цалин авсан аль эсхүл юу байдаг юм чөлөө авсан байдаг юм уу, бага цалин гарсан тэр цалингаас нь татаж авчирч байгаад холиод ингээд бодохоор бүүр тэтгэвэр нь багасаад ийм асуудал гараад байна гэж энэ хүмүүс ярьж байгаа юм.

Тэгтэл энэ 238 дугаар тогтоолын 3 дугаар заалт чинь шинээр тэтгэвэр тогтоож байгаа хүмүүст л хамаатай заалт байхгүй юу. Хуучин тэтгэвэр тогтоосон, өндөр цалин авч байсан тэр хүмүүст ерөөсөө хамаагүй заалт. Тэгээд энийг ингээд ЗГ-ын тогтоол дээр нугалаад гараад байна. Тийм учраас энэ асуудлаар ярьж өгөөч. Тэгээд ер нь бол 7 сарын 1-ний нэмэгдлийн 200 тэрбум нь тэтгэврийн 10 хувийн нэмэгдэлд зарцуулсан, 194 тэрбум төгрөг нь болохоор итгэлцүүрээр тэтгэвэр нэмэгдэх нэмэгдүүлэхэд зарцуулагдсан. Гэтэл энэ нь зөв биш байна гэж энэ хүмүүс үзэж байгаа юм. Тэгээд энэ 238 дугаар тогтоолыг хуульд нийцүүлж, тэр 3 дугаар заалтыг нь иргэн хүнд илүү эергээр шийдэх тэр асуудлыг нь оруулж өгч.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Хэлэлцэх асуудалдаа орно. Пүрэвдорж гишүүнд цагийн минутыг нь яг тодорхой үзүүлээрэй. Хэлэлцэх асуудалдаа оръё.

**Нэг.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон**

**сууцжуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.11.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, нэн яаралтай/**

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ. Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга Дашизэвэгийн Амарбаясгалан танилцуулна. Индэрт урьж байна.

**Д.Амарбаясгалан:** Монгол Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу нийслэл хот өөрийн нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн асуудлыг бие дааж шийдвэрлэх эрхтэй боловч нийслэл хотод тулгамдаад байгаа төвлөрөл, төлөвлөлт дагасан олон асуудлын үр дагавар нь Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхийг ноцтой хөндөж байгаа тул хүний суурь жам ёсны эрхийг хамгаалах, нийгмийн дэг журам, нийтийн ашиг сонирхлыг хангахын тулд зарим эрхийг тохирсон хэмжээнд хуулиар хязгаарлах зайлигүй нөхцөл байдалд хүрээд байна.

Хотын хүн амын өсөлт, шилжилт хөдөлгөөн, хотжилт, түүнийг дагасан тээврийн хэрэгслийн тооноос шалтгаалан Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэл сүүлийн жилүүдэд үлэмж нэмэгдсэнээр тээврийн хэрэгслийн дундаж хурд 9км цагаас 13км цаг болсон. Сүүлийн 3 жилийн байдлаар жилд дунджаар 47 мянган тээврийн хэрэгсэл

нийслэл Улаанбаатар хотод бүртгэгдэж байна. Энэ байдлаар үргэлжилбэл 2030 онд 5км цаг, 2040 онд 0км цаг байх тооцоолол гарч байна. Улаанбаатар хотын нэг иргэн жилд дунджаар 30 хоног буюу 717 цагийг түгжрэлд алдаж байна гэсэн тооцоолол мөн гарч байна.

Нийслэл хотын замын хөдөлгөөний нөхцөл байдал, хот төлөвлөлтийн гажуудал, авто замын сүлжээ, даац хэтрэлт, иргэдийн зорчилт хөдөлгөөн, судлаачдын зөвлөмж, бусад улс орны туршилага зэрэг олон хүчин зүйлийг тооцон үзэж нийслэл хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулахад тээврийн эргэлтийн менежмент ялангуяа түгжрэлтэй бүсийн тогтолцоог бий болгох нь зүйтэй гэж үзсэн байна. Улаанбаатар хотод замын хөдөлгөөний төлбөртэй бүс, түүний хилийн зааг, цагийн хязгаарыг тогтоож, төлбөртэй бүсэд тогтоох төлбөрийн хэмжээг НИТХ тогтоохоор хуулийн төсөлд тусгалаа.

Сүүлийн үед нийгэмд такси үйлчилгээтэй холбоотой олон хэргүүд гарах болсон. Цагдаагийн байгууллагын гэмт хэргийн мэдээллийн санд сүүлийн 5 жилд бүртгэгдсэн такси үйлчилгээтэй холбоотой нийт 3119 гэмт хэрэг бүртгэгдсэнээс нийслэлд дийлэнх буюу 2940 гэмт хэрэг бүртгэлтэй байна. Үүнээс 2636 гэмт хэрэгт таксины жолооч холбогдож гэмт хэрэг үйлдсэн байгааг онцгой анхаарч, цэгцлэх зайлшгүй шаардлагатай болжээ. Такси үйлчилгээг хуульд заасан нөхцөл, аюулгүй байдлын шаардлагыг хангасан этгээд тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх түүнд тавих хяналт зохицуулалтыг бий болгохыг зорьсон.

Замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, хүн амын төвлөрлийг сааруулах, орчны бохирдлын асуудлыг шийдвэрлэх оновчтой шийдэл нь гэр хорооллыг инженерийн дэд бүтцээр хангах, дахин төлөвлөн баталгаажуулах явдал юм. Нийслэл Улаанбаатар хотын хэмжээнд 2021 оны байдлаар нийт 412,5

мянган өрх амьдарч байгаагаас 51,4 хувь буюу 212 мянган өрх орон сууцад, үлдсэн 48,6 хувь буюу 200 мянган өрх нь гэр хороололд амьдарч байна. Нийслэлийн хүн амын тал хувь нь гэр хороолол буюу инженерийн дэд бүтцийн хангамжгүй, агаар, хөрсний бохирдолтой нөхцөлд амьдарч байна. Хуулийн төсөлд нийслэл хотын хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан дэд төвүүдийн байришилд гэр хорооллыг орон сууцжуулах нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх үндэслэлийг нарийвчлан тодорхойлж, газар чөлөөлөлтийн нөхөх олговрыг газрыг газраар дүйцүүлэн олгох, газрыг үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгөөр, газрыг нөхөх олговрын мөнгөн зардлаар худалдан авах болон бусад боломжит хэлбэрээр олгож болохоор тусгасан.

Улаанбаатар хотын гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслүүдийг хотын хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж орон сууцжуулснаар нийгэм, эдийн засаг байгаль орчинд эерэг нөлөөлөл үзүүлж, нийслэлийн иргэдийн ая тухтай эрүүл амьдрах орчин нөхцөл бүрдэнэ гэж үзэж байна. Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэл, төвлөрлийн алдаанд нөлөөлж байгаа хүчин зүйлүүдийг цогцоор шийдвэрлэх зорилгоор нийт 25 хуулийн төсөлд холбогдох өөрчлөлт оруулахаар багцаар нь боловсруулсан болно. Хуулийн төсөл, үзэл баримтлал, хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг шийдвэрлэж өгнө үү. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Төслийн талаарх ТББХ-ны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Бадарчийн Жаргалмаа танилцуулна.

**Б.Жаргалмаа:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ЗГ-аас 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдөр Улсын Их

Хуралд өргөн мэдүүлсэн нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг ТББХ Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасан хуулийн төсөл нэн яаралтай хэлэлцүүлэх дэгийн дагуу 2023 оны 11 дүгээр сарын 2-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн нэг дэх хэсэгт хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх гэж, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-ээс 2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 9.3.27-д орон зай оновчтой төлөвлөлт бүхий суурьшлын зөв тогтолцоотой, эрчимтэй хөгжиж байгаа дагуул хотуудтай, олон улсад өрсөлдөгч метрополитен болж хөгжих зорилтын хүрээнд авто зогсоолын менежментийн боловсронгуй тогтолцоог бий болгох, Улаанбаатар хотын авто замын бүсчлэлийг тогтоож, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг зохицуулахаар заасан байгаа.

Хууль санаачлагч Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан ЗГ-ын 2020-оос 24 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 6.1-д Улаанбаатар хот, Улаанбаатар болон дагуул хотыг орон зайн оновчтой төлөвлөлт, ухаалаг шийдэл, амьдралын таатай орчин бүхий ногоон хот болгож хөгжүүлэх зорилтын хүрээнд Улаанбаатар хотын замын хөдөлгөөний нягтралыг сарниулж, ачааллыг тэнцвэржүүлсэн, тээврийн эрэлтэд нийцсэн авто замын сүлжээг бий болгож, түгжрэлийг бууруулна гэж заасныг үндэслэн нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн орчныг сайжруулах шаардлагатай

гэж үзэж хуульд хуулийн төслийг боловсруулсан байна.

Мөн Монгол Улсын хувьд нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулахын тулд замын хөдөлгөөний түгжрэл ихтэй бүсийг тогтоож, түүнийг тусгай тарифтай болгох буюу улс орнуудын нийтлэг жишигээр эдийн засгийн зохицуулалтыг ашиглах, авто тээврийн хэрэгслийн импортыг тарифын бодлогоор зохицуулах, нийтийн тээврийн хүртээмжийг нэмэгдүүлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдал, агаар, орчны бохирдлыг бууруулах зорилтот цогц арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзсэн байна.

Хуулийн төслийг Dparliament.mn цахим хаягт байршуулж иргэд олон нийтийн саналыг авч байгаа болно. Хуулийн төсөлд замын хөдөлгөөний төлбөртэй бүсийн төлбөр, түүнийг тогтоох, мөрдөх журам, авто зогсоолын асуудал мөн замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах талаар төрийн байгууллагын чиг үүрэг, оролцогчийн эрх үүргийн талаар болон нийгмийн зайлиггүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх үндэслэл, гэр хорооллыг орон сууцжуулах байршил, төрөөс үзүүлэх дэмжлэг, санхүүжилт, хэрэгжүүлэх байгууллагын чиг үүрэг, шилжилтийн үеийн зохицуулалтуудыг тусгасан болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатар шилжилтийн үеийн зохицуулалтын хугацаа хэрхэн тусгагдсан талаар, Улсын Их Хурлын гишүүн Жаргалмаа Тээврийн хэрэгслийн торгуулиа төлөөгүй иргэнд хүлээлгэх хариуцлага, торгуулийн хэмжээг шатлан нэмэгдүүлэх эсэх мөн төвлөрлийг сааруулах зорилгоор шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах эсэх, Улсын Их Хурлын гишүүн Тогтохсүрэн орон сууцжуулах ажлыг гүйцэтгэхэд дэд бүтцийн хангамжийн бодлого байгаа

эсэх, орон сууцжуулах бүсэд оршин суух иргэдийн худалдан авах чадварыг нэмэгдүүлэх талаар авах арга хэмжээ, тус хөтөлбөрт тусгагдсан эсэх, ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөлтийн хэрэгжилтийг хангах болон төлбөртэй бүсийг бий болгосноор түгжрэл хэдэн хувь буурах, хувийн тээврийн хэрэгсэлд ноогдуулах татварын хэмжээг нэмэгдүүлэх эсэх, барилгын стандартыг тогтоох талаар, Улсын Их Хурлын гишүүн Батсуурь нүхэн болон тойрох хурдны зам гарцыг бий болгосноор түгжрэлийг бууруулах боломжтой эсэх мөн тус асуудлаар жолооч нараас санал авсан эсэх, Улсын Их Хурлын гишүүн Оюунчимэг түгжрэл болон орон сууцжуулахтай холбоотой харилцааг зохицуулж байгаа хүчин төгөлдөр эрх зүйн актууд тус хууль батлагдсанаараа хүчингүй болох эсэх, дээрх хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилт улсын төсөвт суусан эсэх, Улсын Их Хурлын гишүүн Доржханд хотыг хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулахад мэргэжилтнүүдийн саналыг авсан эсэх, хувийн ААН-үүдэд үүсэж болзошгүй алдагдлын тооцоолол мөн санхүүжилт байгаа эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Сарангэрэл, Адъяа нар хуулийн төслийг дэмжиж байгаа болон хуулийн төсөлтэй холбоотой тооцоо судалгааг ард иргэдэд танилцуулах нь зүйтэй талаар тус тус саналаа илэрхийлсэн болно. Улсын Их Хурлын гишүүн Энхболд нийслэлд тулгамдаад байгаа асуудлуудын шалтгаан түүнчлэн эрсдэлийг нь харгалзан багцаар нь шийдэх үзэл баримтлалын хүрээнд хууль, тогтоолын төслүүдийг боловсруулсныг тэмдэглэж, анхны хэлэлцүүлгийг холбогдох Байнгын хороодоор хэлэлцүүлж санал, дүгнэлт гаргуулах хэрэгтэйг онцолсон байна.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн

мэдүүлсэн Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь буюу 75 хувь нь дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах, Агаарын бохирдлыг бохирдлын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах, Авто тээврийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийслэл хотын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийслэл хотын, Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн

тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Авто замын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүд болон ЗГ-т чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх талаарх ТББХ-ны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданишатар:** Алга ташилт дууссан бол ажлын хэсгийг танилцуулъя. Дашизэвэгийн Амарбаясгалан Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга, Хишгээгийн Нямбаатар НЗД бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Пүрэвийн Сайнзориг НЗД-ын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч, Дорждэрэмийн Цолмон НЗД-ын Хууль, эрх зүйн асуудал хариуцсан ахлах зөвлөх, Жалбажавын Бямбадулам НЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Ганбатын Ганхүү Нийслэлийн орон сууцын бодлогын газрын дарга, Ганболдын Батзориг Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны дарга, Чимэддоржийн Батзориг Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж, нэгжийн захирал, Доржготовын Хан-Уул Хот байгуулалт, хөгжлийн газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга, Дангаагийн Авирмэд Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төслийн зохицуулагч, Маньбазарын Говьсайхан Нийслэлийн орон сууцын корпорац ХК-ийн гүйцэтгэх захирал.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрээ бүртгүүлнэ. Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүнээр, Дамдины Цогтбаатар гишүүнээр тасаллаа. Хамгийн сүүлд Ширнэнбаньдын Адьшаа, Дамдины Цогтбаатар нарын гишүүдээр тасаллаа. Нэмж, хасахгүй болохыг анхааруулъя. Хассуурийн Ганхуяг гишүүн асуулт асууна.

**Х.Ганхуяг:** Өглөөний мэнд хүргэе. Би зүгээр нэг товчхон асуулт асуух гэсэн юм. 1 дүгээр асуудал бол яалт ч үгүй бид нар нөгөө хот төлөвлөлтөө бол алдчихсан. Тэгээд нэгэн зэрэг зай манай Нарны хороолол гээд бараг 20 мянган оршин суугчтай. Өглөө гарахдаа түгжирнэ, орой гэртээ харихдаа түгжирнэ. Дундаж нэг байрны өндөр нь болохоор 20 хэдэн давхар байгаад байгаа юм. Зарим байрууд нь бол 12 давхар байгаа юм. Тэгээд энэ өндөржилтийн, одоо ингээд та нар бүсчилтийн хязгаарлал, үнийн тариф эд нар тогтоочихсон байна шүү дээ. Ер нь өндөржилтөөр хязгаар тогтоох эсэх, өндөрлөчих дээр аль хэсэгт өндөр байшин барих, аль хэсэгт намхан байшин барих энэ дээр ер нь төлөвлөж байгаа юм байгаа юу?

Ер нь бол манайхаас бусад бүх орнууд бол өндөржилтийн хязгаартай байдаг. Энэ бүсэд бол шинэ төв юм гээд. Шинэ санхүүгийн төв юм гээд. Тэн дээр бол жишээлбэл 100 давхар барьсан ч болдог, тэнчээ бол хүн амьдардаггүй ерөөсөө л зүгээр хүмүүс ажилладаг гэсэн үг. Яг амьдардаг газрууд нь болохоор стрессгүй байх, орой, өглөө гэртээ харьж явах замдаа бол ямар нэгэн түгжрэлгүй байхаар ингээд шийддэг. Манай Нарны хорооллыг хар л даа ганцхан гүүртэй, тэр гүүрэн дээрээ ингээд гэртээ орох гэж цаг 30 минут зогсдог, гарах гэж цаг 30 минут зогсдог. Нөгөө талд нь Алтай хотхон гээд бас л ганцхан гүүртэй, 16 мянган оршин суугчтай. Тэгээд тэнчээ нөгөө ногоон бүс

байхгүй. Уг нь бол стандартаар гэдэг чинь 30 хувийн стандарт тогтоочихсон байдаг. Сургууль байхгүй. Сургууль дээр нь бид нар чинь бөөн жагсаал хийж байж энэ газрыг нь цуцалж өг гээд хүсэлт өгчихсөн байгаа иргэдээс. Тэр өндөржилтийн юун дээр ямар нэг арга хэмжээ авах эсэх энэ хуулиар ямар зохицуулалт хийх вэ? Тэгээд цаашдаа ер нь ямар төлөвлөгөөтэй байна вэ? Энэ ерөнхий төлөвлөгөөг нь эргээж харж байгаа юу?

Анх яг ингээд л хотхон барихдаа ингээд ногоон бүс нь ийм байна, хүүхдийн тоглоомын талбай нь ийм байна, сургууль, цэцэрлэгтэй байна гээд ерөнхий төлөвлөгөөгөө батлуулдаг. Тэгээд л яг хийх болохоороо дан орон сууц хийгээд л дүүргээд хаячихдаг. Тэгээд энэнээс чинь болоод яг шинэ үеийн түгжрэл, хот төлөвлөлтийн асуудал энэнээс л үүдээд байгаа байхгүй юу. Тэгэхээр 1 дүгээрт өндөржилт байна. 2 дугаарт ерөнхий төлөвлөгөө байна. Энэ ерөнхий төлөвлөгөөгөө эргээж харах эсэх, тэгээд цаашдаа ер нь яаж энэ хотын төлөвлөлтийг, төлөвлөгөөг харж байгаа вэ? Энэ дээр нэг хариулт авчихмаар байна. Баярлалаа.

**Г.Занданшатар:** 85 Хишгээгийн Нямбаатар НЗД бөгөөд Улаанбаатар хотын Захирагч асуултад хариулна.

**Х.Нямбаатар:** Баярлалаа гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе. Нийслэл Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний төсөл нийслэл дээр боловсруулалтын ажил төгсөх шатандаа ороод явж байгаа. Маш товчхон хариулахад Хассуурийн Ганхуяг гишүүний асууж байгаачлан барилгын бүсчлэл өндөржилтийг энэ 2040-өөр илүү тодотгон зохицуулж өгч байгаа. Өөрөөр хэлбэл энэ бүсэд ийм өндөртэй орон сууцын хороолол, энэ бүсэд ийм өндөржилттэй оффисын барилга үйлчилгээний төвүүд баригдана гэдгийг нарийвчлан зохицуулахаар орж ирж

байгаа. Нийслэл Улаанбаатар хотыг хөгжүүлэх 2020 төлөвлөгөө үндсэндээ хэрэгжилтийн хувьд төдийлөн хангагдаагүй 5 ийм шалтгаан нөхцөл байдаг. 1 дүгээрт Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө хэрэгжихэд хууль, эрх зүйн орчин хууль тогтоомжуудын өөр хоорондоо уялдаагүй байдлаас шалтгаалж 2040-д алдаа гарсан гэдгийг гаднын судлаачид хэлж байгаа.

2 дугаарт нийслэлийн бүтцийн байгууллагууд, төлөвлөлтийн байгууллагууд, инженерийн барилга байгууламжийн чиг үүрэг, үүрэгтэй байгууллагуудын өөр хоорондын ажлын уялдаагүй чиг үүргийн холбоосгүй байдлаас болж энэ 2040 бас хэрэгжээгүй гээд 2020 хэрэгжээгүй гэдэг ийм дүгнэлт байдаг. 3 дугаарт мэдээж хэрэг санхүүгийн хүндрэлтэй нөхцөл байдлууд гэх мэт ийм шалтгаануудаас 2040 ерөнхий төлөвлөгөө хэрэгжээгүй юм байна лээ, 2020. Тэгэхээр бид нарын оруулж ирэх гэж байгаа энэ 12 сардаа багтаж БХБЯ-аар уламжилж 2040 шинэ төлөвлөгөө орж ирнэ. Энэ 2040 дээр таны саяын ярьж байгаа бүсчлэл, өндөржилттэй холбоотой ийм нарийвчилсан зохицуулалт, хязгаарлалтууд орж ирж байгаа гэдгийг хэлье.

Энэ хууль одоо бидний өнөөдрийн өргөн барьсан хууль дээр бид хотын норм журамтай холбоотой бас нэг шинэ өөрчлөлт орж ирж байгаа. Энэ юу вэ гэвэл нийт барилгажих талбай 70 30-ийн харьцаатай байсныг бид нар 60 40-ийн харьцаатай болгож оруулж ирж байгаа юм. Энэ дүрэм, стандартыг хангаагүй барилгын ажлыг эхлүүлэхгүй. Энэ дүрмийн шаардлагыг хангаагүй барилгыг улсын комисст хүлээлгээж өгөхгүй. Мөн цаашилаад инженерийн дэд бүтцээр холбохгүй байхыг холбогдох байгууллагуудад үүрэгжүүлж, байгууллага хоорондын ажлын уялдааг хангах чиглэлээр тодорхой ажлууд хийж байгаа.

Дараагийн дугаарт нэг хийж байгаа том зохицуулалт бол одоо бид нарын энэ яг байгаа оршин байгаа Их тойруу дотор одоогоор дахиад нэмж 1500 өндөр барилга барих А-ийн даалгавраа авчхаад байгаа юм. Тэгэхээр энийг цаашид барих юм бол энэ их тойруу дотор дахиад бөгс эргэх зайгүй болно. Тийм учраас энэ нягтаршил ихтэй барилгад А-ийн даалгавар авсан компаниудыг өөр газарт байршуулж, барилгын газар.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Эхлээд зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Ширнэнбаньдын Адьяа, Жамбалын Ганбаатар, Хассуурийн Ганхуяг, Салдангийн Одонтүяа нарын урилгаар Ховд аймгийн бизнес эрхлэгч эмэгтэйчүүд, БГД-ийн 16, 17 дугаар хорооны иргэдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Хүндэт эмэгтэйчүүд болон Ховдчууд та бүхэндээ сайн сайхныг Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс хүсэн мэндчилье. Эхлээд энэ хариулчих уу? Тийм. Цэрэнпилийн Даваасүрэн сайд хариулна.

**Ц.Даваасүрэн:** Ганхуяг гишүүний хөндөөд байгаа асуудлуудыг бид нар нийслэл хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх төлөвлөгөөнд болбол бас нэлээн нарийвчилж тусгана. Төлөвлөгөөний дагуу бол бид нар цаашидаа хотыг болбол дэд төвүүдээр хөгжүүлнэ. Дэд төвүүдээр хөгжүүлэхдээ тэнд тэр сургууль, цэцэрлэг, дэд бүтцийн бүх зүйлийг нь байлгах хотын төв рүү аль болох орж ирэхгүй байлгах тэнчээнээ ажил хөдөлмөр эрхлэх, наад захын үйлчилгээгээ авах гэх мэтийн ийм зүйлүүдийг нь бол тусгасан тийм төлөвлөлтүүдийг бид нар хийгээд явж байгаа. Одоо нийслэл дээр Сэлбэ дэд төв, Солонго, Баянхошуу дэд төвийн зураглалууд үндсэндээ төлөвлөлтүүд бол хийгдээд дуусаж байгаа. Энэ хавраас бол бид нар энэ барилгажилтын ажлыг эхлүүлнэ гэж ингэж бодож байна. Тэгэхээр

төлөвлөлтийн хувьд болбол 2040-ийн дагуу гараад ирэхээр Их Хурлаар орж ирж батлуулна. Тэр ажлын даалгаваргүй бүх юмаа авч батлуулахдаа сургууль, цэцэрлэгтэй гэсэн мөртөө тэрийгээ орхидог асуудлыг ярьж байна. Тэгэхээр энийг Барилгын хуулиар зохицуулъя гэж бид нар ингэж бодож байгаа.

Барилгын хуулийн шинэчилсэн найруулгыг бид нар энэ намрын чуулганд багтааж өргөн барина. Та бүхэн харин энийг шийдэж өгөхөд анхаараарай гэж. Тухайлбал өндөр байшин барьж байгаа болбол яг тэр байшиндаа байгаа айлуудын тоогоор гарааштай байлгана. Айлуудын тоогоор. Тэгээгүй барилгыг бол зөвшөөрөхгүй байх, зөвшөөрөл ажлын зөвшөөрөл олгохгүй байх, мөн тухайн байрны орчинд тэр ус зайлуулах мөн усны нөөцлүүрийн савтай байлгах гэсэн ийм зүйлүүдийг бас тусгасан ийм хуулийн зохицуулалтууд орж ирнэ. Өөрөөр хэлэх юм бол өндөр байшин баривал үнэтэй. Яагаад гэвэл тэнд болбол гараашны асуудлыг бүрэн шийдсэн байх гээд. Иймэрхүү маягаар болбол Сингапур бусад улс орнууд болбол өндөр байшин барихыг хотын төвд барихыг болбол зохицуулсан байдаг. Тэгэхээр иймэрхүү хуулийн зохицуулалтыг.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Хассуурийн Ганхуяг гишүүн тодруулж асууя.

**Х.Ганхуяг:** Би Нямбаатар сайдад нэг ганцхан асуудлыг бас хэлэх гэсэн юм. Юу вэ гэхээр ногоон санхүүжилт бол дэлхий даяар маш элбэг болчихсон. Тэгэхээр бид нар Улаанбаатар хотод байгаа бүх яндангаа тоолох хэрэгтэй. Гарч байгаа утааныхаа хэмжээг нь гаргах хэрэгтэй. Тэгээд яндан буурсан хэмжээгээр буцаагаад карбон трейдээр бид нар бас мөнгө авах боломжтой байхгүй юу. Тэгэхээр энэ Мөнгөний бодлого батлагдах гэж байгаа, төсөв батлагдаж байгаа үед яг тэр ипотекийн зээлийг 60 хувийг нь манай орон нутгийн гишүүд орон нутаг руу авч явна гэсэн нэг ийм юм Улсын Их Хурлын тогтоол



батлуулах гээд яваад байгаа. Магадгүй ипотекийн зээлийн 10 юм уу, 20 хувийг бид нар яг гэр хороололд зориулсан, хөрсний бохирдолгүй, эко 0-той, эрчим хүчний хэмнэлттэй ийм байрууд дээр ипотекийн зээлийг жоохон түлхүү гаргаж өгөөд, тэгээд яндангийнхаа тоог бууруулж чадвал манай нийслэлийн санхүүгийнхэн карбон трейдээр хүртэл мөнгө авах буцаагаад боломжтой байхгүй юу. Тэрүүгээрээ санхүүжүүлэх боломжтой. Эргээгээд тэр эрчим хүчний хэмнэлттэй байруудыг санхүүжүүлэх урт хугацааны санхүүжилт бид нар олон улсын зах зээл дээрээс босгох боломжтой.

**Г.Занданшатар:** 85 Хишгээгийн Нямбаатар.

**Х.Нямбаатар:** Ганхуяг гишүүний асуултад хариулъя. Яг таны хэлж байгааг бид нар ногоон бондын санхүүжилтийн босгох ажлын хэсэг ажлаа эхэлж байгаа. Эхний 95 сая долларын санхүүжилтийн эрх нээгдсэн явж байгаа. Нийслэл дотоод бонд гаргахаа зогсоосон. Дотоод бондоор санхүүжүүлэх төсөл хөтөлбөрүүдийнхээ санхүүжилтийг энэ 11 дүгээр сарын 14-ний өдөр хуралдах НИТХ-ын ээлжит хуралдаанаар нийслэл өөрийнхөө төсвийг тодотгоод, яаралтай энэ санхүүжүүлбэл зохих төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх эх үүсвэрээ ишийдэж байгаа. Мөн энэ орон нутгийн төсвийн тодотголоор ирэх жил Улаанбаатар хотод баригдах Сүхбаатар, Чингэлтэй дүүрэгт баригдах 12 мянган айлын орон сууцны иж бүрэн цогцолбор хороолол, сая Даваасүрэн сайдын хэлж байгаа нөгөө сургууль, цэцэрлэг, эмнэлэг, мөн үйлдвэр, үйлчилгээ худалдаа үйлчилгээний бүх цэг салбаруудтай хотын төв рүү заавал явах шаардлагагүй ийм sub center гэж яриад байгаа. Тэр дэд төвүүдээ бид нар барилгажуулах төслийн хөрөнгийнхөө эх үүсвэрийг ногоон бондын эх үүсвэрээр санхүүжүүлж гэдэг ийм ажлын хэсэг гарч байгаа. Энэтэй холбоотой ТЭЗҮ, барилгын зураг, төсвийн тендерээ энэ 11 дүгээр сардаа багтаж зарлана. Энд

тендерийн үр дүнгээр шалгарсан ААН-үүдээр Сэлбэ дэд төвийнхөө ТЭЗҮ, барилгын зураг төсвийг хийгдэж дууссаны дараа бид нар бондын зах зээл дээр гарна.

Бид нар саяхан IFC, EBRD зэрэг байгууллагуудтай уулзаж, бас техникийн зөвлөгөө авах мөн private бонд дээр хамтарч ажиллах чиглэлээр яриа хэлэлцээрүүд эхлүүлчихсэн явж байгаа. Энэ бол green бондын ангилалд нь багтах тэр чиглэл рүүгээ бид нар бас ТЭЗҮ-ээ боловсруулж байгаа гэдгээ хэлье.

**Г.Занданшатар:** Цэндийн Сандаг-Очир гишүүн асуулт асууна.

**Ц.Сандаг-Очир:** Баярлалаа. Өнөөдөр Улаанбаатар хотын 9 дүүрэг, нийслэл Улаанбаатар хот, ер нь 2030 он, 2040 он хүртэлх хотын ерөнхий төлөвлөгөөтэй дүүрэг 9 дүүргээс хэд нь байна вэ? Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөтэй явж байна уу? Ерөнхий төлөвлөгөөгөө хийж батлуулсан дүүргүүд байна уу? Энэ ерөнхий төлөвлөгөөнүүдийн хэрэгжилтийг дүгнэж үзсэн үү? Одоо 2040 он хүртэл ерөнхий төлөвлөгөөг боловсруулж байгаа юм байна. Энэ ерөнхий төлөвлөгөө гэдэг бол асар олон тооцоо судалгаа, бүх салбарынхны тооцоо судалгаа дээр асар их цаг зав, хөрөнгө хүч гаргаж байж хийдэг. Харамсалтай нь ерөнхий төлөвлөгөө хуульчлагдаж чаддаггүй, мөрдөгдөж чаддаггүй. Хотын үе үеийн дарга нар ингээд энэ ерөнхий төлөвлөгөөг барьж ажиллаагүйгээс өнөөдрийн Улаанбаатар хотын эмх замбараагүй байдал бий болсон.

Тэгэхээр цаашид энэ ерөнхий төлөвлөгөөг барьж ажиллах, энэ ерөнхий төлөвлөгөөний гүйцэтгэлийг хангаж чадахгүй зөрчвөл ер нь ямар хариуцлагатай байх юм бэ, энэ хуульд яаж тусгаж байгаа юм бэ? Энэ бол өргөн агуулгатай асуудал шүү. Газраас авхуулаад, стандартаас авхуулаад энийг ерөөсөө мөрдөж ажиллахгүй байгаа

учраас хийхдээ ерөнхий төлөвлөгөө гэж бөөн хөрөнгө мөнгө гаргачхаад, амьдрал дээрээ хэрэгжүүлж чаддаггүй. Тэгээд л тэр хөрөнгө ерөнхий төлөвлөгөө гэдэг чинь зүгээр цаасан дээр хоосон төлөвлөгөө болоод л үлддэг. Ингээж явсаар байгаад 30 жилийн хугацаанд Улаанбаатар хот өнөөдрийн ийм замбараагүй, зохион байгуулалтгүй, иргэндээ ээлгүй ийм хот болсон. Энэ дээр та бүхэн энэ шинэ хуулийн төсөлд хэрхэн яаж хариуцлагын асуудлыг чангаруулж оруулж ирж байгаа вэ гэдгийг тодруулж асууя.

Гэр хорооллыг орон сууцжуулах асуудал ярьж байна. Гэр хорооллын Улаанбаатар хотын 180 мянган айл өрхийг орон сууцжуулах асуудлыг ингээд Сүхбаатар, Чингэлтэй дүүргээс эхлүүлж гэж байгаа юм байна, сайн байна. Гэхдээ Улаанбаатар хотын хүн амын төвлөрлийн чинь хамгийн чухал хэсэг дэд бүтэц. Инженерийн шугам сүлжээ, эрчим хүчний хүрэлцээ хангамж, дулааны хүрэлцээ хангамж чинь одоо ямар байгаа юм бэ, цаашидаа ямар болох юм бэ? Өнөөдрийн энэ Тэц 2, 3, 4 чинь, Амгалан дулааны станц чинь Улаанбаатар хотын энэ өсөн нэмэгдэж байгаа эрчим хүчний эх үүсвэр, хэрэгцээ дулааныг хангаж чадаж байгаа юм уу үгүй юү? Ер нь дөнгөн данган л хүйтний ачааллыг давж байгаа шүү дээ. Эрсдэлтэй байдалтай. Цаашидаа энэ үнэхээр орон сууцжуулах бодлого явна гэж байгаа бол энэ дэд бүтцийн инженерийн газар доорх энэ хангамжийг хэрхэн яаж тооцоолж байгаа юм бэ яаж?

Тэгвэл цаашидаа орон сууцжуулах бодлогоо дэмжинэ гэж байгаа бол алслагдсан энэ 3 дүүргүүдийг орон сууцжуулах бодлогын хүрээнд инженерийн шугам сүлжээг нь нэмэгдүүлэх, сайжруулах хүрээнд ер нь цаашидаа ямар төлөвлөлт энэ 2040 болоод өнөөдрийн энэ өргөн баригдаж орж ирж байгаа хуулийн төсөлд чинь явж байгаа вэ? Энэ асуудлуудыг хариулж өгөөч гэж хүсэж байна. Баярлалаа.

**Г.Занданшатар:** 85 Хишгээгийн Нямбаатар нийслэл хотын Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч. Түр байж байгаарай. Энэ зочид танилцуулъя. Дорнод аймгийн ерөнхий боловсролын I дүгээр сургуулийн 1993 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Гэгээн дурсамж, төрөлх сургууль, хайрт багш нараа эргэн дурсан уулзаж байгаа эргэн дурсах уулзалтад нь амжилт хүсье, гишүүдийн нэрийг өмнөөс сайн сайхныг хүсье. Нямбаатар дарга хариулна 85.

**Х.Нямбаатар:** Баярлалаа. Би Сандаг-Очир гишүүний асуултад хариулахдаа нэг зүйлийг бүүр аягүй тодорхой хэлье. Бид нар цаашид энэ гэр хорооллыг орон сууцжуулах, барилгажуулах төсөл хөтөлбөрийн хүрээнд дэд бүтцийн асуудал дээр урьдын барьж ирсэн бодлогодоо бас зарчмын өөрчлөлт гарах ёстой юм байна гэж ойлголтыг бас өгмөөр байна. Өөрөөр хэлбэл одоо Дулааны 4 дүгээр цахилгаан станцад дулаан үйлдвэрлээд хэдэн 10км явж бүүр 13 дугаар хорооллын цаагуур тойроод буцаж ирж байгаа юм. Энэ бол хуучин үеийн төлөвлөлт. Одоо бид нар энэ Улаанбаатар хотод 6 дэд төвийг барилгажуулах ажил одоо эхлэхэд дэд бүтцийн асуудал дээр арай өөр бодлого баригдаад явж байгаа юм. Би сая бас дутуу хэлсэн байна шүү. СХД-ийн Баянхошуу дэд төвийн барилга угсралтын ажил хэдийнээ эхэлчихсэн явж байгаа. Ирэх жилийн 4 дүгээр сард эхний 800 айлын орон сууц ашиглалтад орно. Ирэх жил бид нар Сэлбэ дэд төвийн 12 мянган айлын орон сууцын барилга угсралтын ажлыг эхлэх гэж байгаа. Сэлбэ дэд төв дээр дулааны 28мвт-ын дэд станц ажиллаж байгаа. Энэ ердөө 15-хан хувийнхаа хүчин чадлаар ажиллаж байгаа. 2025 оны эхээр дахиад 63мвт-ын дэд станц ашиглалтад орно. Ингэхээр энэ 7 буудал, 6 буудал, 5 буудал, Хайлааст, Чингэлтэй хойшоогоо Дамбадаржаа орчмын айл өрхүүдийг орон сууцжуулахад энэ дулааны хүрэлцээ гэдэг асуудал бол

хүрэлцээтэй гэдэг зүйлийг мэргэжлийн байгууллагууд бидэнд техникийн нөхцөл хангалттай гэдэг дүгнэлтээ өгсөн.

2 дугаарт энэ усан хангамж дээр мөн Ус сувгийн байгууллага мөн хэсэгчилсэн ус хангамжийн асуудлыг энэ Сэлбэ дэд төвийн хүрээнд шийдчихсэн явж байгаа. Цахилгааны хувьд бол Даваасүрэн сайд, хэн Чойжилсүрэн сайд энэ тэр бас нэмж хариулах байх. Зүгээр энэ ондоо бол бид нар эрчим хүчний хувьд яг тулаад энэ оныг өвлийг авна гэсэн ийм тооцоотой ажиллаж байгаа. Ирэх жил Бөөрөлжүүтийн 150мвт-ын цахилгаан станц Улаанбаатар хотод эрчим хүч нийлүүлэх асуудал яригдана. Цаашид эрчим хүчний хүрэлцээг нэмэгдүүлэх чиглэлээр хэд хэдэн төслүүд ЗГ дээр хэрэгжиж байгаа болон хэрэгжиж эхлэх ийм төслүүд байгаа. Тэгэхээр би Сандаг-Очир гишүүнд юу гэж хариулах вэ гэхээр бид нар урьдынх шигээ дулаан хангамжийг асуудлыг шийдэхдээ Тэц 5, Тэц 6 гэдэг байдлаар хэт төвлөрсөн байдлаар шийдэхгүйгээр утаа шүүгчтэй ийм хэсэгчилсэн дулаан хангамжийн ийм төслүүдийг цаашид хэрэгжүүлэхээр байгаа. 25 онд, 25 онд Дэнжийн мянгын газар ажиллах бас дулаан хангамжийн дэд станцын ажил эхлэхээр төлөвлөлт хийгдээд эх үүсвэрүүд нь шийдэгдээд явж байгаа гэдгийг хэлье.

Таны хэлсэн асуултад товчхондоо хариулахад энэ Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөөг зөрчиж барьж байгаа барилга, төслүүд дээр ямар хариуцлага тооцох вэ гээд. Өнөөдөр ч гэсэн хуультай. Өнөөдөр ямар хуультай вэ гэвэл албан тушаалын гэмт хэргээр хариуцлагын асуудал яригдаж байгаа. Та бүхэн хэвлэл мэдээллийн байгууллагуудаас сонссон байх. Ер нь бол зүгээр бид нар бас сахилга хариуцлагыг чангатгах чиглэлээр НЗДТГ-аас бас тодорхой байгууллагууд дээр гарсан зөрчил дутагдлыг шалгуулах чиглэлээр АТГ албан бичгүүд очсон. Нийтийн тээвэр, өмчийн харилцаа, барилга, хот байгуулалт, газар зохион байгуулалтын алба гээд маш олон

албадын алба хаагчтай холбоотой ийм албан тушаалын хэргүүд шалгагдах ажлууд явж байгаа. Би нэг талаасаа их харамсаж байгаа. Миний бас урьд нь хамт ажиллаж байсан нөхдүүд яг энэ асуудал дээр шалгагдаж байгаа. Тэгэхдээ бид нар энэ өнгөрсөн гучаад жилийн Улаанбаатар хотын төлөвлөлтийн алдаа, энэ замбараагүй байдлыг засаж шинээр энэ алдаагаа давтахгүйн тулд бид нар ийм ажлыг хийхээс өөр аргагүй байгаа гэдгийг бас та бүхэн ойлгоосой гэж хэлэхийг хүсэж байна.

**Г.Занданшатар:** Цэрэнпилийн Даваасүрэн сайд хариулна. Даваасүрэн сайд.

**Ц.Даваасүрэн:** Сандаг-Очир гишүүний хэлээд байгаа тэр ялангуяа дэд бүтцийн хангамжаас дулааны асуудал дээр бол бас 2040 дээр тодорхойгүй нөхцөл байдал бас үүсчхээд байгаа юм. Одоо бид яах вэ 2040 дээр нэг шийдэл гаргасан нь юу вэ гэвэл түрүүн Нямбаатар дарга хэллээ шүү дээ. Ер нь инженерийн хэсэгчилсэн дэд бүтэцтэй байна, нэг дулааны станцаас эх үүсвэртэй байх бол эрсдэлтэй байна гэдэг асуудал. Тийм учраас болбол дэд төвүүд бүр өөрийн гэсэн дулааны эх үүсвэртэй байх нь гэсэн үг. Тэгэхдээ энэ яг ямар дулааны эх үүсвэр байх вэ гэдгийг бид нар өнөөдөр яг ЭХЯ-тай эцэслэн тохирч шийдэхгүй байна. Шийдэж чадаагүй байгаад байна. 2040 хүлээгдээд байгаа нэг гол шалтгаан бол ерөөсөө энэ байна. Бөөрөлжүүтийн станц бол цахилгаан л нийлүүлнэ, дулаан нийлүүлэхгүй. Тэгэхээр энэ дулааны асуудлыг цаашидаа газ байх юм уу, ямар эх үүсвэртэй байх юм гэдэг нэг асуудал.

2 дугаарт ер нь зүгээр яамнаас бидний нэг барих гэж байгаа чиглэл юу вэ гэвэл дулаан алдагдалгүй барилгажилтын асуудлыг цаашидаа анхаарна гэж байгаа юм. Ингэж чадах юм бол бид нар бүхэл бүтэн дулааны станцыг ч хэмнэж чадна. Дулаан алдагдалгүй болгож чадах юм бол. Манай байшингууд болбол үндсэндээ тэр

үйлдвэрлэсэн дулааныг салхинд хийсгэчхээж байна шүү дээ. Тийм учраас энэ чиглэлд бас тодорхой өөрчлөлт гарна гэж. Тэр төлөвлөлтүүдийн хувьд болбол та бол хэлж байна. Улаанбаатар ийм байна гэж. Би зүгээр өчигдрийн та нарт танилцуулсан бидний шийдэх гээд байгаа арга замыг тэгээд та нөхөд маань хүлээж авахгүй юм байна шүү дээ. Би Багануур хамгийн сайн төлөвлөлтөө дагасан дүүрэг юм байна гэж ойлголоо. Өөрөө тэнд бол даргыг нь хийж байсан. Тийм учраас бусад дүүрэг чинь тэгж ажиллаагүй байна. Тийм учраас одоогийн оруулж ирээд байгаа тэр нэг цонхоор газар олгодог болъё гэдэг хуулийг шийдээд өгчихвөл энэ замбараагүй байдал чинь алга болно л гэж бид нар энэ асуудлыг шийдэх гэж оруулж ирж байгаа арга зам нь тэр шүү.

**Г.Занданшатар:** Цэндийн Сандаг-Очир гишүүн тодруулж асууна 1 минут.

**Ц.Сандаг-Очир:** Энэ ЗГ хотын удирдлагуудын нэг үндсэн чиг үүрэг бол энэ Улаанбаатар хотын сая 500 мянган иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх юуны өмнө байх ёстой, хангагдах ёстой. Тэгээд Даваасүрэн сайд, хотын дарга 2 бол энэ 40, 50 мянгатын энэ олон айл өрхүүдийн аюулгүй байдалд онцгой анхаарал хандуулж, үнэлгээ дүгнэлт хийлгэж яахгүй бол маш аюултай, нэг давхруудыг нь бүгдийг нь цоолсон энд тэндээс нь хаалга гаргасан. Ер нь аюулын ирмэг дээр амьдарч байгаа иргэд байгаа шүү. Асуудал үүсэхгүй байгаа тулдаа л өнөөдөр явж байгаа. Асуудал үүсвэл хамгийн түрүүнд нурах аюултай ийм орчинд ажиллаж, амьдарч байгаа энийг эртнээс ойлгож сануулж хэлэхгүй бол, арга хэмжээ авахгүй бол энэ аюулын харанга дэлдэж байгаа шүү гэдгийг л хэлэх гээд.

2-т Даваасүрэн сайдаа тэр Бөөрөлжсүүтийн 150мвт-ын ДЦС энийг явуулахын тулд Багануур.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Эхлээд Нямбаатар дарга, Хишгээгийн Нямбаатар дарга НЗД бөгөөд Улаанбаатарын захирагчаар бол 85. Дараа нь Даваасүрэн сайд хариулна.

**Х.Нямбаатар:** Энэ анхдагч хуулийн төслийг дагаад Бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт орж байгаа. Саяын Сандаг-Очир гишүүний яг асуусан асуулт буюу нэг давхрын анхнаасаа үйлчилгээний зориулалтаар бариагүй барилгад бүртгэлийн байгууллага үйлчилгээний зориулалттай барилга гэдэг гэрчилгээ өгөх явдлыг хориглож байгаа юм. Өөрөөр хэлбэл анхнаасаа барилгын норм журмын дагуу үйлчилгээний зориулалттай нэг давхар нь байна гэсэн барилгад л үйлчилгээний зориулалттай орон сууц үйлчилгээний зориулалттай гэдэг үл хөдлөхийн гэрчилгээ өгье. Тэрнээс биш зориулалт хийцлийг нь эвдэж нэг давхрын балконоороо хаалга гаргаад үйлчилгээний зориулалттай болгож байгаа зүйл дээр улсын бүртгэлийн байгууллага үйлчилгээний зориулалттай гэдэг гэрчилгээ өгөхийг энэ хуулиар хориглосон ийм зохицуулалт оруулж ирж байгаа.

**Г.Занданшатар:** Цэрэнпилийн Даваасүрэн сайд хариулна.

**Ц.Даваасүрэн:** Тэр таны ярьж байгаа 2040 юу 40, 50 мянгатын айлууд дээр саяхан шалгалт хийж бид нар дууссан, мэдээлсэн байгаа бас. Энэ дээр бол маш ноцтой юм илэрч байгаа. Тухайлбал 40, 50 мянгатын 350-аад айлын тэр 1 дүгээр давхрын айлуудын хувьд болбол барилгын хийцийг өөрчилсөн, даацын ханыг нь авсан, заал болгосон тэнд зөвшөөрөлгүйгээр газ ашиглаж байгаа энэ тэр гээд ноцтой юмнууд бол байгаа. Тийм учраас шалгалтын үр дүнгийн дагуу бид нар ОБЕГ, НЗД-д чиглэл хүргүүлсэн байгаа. Тэр заалыг нь ингээд заал болгоод ашиглачихсан энэ барилгууд газар хөдлөх юм болбол маш хүндрэлтэй нөхцөл байдал үүсэхээр байна. Энэнд болбол холбогдох арга хэмжээнүүдийг аваач гэсэн. Мөн ОБЕГ-т бас энэ галын

аюул бол харанга дэлдэж байна шүү, зөвшөөрөлгүй байна шүү, энэ тэнд 1 дүгээр давхарт үйлчилгээ эрхэлж байгаа хоолны газрууд чинь бол зөвшөөрөлгүй газ хэрэглэж байна гэсэн гэх мэтийн. 40, 50 мянгатын хувьд бол маш ноцтой ийм нөхцөл байдал болбол үүссэн байна лээ. Тийм учраас бол бид холбогдох газруудад нь болбол анхаарлуудыг бол хүргэсэн байгаа гэдгийг хэлье.

**Г.Занданишатар:** Цэндийн Сандаг-Очир гишүүн тодруулж асууна.

**Ц.Сандаг-Очир:** Улаанбаатар хотын дулаан, эрчим хүчний хэрэглээ тулчихсан байгаа. 2017 онд Багануурын ДЦС-ын ажил эхэлсэн шигээ явсан бол өдийд дуусчихсан байх ёстой байсан. Харамсалтай нь Бөөрөлжүүтийн цахилгаан станцыг дэмжиж, Багануурын ДЦС-ын ажлыг бодлогоор гацааж зогсоосон. Үндэсний аюулгүй байдал нэрийн доор. Тэгээд өнөөдөр энэ ажил гацчихаад явж байгаа. Энэний алдагдсан боломж гэдэг бол хэрвээ энэ өнөөдөр ашиглалтад орчихсон байсан бол дулаан Улаанбаатар хотын цахилгаан хангамжийн энэ тулчихсан байгаа гэдэг юм уу, дулаан хангамжийн тулчихсан байгаа хэрэглээг бас хангаад, нөхөөд явах бололцоо боломж бүрэн байсан даа. Энэ дээр бас цаашидаа Улаанбаатар хот, ЗГ, салбарын яамнууд бас онцгой анхаарал хандуулж энэ төслийг үргэлжлүүлэх тал дээр бас дэмжиж тусалж хамтарч ажиллах хэрэгтэй байна шүү гэдгийг бас хэлье.

**Г.Занданишатар:** Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Лувсанцэрэнгийн Энх-Амгалан, Лхагвын Мөнхбаатар, Цэрэнпилийн Даваасүрэн нарын урилгаар Хөвсгөл аймгийн МАН-ын хорооны аймаг, сумдын дарга, тэргүүлэгч, гишүүд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Хүндэт гишүүд та бүхэндээ Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс ажлын амжилт, сайн сайхан бүхнийг

хүсэн ерөөе. Цэрэнпилийн Даваасүрэн сайд хариулна.

**Ц.Даваасүрэн:** Сандаг-Очир гишүүнээ Багануурын, Бөөрөлжүүтийн ДЦС биш энэ чинь зөвхөн цахилгаан үйлдвэрлэнэ. Тэнчээнээ л дулааныг яахаас биш наашаа Улаанбаатарын дулаанд бол ямар ч нөлөө үзүүлэхгүй. Үгүй ээ үгүй тэр чинь зөвхөн тэр юуныхаа Багануураас наашаа дулааны шугам татна гэж хэзээ ч байхгүй шүү дээ. Зүгээр тэнд харин Үндэсний аюулгүй байдлын зөвшил тухайн үедээ харамсалтай нь бас Багануурын станцын үйл ажиллагааг зогсоох шийдвэр гаргаж байсан. Тэгэхдээ бид бол зогсоогоогүй юм. Зогсоогоогүй. Одоо ч гэсэн ажил нь үргэлжлээд явж байгаа. Тэнд ямар асуудал үүссэн гээд тэгэхээр Хятадын Ерөнхийлөгч тухайн үед 21 онд НҮБ дээр энэ нүүрсхүчлийн хий үйлдвэрлэж байгаа энэ технологиудыг цаашидаа бол бид нар хийхгүй гээд. Одоо ирэх жилээс бол бүүр ерөөсөө ийм нүүрсний цахилгаан станцын тоног төхөөрөмж нийлүүлэхгүй болох гэж байгаа юм байна лээ Хятадууд. Тэгэхээр энэ нь хүндрэлтэй нөхцөл байдал бол үүсгэсэн байсан.

Гэхдээ сая болбол нөгөө тэр Багануурын станцыг барих гэж байгаа төрийн өмчийн компани төрийн биш болгоод, хувийн болгоод нэгэнт гэрээ байгуулагдчихсан байсан гэсэн учраас болбол тэр нүүрсний тоног төхөөрөмжийг нийлүүлэхээр болж байгаа юм байна лээ. Тэнд бол харин зүгээр 700мвт-ын генераторыг 200мвт-ын генератор болгож өөрчлөгдсөн ийм, биш ээ 400-хыг. 400-хыг 200 болгож өөрчилсөн ийм л өөрчлөлт явагдсан. Ажил бол би хэвийн явж байгаа гэж ингэж ойлгож байгаа. Төрийн компани нь хувийн компани болсон байна лээ. Тэр нөгөө НҮБ-д хүлээсэн үүргээс нь болоод Хятадын талын.

**Г.Занданишатар:** Ер нь ажлын хэсэг нийслэл хотод нэг ийм санал суудал болбол иргэдээс ирж байгаа нэг ийм санал

байгаа юм. Энэ өвлийн эрчим хүчний ачаалал оргил ачааллын үе бас эрчим хүчний хангамж ямар шатанд байгаа билээ. ЭХЯ-ны мэдээлж байгаагаар болбол хязгаарлалт үүсэхээс нөхцөлгүй байдал үүсэж байна гэж байгаа юм. Агаарын бохирдол, түгжрэл зэргийг тооцоод дунд сургуулийн хичээлийн хөтөлбөрийг 12, 1 сард амрааж, зун, намрын сард шилжүүлэх талаар судалж үзвэл ямар вэ? 7 сарын 1 хүртэл хичээллэж болж байна, 8 сарын 1-нээс хичээл эхэлж болж байна. Хүүхдүүдийн эрүүл мэнд, аюулгүй байдал энэ бүх талаа бодоод, эрчим хүчний. 2 дугаарт болбол энэ нийслэл, дүүрэг, төрийн өмчит нийт албан байгууллагын автомашины хэрэглээг хязгаарлавал ямар вэ? Нөгөө төлбөр юу энэ тэрээсээ гадна яамнууд харьяа газар гэх мэт ч гэсэн тэр. Ийм замаар энэ түгжрэлтэй шууд захиргааны нэг ийм өөрсдийн хэмжээнд хийх асуудлуудыг судалж үзээч гэсэн ийм саналууд бас ирж байгааг судалж үзэх талаар ажлын хэсэг дээр анхаарна биз гэдгийг хэлье. Ганзоригийн Тэмүүлэн гишүүн асуулт асууна.

**Г.Тэмүүлэн:** Та бүхэнд энэ өглөөний мэндийг хүргэе. Тэгэхээр энэ Улаанбаатар хотын түгжрэл, төвлөрлийн асуудал үндсэндээ манай нийслэлийнхний хамгийн том асуудал болсон. 1,6 сая хүн ам, 716 мянган машин, 410 мянган айл өрхийн эрх ашиг хөндөгдөж байгаа энэ асуудал бол энэ байгаа. Тэгэхээр би Нямбаатар сайд бол ажлаа аваад удаагүй байгаа, шинэ санал санаачилгатай ажиллаж байгаа гэж харж байгаа. Санаа өгөх үүднээс замын түгжрэл бууруулах өртөг багатай 5, 6 санааг болбол хэлье гэх гээд байгаа юм. Тэгэхээр механикаар бууруулах би боломж байна уу гэж хараад байгаа юм. Энийг та бүхэн судалж үзээч мэргэжлийн хүмүүс. 1 дүгээрт манайд төвлөрөл үүсгэж байгаа хамгийн том асуудал болбол энэ төлөвлөлтгүй, бодлогогүй орон сууцжилтын асуудал байгаа. Тэгэхээр ерөөсөө шийдэл нь болбол би энэ хотынхоо төв болоод А, Б бүсүүд дээрээ

орон сууц барихыг нь хориглож болдоггүй юм уу? Орон сууц барихыг нь хориглож болдоггүй юм уу? Газар шинээр нэмж олгохыг нь хориглож болдоггүй юм уу? Эргээд газар авдаг, орон сууц барьдаг, түгжрэл нь дийлдэггүй, сургууль, цэцэрлэг нь хүрдэггүй, эргээд хүүхдээ зөөх асуудлууд үүсдэг. Нөгөө нэг ... нарын хуулиар тойргийн цэцэрлэгтээ хүүхэд нь хамрагдах асуудал байхгүй болчихоод байгаа юм. Тэгэхээр ерөөсөө тэр магадгүй тэр орон сууцынхаа оронд оффис барих ч гэдэг юм уу энэ эрхийг нь нээж өгөөд, зохицуулалт хийж өгөөд явахгүй болбол энэ болохгүй байна уу гэж хараад байгаа юм нэгдүгээрх нь.

Хоёрдугаарх нь автомашины зогсоолын асуудал хамгийн хүнд болчихлоо. Машин зорчих ёстой замууд бүгдээрээ зогсоол байдлаар ашиглагдаж дууслаа. 2 эгнээ зам байвал 1 эгнээ нь дандаа зогсоол болоод байна. Тэгэхээр зам дагуух зогсоол хийдгийг нь ерөөсөө хатуу хориглоод, 2 эгнээ замаар нь ашигладаг эсвэл төв зам дагуу ямар нэг үйлчилгээний газар хийлээ гэхэд тэр нь зам дагуу зогсоол хийдгийг хориглоод хийвэл яасан юм бэ? Зогсоолтой холбогдуулж машинтай болох гэж байгаа хүн байвал амьдарч байгаа газраа орон сууцдаа заавал ч үгүй зогсоолтой байх шаардлага тавьж байж, зогсоолтой байвал машинтай болох эрхийг нээж өгвөл яасан юм гэсэн асуудал байгаа хоёрдугаарх нь. Тэгэхээр яг үндсэндээ түгжрэлээс чинь гадна аль ч орон сууцын гадаа ерөөсөө зогсоол байхгүй, орон сууц хороолол дотроо гацдаг энэ нэг асуудлыг бид нар цэгцлэхгүй бол болохгүй байна гэж хараад байгаа.

Гуравдугаарх нь нийслэлээс уг нь анх хэрэгжүүлж эхэлж байсан манай Хууль зүйн сайдын зөвлөх манай Мөнх-Эрдэнийн хийж байсан. Энэ хашаажуулдаг асуудлыг зогсооё гээд, тэгээд одоо бараг зогсчихсон шахуу эхэндээ их эрчим хүчтэй явж байсан. Тэгэхээр хотхон болгон хашаажуулалтыг зогсоогоод өгөөч. Энэ төв зам хооронд нэвтрэх хүчин чадлууд

байхгүй байгаад байна. Нэвтрэх чадварууд нь байхгүй болчихоод байна. Хотхоныг нь тойрч, хашааг нь тойрч явсаар байгаад түгжрэлд орчихоод байгаа юм. Тэгэхээр ерөөсөө энэ нэвтрэх чадварыг дээшлүүлэх үүднээс хашаажуулдгийг хотхон болгоны хооронд больж өгвөл яасан юм бэ?

Дөрөвдүгээрх нь би нэг ийм санал хэлэх гээд байгаа юм. Түгжрэлийн хамгийн том асуудал бол ерөөсөө уулзвар болчихоод байгаа. Энхтайваны өргөн чөлөөгөө бид нар нэвтрэх гээд төв шуудан дээрээ гацаад бүтэн цаг зогсчихож байгаа юм. Тэгэхээр ерөөсөө л энэ түгжрэл үүсгэдэг хамгийн муу зохицуулалт болсон уулзварыг нүхэн гарцаар, гүүрэн гарцаар шийдэх асуудлуудыг нэг ирэх ондоо нэг ядаж 10, 10-ыг шийдчихвэл үндсэн төв замууд маань уг нь саадгүй болох асуудал байх биш үү гэдэг асуудал байгаад байгаа юм.

Тавдугаарх санал нь би энэ түгжрэл үүсгэж байгаа жолооч нартаа бид нар хариуцлага тооцож чадаж байгаа юм уу, хариуцлага тооцож чадаж байгаа юм уу? Энэ торгуультай би мэдээллийг нягтлаад ерөнхийдөө аваад үзсэн чинь үндсэндээ хотын хэмжээнд нийтдээ 4,4 сая авто замын зөрчил үүссэн байна. 4,4 сая торгууль байна гэж байгаа юм. Мөнгөн дүнгээр нь аваад үзэхээр 105 тэрбум төгрөг гэж байгаа юм, 105 тэрбум төгрөг. Тэгэхээр бид нар энэ түгжрэл үүсгэж байгаа, торгуультай хөдөлгөөнд оролцдог, зөрчил үүсгэдэг энэ жолооч нар дээр хариуцлага тооцоод бүгдээрэнг нь механикаар нэг магадгүй юу гэдэг юм долоо хоногийн сарын компаничилсан ажил хийгээд бүх энэ машинуудыг хөдөлгөөнд орохыг нь хязгаарлаад ачаад гэдэг юм уу ингээд явбал яасан юм бэ? Ингэвэл магадгүй тэр торгуультай нөхдүүд торгуулиа төлдөг, эргээд хөдөлгөөнд орох хязгаарлалтууд бий болсноороо хөдөлгөөний төвлөрөл ч гэсэн бас аятайхан хэмжээнд очих юм болов уу гэж бодоод байгаа юм.

Зургаа дахь би санал нь яах вэ төлбөрийн асуудал орж ирж байгаа. Төлбөр авах нь зарчмын хувьд зөв байх. Тэгэхдээ хот өөрөө шийдээд явах нь зөв байх. Тэгэхдээ төлбөртэй бүсээ бид нар зөвхөн төв дээрээ биш жосоохон томруулаад бүсчлэлээ томруулах боломж бололцоо байхгүй юу гэдэг асуудал байгаад байгаа юм.

**Л.Мөнхбаатар:** Асуултад Нямбаатар дарга хариулъя. Ажлын хэсгийн 85 дугаар микрофоныг өгье, 85 уу.

**Х.Нямбаатар:** Баярлалаа. Тэмүүлэн гишүүн яг энэ хуулийн үндсэн үзэл баримтлалын дагуу бүх асуултууд асуулаа гэж би хариулах байна. Энэ хууль 2 үндсэн зорилго агуулж байгаа. 1 дүгээрт гэр хорооллыг орон сууцжуулах, 2 дугаарт авто замын түгжрэлийг бууруулах, 3 дахь нэг бас дэвшүүлж байгаа зорилго бол хэт их нягтаршилтай Их тойруу, Бага тойруу дотор дахиж барилга барих явдлыг хязгаарлая. Үүнийгээ ЗГ-ын журмаар шийдье гэдэг ийм зохицуулалт орж ирж байгаа. Би та бүхэнд нэг статистик хэлэхэд бид нарын Их тойруу үндсэндээ 1100 га газар байгаа. Энэ дотор одоо энэ ийм нягтаршилтай байгаа дээр Барилга, хот байгуулалтаас өгсөн зөвшөөрлөөр дахиад 1500 өндөр барилга барихаар байгаа. 1500 өндөр барилга. Зарим нь тэр 1 дүгээр эмнэлгийн хашаан дотор 20 хэдэн давхар барилга хүртэл барих ажил эхэлчихсэн явж байх жишээтэй. Тэгэхээр энэ бид нарын гол энэ хуулийн бас тэр 3 дахь том дэвшүүлж байгаа зорилго бол өмнөх Улаанбаатар хотын төлөвлөлтийн алдааг 6 дэд төвүүд байгуулах замаар дэд төвүүд рүү энэ шинээр барилгажих барилгуудыг нүүлгэн гаргах, нягтаршил ихтэй байгаа төрийн үйлчилгээний цэг салбаруудыг эдгээр 6 төвүүд рүү шилжүүлэх, их дээд сургуулиудыг шилжүүлэх ийм зорилт дэвшүүлж байгаа.

2 дугаарт энэ хуулиар газар олголтын асуудлыг үндсэндээ

Улаанбаатар хотод зогсоож байгаа. Улаанбаатар хотын төвийн 6 дүүрэг газар олгодог. Утаа өдөр тутамдаа дүүргийн Засаг даргын захирамжаар үйлдвэрлэдэг явдлыг бүрмөсөн зогсоож төвийн 6 дүүргийн Засаг дарга нар 007 га, 004 га газрыг олгохгүй, ерөөсөө цаашид газар олгохгүй байхаар хуульчилж өгч байгаа юм. Дээр нь НЗД газар олголт дахь эрх хэмжээгээ хязгаарлаж байгаа юм. Төр, хувийн хэвшлийн түншлэл, төрийн бүтээн байгуулалтын ажил, саяынх шиг нөхөн олговор байдлаар газар олгоё, дээр нь нэмээд зөвхөн дуудлага худалдаагаар нөгөө дэд төв дотор газар олгохдоо дуудлага худалдаагаар газар олгоё гэдэг л ийм зүйлийг ярьж байгаа юм. Тэрнээс биш Их тойруу дотор дахиж газар олгохгүй, Бага тойруу дотор газар олгохгүй гэдэг ийм хязгаарлалт орж ирж байгаа юм.

Автомашинны зогсоол ашиглалт дээр мөн адилхан. Энэ самбар дээр бид нар анх удаа хэлэлцүүлгийн явцад ийм юу оруулж танилцуулга орж ирсэн. Энийг нэг слайдыг нэг ухраагаад үзүүлчих үү манайхан. Энийг нэг ухраавал одоо яг Их тойруу ийм байгаа. Одоо энэ нөгөө зөвшөөрөл өгчихсөн барилгууд газар олгох юм бол дараагийнх нь слайд нөгөө улаан болгочих, ийм барилгууд дахиж нэмэгдэнэ. Тэгэхээр энийг энэ хуулиараа шийдье. Энийг ЗГ дээрээ тодорхой журам гаргаад энэ өмнө нь газар худалдаж авсан компаниудын эрх ашгийг хохироолгүйгээр бид нар төлөвлөлтийнхөө алдааг засаж өөр байришилд шилжүүлж явъя гэдэг ийм зохицуулалт орж ирж байгаа.

Автомашинны зогсоол ашиглалтыг яг саяын таны хэлсэн бүх зохицуулалтууд орж ирж байгаа Тэмүүлэн гишүүнээ. Харин нэг зохицуулалт байснаа бид нар өргөн барихаасаа өмнө.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Нямбаатар дарга гүйцээгээд хариулчихъя.

**Х.Нямбаатар:** Энэ хууль анхдагч хууль учраас таны саяын санаа орж ирж болно. Орон сууц эзэмшиж байгаа иргэн

тэр орон сууцынхаа орчинд өөрийн гэсэн зогсоолтой байна гэдэг шаардлагыг хэлэлцүүлгийн явцад зарчмын зөрүүтэй санал гаргаж болно. Тэрнээс биш бид нар хажуугийн зогсоолууд энэ тэрийн ашиглалтыг сайжруулах, төлбөртэй болгох ийм чиглэл явж байгаа. Ер нь бол зогсоол нэмээд түгжрэл шийдээгүй жишээ манай урд хөршийн Бээжин хот. Бээжин хот өнөөдөр 5,6 сая автомашинтай, 1,4 сая зогсоолтой байгаа. Зогсоолоо нэмээд шийдээд, түгжрэлээ шийднэ гэж нэг хэсэг явсан. Тэгээд энэ үндсэндээ гүйцээгүй. Тэгэхээр энэ бол зогсоол нэмж барьснаараа асуудал шийдэгддэг ийм зохицуулалт биш юм байна лээ.

Хашаажуулалт дээр өнөөдөр сүүлийн 3 жил Сумъяабазар даргын үед 30км хашааг буулгасан. Одоо дахиад 30км хашаа буулгахаар байгаа. Нэг эерэг үр дүн гарсан, хашаа буулгаснаар гэмт хэрэг зөрчил багассан гэдэг ийм эерэг статистик гарсан. Хашааны булан тохойд дээрэм бусад гэмт хэрэг гарч байсан.

Торгуулиа төлөөгүй жолооч нарыг хөдөлгөөнд оролцуулахгүй гэдэг зохицуулалт энэ хууль дээр орж ирж байгаа. Өнөөдөр нэг нөхөр дээр жишээ авч манай энэ судалгааны багийнхан үзүүлж байна лээ. Нэг тээврийн хэрэгсэл жолоодож байгаа нөхөр 15 сая төгрөгийн торгууль төлөөгүй өнөөдөр хөдөлгөөнд оролцоор байгаа. Өөрөөр хэлбэл тэр машиных нь зах зээлийн дундаж үнээс бараг давсан ийм торгуулиа төлөөгүй бүх дүрэм журмыг зөрчөөд ингээд яваад байгаа юм. Энэ бол бас 10 орчим хувь хөдөлгөөн буурахаар байгаа.

Төлбөр авах бүс дээр яг таны хэлж байгаагаар нийслэл өөрөө үе шаттайгаар тогтооё, бүсчлэлээ би зүгээр жишээ болгож олон нийтийн мэдээллийн хэрэгслээр ярьж байгаа. Бага тойруугаар тогтоох уу, Их тойруугаар тогтоох уу гэдэг бол тухайн үед яригдана. 27 мянган



төгрөг авна гээд бас хүмүүс тийм буруу мэдээллүүд яваад байна лээ. Ийм зүйл ерөөсөө огт байхгүй. Эхлээд Нийслэлийн иргэдийн Хурал бүсчлэлээ тогтооё. 2 дугаарт бүсчлэл дээр мянган төгрөг ч байж болно. Энэ дэлгэцэд харж байгаа бол Бага тойруу. Энийг бид нар Их тойруугаар тогтоож болно. 27 мянга хүртэл төгрөгийг л тогтооё гэж байгаа юм. Мянган төгрөгөөр тогтоож ч болно, 2 мянган төгрөг ч байж болно. Энэ бүс дотор амьдардаг хүн жишээлбэл 2 мянган төгрөгөөр тогтоосон тохиолдолд өдөрт 200 төгрөгийн төлбөр төлнө л гэсэн үг. Тэгэхээр энийг бол аль болох бид нар уян хатан зохицуулна. Дэлхий дээр хамгийн шалгарсан арга бол энэ төлбөртэй бүс тогтоох гэдэг ийм судалгаа байгаа. Ойролцоогоор 15-аас 30 хувь буурсан гэдэг ийм статистик тоо байгаа гэдгийг бас та бүхэндээ хэлье.

**Л.Мөнхбаатар:** Тэмүүлэн гишүүн тодруулж асууя.

**Г.Тэмүүлэн:** 1 зүйлийг тодруулаад асуугаадахъя. Сая нөгөө 4,4 сая замын хөдөлгөөний зөрчил байгаа, торгууль байгаа. Түүний ард 105 тэрбум төгрөгийн торгууль болбол үүсчихсэн байгаад байгаа гээд байгаа. Тэгэхээр энэ 4 сая зөрчлийн цаана энэ 105 тэрбум төгрөгийн цаана ер нь яг хэдэн машин яг зөрчил үүсгэсэн хэчнээн жолооч нар зөрчил үүсгэсэн байгаа бол тоогоороо? Хэрэв бид нар жишээ нь юу гэдэг юм энэ дээр хязгаарлалт хийх юм болбол хэдэн хувиар юу гэдэг юм замын хөдөлгөөний төвлөрлийг сааруулах бууруулах боломж байгаа бол?

Дээрээс нь нөгөө Төрийн албаны хууль дээр бас нэг ийм зайнаас долоо хоногийн нэг өдрийг нь зайнаас төрийн албан хаагч нар ажиллаж болно гэсэн өөрчлөлт орж ирсэн байна лээ. Үүнд жишээ нь одоо хэчнээн албан хаагч нар хамрагдах боломжтой байгаад байгаа бол? Энэ дээр та хэд маань бас тооцоолол хийж, түгжрэлд энэ хэр нөлөөлөх гэдэг

тооцоолол нь гаргасан уу? Зайнаас ажиллах зохицуулалтаар.

**Л.Мөнхбаатар:** Хэн хариулах вэ? Нямбаатар дарга хариулъя. Ажлын хэсгийн 85 дугаар микрофоныг өгье.

**Х.Нямбаатар:** Баярлалаа. Одоо ХЗБХ-н дээр уг нь яг хэлэлцүүлэгдэж байгаа асуудал бол энэ зөрчлөө төлөөгүй торгууль шийтгэлээ төлөөгүй хувь хүний төрийн зарим үйлчилгээ авах эрхийг хязгаарлая гэдэг ийм бас хууль хэлэлцүүлгийн шатад байгаа. Би сая Цогтбаатар даргатай уулзаж энэ талын мэдээлэл авсан. Би танд нэг сүүлийн статистик хэлье. 2023 оны 10 сарын 10-ны байдлаар торгууль нийтдээ сая 639 мянган торгууль бичигдсэн. Харамсалтай нь төлөлт нь 26,5 хувьтай байгаа. Миний бие ХЗДХ-ийн сайдаар ажиллаж байхдаа 2021 оны 7 дугаар сарын 1, 2-ны үед батлуулсан хуулиар торгууль шийтгэлээ төлөөгүй хүмүүст өршөөлийн хугацаа заагаад тухайн хугацаанд төлсөн тохиолдолд нийт торгууль шийтгэлийнх нь 50 хувийг хөнгөлж чөлөөлөх нэг удаагийн хууль батлуулж байсан. Тэр үед торгууль төлөлтийн хувь хэмжээ нэлээн бас өндөр түвшиндээ хүрч 74,7 хувьд хүрсэн. Тэгээд торгуулиа төлөөгүй автомашинд замын хөдөлгөөнд оролцох эрх нь нээлттэй байгаад байхаар торгууль төлөлт өнөөдрийн энэ оны байдлаар 26,5 хувьтай байгаа. Тэгэхээр цаашид бид нар ийм хөшүүрэг тогтоохоос өөр аргагүй гэдгийг хэлье.

2 дугаарт таны хэлж байгаа тэр нөгөө ковидын үеийн бид нар зохицуулалтыг хийж үзсэн. Өөрөөр хэлбэл төрийн албан хаагчдыг зайнаас ажиллах энэ журмаар бид нар бас 2 жил гаруй ажиллаж үзсэн. Тэгэхээр ийм боломжууд бидэнд байгаа гэдгийг бас хэлэх байна. Нийслэлийн төр захиргааны байгууллагад ажиллаж байгаа 3 мянган албан хаагчийн хувьд бол энэ чиглэл дээр ийм ковидоор ажиллах боломж нөхцөлүүдийг судалсан. Бид нар бусад төрийн захиргааны болон бусад төрийн төв байгууллагуудын энэ

тоон дээр бол яг нарийвчилсан тооцоо гараагүй байна. Мэдээж хэрэг энэ хууль хэлэлцүүлгийн шатад бид бид нар тооцоо судалгаа гаргана.

**Л.Мөнхбаатар:** Эдийн засгийн байнгын хорооны дарга Цэдэндамбын Цэрэнпунцаг асуултаа асууя.

**Ц.Цэрэнпунцаг:** Энэ хотын шинэ дарга маань энэ түгжрэлийнхээ хуулийг оруулж ирж байгаа. Энэ асуудлыг шийдье гээд энэ зоригтой том арга хэмжээ авъя гээд явж байгаад нь бас талархаж байна. Тэгэхдээ хамгийн гол нь бид нар чинь хууль гаргаад үр дүнг нь үзэх ёстой. Тэгэхээр зэрэг хотын дарга бол өөрөө энэ том хамгийн том дүүрэг болох энэ Сонгинохайрханаас сонгогдож ажилласан. Энэ хотыг задалж дэд төвүүд байгуулах ажил руу нэлээн өөрөө ажил хийгээд явчихсан, Сонгинохайрханд бол бас нэлээн энэ хотын нэг төв үүсгэх талаар бол бас нэлээн төсвийг ч гэсэн тийш нь нэлээн чиглүүлж ажилласан ийм ажил туршилагатай учраас бол бас үр дүн гарах байх гэж найдаж харж байна.

Тэгээд хамгийн гол асуудал бол хамгийн гол асуудал бол байна шүү дээ энэ хуулийн төслийнхөө үр нөлөөг үнэлэх энэ ажлын тайлангаас харсан энэ ийм ерөнхий л нэг ийм нөлөөллийн үнэлгээ бол ийм ерөнхий юмнууд яваад байгаа юм. Энийг бид нар их нарийсгаад, энэ ард түмэнд орлогоор нь хуваагаад үзсэн ч, хотынхоо байришилд хаана амьдардгаасаа шалтгаалаад, ямар ажил амьдралтайгаас авхуулаад энэ хүмүүстээ яаж нөлөөлж байгаа гэдгийг нь нөлөөллийг нь бид нар маш сайн гаргах хэрэгтэй. Энэ үр нөлөө зардлын тооцоо гэдэг тооцоолол байдаг тийм ээ. Бид нар энэ Улаанбаатар хотыг энэ утаагүй болгох гээд тэр утаагүй зуухны төслийг явахад НҮБ-аас энэ тооцоог, тооцоолол үнэлгээг хийсэн байдаг байхгүй юу. Энэ яг ямар яг аль групп, аль бүлэг дээр ямар хэмжээний үр өгөөж нь очих юм, ямар хэмжээний өртөг зардал ачаалал очих юм бэ гэдгийг бүр нарийн тооцдог ийм

тооцоолол та нар сайн хийгээч. Энэ бол их ерөнхий юмнууд байгаад байх юм. Энэ тэгж байж бид нар ард түмнээсээ дэмжлэг авна.

Ер нь бол энийг хийхийн тулд бол бид нар ард нь хөрсөн дээрээ ажиллаж судалгаа, асуулт хариулт газар дээр нь явуулж ард иргэдтэйгээ уулзаж тэд нарыгаа мэдээллээр хангаж байж, тэгээд энэ хийх гэж байгаа ажлынхаа үр нөлөөг тэд нараараа яг өөрсөд дээр нь яаж тусгахыг нь бол тэд нараасаа сонсвол ийм үр дүнтэй, ийм үр нөлөө үнэлгээний ажил болно. Тэгэхээр энэ дээр нарийсгаж ажиллах хэрэгтэй.

2-т энэ 0,7 га газартай энэ хувийн өмч гэдэг бол хамгийн чухал юм. Бид нар энэ хүний хувийн өмчийг хамгаалах ёстой. Энэ хувийн өмчийг бид нар 07 га газрыг үнэ цэнд оруулах ёстой. Энэ төрийн үүрэг. Тийм учраас бол энэ дэд бүтэц, инженерийн шугам сүлжээ татаж энийг үнэ цэн оруулах гэж байгаа нь зөв зүйтэй, сайшаалтай. Тэгэхдээ өнөөдөр энэ дахиад энэ газрын хуваарилалтыг нэгтгэж нэг газар луу нэгдсэн дээш нь татаж авч байж, нөгөө л бас л лиценз зөвшөөрөл, лиценз, зөвшөөрөл гэдэгт дуртай хүмүүс их олон байгаа шүү. Тэр зөвшөөрлийн ард их олон юм бий. Хүн болгон өөр дээр нь ирж очиж байх, гуйж байх, зөвшөөрөл өгөөч, лиценз өгөөч гэж гуйлгаж байх сонирхолтой улсууд энэ төрийн албанд их байгаа. Эд нараас бид нар зайлсхийж ажиллаж, энэ зах зээлийн жамаараа энэ ард иргэд энэ өөрсдийнхөө эд хөрөнгөтэй харьцах энэ боломжийг бүрдүүлэх ёстой. Хамгийн гол нь энэ төр лүү мөнгө татаж явахын тулд, татвар авахын тулд авах, авахын тулд гардаг зардал ямар зардал байна вэ, яаж тооцож байгаа ю бэ?

Жишээлбэл мянган төгрөгийн торгууль тавиад, тэр торгуулийг цуглуулж аваад авчрахын тулд ямар хэдэн төгрөгийн зардал гарах юм бэ? Төрийн байгууллагын араас нь явах зардал чирэгдэл, энэ захиргааны ажил хийх зардал чирэгдэл яг хэд юм бэ? Мянган

төгрөгийн татвар авахад өнөөдөр хэдэн төгрөгийн зардал гардаг юм бэ? Энэ дээр бүүр тодорхой хариулт авмаар байна. Энийг бид нар сайн тооцох хэрэгтэй. Ер нь энэ төрийн энэ татвар авч байгаа гээд ингээд энэ цоорхой хувингийн үлгэрээр буцаад бид нар авсан татвараасаа илүү зардал чирэгдэл гаргадаг, энийг дагаад авлига, хээл хахууль, тэгээд ард иргэдэд тэр дарамт очдог. Тэгээд л энэ зөндөө олон захиргааны шийтгэл авчихсан иргэд гомдол гаргаад байдаг. Энэнээс бид нар яаж зайлсхийж, ард түмнээ бас энэ түгжрээд бухимдаж байхад нь.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Асуултад хэн хариулах уу? Нямбаатар дарга хариулъя. Ажлын хэсгийн 85 дугаар микрофоныг өгье.

**Х.Нямбаатар:** Баярлалаа. Дэлгэц дээр та бүхнийг бас анхаарлаа хандуулахыг хүсэж байгаа. Бид нар бас хууль хэлэлцүүлэхдээ тухайн хуулийн тооцоолол, үр нөлөөг харуулахыг зорьж байгаа. Энэ жил эхэлчихсэн, ирэх жил нэмэгдээд дэд төв, Сэлбэ дэд төв, буюу Баянхошуу, Сэлбэ дэд төв 2 ашиглалтад орсноор бид нар ДНБ-д 2,5 их наядын тийм нэмэгдэл инфакт үзүүлнэ. 2 дугаарт 25 аравны 25295 ажлын байр бий болно, агаарын бохирдлыг бууруулахад 22 хувийн нөлөөлөл үзүүлнэ, авто замын түгжрэл дээр 36,3 хувийн нөлөө үзүүлнэ гэдэг ийм тооцооллыг манай судалгааны байгууллага хийсэн байгаа.

Тэр зүүн талд нь нөгөө төлбөртэй бүсийн нөлөөллийн талаар тооцоо судалгаа байгаа. Энэ дээр төлбөртэй бүсийн тооцоо судалгаа дээр нэмэх нь энэ дээрх 2 дэд төвөөс гадна 15-аас 20 хувийн бас бууралт ирнэ гэсэн ийм тооцоолол байгаа. Энэ дээр нэмэх нь бид нар нөгөө масс тээврийн хэрэгсэл, метро, тойрог хурдны замын нөлөөллүүдийг бол одоохондоо тооцоо юу загварчлал хийж, хийх ажлууд явагдаж байгаа. Таны хэлж байгаа би асуудлуудтай сая очоод би бас хот дээр очоод удаагүй ч гэлээ гэсэн энэ

хотын санхүүгийн төлөвлөлт, өмчийн ашиглалт гээд энэ зүйлүүдтэй тодорхой хугацаанд танилцлаа. Өрийн удирдлага энэ тэртэй. Тэгэхээр ер нь бол урьд урьдын нийслэлийн санхүүгийн төлөвлөлт, төсвийн төлөвлөлт бол ерөөсөө жил жилээ л харж ирсэн юм байна. Жилдээ яаж нийслэл Улаанбаатар хот юу улсад нэг багахан шиг мөнгө төвлөрүүлэх вэ, байгаа мөнгөндөө юу хийх вэ гэдэг л ийм зүйлтэй ирсэн юм байна.

Гэтэл өнөөдөр Улаанбаатар хотод 1,7 их наяд төгрөгийн дуусаагүй төсөл хөтөлбөрүүд байна. Өөрөөр хэлбэл энэ сүүлийн 24, 5 жилийн хугацаанд хийгдэж ирсэн, дуусаагүй. Дуусах ёстой, эсхүл өөр хувийн байгууллагуудад тэр дуусаагүй төсөл хөтөлбөрүүдээ шилжүүлэх. Хуримтлагдсан өр гэж бас нэлээд их өрүүд байна. Төсөл хөтөлбөрүүдийн уялдаа холбоог хангах гэдэг зүйлүүд байна. Тэгээд бид нар сая хэд хэдэн гаднын санхүүгийн байгууллагуудтай бас уулзалтуудыг хийлээ. Би сая ирэхийнхээ өмнө ч гэсэн 2 гаднын байгууллагатай уулзалтууд хийж ирлээ. Тэгэхээр бид ингэхийн тулд эхлээд нийслэл хотын санхүүгийн төлөвлөлт дээр олон улсын санхүүгийн байгууллагуудын техникийн зөвлөгөөг авч, өгсөн зөвлөгөөний дагуу ажиллалаа гэдэг ийм чиг баримжаа барьж ажиллаж байгаа юм.

Жишээлэхэд энэ удаагийн төсвийн тодотгол бид нар хийхдээ зуу, 37 сургууль, цэцэрлэгийн дуусаагүй барилгын санхүүжилтийг бид нар энэ удаагийн төсвийн тодотголоор өгье. Ирэх жилийн бид нарын санхүүгийн төлөвлөлтийн хамгийн 1 дүгээрт энэ 37 сургууль цэцэрлэгийг 1, 2 дугаар улиралд дуусгах мөнгийг шийдэж өгье гэх жишээтэй. Тэгэхээр 1 иргэдийн хурлын Төлөөлөгч, 1 Засаг дарга гарч ирээд л шинэ төлөвлөлтүүд хийж явсан нь бид нарын алдаа байсан байна. Энэ дээрээ.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн

Лувсанцэрэнгийн Энх-Амгалан, Лхагвын Мөнхбаатар, Цэрэнпилийн Даваасүрэн нарын удирдлагаар Хөвсгөл аймгийн намын хорооны гишүүд, тэргүүлэгч, дарга нар Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүгдийн ажил амьдралд хамгийн сайн сайхан бүгдийг хүсэн ерөөе. Хөвсгөл аймгийн МАН-ын хорооны тэргүүлэгч болон хорооны дарга нар Улсын Их Хурлын үйл ажиллагаатай танилцаж байна. Тодруулж асуух юм уу? Цэрэнпунцаг гишүүн тодруулж асууя.

**Ц.Цэрэнпунцаг:** Тодруулж биш, хамгийн гол нь санал хэлчихье, 2 санал хэлчихье. Нэгд бол энэ үр ашиг, үр нөлөө, зардлын тооцоо гэдгийг бол ийм ерөнхий яах вэ ийм агуулгаар л бид нар хийгээд байгаа юм. Энийг нарийсгаж хийж ажиллая. Та бол бас нэг жоохон зардал чирэгдэл гаргаад ийм манай сайн боловсон хүчнүүд байгаа байх гэж санаж байна. Энэ зардал, үр ашгийн тооцоо боддог. Энэ аргачлалаар нь тооцооллыг нь гаргаж, бүүр яг бүлгүүд болгон дээр тэр гарах ач ноогдох ирэх ачаалал, үр ашгийг нь бол тооцсон энэ тооцооллыг сайн хийгээрэй. Энэ ипотекийн зээлийг бол бид нар анхнаасаа буруу бодлоготой явсны л үр дагаврыг бид нар өнөөдөр энд хүртэж байгаа юм. Тийм учраас ипотекийн бодлогыг энэ цаашидынхаа хотынхоо төлөвлөлт, энэ түгжрээг бууруулахтай бас холбож та бүхэн бас энэ бодлогодоо тусгаж яваарай л гэж л санал хэлье дээ.

**Л.Мөнхбаатар:** Цэрэнпунцаг гишүүн хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан санал хэллээ. Сайнхүүгийн Ганбаатар гишүүн асуултаа асууя.

**С.Ганбаатар:** Хотын дарга Нямбаатараа би үхэхээр чи үх гэж оруулж ирж байгаа юм биш үү энэ чинь. Улаанбаатар хот төлбөр зогсоол энийгээ шийдэхгүй хэмжээндээ хүртлээ ядарсан байна шүү дээ. Энэ чинь Улсын Их Хурал өнөөдөр аймаг болгоны зогсоол төлбөр, замын зогсоолуудыг шийднэ гэвэл энэ баларлаа шүү дээ, энэ чинь Улсын Их

Хурал шүү дээ энэ чинь. Үе үеийн дүүргийн Нийслэлийн иргэдийн хурлын Төлөөлөгч нарын, улс төрчдийн шунал, өөдгүй авлигаас болж Улаанбаатарчууд өнөөдөр төлбөрийг нь төлж байгаа. Олон улсын тэр судалгаагаар гарсан байна лээ. Алдагдсан боломж энэ түгжрэлд бид алдаж байгаа боломж бол 1 тэрбум 245 сая доллар. Нөгөө гайхуулаад байгаа уран, газар эзэжийнхээ хэвлий рүү хор шахаж байгаад авах гээд байгаа нөгөө Ардын намынхан та нарын уранаар олох гэж байгаа мөнгөний чинь тал нь шүү дээ энэ чинь. 3 их наяд 880 тэрбум төгрөгийн алдагдал Монголын энэ Улаанбаатарчууд улс төрчдийн идэж ууж байгаа энэ юмыг нөхөж төлж байгаа.

Өнөөдөр судалгаагаар Жайкагийн судалгаагаар 25 онд Улаанбаатарын хөдөлгөөн 8км цаг болно, 30 онд 5км цаг, 40 онд 0 зогсолт, түргэний тэрэг ч явахаа болино, галын машин ч явахаа болино. Энэ яагаад ингэж байгаа вэ гэвэл үе үеийн Улаанбаатар хотын улс төрчид, төлөөлөгчид, дарга нар идэж ууж, найрлаж, архидсаны шарталтыг өнөөдөр Улсын Их Хурал тайлна гэсэн үг байхгүй юу. Улсын Их Хурлаар яагаад энэ орж ирж байгаа юм бэ? Миний 1 дүгээр асуулт. Нямбаатар өнөөдөр Нийслэлийн Иргэдийн Хурал гэж булиа том байгууллага байгаа. Улаанбаатар хотын тэр зам тээврийн маш олон байгууллагууд байгаа. Эд нарын эрх зүйн орчинд энийг шийдэх ямар ч боломжгүй юу? Заавал хууль батлах ёстой юу? Тэр чинь төлбөр тооцоо янз бүрийн тэр тарифуудыг бол тэдэн дотроо ярьчих боломжтой гэж би ойлгож байна. Нөгөөдүүлтэй ярих гэхээр өөдөөс чинь идэж уучих гээд байгаа юм уу? 1 дүгээр асуулт.

2 дугаарт энэ бидэнтэй жоохон холбоотой байж магадгүй юм шиг асуултыг гүжирдээд л асууя даа. Цахилгааны хэмнэлттэй автомашиныг 2100м<sup>3</sup>-ийн ийм мотор янз бүрийн багтаамжтай машины татварыг нэмнэ, 28 мянгыг 84 мянган төгрөг болгоно. Улаанбаатар хотод бүртгэлтэй суудлын

автомашинны татварыг 2 дахин нэмнэ 2 дугаар асуулт.

3 дугаар асуулт автомашин агаарын бохирдлын төлбөрийг 2 дахин нэмнэ. МАН-ын мөрийн хөтөлбөрт татвар огт нэмэхгүй гэж заасан. Энэнээсээ буцаж байгаа юм уу эсвэл хүмүүсийг зүгээр хуурсан юм уу эсвэл зүгээр уучлалт гуйх гэж байгаа юм уу? Татвар дээрх 2 хуулиар 3 татвар нэмэгдэж орж ирж байна гэж би ойлгож байна. Энийг бол Их Хурал дээр ярьж болно.

Тэгэхээр хотын эрх зүйн орчин зүгээр л идэж уудаг, тэрнийх нь тэр баасыг нь бид цэвэрлэдэг болж байгаа юм уу гэсэн ийм байр суурьтай байна. Тэгээд одоо удахгүй аймаг бусад хотууд бас ингэж орж ирэх юм байна л даа. Миний 2 асуултад хариулт өгнө үү.

**Л.Мөнхбаатар:** Нямбаатар дарга хариулах уу? Нямбаатар дарга хариулъя. Ажлын хэсэг нэмж болно.

**Х.Нямбаатар:** Яах вэ би нөгөө Ганбаатар гишүүнийг сонгууль дөхөж байгаа бас нэг энэ зэргийн юм ярих ёстой гэдэг дээр ойлгож байна. Бид нар Захиргааны ерөнхий хуулиар НИТХ ямар хэмжээнд журам гаргах ёстой вэ гэдгийг тухайн салбарын хуулиар заавал зохицуулалт хийж өгөх ёстой. Өөрөөр хэлбэл бүсчилж тогтоох журам гаргах эрхтэй гэж хуульд заасан тохиолдолд л НИТХ журам гаргана. Тэрнээс биш НИТХ тухайн нутаг дэвсгэрийнхээ бүхий л асуудлаар журам гаргах хууль давсан ийм хэм хэмжээ тогтоох эрхгүй Ганбаатар гишүүнээ. Тийм учраас НИТХ авто замын түгжрэлийг бууруулах чиглэлээр ямар төрлийн хязгаарлалт тогтоох журмууд гаргах вэ гэдгээ энэ эрхээ энэ хуулиар авах гэж байгаа юм.

Таны саяын таны хэлсэн тэр алдагдлууд энд байна. Өөрөөр хэлбэл бид нар өнөөдөр дэлгэц дээр гарч байгаа 3,8 их наяд төгрөгийн ийм алдагдсан боломжийг бид нар түгжрэлд зарцуулж

байгаа. Харин таны тэр сүүлд авсан статистик мэдээлэл хоцорсон байна. Бид нар энэ 25 он гэхэд 3,2км цаг буюу таг түгжрэл рүүгээ жил гарны дараа орохоор ийм судалгааг ММСГ судалгааны байгууллага хийсэн. Жилд дунджаар 50 гаруй мянган автомашин орж ирж байгаа. Тийм учраас цаг алдалгүй бид нар арга хэмжээ авах уу яах вэ гэдгээ л шийдье гэж байгаа юм. Жайка ОУБ-ын 2007 онд хийсэн судалгаагаар нийслэл Улаанбаатар хотын иргэдийн 60 хувь нь нийтийн тээврээр зорчдог байсан бол одоо дөнгөж 24 хувь нь зорчдог болсон.

2 дугаарт цахилгаан машинаас татвар авах гэж байна. Ардын намынхан татвараар шулах гэж байна гээд та бас сая ярьж байх шиг байна. Тэгэхээр бид нар ерөөсөө онцгой албан татвар дээр нэг ч татварын нэмэгдэл тооцоогүй. 2022 онд таны бас батлалцсан хууль дээр энэ тээврийн хэрэгсэл өөрөө явагч хэрэгслийн татварын дээд хязгаарыг тогтоосон байгаа. Бид тэгвэл энэ хуулиар тодотгож дээд, доод хязгаарыг нь тодотгож тогтоолгохоор л оруулж ирж байгаа юм. Тэгэхээр цахилгаан машин бол хэдийгээр байгаль орчинд хөнөөл учруулдаггүй ч гэлээ гэсэн нисэхгүй учраас заавал газраар явж түгжрэл үүсгэнэ. Тийм учраас энэ дээр бид нар бас тодорхой зохицуулалтууд хийж өгөхгүй бол болохгүй байгаа гэдгийг хэлье. Тэгээд сонгууль дөхөхөөр бүх л хүн сонгогчдодоо, ард түмэндээ хайртай болж ярина. Бид нар жил гарны дараа таг зогсох уу, өмнө нь байгаа түвшиндээ асуудлаа автомашиныхаа тоог хязгаарлаж, авто замынхаа сүлжээг өргөтгөж, нийтийн тээврийнхээ хүртээмжийг нэмэгдүүлж дараа дараагийн захиргааны үе шаттай арга хэмжээнүүдийг авч, дунд хугацаандаа хэрэгжих арга хэмжээнүүдийг авъя л гэж байгаа юм. Дэлгэц дээр та анхаарлаа хандуулбал тэр шар болон улаанаар тэмдэглэсэн бол бид нарын.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Хариулт хангалттай юу, тодруулах уу?

Сайнхүүгийн Ганбаатар гишүүн тодруулж асууя.

**С.Ганбаатар:** Тэр сонгууль тийм балай юм ярихаа болиоч. Бид би харин ч гэж энэ өнгөрсөн 3 жил идэвхтэй ярьж байгаад, одоо сонгууль дөхөж байгаа нэг жаал дуугүй жоохон амаръя гэж бодсон юм. Би ажил хэргийн юм яриад байгаа шүү дээ. Нөгөө гахай хариулсан хүн гахайны тухай л ганцхан боддог гэдэг шиг юун сонгууль яриад явчхав. Миний асуулт бол нийслэлийн эрх зүйн орчин дотроо энийгээ ярих, энэ төлбөр нэг энэ ард иргэдийг боомилох энэ дандаа нэг ийм төлбөр нэмэх, зогсоол юмнуудаа ярих боломж байна уу гэж асуусан. Татвар 3 нэмэх заалт орж ирлээ. Энийгээ нэг намын сонгуультай чинь болж байна уу гэж асуусан. Би ажил хэргийн юм ярьж байгаа. Тэгээд би энийг одоо дахиад тодруулж асуух юм гэвэл энэ Антони Дэвисийн онол гээд нэг юм яриад явчихлаа. Ер нь тэр тойруу зам, метро гэдэг юмыг бол би их дэмжээд байгаа. Энэ төсөвт орсон уу? Энэ бол манай Улаанбаатарын энэ to reak-г нэг гаргах гаргалгаа гэж бодож байгаа. Энэ ямар шатдаа явж байгаа вэ?

**Л.Мөнхбаатар:** Тодруулгад хариулъя. Хэн хариулах вэ? Нямбаатар дарга хариулъя.

**Х.Нямбаатар:** Ганбаатар гишүүний асуултад би дахиад хариулъя. НИТХ тодорхой харилцааг зохицуулсан журам гаргахын тулд заавал салбарын хуулиудаар энэ төрлийн харилцааг зохицуулсан журмыг аймаг НИТХ гаргаж болно гэдэг эрх хэмжээгээ хуулиар авдаг. Үгүй ингээгүй тохиолдолд захиргааны хэм хэмжээг нийтээр дагаж мөрдөх журмыг ХЗДХЯ-ны бүртгэлийн нэгдсэн санд бүртгэж авдаггүй хуультай. Тийм учраас хөдөлгөөн зохицуулалттай холбоотой тодорхой журам гаргах эрхээ хуулиар авъя гэж байгаа юм.

Би таныг тэр нөгөө нэг метро, тойрог замын асуудал ярьсанд их

баярлаж байна. Яг өнөөдөр нийслэлийн төсөв дээр ийм том хэмжээний төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх эдийн засгийн боломж байхгүй. Харин бид нар муу нуухаар сайн илчил гэдэгчлэн нийслэл Улаанбаатар хотын эзэмшиж байгаа нүүрсний төслөөр санхүүжилт босгож, 2024 оны ондоо багтаж бид нар метро болон тойрог хурдны замын төсөл хөтөлбөрүүдийг эхлүүлэх асуудлыг хэлэлцээр энэ 11 дүгээр сарын дундуур хийгдэнэ. Дэлгэц дээр харуулж байгаа тэр эхний бид нарын концепц дизайн буюу тэр доороосоо голд нь байгаа тэр 3 өнгөөр тэмдэглэгдсэн юу бол бид нарын эхний нөгөө хэлэлцээрийн явцад нөгөө хамтрах ААН байгууллагуудаа санал болгож байгаа 3 метроны шугам байгаа. Улаан, ногоон, саарал харагдаж байна уу тийм ээ? Тийм энэ дээр бид нар энэ 11 сарын дундаас эхлээд хэлэлцээр хийж эхэлнэ. Хэлэлцээр амжилттай, үр дүнтэй болсон тохиолдолд Улсын Их Хуралд оруулж ирж, нийслэлийн тэр өмчлөлд бүртгэлтэй байгаа нүүрсний төслийг эдийн засгийн эргэлтэд оруулах эсэх зөвшөөрлөө Их Хурлаар шийдүүлнэ гэдгээ би та бүхэнд шулуухан хэлье. Бидний одоогийн баримталж байгаа бодлого бол тойрог хурдны зам, метроны төсөл хоёрыг хамтад нь хэрэгжүүлж байж Хөх хотын тэр түгжэрэл шууд 80.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Цэрэнпилийн Даваасүрэн сайд нэмж хариулъя.

**Ц.Даваасүрэн:** Тийм нийслэл дээр тулгараад байгаа асуудал болбол нэг том асуудал бол утаанаас гадна түгжэрэлийн асуудал байгаа. Түгжэрэлийн асуудал дээр бид нар хэд хэдэн шийдэл гаргах гэж нийслэлтэйгээ бол ярилцаж байгаа. Энэ хүрээнд болбол бид нар Сэлбэ сэргэлт гээд бас замын зургийг нь хийчихсэн байгаа тийм ээ. Тийм 97, 8 хувьтай байгаа. Тэгэхээр энэ зураг ашиглалтад орохоор босоо тэнхлэгийн зам, тэгээд мөн Бямбацогт сайд дээр болбол том тойрог зам байгаа. Ингээд тойрог замуудаа, хөндлөн замуудаа шийдсэний

дараа бол авто замын хувьд болбол нэлээн ахиц дэвшилүүд гарна.

Одоогийн Нямбаатар сайдын яриад байгаа метро дээр бол бид нар бас дэмжиж байгаа юм. Тэгэхдээ метрог ярихад бас бид нар тэр light rail гээд байгаа трамвай ч гэх тийм юмнууд, газрын метрог бол эхэлж шийддэг юм байна бусад улс орнууд. Тэгээд энэ чиглэл дээр бас бид нар ярилцъя гэж ингэж бодож байгаа. Бид 2 хараахан уулзаж амжаагүй байна. Ер нь түгжрэлийн чиглэл дээр болбол бид нар боловсон хүчин бэлэн байгаа юм байна лээ. Австралид бол манай залуучууд метро барьж байна шүү дээ. Тэр метроны туннел тэр metro station болбол манай залуучууд барьж байна. Тэр LRT-н чинь замыг манай залуучууд барьж байна. Тийм учраас болбол боловсон хүчин бол Монголд байгаа гэдгийг бол бид нар бас анхаарах цаг болчихсон юм байна лээ. Мэргэжлийн боловсон хүчнүүд Австралид бий болчихжээ гэж. Тэр метроны туннелийн хяналтын инженер нь хүртэл Монгол хүн байж байна шүү дээ. Тэгэхээр тэнд бүхэл бүтэн баг бэлэн болчихсон байгаа юм байна лээ. Тэгээд метрог хямдханаар барих, LRT хямдханаар барих боломж үндэсний мэргэжилтнүүд бол манайд байгаа гэдгийг би бас хэлэхийг хүсэж байна.

Тэгээд ер нь болбол Нямбаатар сайдын энэ хэлээд байгааг бас сошиалаар гуйвуулаад байх шиг байгаа юм. Би одоо тэдэнд хандаж хэлэхэд энэ бол үлгэр биш. Мянганы замыг ярьж байхад чинь үлгэр л гэж байсан юм. Метро барих боловсон хүчин манайд бэлэн болчихсон. Та бүхэн жишээлбэл яах вэ технологи нь арай өөр. Гэхдээ л метро шиг туннел хийж байгаа газар бол Оюу толгой тийм үү? 200 метрийн гүнд 200км-ийг бид нар мянган метрийн гүнд хийж чадаж байна шүү дээ. Тэгэхэд энэ бол.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Нэмж өгнө. Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Лувсанцэрэнгийн Энх-Амгалан, Лхагвын

Мөнхбаатар, Цэрэнпилийн Даваасүрэн нарын урилгаар Хөвсгөл аймгийн МАН-ын аймаг, сумдын хорооны дарга, тэргүүлэгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүгдийнхээ ажил амьдралд хамгийн сайн сайхан бүгдийг хүсэн ерөөе. Сандагийн Бямбацогт гишүүн асуултаа асууя.

**С.Бямбацогт:** Орж ирж байгаа хуулийн төслийг дэмжиж байгаа. Бас ажил хийх гээд хурдтай, бас зоригтой зүтгэж байгаа энэ хүмүүсийг шүүмжлэхгүй. Аль болох бололцоо боломжоороо дэмжинэ. Гэр хорооллыг орон сууцжуулах гарцаа байхгүй хийх ёстой асуудал. Бид нар утааг шийдэх гэж утаагүй зуух, шахмал түлш, утаагүй түлш гээд 20 жил ноцолдсон. Ерөөсөө л орон сууцжуулж, орон сууцжуулж байж гэр хорооллыг агаарын бохирдол, утаанаас салгана. Орон сууцжуулж байж тэр хөрсний бохирдол, жорлонгоос салгана. Энэ орон сууц нь харин нийтийн байх уу, амины байх уу гэдгийг бас нэлээн сайн бодох ёстой байх. Энийг бас хуулийн төслийг хэлэлцэх үед бас нэлээн саналаа хэлнэ.

Улаанбаатар хотын түгжрэлийг бууруулах, сая одоо бас ярьж байгаа. Ховдоос Улаанбаатар луу 1 цаг 40 минут нисэж ирдэг, Чингис хаан нисэх буудлаас Улаанбаатар хотын төв ортол гэртээ иртэл 2 цаг гаруй явдаг, заримдаа 4 цаг явдаг ийм болчихоод байгаа шүү дээ. Үүнд бас манай зам тээврийн салбарынхан бас тодорхой хувь нэмэр оруулж байгаа бас түгжрэлд. ИНЕГ, МИАТ, Буянт-Ухаа нисэх буудал, Чингис хаан нисэх буудал гээд 2 мянга орчим хүн өглөө болгон өдөр ажилдаа Улаанбаатар хотын төвөөс явдаг, орой болгон ажил тараад гэр лүүгээ ирдэг, бас л замын түгжрэлд хувь нэмэр оруулдаг, өөрсдөө бас ажил амьдралынхаа тодорхой цагийг нь энд зарцуулдаг. Уул нь үүнийг шийдчихье гээд Буянт-Ухаа нисэх буудал орчимд тийм ээ Буянт-Ухаа дүүрэг гэж ярих уу, тэнд 6 га газар дээр МИАТ-ийн эзэнгүй болчихсон,

балгас болоод нурчихсан, актлагдсан агуулах дээр Тээвэрчин хотхон барья. Тэнд 1500 орчим айлын орон сууц барья, тэр айлд амьдарч байгаа иргэдийнхээ хүүхдийг сурах сургуулийг нь барья, цэцэрлэгийг нь барья, эмнэлгийг нь барья.

Мөн үүнийг дагаад Улаанбаатар хотод бас төвлөрлийг бууруулах хүрээнд манай зам тээврийн салбарын ААН байгууллагууд байж байгаа. Монголын төмөр зам, Тавантолгой төмөр зам, Авто тээврийн үндэсний төв, Зам, тээврийн хөгжлийн төв, Галт тэрэгний хөдөлгөөний зохицуулалтын нэгдсэн төв гээд энэ олон байгууллага оффисгүй. Дандаа түрээсийн байранд байдаг. Эдгээр оффисыг тэнд нь барьчихъя. Тэгээд тэндээ үндсэндээ хүүхдүүд нь сургуульдаа явчихдаг, цэцэрлэгтээ явчихдаг, аав ээж нар нь ажилдаа гэрээсээ гараад ажилдаа явчихдаг. Өөрөөр хэлэх юм болбол тийм тэндээ амьдарчихдаг ерөөсөө хотхон. Ажиллах, амьдрах, амрах тийм үү, амрах гэх юм бол нөгөө спорт цогцолбор, эрүүл мэндийн төв, худалдаа үйлчилгээ, гуанз, ресторан, дэлгүүр бүгдийг нь нэг дор нь хийгээд өгчихье. Ерөөсөө тэр хотхоноосоо гарахгүйгээр тэндээ ажиллаад, амьдраад амраад байх ийм орчин нөхцөлийг бүрдүүлэх гээд зүтгээд байгаа юм л даа.

Харамсалтай нь бас зарим нэг хүмүүс, зарим нэг байгууллага гацаагаад бас зөвшөөрөл өгөхгүй удаж байгаа. Энэ бодлого маань яагаад удаад байгаа юм бол, энийг та дэмжих үү? Энэ зөв үү, буруу юу? Ингэчих юм бол үндсэндээ 2 мянга орчим тийм үү машин өдөр болгон нааш цааш явахаа болих нь. Улаанбаатар хотын төвд түгжирч байгаа энэ олон байгууллагуудаас Улаанбаатар хотын зах руу гарах нь. Тэгэхдээ тэндээ тийм үү ажиллах, амьдрах, амрах, сурах бүх орчныг нэг дор хийчихье. Түрүүн хэллээ шүү дээ худалдаа үйлчилгээ тийм үү, худалдаа үйлчилгээ нь хамтдаа байна, спорт цогцолбор нь хамтдаа байя? хоол нь хамтдаа байя, сургууль цэцэрлэг нь хамтдаа байя, оффист нь хажууд нь

байж байг, гэр нь хамтдаа байж байг, сургууль цэцэрлэг нь байж байг нэг ийм л юм дэвшүүлээд байгаа юм цогцоор нь бүх юмыг. Тэгээд энийг та дэмжих үү? Энийг ийм бодлого явуулах гээд бид нар бас оролдоод ингээд тодорхой бас манай ЗТЯ-ныхан бас ажиллаад байгаа. Энэ буруу юу зөв үү бас? Зөв бол бид нар жоохон зоригтой, хурдтай явмаар байна, буруу гэж бодож байгаа болбол тийм үү яамаар байгаа юм бэ? Буянт-Ухаад шүү дээ одоо тэр, бүүр тэр хаана байсан Буянт-Ухаа дэнжийн цаад талд. Энийг та нар хариулж өгөөч.

**Л.Мөнхбаатар:** Бямбацогт гишүүний асуултад Нямбаатар дарга хариулъя. Ажлын хэсгийн 85 дугаар микрофон.

**Х.Нямбаатар:** Баярлалаа. Би бас та бүхнийг нэг дэлгэцэд анхаарлаа хандуулахыг хүсэж байгаа юм. Энэ хуулийн маань хамгийн том концепт бол утааг хэрхэн яаж бид нар бууруулах вэ гээд. Энэ дэлгэц дээр та бүхний харж байгаагаар бол яг нүүрсхүчлийн хий хамгийн их бусад агаарын бохирдлыг үүсгэж байгаа 2 том голомт бол Баянхошуу, Толгойт орчим, нөгөөх нь 7 буудлаас урагшаа Хайлааст, Чингэлтэй, энэ Дэнжийн мянга орчим гэсэн ийм 2 том голомт байгаа. Тэрний доод талд энэ улаан тойргоор дугуйлчихсан нь юу байгаа. Одоо энэ нөгөө Их тойруу доторх автомашины түгжрэлтэй хэсэгт хамгийн хүнд хортой элемент буюу азотын давхар исэл гэдэг ийм химийн хортой бодис ялгардаг ийм байгаа юм.

Тэгэхээр бид нар энэ гэр хорооллыг орон сууцжуулах төлөвлөгөө энэ хуулиудаар ямар эрхийг авах гэж байна гэхээр дараагийн слайдууд дээр би та бүхэнд харуулъя. Энэ слайд. Энэ эхний тэр зурагт үзүүлж байгаа 158 га дээр одоогийн байдлаар 2 мянган айл өрх байгаа юм, 2 мянган хаашаа. Энэ 2 мянган хаашаатай айлуудтай бид нар энэ хууль батлагдсаны дараа хэлэлцээр хийгээд, газрыг түр чөлөөлөөд авч чадах юм бол



бид нар энэ 2 мянган айлын 158 га дээр 12 мянган айлын орон сууц нам ихэвчлэн давхрын орон сууц барих юм. Энэнийхээ дараа тэр зурагт өгүүлж байгаа 2 дахиар нь энэ нийт 12 мянган айлын орон сууц баригдвал энэ Дэнжийн мянга, Хайлааст, 5 буудал орчмын нийт 10 мянган айл, өмнөх 2 мянган айлтайгаа нийтэд нь ингээд 12 мянган айл, замын голын зүүн талын Дарь-Эхийн замын баруун талын хэсэг айлуудыг ингээд бүхэлд нь нүүлгэн шилжүүлж оруулснаар бид нар 700 га газрыг дахиж орон сууцжуулах ийм төлөвлөлттэйгөөр хөгжүүлэх ийм эрх зүйн орчин бүрдэх гээд байгаа юм.

Хамтад нь бид нар сая Даваасүрэн сайдын ярьж байгаа нөгөө Сэлбэ сэргэлт хурдны зам түүний бас нэг салшгүй нэг хэсэг болсон Сэлбийн усны тохируулга бүхий ийм усан сан хуримтлуурыг үүсгэж, үерийн усыг зайлуулах ийм боломжууд бас давхар бүрдэх энэ төслийг бид нар энэ хууль батлагдаад хэрэгжиж эхэлсний маргаашаас бид нар нийслэл хот энэ төслөө өөрөө хэрэгжүүлэх ийм эрх зүйн орчин бүрдэх гээд байгаа гэдгийг та бүхэнд хэлье. Бид нарын орон сууцжуулах төслийн өмнөх алдааг бид нар бас энэ мэргэжлийн байгууллагууд гаргаж ирсэн. Цогцолбор байдлаар газрыг нь чөлөөлөөд, цогцолбор байдлаар хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу орон сууцжуулах ажил хийлгүй, 3 айлын хашаа чөлөөлөөд 2 өндөр байшин барих замаар энэ Натур, Дэнжийн мянга орчмын асуудлууд бол ингээд шийдэгдээд алдаа гарчхаад байгаа юм. Энийг л энэ хууль, эрх зүйн орчныг энэ хуулиар авах гэж энэ хуулийн төслийг боловсруулж оруулж ирсэн гэдгээ товчхон хэлье.

Би Бямбацогт сайдын тэр юуг 2 гараа өргөөд дэмжиж байна. Таны оруулж ирж байгаа тэр танай салбарын алба хаагчдын орон сууцын, оффисын барилгуудыг төвлөрүүлэх, орчинд нь орон сууцын хорооллыг барих, сургууль цэцэрлэг, дэд бүтцийг шийдэх дээр. Энэ дээр ерөөсөө би бол миний ойлгосноор Төрийн өмчийн хороо.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Улсын Их Хурлын гишүүн Ням-Осорын Учрал асуултаа асууя.

**Н.Учрал:** Энэ сонгуулиас сонгуулийн хооронд энэ нэг 4 жилийн цикл дээр бодлого боловсруулдаг энэ замбараагүй төлөвлөлт бодлогын алдаанууд өнөөдрийн байдалд хүргэлээ. Тэгэхээр Нямбаатар даргын хувьд бол зөвхөн дараагийн сонгуульд зориулж биш, урт удаан хугацааны Улаанбаатар хотынхоо хөгжлийг бас өргөн агуулгаар нь хараад, энэ иргэдийн төлөө гэсэн энэ орон сууцжуулах бодлогыг бас ингээд зоригтой шийдье гэж авч орж ирж байгаад би бол талархалтай байгаа. Энэ бол тийм агаарын сэдэв бол биш. 16 оноос хойш Нямбаатар сайд бид бол СХД дээр ажилласан. Тэгэхээр Баянхошууны дэд төв болбол бүрэн дэд бүтэц нь шийдэгдсэн газар. Энэ АХБ-ны төслөөр. Тэгээд яг энэ дэд төвөө түшиглээд өнөөдөр бол бараг 5,6 га чөлөөлөгдөж бараг 100 орчим айл энэ Буянт-Ухаа руу нүүж очоод ингээд суурьшиж байна шүү дээ. Тэгэхээр газар чөлөөлөөд болж байна, тэнд дэд бүтэц нь байгаа газар боломж байна гэж.

Тэгэхээр би Сэлбэ дэд төв дээр ч гэсэн очиж танилцсан. Сэлбэ дэд төвийг дагуулаад ч гэсэн нэгэнт дэд бүтэц нь бүрэн шийдэгдсэн байгаа газар орон сууцжуулахад болохгүй зүйл байхгүй шүү дээ. Тэгээд өнөөдөр орон сууцнаас өөр ямар нэгэн тийм том шийдэл байхгүй. Энэ Улаанбаатар хотын иргэдийг сайн сайхан амьдруулахад орон сууцнаас өөр ямар ч том шинжлэх ухааны нээлт байхгүй. Тийм учраас энэ гэр хороололд байгаа иргэдийгээ бодохгүй болбол энэ шууд бус утгаараа энэ иргэд чинь энэ эрүүл мэндээрээ, энэ боловсролын салбарын хүртээмж, энэ эрүүл мэндийн салбарын тэгш боломж бүгдээрээ ингээд дутагддаг. Тийм учраас бид нар энэ гэр хороололд байгаа иргэдийгээ орон сууцжуулах асуудал руу ханиуу шамлаад орох ёстой.

Тэгээд мэдээж нэг асуудал үүсдэг. Өнгөрсөн хугацаанд бол жил бүрийн төсөв дээр л газар чөлөөлөх зардлыг суулгаад явдаг. Тэгээд газар чөлөөлөх гээд ирэхээр мэдээж энэ шийдвэрүүд нь иргэдэд төдийлөн бас зарим нь таалагддаггүй, ойлголцдоггүй байсан. Тэгэхээр энэ Баянхошууны дэд төв дээр энэ олон айлыг Буянт-Ухаа руу нүүлгээд болоод энэ иргэд маань сэтгэл хангалуун тэндээ амьдарч байна. Тэгвэл ер нь газар чөлөөлөхөд хэрхэн тэр энэ ажлыг өнгөрсөн хугацаанд тэр Баянхошууны дэд төв дээр зохион байгуулж байсан юм бэ? Цаашидаа энэ хуулиа баталсны дараа бид нар энэ Сэлбийг дагасан, Баянхошууг дагасан энэ айлууд дээр газар чөлөөлөх дээр яг ямар бодлого барьж ажиллаж иргэддээ хохиролгүйгээр энэ асуудлыг шийдэх юм бэ? Иргэд маань хэрхэн сэтгэл ханамжтайгаар ойлголцож, энэ орон сууцанд орох асуудлыг дэмжих вэ гэдэг дээр бас ямар шийдэл байгаа вэ гэдгээ их тодорхой хэлбэл зүгээр байна.

Тэгээд мэдээж Нямбаатар дарга, түүний баг 12 мянган айлыг орон сууцжуулна гэж байгаа юм байна. Энэ бол том зоригтой шийдвэр. 12 мянган айлын орон сууцжуулчихвал, орон сууцжуулж чадах юм болбол ер нь Нямбаатар даргынхаа хөшөөг бараг Улаанбаатар хотод барьчихсан ч багадааар л ийм л том асуудал юм л даа. Тэгээд энийг бол бид дэмжихээс өөр гарц байхгүй. Улаанбаатар хотын иргэд гэр хороололд байгаа иргэдийгээ бүгдээрээ л орон сууцтай л больё гэж байна шүү дээ. Тэгэхээр бүгдээрээ энэний төлөө явах ёстой.

Хоёрт бол, 2-т болбол энэ өнгөрсөн оны төсөв дээр таныг бас Хууль зүйн сайд байхад бид энэ нэг цэгийн үйлчилгээг иргэдэд ойртуулах гэж хичээсэн, хурдан цэг байгуулагдсан. Энэ болбол түгжрэлийг шийдэхэд болбол зөвхөн нэг хотын дарга зүтгээд байх биш, салбар болгон оролцоотой байх ёстой. Сая Бямбацогт сайдын хэлдгээр. Тэгэхээр

манай технологийн салбар ч гэсэн үйлчилгээг цахимжуулаад л, өнөөдөр мянган үйлчилгээг онлайнаар авдаг болгоод л бас дэвшил харуулж байгаа юм. Энэ хурдан цэг дээр гэхэд л нийслэлд өнгөрсөн хугацаанд 3 сарын 18-наас хойш 75 мянган үйлчилгээ авсан байна лээ. Улаанбаатар их дэлгүүр дээр байгаа хурдан цэг дээр сууж байгаа нэг ширээнээс 4 мянган үйлчилгээ авсан байгаа. Тэгэхээр ер нь хорооныхоо энэ үйлчилгээг иргэдэд нь ойртуулах, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн том зохион байгуулалтын өөрчлөлтийг хийж энэ хурдан цэгийг иргэдэд ойртуулах ажилд хамтарч ажиллахыг хүсье.

**Л.Мөнхбаатар:** Санал уу, асуултад хариулъя. НЗД Нямбаатар хариулъя.

**Х.Нямбаатар:** Тийм. Бид нар ерөөсөө газар чөлөөлөлтөө л хийх л хамгийн чухал байгаа. Тэгээд бид нарын энэ нөгөө нэг санхүүгийн схемд бас нөгөө green бонд буюу ногоон бондын харилцаа орж ирж байгаа учраас газрыг албадан чөлөөлөх гэхээсээ илүүтэй тухайн иргэдтэй хамгийн сайн ойлголцож, бүх боломжит хувилбаруудаар газрыг иж бүрнээр нь чөлөөлөх харилцааг энэ хуулийн төсөлд тусгаж байгаа юм. Тэгэхээр бид нар 1 дүгээрт энэ нөлөөлд өртсөн айлуудтай шууд газрыг нь бэлэн мөнгөөр авъя гэдэг ийм саналыг тавьж болно, тавих гэж байгаа энэ хуулиар. 2 дугаарт бэлэн байгаа НОСК-ын Нийслэлийн орон сууцны корпорацын өмчлөлд байгаа байраар шууд бэлнээр газрыг чинь шууд байраа сольё гэдэг нэг ийм боломж байгаа. 3 дугаарт та энэ өөрийнхөө өсөж төрсөн энэ суурин дээр чинь босох энэ орон сууцны иж бүрэн цогцолбор хороололд та амьдрахыг хүсэж байгаа бол энэ төсөл 12-оос 24 сарын хугацаанд хэрэгжинэ. Энэ хугацаанд танд Улаанбаатар хотын нөгөө байрны түрээсийн жишигээр танд бэлэн мөнгийг өгье гэдэг нэг ийм хувилбар байгаа.

Дээр нь БХБЯ-наас хэрэгжүүлж байгаа 1008 айлын орон сууцын төсөл ирэх онд ашиглалтад орно. Энэ төсөл рүү шилжиж орох ийм олон хувилбаруудыг дэвшүүлж байгаа юм. Тэгээд бид нар энэ дэлгэц дээр үзүүлж байгаа ирэх жил эхлүүлэх гэж байгаа төслийн маань гол үндсэн концепц бол бид нар энэ байршил дээр орон сууцад шилжиж амьдрах иргэд заавал хотын төв рүү орох шаардлагагүй. Дээр нь ажлын байр энд нэмэгдэнэ, эдийн засгийн нөлөөллүүд байна. Та хааш хаашаага 15 минут яваад авъя гэсэн бүх үйлчилгээнүүдээ авна гэдэг нэг ийм концепцтойгоор энэ зураг, төсөв хийгдэх юм, хийгдээд эхэлчихсэн юм.

2 дахь зүйл нь таны ярьж байгаа танай салбарын асуудал болох хурдан тэр цэг киоскуудыг бид нар хамгийн боломжит байршил дээр байршуулах замаар төрийн үйлчилгээг авъя гэдэг ийм боломжууд бүрдүүлж байгаа юм. Сүүлд нэг ийм бас нэг эерэг ийм дүн мэдээнүүд гарч ирж байгаа юм. Энэ юу вэ гэвэл хороогоор биеэр очиж үйлчлүүлдэг иргэдийн тоо энэ төрийн үйлчилгээний цахим системүүд нэвтэрснээс хойш эрс багассан. Та бид хоёрын хамтарч хэрэгжүүлсэн нөгөө Бүртгэлийн ерөнхий хуулийн дагуу сүүлд нөгөө Цахим багц хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд хийгдсэн бас ажлуудын үр дүн гарч, одоо хороогоор үйлчлүүлдэг иргэдийн тоо өдрөөс өдөрт багасаж байгаа гэж байгаа юм. Тэгэхээр энэ шинэ төслүүд дээр энэ цогц бодлогуудыг хамтад нь хэрэгжүүлж явуулах төлөвлөгөөтэй байгаа гэдгийг хэлье.

**Л.Мөнхбаатар:** Амгалангийн Адъяасүрэн гишүүн асуултаа асууя.

**А.Адъяасүрэн:** Нэг үндсэн 2 асуудал байна. Нэн яаралтай горимоор Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн энэ хуулийн төслийг яаран боловсруулж орж ирсний хамгийн гол шалтгаан нь юундаа байгаа юм бэ? Улаанбаатар хотын замын түгжрэлийн асуудлаар яагаад Нийслэлийн Төлөөлөгчдийн хурал

хэлэлцэж шийдвэр гаргаж болохгүй байгаа юм бэ? Яагаад заавал бид нар ингээд Их Хурал дээр энэ асуудлыг хэлэлцээд байгаа юм бэ? Сүүлийн үед бас ингээд бас бодогдох боллоо. Энэ нийслэлд ИТХ гэсэн өөрөө удирдах байгууллагын хэрэг ер нь байгаа юм уу? Нийслэлийн хэмжээнд өнөө журам заавар гаргаад энэ шийдчих асуудлаа л Улсын Их Хурал ингээд цаг заваа бараад ярилцаад суумааргүй байна.

Тэр дундаа энэ ЗГ чинь түгжрэлийн асуудал эрхэлсэн сайдтай биз дээ. Сүүлийн үед энэ ЗГ-ын гишүүд дандаа л нэг энэ Улаанбаатар хотын нийслэлийн асуудлыг л яриад байх боллоо гэж би хараад байдаг. Тийм учраас энэ бид нар Улсын Их Хурлаар Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийг шинэчлэн батлаад өгсөн шүү дээ. Нийслэлд өөрийнхөө энэ хуулийнхаа хүрээнд өөрсдийнхөө ажлыг хийгээд явбал яасан юм бэ гэдэг бас санал бас байна.

Түүнээс гадна бас нэг 2 дугаарт нь энэ орон нутгаас бас нэлээд олон саналууд энийг заавал Их Хурал дээрээс асууж өгөөч гэдэг санал ирсэн. Энэ хуулийн төслийг дагалдаад өргөн барьсан Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд аймаг орон нутагт ажилладаг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зөвлөлийг Иргэдийн хурлын дарга ахалдаг байсныг Засаг дарга ахлахаар өөрчлөлт оруулсан байна. Энэ өөрчлөлт энэ Улаанбаатар хотын түгжрэлд ямар хамаарал, ямар үр нөлөөтэй учраас энэ заалтыг оруулж ирсэн юм бэ? Энэ дээр бол тодорхой тайлбар авмаар байна. Энэ өөрчлөлтийг орон нутгаас нэлээд асууж байгаа, тодруулж өгөөч гэдэг бас мөн эсрэг байр суурьтай байгаа учраас энэ асуудлыг бол асууж байна.

Ер нь тэгээд ер нь сүүлийн үед яагаад аймаг орон нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааг хязгаарлаж, нэг удирдлага руу, нэг хүний

энэ засаглал руу ингээд хазайгаад байгааг бас би бас ингээд бас жоохон ойлгохгүй л байгаа. Энэ тал дээр бас ингээд тодорхой хариултыг өгөх байх.

**Л.Мөнхбаатар:** Адъяасүрэн гишүүний асуултад эхлээд Нямбаатар дарга хариулаад, дараа нь Даваасүрэн сайд нэмж хариулъя. Ажлын хэсгийн 85 дугаар микрофоныг өгье.

**Х.Нямбаатар:** Адъяасүрэн та бид нарын цуг баталсан Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хууль дээр гэмт хэрэг зөрчилтэй тэмцэх чиг үүргийг 22 онд угаасаа бүх шатын Засаг даргад харьяалуулъя. Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар гэмт хэрэг зөрчилтэй тэмцэх чиг үүрэг нь ЗГ-ын чиг үүрэг гэж Үндсэн хуулийн суурь концепцтойгоо нийцүүлье гээд хуулиа баталчихсан юм шүү дээ. Таны ярьж байгаа юм бол энэ асуулт чинь бол нөгөө батлагдсан хуулийн юмыг асууж байна. Миний бие энэ хуулийг дагуулж орж ирэхдээ чиг үүргийн дагуу Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуулиар Засаг даргад шилжсэн чиг үүргийн тэр санг хөрөнгө мөнгийг ИТХ удирдаад зарцуулаад байна энэ хуулиа эсхүл нөгөө хуулиа засъя эсхүл энэ хуулиараа энэ хууль хоорондын зөрчлийг арилгая л гэж байгаа шүү дээ.

2 дугаарт Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль батлагдсан 22 онд. Нийслэлийн эрх зүйн байдлын хууль батлагдсанаас хойш тодорхой хэрэгжилтийн явцад дүн шинжилгээ хийсний үндсэн дээр тодорхой зүйлийг тодотгож оруулж ирж байгаа юм. Та бид нарын байнгын үйл ажиллагаатай парламент байдгийн үндсэн чиг үүрэг ерөөсөө л хууль тогтоомжийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, түүнийгээ хурдан засаж байхад л оршиж байгаа шүү дээ. Та сая хэлж байна. Сүүлийн үед ЗГ хэт Улаанбаатар луу хайртай болоод байна гээд. Үгүй ээ тэгээд Улаанбаатар хотын асуудлыг шийдэхгүйгээр улсын хөгжлийн асуудал яригдахгүй шүү дээ. Та яагаад

Улаанбаатар луу ЗГ-ын бодлого шийдвэр энэ Улаанбаатарын тулгамдсан асуудлыг шийдэхэд та яагаад бухимдаад байгааг би ерөөсөө ойлгохгүй байна.

НИТХ өөрөө хэлэлцээд яагаад энэ хуулийг бариагүй юм бэ гээд. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар ч тэр, Хууль тогтоомжийн тухай хуулиар НИТХ нийслэлтэй холбоотой хуулийг төслийг боловсруулах түүнд санал, дүгнэлт өгөх асуудал яригдаагүй. Гэхдээ бид нар энэ зөвхөн би ирээд энэ хуулийг өргөн барьж байгаа зүйл биш. Өмнө нь НИТХ нийслэлийн бүтцийн байгууллагуудтай бараг жил гаруй хэлэлцсэн асуудлууд дээр бид сүүлд нь жоохон сайжруулалт, боловсруулалт хийж энэ хуулийг оруулж ирж байгаа. Яагаад энэ хуулийг яаралтай оруулж ирж байгаа юм бэ гээд. Яагаад гэвэл гадаа хамгийн их бухимдал, хамгийн их түгжрэл, хамгийн их агаарын бохирдол байгаа энэ асуудлуудтай бид цаг алдалгүй тэмцье гэхээр таны бухимдаад байгаа би шалтгааныг ерөөсөө ойлгохгүй байна. Тэгэхээр энэ энэ түгжрэлийн асуудал, энэ агаарын бохирдлын асуудал, энэ барилгажуулах асуудал дээр хэдүүлээ улс төржмөөргүй байна. Энэ асуудал сонгуулийн мөчлөг дагаж явмааргүй байна.

Би өөрөө бас улс төрийн албан тушаал хашиж байгаа хүний хувьд намын маань бас зарим гишүүд над руу утсаар хэлж байсан. Чи яагаад энэ сонгууль дөхчихсөн үед ийм түгжрэлийг бууруулах захиргааны шинжтэй арга хэмжээнүүдийг оруулж ирж байгаа юм бэ. Намд эсрэг санал орж ирэх юм биш үү гээд. Би эсрэгээрээ бид нар энэ тулгамдаж байгаа асуудлыг углуургаар нь шийдэхийн тулд бодлогын өөрчлөлт оруулахаас өөр сонголт алга байна гэдэг хариултыг өгсөн шүү.

**Л.Мөнхбаатар:** Даваасүрэн сайд нэмж хариулъя.

**Ц.Даваасүрэн:** Адъяасүрэн гишүүний асуултад хариулъя. Адъяасүрэн гишүүнээ энэ хуулийн зохицуулалт шаардагдаад байгаа учраас нөгөө иргэдийн хурал хууль гаргадаггүй. Ялангуяа тэр нөгөө түгжрэлтэй холбогдолтой ер нь бол улс төрийн маши эрсдэлтэй шийдвэрийг Нямбаатар дарга оруулж ирээд байгаа юм л даа. Уг нь бол сонгууль дөхөж байхад ийм шийдвэр авахад бол төвөгтэй. Одоо ч гэсэн нийгмийн дунд бас шүүмж үүсчхээд байна шүү дээ. Хотын төвд ер нь аль ч нийслэлд болбол хураамж, татвараар зохицуулдаг. Тэгэхээр энэ хураамж татварын асуудлыг Их Хурал шийддэг учраас Их Хурал энийг авч хэлэлцэхээс өөр арга байхгүй.

Өөр нөгөө нэг асуудал юу үүсээд байна вэ гэвэл бас энэ газар чөлөөлөлттэй холбогдолтой асуудлууд үүсээд байгаа юм. Энэ дээр өмчийн харьцааны асуудлууд ороод ирнэ. Энэ бас хуулиар зохицуулна. Тийм учраас хуулиар зохицуулах шаардлагатай асуудлууд, хөрөнгө санхүүтэй холбогдолтой төсвийн асуудлууд Их Хурлаар шийдэгддэг учраас Их Хурал руу орж ирж шийдэгдэж байгаа гэдгийг бас танд хэлье. Ялангуяа бид нар энэ Улаанбаатарын түгжрэл, агаарын бохирдлын асуудлыг бол шийдэхээс өөр арга байхгүй. Энэ нь хүн амын аюулгүй амьдрах, тавлаг тухтай орчинд амьдрах энэ Үндсэн хуулийн нөхцөл байдал муу байгаа учраас бид нар ард иргэдийнхээ сайн сайхны төлөө зайлиггүй ийм арга хэмжээг хуулиар зохицуулж хийхээс өөр аргагүй байна. Тийм учраас иргэдийн хурал шийдвэрлэх боломжгүй асуудлуудыг хуулийн зохицуулалтуудыг оруулж ирж байгаа гэдгийг та бас ойлгоорой.

**Л.Мөнхбаатар:** Зочин танилцуулъя Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуяг, Жамбалын Ганбаатар, Салдангийн Одонтуяа нарын удирдлагаар Бэст Инглиш академийн сурагчид Төрийн ордон, Улсын Их Хурлын үйл ажиллагаатай танилцаж байна. Хүүхдүүд та бүхэнд сурлагын өндөр

амжилтыг хүсэн ерөөе. Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн асуултаа асууя.

**Ж.Бат-Эрдэнэ:** Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах гэсэн энэ хууль орж ирж байна, маши яаралтай орж ирж байгаа 1 дүгээрт. 2 дугаарт энэ сонгууль болох болохгүйгээс үл шалтгаалаад зайлиггүй орох ёстой хуулийн нэг шүү дээ. Тийм болохоор зөв хууль орж ирж байна гэж. Чухам дотор нь орсон заалтуудыг ер нь бол бас нэлээн харах шаардлагатай л байх шиг байна даа. Энэ замын хөдөлгөөний төлбөртэй бүс гэсэн асуудал нэлээн иргэдийн анхаарлыг татаад байгаа шүү дээ. Тэгэхээр замын хөдөлгөөний энэ төлбөртэй бүс байх юм уу, төлбөртэй зогсоолууд байх юм уу гэдэг дээр ер нь хийсэн судалгаа байна уу Нямбаатар сайд? Энэ уг нь болбол одоо тэр бид бол жишээ татаад л гадаад орныг л дандаа жишээ татаад явдаг. Тэр гадаад орон чинь болбол төлбөртэй зогсоолууд чинь үндсэндээ болбол илүү их үр дүнгээ өгөөд байх шиг харагдаад байгаа шүү дээ. Тэгээд төлбөртэй зогсоол байх. Хэрвээ чадвартай бололцоотой нь болбол төлбөртэй зогсоол дээрээ машинаа зогсоогоод, тэгээд ажил хөдөлмөрөө хийгээд явдаг. Хэрвээ чадвар боломж бололцоо байхгүй болбол шууд нийтийн тээвэр лүүгээ ордог ийм систем рүү л ороод байгаа шүү дээ ер нь болбол. Яах вэ тэр бүсээр нь бүсчлээд төлбөр авах эсвэл зогсоолууд нь төлбөртэй байх 2 чинь бас арай л ондоо ялгаатай байна байх ёстой юм байгаа юм. Тэгэхээр энэ дээр судалгаа нь ер нь яаж гарсан юм бэ? Бүс нь дээр гэж үзсэн юм уу та бүхэн тийм үү? Энэ дээр нэг асуудал.

2 дугаарт өнөөдөр Улаанбаатар хотын авто замын нэвтрэх чадвар гэдэг чинь хамгийн чухал байгаа шүү дээ. Авто замын нэвтрэх чадвар. Тийм болохоор ер нь авто замын нэвтрэх чадварыг дээшлүүлэхийн тулд ерөөсөө энэ уулзвар, зөрлөг, уулзваруудыг гарцуудыг 2 түвшний болгох ийм зайлиггүй шаардлага гараад байгаа юм. Бид энийгээ яриад л

байгаа мөртөөрөө ерөөсөө хийж чадахгүй л байгаад байгаа шүү дээ. Нэг талаасаа болбол социалаас айгаад байгаа, Улаанбаатар хотыг нэг л баахан гүүр гүүрэн гарцтай болгоод хаячих юм байна гэсэн байдлаас бид нар айгаад байх шиг байна. Гэтэл нөгөө талдаа болбол үнэхээр нэвтрэх чадварыг бий болгоё гэж гэж байгаа болбол энэ Баруун 4 зам, Зүүн 4 зам, Сапторогийн тойрог ч байдаг юм уу энэ их тойргуудынхаа том, том түгжрэл болоод байгаа энэ уулзваруудаа бид нар чөлөөтэй нэвтрэх ийм боломж бололцоог нээх ёстой шүү дээ. Тийм болохоор энэ дээр хэдэн уулзвар гарцуудыг тооцоолж байгаа юм бэ, тооцоон дотор чинь байна уу үгүй юу?

Дээрээс нь тэр тойрог зам нэвтрээд нэвт явж байгаа тэр 2 түвшиний, 3 түвшиний давхар замууд чинь ер нь хаагуур хаагуур төлөвлөж байгаа юм бэ? Энийгээ ер нь хэр төлөвлөж байгаа юм бэ? Энэ дээр нэг асуулт хийж юу яагаад өгөөч, хэлж өгөөч. Үнэхээр энэ хуульд чинь бас тодорхой хэмжээний зах үзүүр нь болбол суусан байж бид нар болбол энийг хийх ёстой шүү. Энийгээ дагаад мэдээж нийтийн тээврээ сайжруулах асуудал. Одоо автобусны асуудлуудыг та нэлээн хөндөөд байх шиг байна. Автобусныхаа дахиад нийлүүлэлтийг сайжруулах хэрэгтэй болж байх шиг байна. Тэгээд дараагийн асуудал болбол мэдээж метроны асуудал болбол зайлшгүй яригдаж явах ёстой.

3 дугаарт яг одоо өнөөдөр авто зам дээр чинь явж байгаа тээврийн хэрэгслүүд бид яриад л байгаа нөгөө нэг халтуур хийж байгаа хүмүүс түгжрэл үүсгээд байна л гээд байгаа шүү дээ. Хэдэн хувь нь халтуур хийж байгаа юм бэ, хэдэн хувь нь үнэхээр хүүхдээ зөөгөөд ингээд өөрсдийнхөө амьдралдаа зайлшгүй шаардлагатай энэ зорчих хөдөлгөөнөө хийгээд байгаа юм бэ?

3 дугаарт, 4 дүгээрт одоогийн байгаа нэг жоохон хэдэн зогсоолууд дээр бүтэн өдөр хүрч ирээд ингээд машинаа

хаячхаад алга болчихдог асуудлууд байж байгаа. Энэ дээр хийсэн судалгаа бас байна уу, үгүй юу? Энэ дээр ямар арга хэмжээ авах юм бэ? Тэр тусмаа том том үйлчилгээний газруудын зогсоол гэдэг болбол үйлчилгээний байгууллагынхан нь өөрсдөө тэр чигээр нь бүтэн өдрөөр нь эзэмшээд ингээд машинаа хаячхаад, түгжчихээд ингээд алга болчихдог ийм асуудлууд гараад байгаа шүү дээ. Нөгөөтээгүүр яг зам дагуу зогсож байгаа асуудал дээр ямаршуу арга хэмжээ авах юм бэ гэсэн асуудал байгаа. Тэгээд дараа нь дахиад тодруулъя.

**Л.Мөнхбаатар:** Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. НЗД Нямбаатар, дараа нь Даваасүрэн сайд нэмж хариулъя.

**Х.Нямбаатар:** Би Бат-Эрдэнэ гишүүний асуултад товчхон хариулъя. Энэ хуулийн бас нэг том дэвшилж байгаа зорилт бол ерөөсөө зогсоол ашиглалтыг сайжруулъя. Тэр хажуугийн зогсоол манайхны ярьдаг нөгөө ёндооны зогсоол гэдэг зүйлийг байхгүй болгоё. Зогсоол заавал төлбөртэй байх ёстой. Зогсоолыг өдөржин ирээд ашиглалтгүй өөр машин сэлгэлтгүй байлгаж болохгүй. Бид нар бол судалгааны байгууллагаас хийсэн судалгаагаар Улаанбаатар хотод өдөрт төлбөртэй зогсоол дээр дунджаар 86 минут нэг автомашин зогсож байна гэдэг ийм судалгаа гарсан. Судалгаагаар нэг цагийн тарифыг 1000-1500 байхад иргэд тийм дэмжих хандлагатай байна лээ. Таны хэлж байгаа нөгөө хувиараа таксины үйлчилгээ эрхэлж байгаа иргэдийн тоо урьдчилсан судалгаагаар 86 мянга орчим иргэд байгаа. Тэгэхдээ энийг яг нарийвчилж тогтооход хэцүү. Хүн өөрийнхөө өдөрт ажилдаа явах замдаа хүн гар өргөвөл аваад хүргээд өгчихдөг, буцахдаа хүргээд өгчихдөг ийм үйлчилгээ бол нийт тээврийн хэрэгслийн 1/3 нь ийм байдлаар хөдөлгөөнд оролцож байна гэдэг ийм мэдээлэл байгаа.

Мөн хөдөө орон нутгаас орж ирж таксины үйлчилгээ эрхэлж байгаа

иргэдийн тоо бас ийм судалгаанууд гараад байгаа. Яг орчин цагийн ийм таксины үйлчилгээ Улаанбаатар хотод хэдэн мянган машин өдөр тутамдаа оролцох хэрэгтэй гэвэл 5 мянга орчим машин хэрэгтэй гэсэн судалгаа гарсан байгаа.

Метроны талаар би түрүүн ярьсан. Бид нар та ч бас ажлын хэсэгт орж явсан. Хөх хотод бид нар метроны тэр бүтээн байгуулалтын ажил, тойрог хурдны замын ажлуудыг үзсэн. Энэ бүтээн байгуулалтуудыг хийсэн ААН байгууллагуудын төлөөлөл энэ 11 дүгээр сарын дундуур Улаанбаатар хотод ирж, нөгөө урьдчилсан хэлэлцээрээ эхэлье гэсэн ийм төлөвлөгөөтэй байгаа гэдгийг танд хэлье.

Нийтийн тээврийн шинэчлэлийн асуудал ярьсан. Дэлгэц дээр уг нь өгвөл бид нар нөгөө нэг нийтийн тээврийн нэг шинэчлэлийн талаар уг нь маршрутуудыг бид нар бэлдсэн байгаа. Шинэ автобуснуудыг оны өмнө эхнээсээ хүлээж авахаар ийм худалдан авах ажиллагаа зарлачихсан явж байгаа. Гүүрэн байгууламжийн асуудал нөгөө тэр давхар хурдны замтайгаа бас хамтдаа ярьж байгаа. Гэрлэн дохио дээр хамгийн их асуудал байгаа. Гэрлэн дохио ерөөсөө 2008 оны үед байхаа Солонгосын ЗГ-ын төслөөр хэрэгжсэн. Энэ одоогоороо аналог системтэй байгаа, бараг манайхаас өөр орон яг энэ наадхаа орхичхоорой. Манайхаас өөр орон ерөөсөө аналогior байхгүй, бүгд дижитал шилжилт хийгдсэн. Бид нар бас шинэ шилжилт хийхээр ярьж байгаа. Авто зогсоол төлбөртэй бүсийн ийм зохицуулалтууд байгаа. 18 уулзварыг бид нар шинэчилье гэдэг ийм төлөвлөлт орж ирж байгаа. Сая энэ дэлгэц дээр харж байгаа тэр шар энэ өмнө нь хэтэрчихлээ дээ. Энэ шар бүсээс шууд энэ тэр 1 дүгээр магистрал руу орж ирэх ийм тээвэр зохицуулалтуудыг хийж байгаа. Одоо энэ дэлгэц дээр харж байгаа улаанаар тэмдэглэгдсэн замуудыг бид нар ирэх жил хийнэ. Улаанаар тэмдэглэснийг. Энхийг

хийснээр бид нар нөгөө 1 дүгээр.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Даваасүрэн сайд нэмж хариулъя.

**Ц.Даваасүрэн:** Бат-Эрдэнэ гишүүн маш чухал асуудал хөндлөө. Ер нь энэ уулзваруудыг 2 түвшний болгох асуудал маш чухал. Баруун зүүн 4 замыг болбол Жайкагийн төслөөр хийчихсэн төсөл бэлэн байж байгаа шүү дээ. Тэгэхээр энийгээ бол бас 2040-дөө тусгаад ингээд явах боломжтой. Бид нар одоогийн шинэ хийж байгаа жишээлбэл Сэлбэ сэргэлтээр бол яг ингэж хийж байгаа юм. Тухайлбал 100 айлын гүүр Сэлбэ сэргэлт чинь бол босоо тэнхлэгийн зам байж байгаа шүү дээ. Тэгээд баруун талтай холбосон. 100 айлынх, Энхтайваны гүүр, Нарны зам, тэр нөгөө Нарны гүүр энэ бүгд 2 түвшний уулзваргүй байх юм. Тийм учраас нөгөө урсгал чөлөөтэй шууд нэвтэрнэ. Яг таны ярьж байгаа тэр концепцын дагуу бол хийгдэж байгаа. Тэгэхээр болбол одоогийн нэг гол түгжрэлийн нөлөөлөл бол тэр нь Нарны гүүрнээс цаашаа очоод нөгөө цаашаа буухдаа аваачаад нөгөө гэрлэн дохио дээр түгжирчхээд байгаа байхгүй юу. Тэрийг болбол 2 түвшний жишээлбэл гүүрэн зам болгож өгч байгаа юм. Одоогийн хийж байгаа зургаар гэх мэтээр аль болох бол гэрлэн дохио дээр хязгаарлагдахгүй байх, чөлөөтэй урсах энэ чиглэлийн юмнуудыг бол хийж байгаа.

Мөн энэ баруун чиглэлийн зам дээр ч гэсэн манай нийслэлийнхэн бас иймэрхүү төлөвлөлтүүдийг хийгээд явж байгаа юм байна лээ. Хамгийн гол зам болбол бас нэг ачааллыг бууруулах зам бол Ард Аюушийн өргөн чөлөөний Содон хороололтой холбох зам. Энэ бол газар чөлөөлөлтөөс болоод зогсчоод байгаа байхгүй юу. Тийм учраас л өнөөдөр нийслэл энэ газар чөлөөлөлтийн асуудлыг оруулж ирж, тэнд тавхан айлаас болоод бүхэл бүтэн том бүтээн байгуулалтын нэг зам бүтэн жилээр зогсчхож байна шүү дээ. Хэрвээ энэ зам орсон бол 1 дүгээр хороолол, 10

дугаар хорооллын ачаалал 2 хуваагдаад л явчих байхгүй юу. Та бол энэ замыг сайн мэдэж байгаа шүү дээ. 4 дүгээр хорооллын эцсээс шууд 5 шар луу очих зам гэсэн үг шүү дээ гэх мэтийн юм бас саад нэлээн байгаа учраас энэ замуудын төлөвлөлтөөр гэр хорооллын тэр газар чөлөөлөлттэй холбогдолтой асуудлууд бол Сэлбэ дээр ч гарч байна. Тэр хэлж байгаа тэр нөгөө Ард Аюушийн өргөн чөлөөтөөс.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Тодруулах уу? Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн тодруулж асууя.

**Ж.Бат-Эрдэнэ:** Би наад Жайкагийн чинь судалгааг асууя гэж бодож байсан юм. Та бас хэлэх шиг боллоо. Энийг нэг жоохон тодруулж өгөөч. Энэ Жайкагийн судалгааг чинь 2050 он хүртэл ер нь болбол ачааллыг болбол бууруулна, түгжэрэлгүй байлгана гэсэн нэг ийм л судалгаа уг нь тухайн үед гарч байсан юм шүү дээ. Яах вэ магадгүй зүгээр ямар хэмжээнд судалгаанд гаргаад, өнөөдөртөө бас хөгжлийн түвшинд нэлээн өөрчлөлт гарсан байж болох юм. Тэгээд наад дээр чинь нэлээн олон тийм замуудыг, нэлээн олон уулзварууд байх ёстой тийм үү? Тэрийг та бас нэг тодруулж нэгдүгээрт хэлээч.

2 дугаарт түрүүн тэр хорооллууд дундах замыг нээж өгөх, тэр нөгөө хашаа байшингуудыг чөлөөлье гэж байсан шүү дээ. Энэ талаас ер нь хийж байгаа ажлууд чинь ямар зүйл байна вэ? Сумъяабазар даргын үед болбол нэлээн олон хашаа авсан. Хамгийн гол нь хашаа хашаа гэхдээ хорооллууд дундуур шилжээд сүлжээд ингээд явах гарах гарам гарц гаргах энэ тал дээр нэлээн анхаарал хандуулаад, нэлээн ажил хийх шаардлагатай байгаа байх. Нэлээн ААН-үүдийн газрыг чөлөөлөх ч байдаг юм уу ийм асуудал байгаа байх. Энэ дээр нэг хариулт сонсоодохъя.

**Л.Мөнхбаатар:** Хэн хариулах вэ? Ажлын хэсгийн 86 дугаар микрофоныг

өгье. Албан тушаал, нэрээ хэлээд хариулаарай.

**Ч.Батзориг:** Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Жайка бол үндсэндээ 2007, 2022 гэсэн 2 удаагийн үндсэн судалгаа хийж өгсөн. 2007 онд бол Масс транзит буюу хөдөлгөөн зохион байгуулалтын судалгааг хийж өгсөн. Сүүлд 2022 онд болбол дахин шинэчилсэн судалгаагаар гарсан. Энэ дээр болбол нийтдээ хөдөлгөөн зохион байгуулалт, дээрээс нь уулзварын дахин шинэчлэлийн асуудлуудыг шинээр оруулж ирсэн. Дээрээс нь өмнөх масс транзиттай холбогдож байгаа 2 түвшин дээр 18 уулзвар дээр дахин инженерчлэл хийхээр төлөвлөлт оруулж ирсэн. Тэрэн дээр нь 18 дээр болбол 2 түвшний 6 уулзварыг шинээр оруулж ирэх төлөвлөгөө төлөвлөлтийг оруулж ирсэн. Тэгээд хамгийн том нь бол бид нарын хамгийн сайн мэдэх ажилчны гүүр Ажилтны гудамж буюу Нарны гүүртэй зэрэгцээ байрлалаар одоо манай хийгдэж байгаа нүхэн гарцын дээгүүр хийе гэсэн иймэрхүү төлөвлөлтийг бол шинээр оруулж ирсэн.

2 том уулзвар байгаа. Нэг нь Баянбүрдийн уулзвар, нөгөөдөх нь Саппорогийн уулзвар 2-ыг болбол бас бүрэн шинэчилье гэсэн ийм төлөвлөлтийг болбол Жайкагаас болбол хийсэн. Энэ нь нөгөө Монгол Японы Найрамдалт нийгэмлэгийн ойн арга хэмжээнд болбол зарим нэг бас буцалтгүй тусламжийн асуудлыг бас оруулж ирсэн.

**Л.Мөнхбаатар:** Асуултад хэн хариулав, албан тушаал, нэрээ хэлээд байгаарай. Тэгэхгүй болбол нь хэний асуултад хэн хариулж байгаа нь бас протоколд тодорхой үлдэж байх учиртай гэдгийг ажлын хэсгийнхэнд хэлье. Болчихсон уу, хариулт болчихсон уу? 84 дүгээр микрофоныг өгье.

**Г.Батзориг:** Бүгдэд нь энэ өдрийн мэндийг хүргэе. Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны дарга Батзориг. Хашааны хашаа арга хэмжээний талаар



бас танилцуулъя. Нийслэлийн сүүлийн 3 жилийн хугацаанд нийтдээ 2251 байриилд 87808 метр хашааг буулгаж чөлөөлсөн. 40 байриилд 4 мянга, 5490 хашааны стандарт мөрдүүлэх ажлыг бол зохион байгуулсан. Мөн дээр нь гарааш арга хэмжээ гээд нэгдсэн байдлаар зохион байгуулсан. Өнөөдрийн байдлаар сүүлийн 3 жилд 9500 гараашийг буулгаж, 16 га газрыг бол чөлөөлж, нийтийн эдэлбэрт авч ногоон байгууламж, тохижилтын ажил, сургууль, цэцэрлэгт нэмж өгөх газруудын байрилуудыг бол гаргаад байна.

**Л.Мөнхбаатар:** Тодруулж асууя. Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн 1 минут.

**Ж.Бат-Эрдэнэ:** Тэр Нарны замын төгсгөл авто төмөр замын вокзалаас баруун тийшээгээ яваад нөгөө эргэлтийг цаашаага төмөр зам давуулаад 4 дүгээр цахилгаан станцаас ирж байгаа замтай холбох нэг нэлээн чухал зам байгаад байгаа шүү дээ. Энэ ер нь хаягдсан. Ерөөсөө сүүлийн үед би та нарын амнаас ерөөсөө сонсохоо больчихлоо. Энэ явж байгаа юу үгүй юу?

2 дугаарт ер нь тэгээд нэлээн асуудлууд хэн Нямбаатар сайд даргаа нэлээн асуудлууд та оруулж ирж байна. Хамгийн гол асуудал болбол ерөөсөө яг энийг хэрэгжүүлэхэд бид нар буцаад наад төлөвлөлт чинь алдагддаггүй байх асуудал чинь ер нь яг баараагүй баталгаатай болж чадаж байна уу үгүй юу? Нөгөө албан тушаалтан, нөгөө төрийн албан хаагчид чинь нэг мэдэхэд доогуур чинь будилуулаад, будилуулаад тэгээд нөгөө хүн амьтны гуйлт энээ тэрээ гуйлт энээ тэрээ гэсээр байгаад л нэг мэдэхэд л нөгөө төлөвлөлт чинь буцаад алга болчихсон байдаг ийм түүхтэй улс шүү дээ бид нар болбол ер нь. Ямар нэгэн албан тушаалтан гуйдаг, ямар нэгэн эрх мэдэлтэн гуйдаг, тэгэнгүүт л нөгөө төлөвлөсөн төлөвлөлтөө устгадаг. Энэ дээр ямар анхаарал хандуулж тавьж байгаа вэ? Энэ дээрээ л.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Тодруулгад ажлын хэсэг хариулъя. Ажлын хэсгийн Нямбаатар дарга хариулах юм уу? Нямбаатар дарга хариулъя.

**Х.Нямбаатар:** Баярлалаа. Би Бат-Эрдэнэ сайдад маш товчхон хариулъя. Бид нар энэ удаа өргөн барьж байгаа энэ хууль, эрх зүйн орчны шинэчлэлийн хүрээнд дүүргийн Засаг дарга нар газар олгохгүй. Өөрөөр хэлбэл одоо дахиж төлөвлөлтийн алдаатай газар огт олгохгүй. 2 дугаарт НЗД газар олгох бүх хүрээ хязгаараа хумиад зөвхөн энэ нөгөө дэд төвүүдийн хүрээнд дуудлага худалдаагаар ерөнхий төлөвлөгөөнд туссан асуудлаар газар олгоно. Дээр нь барилгажих талбай нийт олгосон газар олголтын зөвхөн 60 хувьд нь барилгажна, 40 хувь нь ногоон байгууламж байна гэдэг шинэ стандартыг оруулж ирж байгаа. Энийг хангаагүй барилга, байгууламж барьсан, түүнд зөвшөөрөл олгосон албан тушаалтанд албан тушаалын тэр гэмт хэргээрээ албан тушаалаа хэтрүүлэх, хайнга хандах тэр юугаараа хариуцлага хүлээх ийм зохицуулалт байгаа.

Дээр нь нэмээд нэг зүйлийг нэмж хэлэхэд бид нар энэ их тойруугийн 1100 га дотор одоо дахиад 1500 өндөр цамхаг барилгууд босох гэж байна. Тэгэхээр энэ удаагийн энэ өргөн барьж байгаа анхдагч хуулийн төсөл дотор нягтаршил хэт ихтэй газар дахин барилгажих асуудлыг ЗГ-ын журам гаргаж өөр дэд төвүүдэд нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой харилцааг энэ хуулиар зохицуулж өгч байгаа. Өөрөөр хэлбэл бид нар өнгөрсөн жилүүдийнхээ энэ хот төлөвлөлтийн алдааг энэ хуулийг гаргаснаараа бид нар засах, түгжрэлийг энэ их тойруу дотор байгаа хэт их төрийн болон бусад үйлчилгээний энэ цэг салбаруудыг дэд төвүүддээ тархаан байршуулах ийм л бодлогыг оруулж ирж байгаа юм. Түрүүн би дэлгэцэд слайдаар үзүүлсэн. Зөвхөн Баянхошуу дэд төв, Сэлбэ дэд төв 2 ашиглалтад орсноор 2,5 их наяд төгрөгийн ДНБ нэмэлт гарч ирэх, 22

мянга орчим ажлын байр нэмэгдэх, 36 орчим хувиар түгжэрэл буурах, 22 хувиар.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Ажлын хэсгийн 86 дугаар микрофоныг өгье. Тодруулгад хариулъя.

**Ч.Батзориг:** Бат-Эрдэнэ гишүүний тодруулалт хариулъя. Нийслэлийн замын нэгдсэн төслийн захирал Батзориг. Нарны гүүрний урд талын төмөр зам дагасан 2,3км замыг ноднин ЗТЯ-наас ашиглалтад оруулсан. Үүнийг дагуулаад нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 1,8км замыг урагшаа Алтай хотхоны гуравдагч гүүр гэж орж ирж байгаа. Урагшаа Эрэлийн зүүн талаар Наадамчдын өргөн чөлөөтэй холбох энэ ажил Эрэлийн зүүн талын төмөр замын 750 метр дээр очоод гацчихсан байна. Гүүр болон замын ажил бол үндсэндээ дууссан. Хойд чиглэлээс болбол Хермес-н гэж яригдаж байгаа. Нарны замаас урагшаагаа нүхэн гарцаар холбогдох ажил орж байгаа. Энэ нүхэн гарц бол нийтдээ 2,8км замтайгаа хамт ирэх оны 7 сард ашиглалтад орохоор ингээд төлөвлөлттэй явж байна. Цаашаагаа холбогдоно гэсэн үг. Урагшаагаа. Тэгээд Сэлбэ гол, Сэлбэ, Сэлбэ сэргэлтийн трастай бас зэрэгцэн холбогдох ийм 3 хаб ийм замын уулзвар байгаа. Тийм нүхэн гарцаар хийж байгаа юм.

**Л.Мөнхбаатар:** Байнгын хороон дарга Баагаагийн Баттөмөр асуултаа асууя.

**Б.Баттөмөр:** Ингээд нийслэлийн цаашдын хөгжилтэй холбоотой тулгамдсан асуудлуудыг шийдэх чиглэлээр оруулж ирж байгаа саналыг бол дэмжиж байгаа. Хамгийн гол нь болбол манай нийслэлийн удирдлагууд хийх гэж байгаа ажлаа ард иргэддээ их зөв ойлгуулах шаардлагатай. Дөнгөж төсөл байдлаар явж байхад л 27 мянган төгрөгийн татвар авна гээд л ингээд л яваад байгаа байхгүй юу. Өдөржингөө

зогсоолд тавьсан хүн бол яагаад 27 мянган төгрөг төлж болохгүй гэж. Төлбөргүй юм гэж ер нь хаана ч байхгүй шүү дээ. Энэ замыг засна барина гэдэг чинь бүгд л төлбөр шүү дээ. Татвар авч байж л засдаг л жишиг дэлхийд байгаа шүү дээ. Тэгэхээр зэрэг ер нь иргэдийнхээ орлогыг нэмэгдүүлэх энэ чиглэлд л бид их голлож анхаарах ёстой юм байгаа юм л даа. 200 мянган өрх байна яндантай гэр хороололд амьдарч байгаа. 164 мянган яндан байгаа, 145 мянган нүхэн жорлон гээд л ер нь дэлхийд байхгүй аймшигтай тоо болбол манай нийслэлд байгаа шүү дээ.

Тэгээд энэ ингээд яагаад ингэж байна гээд ингээд үзэхээр зэрэг энэ Монголын хөгжлийн мухардал, энэ нийслэлийн энэ хөгжлийн мухардал чинь ерөөсөө л хүнтэйгээ л холбоотой шүү дээ. Энд ер нь гаднын ямар ч нөлөө байхгүй байна шүү дээ. Тухайн тухайн үед л энэ асуудлуудыг шийдээд яваад байхад бол ийм асуудал үүсэхгүй байна шүү дээ. Тэр Жеймс Ульсан гэдэг хүний хэлсэн нэг онол байгаа шүү дээ. Нөгөө broken windows theory гэж нөгөө хагархай цонхны онол гэж. Нэг цонх хагарахад тэрийг шиллэхгүй бол цаашаа бүгд хагардаг. Асар их хохирол учирна, хойноос нь ажил хөөцөлдөх болно гэж. Яг энэ дүр зураг өнөөдөр манай нийслэл дээр л бий болчихсон л байна л даа. Манай улсад ч байна. Тийм учраас энийг шийдэх гээд оруулж ирж байгаа энэ юунууд бол шийдлийн нэг хэсэг нь. Цаашидаа энийг бид ер нь яах вэ гэж. Тэгээд энэ асуудлыг бид нар аль ч түвшинд үзэхдээ дандаа яг нэг цэгээ л олохгүй байгаад байгаа юм. Хүнтэйгээ л ажиллах ёстой байгаа юм. Хүний хүчин зүйл гэдэг болбол энэ хөгжилд бол хамгийн шийдвэрлэх хүчин зүйл шүү дээ. Одоо орчин үеийн энэ хүмүүс болбол юу гэхээр улс эх орныхоо төлөө чин сэтгэлээсээ ажилладаг юм огт байхгүй болчихсон. Ийм л болчихсон байгаа. Тэгээд энэ дээр анхаарна биз.

Тэгээд 2, 3 асуултууд байна. 1 дүгээрт нь за яах вэ ийм маягаар явбал энэ

яг үр эцсийн үр дүнг бол үзэхгүй нэг хэсэг хүмүүс одоо эд нар үзэхгүй. Тэгэхээр энэ хийж байгаа ажилтайгаа уялдуулаад өөр жишээлбэл энэ дагуул хотын асуудлаа яах юм бэ? Налайхын асуудал, Төв аймаг, Дарханд баахан сургууль шилжүүлбэ гээд л тэгсэн. Одоо сүүлийн үед таг болчихлоо. Энэ дээр би Нямбаатар сайдыг бас хариулт өгөөч гэж яаж байна.

2 дахь асуудал болбол энэ гаднын нэг хүн хэлсэн байгаа шүү дээ. Энэ танай түгжрэлийн чинь нэг хэсэг нь бол тархины түгжрэл гэж. Соёлгүй жолооч нар, замын хөдөлгөөний буруу зохицуулалтууд, хүний хийх зүйлүүд хүнээс шалтгаалсан. Дуртай нь таксинд явдаг, хүн алдаг аваачиж, замын хөдөлгөөнд саад учруулдаг. Тэгээд энэ жолооч нарыг бэлтгэх асуудал энэ жолооч, тээврийн хэрэгслийн жолооч нарын энэ ёс зүй, ёс суртахуун гэдэг юман дээр яах ёстой юм бэ? Энийг та нар юу бодож байна гэж ийм байгаа юм.

Энэ дараагийн асуудал болбол энэ зүгээр яах вэ бид нар ингээд л орон сууцажна, барина ингээд л явж л байгаа. Хамгийн аюултай юм бол энэ нүхэн жорлон байгаа шүү. Энэ жил нөгөө үер болсон. Дандаа өндөр цэгүүд дээр нүхэн жорлонгууд нь байрлаж байгаа. Бид бол үндсэндээ баас шээсээрээ л хооллож байгаа шүү дээ ний нуугүй ярихад бол. Энэ 164 мянган нүхэн жорлонг ер нь яах юм бэ? Тэр саармагжуулдаг барьдаг, энэ 21 дүгээр зуунд амьдарч байна даа. Ямар шийдлүүд байна вэ? Энэ хамгийн аюултай.

**Л.Мөнхбаатар:** Баттөмөр даргын асуултад хариулъя. НЗД Нямбаатар хариулъя.

**Х.Нямбаатар:** Би Баттөмөр гишүүний тэр хэлсэн нөгөө хагархай цонхны онолтой 100 хувь санал нэг байна. Ньюйорк хот ч гэсэн 1980-аад оны эхэн үед ерөөсөө гэмт хэрэг зөрчил нь дийлдэхээ больчихсон, энд тэндгүй залуучууд нөгөө графит зураг зурж

эрээчдэг ийм л байсан юм байна лээ. Тэгээд метронд туулайчилдаг ийм л байсан. Тэгээд энэ дээр бас Ньюйорк хотын захиргаа, цагдаа яаралтай арга хэмжээ авч, энэ нөгөө яг хагархай цонхны онолын дагуу явсан. Ингээд энэнээс хойшоо асуудлаа ер нь цэгцэлж чадсан юм байна лээ.

Тэгэхээр өнөөдөр Улаанбаатар хотод энэ хотын дүрэм журам, стандарт гэдэг бол яг энэ л хагархай цонхны онолоор л бид нар бүгдийг нь жигдрүүлэх л ийм арга хэмжээ авахаас өөр аргагүй байдалтай байгаа юм. Ирэх жил нийслэл Улаанбаатар хот 70 орчим тэрбум төгрөг төсөвлөж камерынхаа асуудлын дэд бүтцийг бүхэлд нь тендер зарлаж шийдье гэдэг ийм төлөвлөгөөтэй байгаа. Камерын асуудал шийдэгдсэнээр энэ соёлгүй жолооч нар, энэ хотын дүрэм журам зөрчдөг хүмүүсийн асуудал шийдэгдэнэ. Сая Яармагт тэр 1 дүгээр эгнээ дээр нэг хайс тавиад буцааж хураалаа л гээд байсан. Яг үнэндээ тэр хайсны дийлэнхийг нь нөгөө соёлгүй жолооч нар, мөн хөдөлгөөний нягтралаас болоод л бүгдийг нь дайрч эвдэрхий болгосон. Өнөөдөр Улаанбаатар хотын энэ бордюрын асуудал байгаа. Мөн л ялгаагүй дандаа бордюр давж явах, түгжрэлээс гарахын тулд л ийм алхам хийсээр байгаад бордюрүүд эвдэрдэг хэмхэрдэг ийм л юунууд байгаа. Тэгэхээр бид нар энэ камержуулалтаар 1 дүгээрт энэ хариуцлагын механизм тооцох механизмыг сайжруулж, энэ хотын соёлыг жигдрүүлэх ийм арга хэмжээ авахаар бас төлөвлөж байгаа.

Дагуул хот, дэд төвүүдийн асуудал дээр 6 дэд төвийг ер нь бид нар ойрын хугацаанд 2 дэд төвийг нь бол ер нь гараас гаргая. Ирэх жил бид нар Баянхошуу дэд төв дээр 800 айлын орон сууц энэ 4 сард ашиглалтад орно. Ирэх оны. Үргэлжлээд ер нь 6 мянга орчим айлын орон сууцыг, одоо 800 орсон дээрээ 800 айлын газрыг чөлөөлөөд ингээд цаашаа 5-аас 6 мянган айлын орон сууц барина, төлөвлөнө. Ер нь дэд төвүүдээр эхний ээлжид бид нар

худалдаж борлуулах гэхээсээ илүүтэй ойр орчмынх нь айл өрхүүдэд нөхөн олговор байдлаар орон сууцыг нь шилжүүлж, газрыг нь чөлөөлж авъя, цогцолбор байдлаар хөгжсүүлье гэдэг ийм төлөвлөлт барьж байгаа.

Дагуул хот эдийн засгийн тусгай бүсийн зохицуулалтууд бас нэлээн нарийвчилж энэ төсөлд орж ирж байгаа юм. Жишээлбэл СХД-ийн 21 дүгээр хороо бид нарын нэрлэж заншсанаар Партизан орчмыг бид нар тэр эдийн засгийн тусгай бүс болгоё. Энэ дээрээ Улаанбаатар хот орчмын нарийн ногоо, хүнсний ногоог бүхэлд нь хангадаг. Ингээд цаашид хүнсний сүүн бүтээгдэхүүнийг хангадаг болгоё. Цаашаагаа Батсүмбэр лүүгээ тэлье, эдийн засгийн хувьд Төв аймагтайгаа интеграцид орёе гэдэг бас зохицуулалтыг оруулж ирж байгаа.

**Л.Мөнхбаатар:** Асуултад БХБ-ын сайд Даваасүрэн нэмж хариулъя.

**Ц.Даваасүрэн:** Энэ дэд төвүүдээр ингээд хөгжүүлээд явна. Дэд төвүүдийг гэр хорооллын дахин төлөвлөлтийг хийхдээ түрүүн Нямбаатар дарга ч хэлсэн. 1008 айлын Хятадын тусламжаар явж байгаа орон сууц бол ирэх 9 сар гэхэд ашиглалтад орчих байх. Энүүгээр ингээд шилжүүлээд байхаар бас ингэж зохицуулъя гэж бодож байгаа юм. Заримыг нь шууд худалдан авалтаар нөхөн төлбөр олгоод явна. Зарим нэг хэсгийг нь болбол дамжуулаад 1008 айлын орон сууцад оруулаад ингээд явуулах, шилжүүлээд явах энэ байдлаар ашигтай. Энэний дараагийн төлөвлөлт болбол Дэнжийн мянган дэд дэд төв байгаа. Дэнжийн мянган дэд төвийн бас бүх юм хийгдээд бас явж байгаа Нийслэл дээр болбол.

Та бол маш чухал асуудал хөндлөө. Энэ дээр бас нэг иргэний ёс зүйн асуудал байгаад байгаа юм. Манайд болбол нэг хавтгайдаа нэг энэ сошиалыг дагаад нэг өвчлөл бий болчихсон. Бусдыг ингээд шүүмжилж чаддаг, бусдыг маш сайн

шүүмжилнэ. Өөрийгөө үгүй. Одоо яг авто зам дээр гарч байгаа таны хэлээд байгаатай би санал нэг байна. Манай иргэд Монголчууд бид яаж байна вэ гэж. Ингээд зам дээр машинаа хүн тавьчихсан болохоор үгүй ээ энэ нови ингээд машин тавьчхаад явчхаж гээд л ингээд хараагаад л байгаа юм. Тэгсэн мөртөө өөрөө болохоор машинаа тавьчхаад тэнэг ч үгүй зүгээр яваад өгч байгаа байхгүй юу. Өөрөө болбол. Хүнийг тавьчихсаныг хараагаад байгаа юм, энэ машинаа тавиад ингээд одоо гээд л ингээд л. Өөрөө тавихаараа ямар ч өөрөө ингээгээд яваад өгч байгаа байхгүй юу. Энэ энийгээ л бид нар өөрчилмөөр байна. Тэгэхгүй бол бид нар бас ингээд ямар ч хууль, эрх зүй юм гаргаад төгс шийдэж чадахгүй. Хэрвээ нийгэм маань өөрөө энийг бас хүлээж авах сэтгэл зүйтэй, энийг хууль, эрх зүйг дагах ёс зүйтэй байх асуудал болбол хамгийн чухал болсон байна. Тийм учраас бас таны би хэлж байгаатай 100 хувь санал нэг байна. Энэ энэ чиглэл дээр ялангуяа энэ замын автын үйлчилгээний соёлын асуудал дээр бид нар бас анхаарах ёстой. Хэчнээн чанга хууль гараад хэрвээ иргэд ёс зүйгүй байх юм бол энийг энэ хууль хэрэгждэггүй.

**Л.Мөнхбаатар:** Тодруулах уу? Баагаагийн Баттөмөр гишүүн тодруулж асууя.

**Б.Баттөмөр:** Ер нь бол хөгжил гэдэг бол хүний хөгжил. Тийм учраас хүнтэйгээ ажиллах ёстой. Аливаа хууль дүрэм хийхдээ заавал энэ ёс суртахуун ёс зүй, хүний энэ асуудлыг бол ерөөсөө бид орхигдуулж ирсэн. Энийг орхигдуулж ерөөсөө болохгүй. Энд болбол янз бүрийн асуудал хуульчлахгүйгээр шийдчих юм байгаа юм. Жишээлбэл үйлчилгээний газрууд шөнө татан авалтаа яагаад хийж болохгүй гэж. Заавал өдөр ингэж хийж байх ямар хэрэгтэй юм бэ? Үйлчилгээний газрууд гэхэд чинь машинаа түрүүлж аваачаад үйлчлүүлэгчээс түрүүлж аваачаад бүх талбайгаа дүүргэчихдэг. Том дарга нар том машинтайгаа очоод байгууллагынхаа

гадна очоод хаагаад зогсоод авчихдаг. Тэгээд ийм, ийм зохицуулах юмнууд болбол асар их байна. Тэр нөгөө Сингапурын Ерөнхийлөгчийн хэлсэн үг байгаа шүү дээ, Ерөнхий сайдын хэлсэн үг. Тэр хөгжих болбол хэцүү биш. Хүний ухамсрын доройтолтой тэмцэх маш хэцүү. Одоо ч бид тэмцэж байна гэж хэлсэн үг байгаа шүү дээ. Тийм учраас энийг ерөөсөө мартаж болохгүй.

**Л.Мөнхбаатар:** НЗД Нямбаатар хариулъя.

**Х.Нямбаатар:** Баттөмөр гишүүний асуултад сүүлийнхэд нь хариулъя. Бид нар түгжрэлийг бууруулах чиглэлээр өмнө нь хийгдсэн бүх судалгааны ажлуудтай бас нэлээн хэд хоног танилцаж суусан. 2 дугаарт бас нэг судлаачдын гаргаж өгч байгаа хэд хэдэн санал, дүгнэлтүүдтэй танилцсан. Дээр нь хувийн хэвшлийнхэнтэй Худалдаа аж үйлдвэрийн танхим, Нийслэлийн худалдаа аж үйлдвэрийн танхимын салбар зөвлөлийнхэнтэй бид нар бас уулзалтууд хийсэн. Энд нэг ийм зүйл дээр бид нар бас хувийн секторынхонтой хамтарч ажиллая гээд санал солилцож байгаа. Тэр юу вэ гэвэл шөнийн түгээлтийн менежмент. Энийг хамгийн их төгс хэрэгжүүлж чадаж байгаа 2 байгууллага бол CU, GS25 гэдэг 2 байгууллага энэ шөнийн цагийн түгээлтийн схемээ бидэнд бас танилцуулсан. Өөрөөр хэлбэл өдөрт түгээлтэд зарцуулдаг хөрөнгө, цаг хугацааг шөнийн цагт хийснээрээ нөгөө шууд өртөөчлөөд түгээлтээ хийдэг ийм аягүй их хэмнэлтүүд гардаг юм байна. Тэгэхээр бид нар хувийн секторуудын энэ ХАҮТ-ын нөхдүүд бид нарт удахгүй саналаа танилцуулъя гэсэн. Бид нар шөнийн цагийн түгээлт хийж байгаа, хүргэлт хийж байгаа, шөнийн цагийн үйлчилгээ үзүүлж байгаа ААН-үүдэд санхүүгийн бас тийм дэмжлэг комбинсац үзүүлье гэдэг ийм байдлаар хамтарч ажиллая гэдэг ийм санал солилцоод, одоо удахгүй бид нар нарийн деталь дээрээ ярих гэж байгаа.

2 дугаарт бид нар энэ хүнсний захууд, худалдаа үйлчилгээний төвүүд, энэ нөгөө захуудыг бид нар өглөө эрт онгойж, орой эрт хаах энэ зохицуулалтууд дээр бас хамтарч ажиллая гэсэн ийм зохицуулалтын ажлууд яригдаж байгаа. Тэгэхдээ ер нь бол зүгээр Баттөмөр гишүүнд товчхондоо хэлэхэд бид нар энэ Улаанбаатар хотын Бага тойруугийн 50 га дотор Монгол Улсын бараг бүх амьдрал явж байгаа юм байна лээ. Бүх их, дээд сургуулиуд, бүх эрүүл мэндийн том байгууллагууд, төрийн захиргааны төв байгууллагууд, нутгийн захиргааны төв байгууллагууд бүгд энэ дотроо. Тэгээд энэ дээр 5 зүгээсээ ирж өглөө, орой 2 түгжрээд буцаж байгаа юм, 2 сая 900 мянган.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Багаагийн Баттөмөр гишүүн тодруулж асууя 1 минут.

**Б.Баттөмөр:** Нямбаатар даргатай бол сүүлийн хэдэн жил нэг хамт ажилласан, бас ажил хийчих гээд гүйгээд байдаг, зүтгэдэг ийм сайхан чанар байдаг. Хамгийн гол нь болбол хөгжил гэдэг бол хүний хөгжил. Тийм учраас өөрийнхөө харьяанд байж байгаа шууд удирдагддаг хүмүүсийнхээ чадварыг үнэлэх ёстой шүү. Хамгийн гол нь хүний бид Монгол яагаад хөгжихгүй байна вэ, нийслэл яагаад хөгжихгүй байна гэхээр ерөөсөө хүнээсээ л болсон. Өөр ямар ч шалтгаан байгаагүй шүү дээ. Тэр хагархай цонхны онолын дагуу юмыг хараад яваад байсан бол болох байсан, байхгүй 1 дүгээрт тэр.

2 дугаарт бол энэ автомашин гэдэг чинь энэ анхдагч хэрэгцээ мөн юм уу биш юм уу? Нийтийн тээврээ цаашаа хөгжүүлдэг, тэнд урамшуулдаг, зарим юманд үнэгүй ч явдаг барьдаг юм, тэртээ тэргүй л татаас зөндөө авдаг юм байна лээ шүү дээ. Ерөөсөө тэр чигээрээ л хуйвалдаан юм байна лээ энэ автобус. Тэгээд энэ юмнуудыг хийгээч гэж. Дараагийн асуудал болбол бид энэ нефть бүтээгдэхүүний татвар бол тэг. Хэрвээ

энийг ингээд татвар оногдуулах юм бол 7, 800 тэрбум төгрөг.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Санал хэлсэн үү, хариулах юм уу? Нямбаатар дарга тодруулгад хариулъя.

**Х.Нямбаатар:** Нийтийн тээврийн шинэчлэлийн асуудал ирэх онд хийгдэнэ. Би уг нь ингээд анх удаагаа л бид нар хууль хэлэлцэхдээ яг хийх гэж байгаа юмаа дэлгэцэн дээр гаргаад явъя гэсэн юм. Энэ юу вэ гэхээр Улаанбаатар хотын арын гэр хорооллын өндөрлөг хэсгүүд дээр бид нар 50 орчим дунд оврын автобуснууд явуулна, 25 орчим хүний суудалтай. Тэрийг зогсолтгүй ийм эргэлттэй кольцо болгож явуулна. Сая бид нар замаа судалсан. Одоо тэр шарууд. Шарууд тэр хар хөх өнгийн кольцонууд дээр авчирч хүнээ буулгана. Хар хөх өнгийн кольцо замууд ерөөсөө тууш замдаа явна. Илүү ийм урт эргэлт хийхгүй. Дандаа богинын рейсүүд хийнэ. Жишээлбэл офицеруудын ордноос Таван шар хүртэл л байнгын тасралтгүй ийм эргэлдэж байдаг автомашинууд том оврын автобуснууд байна. Хайлаастын тэр дээд талын шараар бичсэн шугамаас бууж ирээд Хайлаастын одоогийн эцсийн буудал дээр ирэнгүүт Хайлаастын автобус тэр доошоогоо уруудаж ирээд Багийн дээд дээр ирээд л хүнээ буулгачхаад л буцна. Өөрөөр хэлбэл хамгийн дээд талын өндөр дээр байгаа хүн өдөрт очих цэг дээрээ хамгийн багадаа 3 дамжаад л очно. Ингээд уртын рейс байх тусмаа түгжрэл, нийтийн тээврийн нөгөө нэг ар өврийн хаалга гэдэг ийм тээвэр зохицуулалтууд яваад байгаа юм.

Бид нар өнгөрсөн хугацаанд 2014 оноос хойш жилд дунджаар 200 орчим тэрбум төгрөгийн татаасыг олгохдоо нэг ч удаа гүйцэтгэл буюу хүнийг нь тоололгүйгээр шууд бүтэн юуг нь татаасыг нь өгөөд ирсэн. Гэтэл 60 хувь байсан нийтийн тээврийн зорчилт 24 хувь болтол буусан, буурсан гэж бодоход энэ дунд дандаа нөгөө авлига, ашиг сонирхлын зөрчил, хүн тоолоогүй явдал явж байгаа.

Тэгэхээр энэ дээр бид нар ийм өөрчлөлт гаргана. Хүний нөөц дээр би Мөнхбаатар дарга нэг уг нь нэмээд хариулчихмаар л байгаа юм. Энэ цаг дуусаж байх шиг байна. Бид нар хот байгуулалт, зам төлөвлөлт, архитектур төлөвлөлт, инженерийн байгууламж зэрэг дээр манай нийслэл Улаанбаатар хотод.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** 1 минутад багтаагаад гүйцээгээд хариулчихъя. Нямбаатар дарга.

**Х.Нямбаатар:** Тийм орчин цагийн яг энэ хотын хөгжлийн нөгөө шинэ инновац технологи нэвтрүүлэх мэргэжилтнүүд дулимаг дутмаг байна. Тэгэхээр бид нар энэ удаад дагуулж байгаа хуулиараа үйлчилгээний албанд зөвлөх мөн цаашилаад багаар нь гаднын мэргэжилтнүүдийг авч ажиллуулах ийм нарийн мэргэжлийн мэргэжилтнүүдийг авч ажиллуулах боломжийг энэ дагасан хуулиараа бас нээхээр оруулж ирж байгаа гэдгийг бас танд ний нуугүй хэлье. Өөрөөр хэлбэл бид нар 100 хувь Монгол хүмүүс яг энэ чиглэлийн нарийн мэргэжилтнүүд дээр нэмж бид нар гаднаас зөвлөхүүдийг өдөр тутамдаа энэ яг саяын хэлсэн барилга хот төлөвлөлт дээр, зам, барилга байгууламж, гүүрний байгууламж дээр хийцлэлүүд дээр гаднын нарийн мэргэжилтнүүдийг авч ажиллуулах боломжийг хуулиар нээж нээхээр оруулж ирсэн.

**Л.Мөнхбаатар:** Ганибалын Амартүвшин. АН-ын бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл асуултаа асууя.

**О.Цогтгэрэл:** Нэлээн тийм яаралтай горимоор тийм нэг асуудал дагуулсан хууль орж ирж байна л даа. Асуудал дагуулсан гэдэг нь зорилго нь болбол яалт ч үгүй тулгамдчихсан асуудал, тавьж байгаа шийдлүүд болбол үнэхээр бас асуудалтай байна. Ерөнхийдөө л манай Улаанбаатар хотын түүх болбол улс төрчид, улс төрийн намууд удирдахаар ямар болдгийг, хотыг

удирдахаар ямар болдог гэдгийг харуулсан л олон жилийн түүх л байна л даа. Уг нь болбол энд ерөнхий төлөвлөгөө гэж бас мэргэжилтнүүдийн гаргасан төлөвлөгөө байдаг. Энийгээ хэрэгжүүлсэн болбол. Жишээ нь магадгүй тэр нийтийн тээвэр гэж байна. Энэ дээр тэр нэг хууль дүрэм журам нээлттэй тендерээрээ аваад, нийтийн тээвэрээ 800 автобус өнөөдөр явж байх ёстой байсан болбол гэх мэт одоо, гэх мэт энэ асуудлуудаас болж л үүсэж, одоо орж ирж байгаа шийдэл нь, тэгэхээр энэ бүх бурууг иргэдээсээ, иргэдийн халаастай яриад асуудлаа шийдье, захиргааны аргаар шийдчихье гэдэг л нэг ийм арга хэрэгслүүдийг сонгож байгаа юм байна.

Тэгэхээр эндээс нэг зарим, зарим яагаад би зорилго нь зөв ч, энэ шийдэл чинь асуудалтай байна гээд. Одоо энэ хуулийг дагаад энэ анхдагч хууль юм байна. Энийг дагаад 23 хууль дагалдаж орж ирж, 23 хууль. Зөвхөн энэ хуулийг дагаад 23 хууль дагалдаж орж ирж байна. Энэний зөвхөн зарим хуулиуд нь жишээ нь тэр газар чөлөөлөлт гэсэн, мэдэхгүй энэ дээр болбол 23 юм дагалдчихсан л байна лээ. Газар чөлөөлөлт гэсэн чинь тухайн бүс нутгийн иргэдийн 65 хувь нь дэмжвэл шууд трактор ороод л буулгаад хаячих л юм байна л даа. Үгүй ээ энэ чинь яг энэ Үндсэн хуульдаа зүгээр нийцдэг юм уу энэ одоо. Энэ хууль чинь тэгээд ҮХЦ дээр очоод маргааш нь унах юм биш үү? Шууд иргэний тэр бүр өмчлөх эрхтэй, газар болоод, хашаа болоод бүр үл хөдлөх хөрөнгийг чөлөөлчихнө гэж байна. Жишиг үнэ тогтоогоод. Мэдэхгүй тэр одоо Үндсэн хууль дээрээ яаж нийцэх гэдгийг бол ойлгохгүй байна л даа.

2 дугаарт нь дагалдаж орж ирсэн хуулийн нэг нь энэ Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, үйлчилгээ худалдаж авах хууль гээд. Энэ хууль дээр 34.1 гэдэг заалт дээр шууд худалдан авах заалтууд гээд 3, 4 зүйл дээр нийслэл ийм, ийм зүйлийг шууд худалдан авалт хийнэ. Саяын нөгөө ногоон автобус мэтийн

зүйлийг шууд хийх юм байна л даа. Шууд худалдан авалт хийхээр чинь энэний цаана ямар их булхай, авлига хээл хахууль явдгийг бид нар бас харчихлаа шүү дээ. Үнэхээр бас хуулиараа тэр Үндэсний аюулгүй байдалтай холбоотой зүйл байдаг болбол бас байж болдог байх. Гэтэл хотын ажил чинь хэвийн, өдөр тутмын жилийн 12 сардаа ингээд урсаад явдаг л, урсаад явдаг ажил. Тэнд чинь нөөцүүд нь байх ёстой бас. Нямбаатар сайдаа би асуултаа эхлээд асуучихъя. Тэгэхээр энэ асуудлууд чинь үнэхээр бас ингээд ийм асуудал цаана нь их байна. Тэр 27 мянга гэдэг тооцоо яг яаж гарсан юм бэ, хэчнээн иргэнээс авах юм бэ, жилдээ энэнээс татвар хураамжаар хэчнээн мөнгө төгрөг энд хуримтлагдах юм бэ, иргэдийн халааснаас хэчнээн мөнгө гарах юм бэ? Гол нь ингээд асуудлыг шийдэл нь хамгийн хялбархан захиргааны аргаар, төрийн далайлтаар хязгаарлана, бооно, тэгээд тэрний цаана нь газар чөлөөлчихнө. Үгүй ээ яах вэ иргэдэд зарим ашиг сонирхол нь хөндөгдөхгүй байгаа иргэдэд зарим иргэдэд зөв сонсогдож магадгүй.

Гэхдээ тэгээд иргэний өмч хөрөнгийг шууд 10 иргэний 6 нь зөвшөөрчихөөр, 4 иргэн, 7 нь зөвшөөрчихөөр 3 иргэнийхийг нь шууд трактороор түрж унагаагч юм уу энэ чинь одоо. Нөгөө бид нарын сонгож авсан хүний эрх, хувийн өмч, эрх чөлөөний тэр үзэл санаа, энийгээ Үндсэн хуулиараа хамгаална гээд энэ олон зүйл хаачсан юм бол гэх мэтийн ингээд олон зүйлүүд байна. Яг энэ та энэ дагалдаж орж ирж байгаа тэр 23 хуулийн 2-хон хуулийг нь л харахад нэг хууль нь шууд худалдан авалтыг нийслэл хийж болно, нөгөөдөх нь газар чөлөөлтийг шууд чөлөөлж болно. Тэгэхээр бусад хуулиудыг нь үнэндээ энэ өнөө өглөө уншиж байгаа болохоор бусад хуулиудыг нь харж амжсангүй. Одоо энд бол лав л дагалдаж байгаа их, бага 23 хуулийн асуудал энд харагдана лээ. Тэгэхээр энэ зөв зорилгыг ийм захиргааны аргаар, хүч хэрэглэсэн аргаар.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. НЗД Нямбаатар хариулъя. Дараа нь Даваасүрэн сайд нэмж хариулна.

**Х.Нямбаатар:** Би сонссон Цогтгэрэл даргаа. Танай нам дээр Нямбаатарын оруулж ирж байгаа хуулийг унагаах, харлуулах ийм ажлын хэсэг байгуулагдсан гээд сонссон. Тэгэхээр өчигдрөөс ажлын хэсэг байгуулагдсан гэсэн. Нөгөө Элбэгдорж даргын үед шударга бусын хонгил нэгийг угсарч байхад сантехникийн слесариэр нь ажиллаж байсан Өнөрбаяр гээд залуу өчигдөр тийм юм ярьж байна лээ. Тэгээд тэр одоо нийслэлийг бид нар энэ түгжэрэлгүй, утаагүй болгоход Монгол Улсын Үндсэн хуулийн хүрээнд дэлхийн бусад их томоохон хотуудад байдаг түгээмэл арга хэлбэрүүдийг бид нар сонгож авч энэ хуульд оруулж ирсэн. Энийг би ирээд ч хийсэн юм биш. Энэ 2 жил гаруй боловсруулж байсан хуулийн төсөл дээр сайжруулалт хийсэн гэдгийг хэлье.

2 дугаарт таны барьсан Содон хороолол ерөөсөө ганцхан тал руугаа авто замаар гарах гээд тэнд хэдэн мянган хүн түгжэрээд байгаа шүү дээ. Тэрийг хойд талаар нь дахиад 2 эгнээ, 2 урсгалтай зам, 6 эгнээ зам барих гэсэн чинь тэнд 9 айл 19 тэрбум төгрөг нэхчхээд тэр ажил ингээд зогсчихсон байгаа шүү дээ. Тэр таны нөгөө Содон хорооллын иргэдийн эрхийг хамгаалахын тулд л бид нар энэ хуулийг газар чөлөөлөлтийн хуулийг Үндсэн хуулийн 6.4-д нийцүүлж л оруулж ирж байгаа шүү дээ. Төрийн худалдан авалтын хууль дээр шууд худалдан авалт хулгай зэлгий яриад байна. Та сайн наад төслөө уншаарай. Дулааны шугам задарчихсан тохиолдолд бид нар 30 хоног тендер зарлах уу, цэвэр усны шугам задарчихсан, бохирын шугам задарчихсан үед тендер зарлах уу гэдэг энэ харилцааг л зохицуулж байгаа юм.

2 дугаарт тэр хот нийтийн аж ахуйн тоног төхөөрөмжтэй холбоотой харилцааг 2019 онд баталсан Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуульд энэ Худалдан авах хуульд нийцүүлэлгүйгээр шууд авч болно гээд зохицуулалт байгаа. Бид нар 2 хуулийг л нийцүүлэе гэсэн юм. Та хэд ажлын хэсэгт ороод наадхаа хасаж болно шүү. Би дахиад таныг нэмж асуулт асуувал би бас хариулах хариултууд бэлэн байгаа.

**Л.Мөнхбаатар:** Яах юм бэ тодруулах юм уу? Тэгье, тэгье. БХБ-ын сайд Даваасүрэн асуултад нэмж хариулъя. Тэрний дараа тодруулаарай.

**Ц.Даваасүрэн:** Бид ингээд нэг улс төр хийхдээ нэг хязгаар байдаг баймаар байгаа юм. Нэг үндэсний эрх ашиг гэж. Тэрэн дээрээ болбол бид нар улс төр хиймээргүй байгаа юм. Одоо ингээд ард түмэндээ хайртай болж тоглосоор байгаад халамжийн улс болгоод хаячихсан. Тэр мөнгөөр үйлдвэрүүд бариад байсан бол өнөөдөр бид нар ядууралгүй болчих л байсан байхгүй юу даа. Өөрөө та бол бас бизнес эрхэлдэг хүн, өөрөө болбол бас харьцангуй сайн бизнес эрхэлдэг юм байна лээ. Тийм учраас бол энийг ойлгож байгаа шүү дээ. Бизнесийн үнэ цэн, ажлын байр, тогтмол орлоготой, Нямбаатар байж бай л даа би, тогтмол орлоготой болно гэдэг чинь хамгийн чухал байхгүй юу. Гэтэл бид нар ингээд үндэснийхээ эрх ашгаар тоглочоод байна шүү дээ, ингээд ард түмэндээ хайртай болж, одоо ингээд хамаг мөнгөө үрэн таран хийгээд. Тэрэнтэй ижилхэн энэ утаа дээр, энэ түгжэрэл дээр хэдүүлээ тогломооргүй байгаа юм.

Хэрвээ бид нар ингээд ийм юмаар ингээд улс төр хийдэг бол хэзээ ч энэ нэг үхлийн тойрогт орсноосоо бид нар гарч чадахгүй. Та нар энийг нэг сайн бодооч. Энэ ер нь намын удирдлагууд энэ улс намууд нэг хоорондоо уулзаад нэг ярих хэрэгтэй. Бид нарын хүрч болохгүй цэг гэж нэг байна. Үүгээр бол хэдүүлээ улс



төр хийхээ больё гээд тогтох хэрэгтэй шүү дээ. Энэ утаагаар, энэ түгжэрэлээр улс төр хийгээд яах юм бэ. Жишээлбэл 9 айлаас болоод Улаанбаатарын бүхэл бүтэн хорооллын эрх ашиг хохирч болохгүй шүү дээ. Нэг жил гаруй хүлээлээ. Сая тодотголоор 183 тэрбум төгрөг шийдсэний чинь нэг нь тэр Ард Аюушийн өргөн чөлөөнөөс тэр Содон хороололд хүрэх гэж байгаа замын мөнгө байхгүй юу. Гэтэл өнөөдөр мөнгө нь бэлэн байна. Нөгөө 9 айлаас болоод юм явахгүй байна шүү дээ. Тийм учраас бид нар нийтийн эрх ашгаа илүүд үзэх үү, 1, 2 хүний эрх ашгаа илүүд үзэх үү гэдэг юм чинь бас Үндсэн хуулиар зохицуулагдсан байгаа. Тийм учраас хэдүүлээ энэ нэг яг үндэсний аюулгүй байдлын хэмжээнд нөлөөлж байгаа энэ агаарын бохирдол, түгжэрэл, энэ үер усны аюул гэсэн ийм юман дээрээ гэдэг юм уу нэг үндэсний эрх ашиг хөндөгдөж байгаа юман дээрээ болбол улс төр хиймээргүй байгаа юм.

**Л.Мөнхбаатар:** 13 цаг болсон байна. Гэхдээ хэлэлцүүлгийг үргэлжлүүлээд явуулъя. Даргын зөвлөл хуралдана. Даргын зөвлөлийн гишүүд Улсын Их Хурлын даргын өрөөнд цуглахыг мэдэгдье. Та тодруулж асуух уу? Одонгийн Цогтгэрэл гишүүн тодруулж асууя.

**О.Цогтгэрэл:** Нямбаатар даргаа та чинь одоо тэгээд тэмээ гэхээр ямаа гээд хаа байсан тэр Содон хороолол руу яваад байгаа. Харин тэр Содон хороолол чинь Улаанбаатар хотын төвөөс хамгийн хол зайд ямарваа нэгэн төрийн төсвийн янз бүрийн дэмжлэггүйгээр, дахин төлөвлөлт элдэв зүйлд нь оролгүйгээр 3 мянган айл орон сууцтай болсон нь хамгийн бизнесийн зарчмаар явсан сайн төсөл. Гэхдээ таны ярьж байгаагаар Содон хороолол руу зам тавина гээд, нэмэлт зам тавина гээд тэнд байгаа иргэдийг трактороор дайрна гэдгийг чинь л би ойлгохгүй байна даа. Тэнд байгаа иргэдийн хашаа байшинг буулгах юм байна л даа. Үгүй ээ тэрийг чинь ямар нэгэн аргаар та нарын энэ яг хэлж байгаа

энэ арга зам чинь яалт ч үгүй л Үндсэн хууль л зөрчинө. Энэ захиргааны арга зам чинь.

Нөгөө талаасаа тэр 27 мянгаар ямаршуу санд хэчнээн тэрбум төгрөг яаж цуглах гээд байгаа юм бэ? Энэ тооцоо үндэслэл 27 мянга гэдэг чинь яаж ч бодсон дундаж цалинтай иргэний хотын төвд ажилладаг иргэний бараг сая гаруй төгрөгөө төлөх юм байна л даа тэр иргэний. Тэгэхээр энэ.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Цогтгэрэл гишүүний тодруулгад хариулъя. НЗД Нямбаатар.

**Х.Нямбаатар:** Сая Даваасүрэн гишүүн уг нь аягүй тодорхой хэллээ л дээ сайд. Энэ хэдүүлээ үндэсний эрх ашиг, энэ хүн амын эрүүл аюулгүй орчинд амьдрах ноцтой эрх зөрчигдөж байгаа ийм суурь асуудлуудаар улс төржилт хиймээргүй л байгаа юм. 27 мянга гэдэг тоог танай намынхан л гаргаж ирсэн шүү дээ. Энд ерөөсөө ямар зохицуулалт байгаа вэ гэвэл төлбөртэй бүс тогтоох тэр журмыг НИТХ тогтооно л гэж ийм зохицуулалт байгаа. Энэ та наад төсөл дээрээсээ олоод үзээрэй, 27 мянган төгрөгөөр төлбөртэй бүс дээр төлбөр авна гэсэн нэг ч тийм үг байхгүй. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тэр хязгаарт тогтоож төлбөр тогтоох энэ эрхийг НИТХ авна гэж байгаа юм. Тэгэхээр логикийн хувьд эхлээд бид нар нийтийн тээврийнхээ шинэчлэлийг энэ оны 1 дүгээр улиралдаа бүрэн хийж дуусгана. 2 дугаарт зам холбоос замуудыг ирэх оны 2 дугаар улиралд, 3 дугаар улиралд бид нар багтааж барьж дуусгана. Энэний дараа бид нар зогсоолуудынхаа менежментийг хийнэ. Энэний дараа НИТХ төлбөртэй бүс тогтоох эсэх асуудлаа шийднэ. Энэний энэтэй зэрэгцээд метро, тойрог хурдны замын ажлуудыг явуулна гэдэг л ийм л логик дараалалтай байгаа юм. Тийм 500 төгрөгөөр ч тогтоож болно, мянган төгрөгөөр ч тогтоож болно, 0-ээс гэж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ 27500 гэдэг тоо бол АН-ын өгсөн, нийгэмд өгч байгаа

тоо шүү. Иргэд сонгогчдод би хандаж хэлэхэд. 2 дугаарт тэр Содон хорооллын тэр хойд талаар явах 6 эгнээ замыг тэгээд одоо нэгэнт эхэлчихсэн ажлыг бид нар дуусгах юм уу дуусгахгүй юм уу? 9 айл, айл болгонд бид нар 19 тэрбум төгрөг өгөх ийм төсвийн боломж нийслэлийн төсөв дээр байхгүй. Тэгэхээр 65-аас дээш хувь нь нийслэлээс өгч байгаа жишиг үнэ, тэнд чинь жишиг үнэ нь 9 тэрбум байхгүй юу. Үндсэн хууль дээр чи өөрөө унш.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Улсын Их Хурлын гишүүн Наянтайн Ганибал асуултаа асууя.

**Н.Ганибал:** ЗГ ингээд яаралтай гээд нэг хууль оруулж ирээд тэгээд 1 хоногийн өмнө гишүүдэд өгчөөд, тэгээд өнөөдөр ингээд тэрэн дээрээ маргаан үүсгээд ингээд явж байгаа нь хүртэл жоохон харамсалтай байна. Үнэхээрийн нухацтай зайлиггүй ард олны иргэдийн хэлэлцүүлэг дээр хийгдэх ёстой хууль байсан бол уг нь зөв байх л даа. Энэ чинь олон нийтийн эрх ашгийг хөндсөн асуудал учраас олон нийтийн оролцоог л илүү оролцуулж байж энэ хууль өөрөө мөрдөгдөнө л дөө. Тэрнээс өнөөдөр ингээд яаралтайгаар оруулж ирээд, ингээд хуулийг бас уншлаа. Тэгээд 2 асуудлыг л хөндсөн байна. Авто тээврийн хөдөлгөөний асуудал, нөгөөдөх нь болохоороо орон сууцжуулах барилгажуулах асуудал гээд. Тэгээд энэ 2 хууль нь өөрөө энэ хуулийг хоёуланг нь заавал нэгтгэж оруулж ирээд, ингээд ийм маргаан үүсгээд байх шаардлага байгаа юм уу даа. Уг нь өөр өөрийнх нь асуудал дээр нь тэр тухай тухайн хууль дээр нь энэ асуудлуудаа оруулаад тэр Газрын тухай хуульд нь газрынх нь асуудлыг оруулаад, Авто тээврийнх нь тухай хуульд нь энэ тээврийнхээ зохицуулалтын асуудлыг ч юм уу оруулаад ингээд явсан бол энэ ямар нэгэн маргаан үүсгээд байх шаардлага байхгүй л дээ. Нэг асуудлыг яриад нөгөөдхийг ингээд үгүйсгээд ийм 2 асуудал болчихоод байгаа байхгүй юу. Нэг нь нөгөөдхөө үгүйсгэсэн ийм 2 асуудлыг

нийлүүлж оруулж ирээд ингээд хууль болгоод маргаан дэгдээхээр чинь энэ чинь ингээд явахгүй байна л даа.

Ер нь бид нар тэр төлбөртэй бүс гээд л яриад байх юм. Төлбөртэй бүс чинь тэр төлбөртэй бүс гэдэг чинь олон улсад байгаа л асуудал мөн. Гэхдээ ямар улс орнууд, ямар хотууд энийг хийж байна вэ гэхээрээ тэнд нийтийн тээврээ бүрэн шийдчихсэн, тэнд авто замынхаа хотын авто замын асуудлыг сүлжээгээ бүрэн шийдчихсэн ийм хотуудад л энэ төлбөртэй бүсийн асуудал яригдаад яригддаг юм шиг байна лээ ингээд хараад байхад. Тэгээд манайх чинь байгаа энэ зам дээрээ төлбөртэй бүс байгуулна гэдэг санаа оруулж ирж байгаа нь л өөрөө логикийн хувьд хамгийн буруу. Бид нар машин ачиж үзлээ. Янз тоо номероор нь хязгаарлалаа. Янз бүрийн аргууд хэрэглээд энэ чинь 1, 2 сар болоод болохгүй болоод байгааг бүгдээрээ харж байна шүү дээ. Харин та бүхэн маань ингээд оруулж ирэх асуудал маань хамгийн түрүүнд энэ тойрог замынхаа асуудлыг бүрэн шийдэх хэмжээний санхүүгийн асуудлуудыг шийдүүлэх дээр та хэд явсан бол бас илүү бодитой байх ёстой.

Социализмын үеийн бүтээн байгуулалт Улаанбаатар хотод анх байгуулагдахдаа Бага тойруу, Их тойруу гээд 2 тойрогтой байсан. Одоо бид нарт өөр тойрог алга байна шүү дээ. 3 дахь тойргоо ярь л даа, 4 дэх тойргоо ярь. 5 тойрогтоо Улаанбаатар хотод тэр төлбөртэй бүс байх уу янз бүрийн бүсчилсэн хөгжлийн асуудлыг ярьж болно. Одоо байгаа замууд дээр бид нар төлбөртэй бүс яриад бол болохгүй. Энэ чинь өөрөө тэр замын урт гэж байна, хүн амын тоо гэж байна, авто тээврийн хэрэгсэл гэж байна, тоо гэж байна, нийтийн тээвэр гээд энэ олон өгөгдлүүдийг чинь хамгийн зөв гарц нь тойрог замынхаа бүтцүүдийг бид нар бүрэн хийх ёстой. Цаашиаад метроны асуудал ярьж байгаа бол метрогоо бүрэн хийх ёстой. Ингэж явж байж бид нар өнөөдөр гаргалгаага ярина уу гэхээс

тэнд байгаа жижиг, жижиг асуудлыг шийдсэнээрээ том асуудлаа шийднэ гэж ойлгож байгаа бол эндүүрэл болоод байгаа юм.

2 дахь нь тэр барилгажуулалт. Гэр хорооллыг барилгажуулна гээд энэ нэр хүндийг хэн унагасан юм бэ? Энэ уг нь АН-ын үед Бат-Үүл дарга маань эхэлж байсан ажил. Энийг аль болохгүй болгоныг нь сэвсээр байгаад өнөөдөр Улаанбаатар хотыг та бүхэн маань ингээд 8 жил байна уу, бараг 12 жил удирдаж байгаа байх. Тэгээд хийсэн юм юу байгаа юм бэ? Тэрийг эхлүүлж байхад нь та нар улс төржихгүйгээр зөвийг нь ярьж байгаад асуудлынхаа ард гарсан бол өнөөдөр бид нар харин гэр хорооллын барилгажуулалтын асуудал маань нэр хүнд сайтай хийгдэж байх ажил байсан байх гэж бодож байгаа. Тэгэхээр энэ дээр энэ жижиг олон асуудлуудыг.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Асуултад НЗД Нямбаатар хариулъя.

**Х.Нямбаатар:** Ганибал гишүүний асуултад хариулъя. Яг харин та яг зөвлөл сэдэв хөндөөд байна. Бат-Үүл дарга газар чөлөөлөлтийн албан чөлөөлөлтийн журам гаргасан байхгүй юу. Нийслэлийн иргэдийн хурлаар батлуулсан юм. Тэгээд тэр нь хуульд ийм эрх хэмжээ заагаагүй байна гээд ҮХЦ дээр унасан байхгүй юу. Тийм учраас бид нар энэ ҮХЦ дээр унасан энэ асуудалд дүгнэлт хийгээд, хуульд газар чөлөөлөлттэй холбоотой харилцааг Үндсэн хуулийн 6.4-д нийцүүлж, нийгмийн зайлшгүй хэрэгцээ шаардлагаар хотын ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу газар чөлөөлөлтийг нөхөх олговрын нөхцөлтэйгөөр ийм чөлөөлөх ийм л харилцаа, эрхээ нийслэл өөрөө авъя гэж л энэ хуулийг оруулж ирж байгаа.

Би зүгээр Ганибал гишүүнд нэг юм хэлэхэд хэдүүлээ энэ нөгөө утаа, түгжрэлтэй холбоотой асуудал дээр нам яриад, манай нам, танай нам тэр, тэр

дарга маань, энэ дарга маань гэдэг ийм жижигхэн зүйл яримааргүй байна. Би түрүүн хэлсэн шүү дээ сонгууль ийм ойртчихсон үед бид нар яг энэ тулгамдсан 2 асуудлыг бид нар сонгуулийн мөчлөг болгон дээр иргэдэд таалагдахын тулд явсан бодлогоосоо татгалзаж хэдүүлээ энийг зоригтой шийдье, өөрчилье гэдэг дээр л хэдүүлээ хамтдаа урагшаа харж л явмаар байгаа юм. Тэрнээс би сонгууль дөхсөн дээр ингээд нэг тийм энд тэнд тууз хайчлаад, энд тэнд барилга байшин нураагаад ийм зүйл хиймээргүй байна. Яг үндсэндээ бид нар асуудлынхаа голыг барьж аваад, ойрын хугацаанд бид нар яг юу хийх юм, алс хэтдээ ямар үр дүнгүүд гарах юм гэдэг ийм тооцоо судалгаатай ажлуудыг л хийхийн тулд дутагдаж байгаа энэ эрх зүйн орчнуудаа л оруулж ирсэн гэдгийг би танд хэлье.

Зүгээр юуны нийслэлийн таны саяын хэлж байгаа тэр тойрог хурдны замтай асуудал дээр бид нар удахгүй 12 сард хэлэлцээр дуусвал Улсын Их Хурал дээр тойрог замыг бид нар ийм санхүүгийн instrument ашиглаж барихаар байна, энэ дээрээ Их Хурал хотод зөвшөөрлөө өгөөч гэдэг Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулж орж ирэх гэж байгаа гэдгийг бас өөрт чинь хэлье.

**Л.Мөнхбаатар:** Яах юм бэ, тодруулах юм уу? Наянтайн Ганибал гишүүн тодруулж асууя.

**Н.Ганибал:** Улс төржихгүйгээр асуудлаа шийдэж байвал сайн л даа. Тэгээд хамгийн гол нь бид нар зовлон гэдгийг юун дээр үзээд байна вэ гэхээрээ хийж байгаа, гаргаж байгаа шийдлүүд маань эргээд яг ард иргэддээ бодит амьдрал дээр яг бид нарын хүсээд байгаа шийдэл болж чадаж байна уу гэдэг л хамгийн чухал асуудал л даа. Тэгээд энэ дээрээ бас ингээд энийг хийхийн тулд гэж байгаад бас Үндсэн хуулиа юу зөрчих юм уу, хүний эрх рүү халдах, бас нөгөө төлбөртэй бус ингээд тийм төлбөртэй өндөр төлбөртэй амьдралтай нэг хэсэг бүлэг хүмүүсийг бий болгох. Түрүүн бас

Цогтгэрэл гишүүн асуугаад байна л даа. Тэр Төрийн болон орон нутгийн өмчөөр нөгөө бараа, бүтээгдэхүүн худалдан авах тухай хууль дээр 34.1-ийн 14, 15, 16 гээд нэмчихсэн байв уу даа. Тэнд автомашин, тоног төхөөрөмж гээд байна лээ шүү. Тэр дулааны шугам сүлжээ сүлжээ нь ч байна, бас машин тоног төхөөрөмж гээд байна лээ. Та тэрийгээ, тэрийгээ тэгвэл цас цэвэрлэдэг ч гэдэг юм уу тодорхой томъёоллоор нь бас оруулж.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Санал юм биш үү дээ. Энэ хэлэлцэх эсэхийг нь шийдэж байгаа шүү дээ. Ингээд анхны хэлэлцүүлгүүд яваад ирэхээр ажлын хэсэг байгуулагдаад түүн дээрээ сайн ярья. Балжиннямын Баярсайхан гишүүн асуултаа асууя.

**Б.Баярсайхан:** Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод жилд дунджаар 40 гаруй мянган иргэн шинээр бүртгэгдэж байгаа бол сүүлийн 3 жилийн байдлаар жилд дунджаар 47 мянган тээврийн хэрэгсэл бүртгэгдэж байгаа нь нэг жилд Улаанбаатар хотод импортоор орж ирж байгаа машины тоо шинээр бүртгэгдэж байгаа иргэдээсээ даруй 7 мянгаар их байгаа нь түгжрэл жил ирэх тусам нэмэгдсээр байгаатай холбоотой гэсэн ийм зүйлийг уншиж байна. Энэ дээр хамгийн гол шийдэл нь Нямбаатар сайдаа ерөөсөө хотод түгжрэлийг бууруулья гэвэл хөдөө орон нутгаа сэргээх ёстой, хөдөө орон нутгаа хөгжүүлэх ёстой гэдэг дээр та санал нэгтэй байна уу? Та Хууль зүйн сайд, Улсын Их Хурлын гишүүнээр ажилласан туршилагатай парламентчдын хувьд НЗД-аар томилогдсоноосоо хойш зөвхөн нийслэлийн биш нийслэлийн асуудлыг шийдэхийн хажуугаар хөдөөгийн хөгжилд санаа тавих ёстой, энэ хөгжилд анхаарах ёстой гэдэгтэй та санал нийлэх үү?

Өнөөдөр хөдөө орон нутагт хэрвээ сэргэлт ирэх юм болбол хотын түгжрээ, хотын утаанд амьдраад байх сонирхолтой залуусын тоо бол багасаж

байна гэж харж байна. Жишээлбэл Завхан аймаг руу ингээд зам гэхээр зам нь төсөвт суугддаггүй, нислэг үйлдье гэхээр нислэг нь явж өгдөггүй ийм байхад яаж орон нутгаа зорих юм бэ. Тэгээд энэ хөдөө орон нутаг ялгавартай хөгжиж байгаа асуудал дээр та бас Их Хурлын гишүүний хувиар анхаарах шаардлагатай. Энэ нь таны хотын төвлөрлийг сааруулахад бол ахиц дэвшил гаргана гэж ингэж харж байна. Энэ дээр таны санаа оноог сонсьё.

3 дугаарт бол энэ салбар болгонд манай салбар болгонд энэ нүүрлэсэн авлига гэдэг бол хотод бол үнэхээр цэцэглэсэн, хөгжсөн. Төлөвлөлт, зарчим сахилга бат гэж байдаггүй учраас нийслэл хот бол хамгийн их авлигатай ийм газар гэж ингэж хардаг шүү. Тийм учраас та энэ нийслэл дээр байгаа авлигын асуудлыг шийдэх, энэ дээр байгаа энэ хүний нөөцөө ёс зүйжүүлэх тал дээр та яг юу хийж байна вэ? Энэ асуудал шийдэгдэх юм бол энэ түгжрэл, утаа зэрэг энэ асуудлууд бас багасах болно гэж ингэж боддог.

Энэ миний нэг маш гайхдаг зүйл. Жишээлбэл энэ Замын цагдаагаас урагшаа тавьсан шинэ гүүр байна. Машин явах гүүрийг нь тавьсан юм бол хажуугаар нь хүн алхах замыг нь тавьчихаж болдоггүй юм уу? Үнэхээр тэр Зайсангаас наашаагаа хот руу орж ирэхэд хүмүүс алхаад явах сонирхолтой байна. Өдөрт алхдаг болж байна. Гэтэл явган хүн явах ямар ч зай байхгүй. Тэгээд дайруулчих гээд ингээд явдаг нэг ийм асуудал байна. Тэгэхээр явган хүнийхээ замыг нэн түрүүн шийдэж өгөөч гэдэг асуудал байна.

Сүүлийн асуудал болбол энэ бүхэл бүтэн улс үндэстний нийслэл хот гэгдэж байгаа болбол нийслэлийн соёл бол үнэхээр зарим аймгийн соёлоос долоон дор болсон. Нийслэлийн иргэдийн энэ биеэ авч явах байдал ялангуяа замын хөдөлгөөнд оролцож байгаа асуудал болбол үнэхээр бүдүүлэг ийм байгаа. Тэгээд та энэ дээр та юу хийх гэж байна вэ? тухайлбал

жолооч нарыг бэлдэж байгаа энэ жолооны курс байна. Энэ жолооны курст жолоо барихыг нь заахаас гадна, бусдыг хүндэтгэх энэ зам тээврийн хөдөлгөөнд оролцож байхдаа бие биедээ хүндэтгэлтэй хандах, зам тавьж өгөх гэдгийг заадаг жолооны курс байна уу? Тэгээд энэ жолоочдын ухамсрыг дээшлүүлэх нь түгжрэлийг бууруулахад бас нэг чухал алхам гэж ингэж харж байна. Тийм учраас энэ миний асуусан энэ 4 асуултад та тодорхой байр сууриа илэрхийлээч гэж хүсэж байна. Баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Нямбаатар дарга хариулъя.

**Х.Нямбаатар:** Баярсайхан гишүүн 9 асуулт асуусан. Би яг энэ хугацаандаа амжуулаад хариулахыг хичээе. Импортыг хязгаарлахын тулд бид нар НИТХ нийслэлийн авто замын сүлжээний даацад тохирсон автомашины дугаар олголтын дээд хязгаарыг тогтооно гэдэг энэ эрхээ НИТХ авах гэж байгаа юм. НИТХ одоо байгаа 720 мянган машин, магадгүй энэ хууль батлагдаад хэрэгжиж эхлэх хугацаанд олголттойгоо юу гэдэг юм 740 мянган машин байна, энэнээс дээш дугаар олгохгүй гэвэл яг энэ тоондоо хэсэг хугацаанд авто замын сүлжээгээ өргөсгөх хүртэл хязгаарлах л ийм бодлого барина. Энэ тохиолдолд шинээр хүн автомашин авч болно. Энэ тохиолдолд өөрийнхөө хуучин автомашиныг устгах юм уу эсхүл хөдөө орон нутагт боломжтой нь зараад дугаараа зүүгээд шинэ машин авч болно. Эсхүл өөрөө цоо шинээр автомашин авъя гэвэл хэн нэг хүний хуучин автомашиныг худалдаж аваад, дугаарыг нь аваад мөн нөгөө автомашиныг нь хөдөө рүү явуулах уу эсхүл устгалд өгөх үү гэдэг байдлаар яахаар нөгөө тоо ерөөсөө 700 30 юм уу, 40 мянга гэдэг дээрээ л хөдлөхгүй байна гэсэн үг. Энэ бол бид нар ингээд нөгөө жил болгон орж ирж байгаа 50 мянган машины тэр урсгалыг ингээд тогтоон барих эхний алхам гэдэг утгаар тайлбарлая.

Та бид бүгдийн нөгөө 2050-д нийцүүлээд ЗГ Шинэ сэргэлтийн бодлого гэж гаргаж ирсэн. Үүнийг сүүлд 2021 оны 12 дугаар сард бас Их Хурлаар баталсан. Шинэ сэргэлтийн бодлогын 5 дахь том сэргэлт бол хот хөдөөгийн сэргэлт гэж байгаа. Хот хөдөөгийн сэргэлтийн зорилго бол яг л бидний ярьж байгаа энэ хөдөөгөөс хотоос хөдөө рүү амьдрах, шилжих тэр бүх боломжийг л дэмжих. Энэ утгаараа энэ оны 7 дугаар сард Улсын Их Хурал баталсан АХБ-ны 735 сая ам.долларын төсөл нь цэвэр хөдөө орон нутаг дахь барилга байгууламж барих дэд бүтцийн ийм төсөл удахгүй хэрэгжиж эхэлнэ. Одоо энэ нөгөө төслийн мэргэжилтнүүдээ сонгон шалгаруулах ажил энэ шатдаа явж байгаа. Дээр нь саяхны ЗГ-ын хуралдаан дээр нийт Монголбанк хэрэгжүүлж байгаа ипотекийнхээ зээлийн төслийн 50 хувийг хөдөө рүү, 60 хувийг хөдөөд олгох ийм бас шийдвэр лүү очсон.

Өөрөөр хэлбэл дэд бүтэц нь шийдэгдээд, барилгын компаниуд аймгийн төв, сумдын төвд орон сууц барьж байгаа тохиолдолд ипотекийн бодлогоор дэмжих, ингээд орон сууцын хүртээмж нэмэгдэхээр хөдөө рүү амьдрах энэ хандлагууд нэмэгдэнэ. Би бас Хууль зүйн яаманд ажиллаж байхад сая Архангай аймаг энэ тэрд очоод ажиллахад шинэ очсон алба хаагчид тэгж байсан. Бид нар энд бүүр ядаж түрээслэх ч байр олдоогүй, бүх аймгийн төвүүдэд түрээслэх байр олдохоо больчихсон. Тэгэхээр яах вэ гэхээр шинээр очиж томилогдож байгаа хүмүүс гэр бариад нөгөө амьдрахад маш төвөгтэй байна л гэдэг байгаа. Тэгэхээр бид нарын ерөөсөө хамгийн том юм бол хот хөдөөгийн бодлого. Би Улаанбаатар хотод ирээд яг өнөөдөр ажлын 16 дахь хоног дээрээ ажиллаж байна. Энэ хугацаанд яг үнэнийг хэлэхэд энэ.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Хариулт болсон уу? Яг гоё хариулж байсан чинь цаг дуусжээ. Гүйцээгээд хариулчихъя Нямбаатар дарга.

**Х.Нямбаатар:** Тийм зүгээр энэ би нэг ажлын 17, 8 хоног л ажиллаж байна. Тэгээд бид нар энэ хууль гаргаж ирэх гээд үзлээ. Бүтцийн шинжилгээ, чиг үүргийн шинжилгээ, мандатын шинжилгээ хийлээ. Хариуцлага алдсан хүмүүсийг шалгуулахаар өглөө. Зүгээр нэг талдаа их л муухай байна. Газрын албаны бараг 9 албан хаагч АТГ дээр шалгагдаж байна. БХБ-ын олон хүмүүс бас шалгагдаж байна. Нийтийн тээвэр, өмчийн харилцааны хүмүүсийг бас шалгуулах ажлууд явагдаж байна. Энэ нэг талдаа би дандаа л урьд нь мэддэг, таньдаг, цуг ажиллаж байсан хүмүүс. Тэгэхээр бид нар энэ өмнөх бүх л алдаа завхралаа энд хэдүүлээ цэг тавья. Тийм учраас энэ оруулж ирж байгаа хуулиар дүүргийн газрын албыг бүүр огт газар олгохоо больё. Худалдан авах ажиллагааны үйл ажиллагааны яг нөгөө ...баримт, бичиг баримт боловсруулах хэсгийг Худалдаа аж үйлдвэрийн танхим мэт мэргэжлийн холбоодод шилжүүлж өгье гээд л энэ нөгөө авлига байдаг бүх цэгүүдийг л бид нар энэ хуулиар таслан зогсооё, хүмүүстэйгээ хариуцлага бас нэг хүний өөрийнгүй тооцъё л гэж байгаа.

Явган хүний замын стандартыг одоо шинэчилж тогтооно. Сайнзориг дарга хариуцахаар явж байгаа. Хотын соёл дээр бид нар Номинчимэг дарга хотын соёлын арга хэмжээ бас ахалж байгаа. Удахгүй энэ ондоо багтаад бид нар бүх гэрлэн дохио харанхуй цэгүүдийг нөгөө сая 11 дүгээр хороололд нэг ийм лазер уулзваруудыг хийсэн байгаа биз. Яг энийг бид нар энэ ондоо багтаагаад л хийе. Хотын соёл нэвтрүүлэх тал дээр хэд хэдэн ажлуудыг хийе гээд явж байна. Зүгээр би дараа нь Баярсайхан гишүүн бид 2 яг энэ чиглэлээр их тийм нөгөө санал нэгддэг хүмүүс учраас бид хэд танаас бас хэд хэдэн саналууд авъя.

Энэ жолооны, жолооны нөгөө жолоочдын ухамсар соёлыг нэмэгдүүлэх тал дээр хот энэ жолооны курсүүдтэй бас гэрээ байгуулж ажиллаж гэдэг ийм хэд

хэдэн зүйлүүд байгаа. Таны тэр хөндөж байгаа тэр авлигатай тэмцэх чиглэлээр хот дээр бол бид нар бас нэг тодорхой өөрчлөлтүүд гарна гэдэгт та бүхэн итгэлтэй байж болно. Энэ нөгөө зөвшөөрөл лицензийн тогтолцоог илүү боловсронгуй болгоё, цахимаар илүү олголтууд өгье.

**Л.Мөнхбаатар:** МАН-ын бүлгийн дэд дарга Мөнхөөгийн Оюунчимэг асуулт асууя.

**М.Оюунчимэг:** Би нөгөө Өргөдлийн байнгын хорооны даргаар ажиллаж байхдаа Улаанбаатар хотын утаанд ийм их 600, 700 тэрбум төгрөг гараад зарцуулчихаад, тэгээд цогцоор нь шийднэ гэхээд буурах биш бүүр гамшигийн түвшинд хүрсэн ямар учиртай байдаг юм бол гээд аудит аудиттай нийлж байгаад нийцлийн аудит энэ тэр хийлгэж үзсэн чинь үнэндээ манай зарим улс төрчид, дарга нар, улс төрийн намууд энэ Улаанбаатарын утааг шийдэх, түгжрэлийг шийдэх, хөрсний бохирдлыг шийдэх сонирхол байхгүй нь тэндээс бол тодорхой харагдаж байсан л даа. Тэгээд л улс төржөөд л одоо ингээд л аль болохоор зогсоочихдог. Ингэж энэний хохирлыг нь хэн амсаж байна вэ гэхээр ард иргэд амсаж байна. Хэдэн жил болоогүй 20, 30 жил гэр хорооллыг орон сууцжуулах, дэд бүтэцжүүлэх гээд тэгээд үе үеийн нийслэлийн удирдлага, төр засгийнхан баахан журам гаргадаг. Одоо энэ НИТХ-ын гэр хорооллыг барилгажуулах 30, 40 журам жишигээр би энд ингээд л хараад л сууж байна л даа. Тэгээд хэрэгжсэн нь бараг байхгүй. Бат-Үүл даргаас эхлээд л гаргасан журмууд байдаг юм. Жишээ нь манай ЧД-т хохирсон иргэд маш их. Яагаад гэвэл уг нь бол зөв юм эхлүүлсэн. Чингис бондоос асар их хөрөнгө мөнгө зарцуулсан. Нөгөө зохион байгуулалт нь төр, иргэн, компани гээд энэ гуравласан ажлуудаа ингээд яг цогцоор зохион байгуулалтаа хийгээгүйгээс болоод компани, иргэн 2 муудалцсаар байгаад одоо хэдхэн иргэн нөгөө түрээслээд өмчлөх түрээсийн

байранд байгаад, одоо түрээсийн мөнгөө ч төлж чадахгүй нэг газар нь байхгүй. Нөгөө компани нь нэг ч хүрз хөдөлгөөгүй хэдэн ч жил болчихов.

Тэгээд дараа нь бас л үе үеийн хотын дарга нар баахан журам гаргаад л, бүсчлээд л байсан, бас нэг их хэрэгжиж чадаагүй иргэд хохироод байгаа юм. Асар их хүлээлт байгаа. Тийм учраас би энэ Нямбаатар сайдыг яаралтай горимоор, гэхдээ цогцоор нь өмнө нь 2, 3 жил бас судалгаа мэргэжлийн багууд ажилласан энэ юмыг ингээд цаг алдалгүй оруулж ирээд байгаа учраас ингээд талархан дэмжээд байгаа юм. Яагаад гэвэл би жишээ нь ЧД-ээс сонгогдсон. Манай дүүргийн 70 орчим хувь нь гэр хороололд амьдардаг. Тэгээд энэ гэр хороололд амьдардаг иргэдийн тухай асуудал биш, агаар хөрсний бохирдол чинь өөрөө нийслэл Улаанбаатар хотын нэг номер, бүүр одоо бол хамгийн ноцтой асуудал болчихоод байгаа учраас л бид нар энийг яаралтай шийдэх хэрэгтэй байгаа юм. Тэрнээс одоо энд улс төржмөөргүй байна. Сонгуулийн өмнө бас дэндүү галтай юм орж ирж байгаа гээд байгаа юм. Гэхдээ сонгуулиас сонгуулийн циклийн дунд амьдарч болохгүй. Тийм учраас энийг бол яаралтай хийх ёстой гэсэн байр суурьтай байгаа. Тэгээд би Нямбаатар сайдыг энэ хуулийг бид бол яаралтай батлах байх гэж бодож байгаа. Тэрэн дээр ч уриалж байна.

Тэгээд Сэлбэ дэд төвийг түшиглээд 12 мянган айл өрхийг Чингэлтэй, Сүхбаатар ингээд оруулах ажлыг шуурхайлан хийгээрэй. Тантай энэ дээр үнэхээр хамтарч ажиллана шүү. Нөгөө талаасаа энэ 2017 оноос хойш яг л энэ Телевиз орчмын гэр хорооллыг дэд бүтэцжүүлэх ажлыг бид нар бас хамтдаа та ч өөрөө Улсын Их Хурлын гишүүн байсан СХД-ээс бид нар энийг яаралтай хийх ёстой гээд 40 тэрбум төгрөгийн цэвэр, бохир усны хоолой татчихсан байгаа. Энэ өөрөө ЧД-ийн гэр хорооллын бараг 40-хөн хувьд нь байгаа. Энийг энэ дээр барилга байшингаа яг сая

таны энэ оруулж ирж байгаагаар 5 давхраас дээшгүй байшин барилга байх уу, зарим нь хашаанд нь хаус болгох уу эсвэл айлуудыг нь нүүлгээд дараа нь нөгөө түрээслээд өмчлөх гээд бас ийм зүйлүүд рүү цаг алдалгүй ингээд оруулаад, ажлыг зэрэгцүүлээд ингээд явах нь өөрөө их чухал байгаа. Та энэ дээр бас надад тодорхой хариулт өгөөч.

Бид нар бас 300 айлын дунд сервис центр буюу дэд төв гээд ЧД-ийн 7 дугаар хороо одоогийн 20 дугаар хороонд хэрэгжүүлсэн, үр дүнгээ өгч байгаа. Тэр айлын газрууд газрын үнэ бусад гэр хорооллын газрын үнэтэй харьцуулахад бараг 5, 10 дахин нэмэгдчихсэн. Тэгээд хашаандаа айлууд нь бүүр зүлэг ногоо, тэр ногоон байгууламж, хүлэмж гээд маш гоё болсон. Зарим нь бас тэр газраа зараад компаниуд тэрийг нь аваад өөр зүйл болгоод ингээд явчихсан тал ч байгаа. Гэхдээ гэр хорооллын энэ айл өрхүүдийг орон сууцжуулахад бас нөгөө нэг СӨХ гэж байгаа шиг, ГӨӨХ гэдэг юм уу бас тийм нэг зохион байгуулалтын юмнууд өөрөө маш чухал байгаа. Энэ нь өөрөө энэ хуулийг дагаад энэ хуультайгаа цуг.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** НЗД Нямбаатар хариулъя.

**Х.Нямбаатар:** Бид хэд энэ Оюунчимэг гишүүний асуусан асуултын би сүүлийнхээс нь эхэлж хариулъя. Энэ СӨХ-н тухай хуулийг бид нар шинэчлэх ажил эхэлж байгаа. Энэ нөгөө өнгөрсөн хугацаанд бас СӨХ-н эрх зүйн зохицуулалт бас төдийлөн үр дүнтэй биш, Сууц өмчлөгчдийн холбоо өөрийн хуримтлал үүсгэж чадаагүй, дандаа татвар төлөгчдийн мөнгөөр лифт, фасад, нийтийн эзэмшлийн зүйлүүдийг засдаг ийм л байдалтай явж ирж байгаа юм. Тэгэхээр энийг жосоохон илүү боловсронгуй болгоё, тэгээд гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд бас шинэ ийм бодлого руу бид нар явж байгаа. Энэтэй холбоотой манай хуулийн бодлогын ахлах зөвлөх Цолмон энэ СӨХ-н

тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ийм ажлын хэсгийг ахлаад явж байгаа. Тэгээд энэ дээр би танд жичдээ мэдээлэл өгнө.

Яах вэ бид нарын энэ өнгөрсөн бараг 2 мянгаад оны эхэн үеэс эхэлж ер нь гэр хорооллыг орон сууцжуулья гэж үе үеийн Засаг дарга нар бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө гаргасан юм байна лээ. Тэгэхээр энэ дэлгэц дээр харагдаж байгаа бол ЧД, СБД-ийн нутгийг дамнасан нэг нийтдээ бараг 900 орчим га газар, хойд тал нь 7 буудлын дээрээс эхлээд доошоо 32-ын тойрог хүртэл ЧД-ийн Хайлааст, Дэнжийн мянга, СБД-ийн 7 буудал, 6 буудал, 5 буудал тэгээд бүр урагшаагаа юу 32-ын тойрог хүртэлх энэ нутаг дэвсгэр дээр бид нар 3 үе шаттай эхний энэ төлөвлөлтийг хийж байгаа юм. Эхний ээлжид энэ хууль батлагдвал энэ хуулийн эрх зүйн орчны хүрээнд 158 га дээр байгаа 2 мянган айлын газар чөлөөлөлтийг хуульд заасан арга хэрэгслээр түр нүүлгэн шилжүүлэх юм уу, нөхөн олговортойгоор солино. 158 га дээр бид нар 12 мянган айлын орон сууц барина. Ингээд өмнөх 2 мянган айлыг буцааж нүүлгэж оруулахаар цаана нь 10 мянган айлын орон сууц бэлэн байна. Тэр байран дээр Чингэлтэйн Хайлааст Чингэлтэй, Дэнжийн мянга, 5 буудал орчмын айл өрхүүд мөн Дарь-Эхийн замын баруун талын тэр гол дагуух айлуудыг ингээд нүүлгэж оруулахаар 10 мянган айл орж байгаа юм. Ингээд нийтдээ 12 мянган айл бол нөхөх олговортойгоор ингээд байрандаа орчихно. Тэр замын зүүн талын тэр цэнхэр Сэлбэ орчмыг ингээд усан сан үүсгэж байгаа энэ орчмыг бол ерөөсөө орон сууцжуулахгүй ийм цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламж байдлаар нь төлөвлөнө. Тэр зургийн гол хэсэгт байгаа ногооруулсан хэсэг дээр 700 га газар дээр үндсэндээ 50 мянга орчим айлын орчин үеийн орон сууцын хороолол байгуулах ийм 2 дахь үе шаттай төсөл хэрэгжихээр байгаа.

Бид нар тэгээд санхүүгийн эх үүсвэр моделийнхоо эхний 25 хувийн

санхүүжилтээ бэлэн болгочоод байгаа юм. Одоо бид нар энэ нөгөө үлдсэн 75 дээрээ ТЭЗҮ, зураг төсөв гаргах энэ ажлуудаа хийгээд бонд green бонд босгох ийм.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Тодруулах уу? Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн тодруулж асууя.

**М.Оюунчимэг:** Богино хугацаанд бас шуурхай ажлуудыг ингээд бодитой зурагтай харуулаад ингээд явж байгаа нь иргэдэд маш их итгэл төрүүлж байна. Тийм учраас л Улсын Их Хурал ч гэсэн энэ дээр бол дэмжиж байгаа. Тэгээд сая таныг хэлж байна, бас нэг зүйл байгаад байгаа юм. Сая танд бол энэ одоо нийслэлийнхэнд бас хүндрэлтэй юм үүсэж магадгүй гэдэг нь нөгөө доор инженерийн хэсэгчилсэн дэд төв татсан газруудад мөнгөтэй яам тамгын газрууд бас ингээд байшингууд бариад ажилчдын орон сууц гээд бүүр ингээд бариад эхэлчихсэн. Энэ нь өөрөө дахиад яагаад. Гэтэл нөгөө иргэд нь өөрөө бид нар энд орон сууц манайх хашаандаа хаус бариад амьдармаар байна эсвэл түрээслээд өмчлөх сонирхол нь өөрөө 64 хувьтай энэ тэр ингээд яваад байгаа. Тэгэхээр нөгөө 1-д газрын маргаан, 2-т тэр санхүүжилт 3-д одоо энэ бид цогцоор явж байтал хажуугаар нь манай 9 дүгээр хороо, 11 дүгээр хороо, 10 дугаар хороонд тийм ажилчдын орон сууц энэ тэр гээд бүүр цогцоороо бас яваад байлаа. Маш хурдтай мөнгөтэй газруудынх нь. Тэгэхээр энэ тэр дээр бас арга хэмжээ бас аваад иргэдийг хохироохгүй байх, яг л тэр гэр.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Тодруулчихсан, болчихсон. Хариулах юм уу тийм ээ? Ерөнхийдөө санал хэлээд байна даа. Нямбаатар дарга хариулъя.

**Х.Нямбаатар:** Энэ АХБ-аас явуулсан судалгаагаар энэ гэр хорооллыг дахин төлөвлөх явцад зөвхөн орон сууц бариад газрыг, газрыг нь орон сууцаар солиод бас тийм төгс шийдэл биш юм.



Ядуурлын олон хэмжээст үзүүлэлтийг шалгуур болгож тухайн тэр орон сууцжих хорооллынх нь бүсэд нь ажлын байрууд, төрийн байгууллагууд, эрүүл мэндийн байгууллагууд, соёлын байгууллагууд, боловсролын байгууллагууд мөн хүнсний томоохон цэг салбаруудыг байгуулж, ажлын байр, өрхийн орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр ийм цогц төсөл хэрэгжүүлэх ёстой гэдэг анх агуулгаар 2015 онд эхэлсэн юм. Тэгэхээр бид нарын өнөөдөр энэ хэрэгжүүлэх гэж байгаа концепт бол яг энэ ADB-ийн зөвлөсөн зөвлөмжийн дагуу орон сууцын, нөгөө талаасаа нийгмийн бүхий л асуудлуудыг шийдсэн, эдийн засгийн таталцыг бий болгосон, Улаанбаатар хотын Их, Бага тойруу доторх нягтарилыг задалсан, төвлөрлийг задалсан ийм цогц төслийг л хэрэгжүүлэхээр энэ удаагийн энэ хуулийн төслийг оруулж ирж, өргөн барьж байгаа гэдгийг бас танд товчхондоо хариулъя. Тэгээд дараа нь би бас танд дэлгэрэнгүй мэдээллийг өгнө.

**Л.Мөнхбаатар:** Тогмидын Доржханд гишүүн асуултаа асууя.

**Т.Доржханд:** Баярлалаа. Манайх чинь парламентын засаглалтай. Тэгээд парламент дээр хотын дарга нь анх удаагаа бас хууль барьж оруулж ирж байна шинээр. Юу хэлэх гээд байна вэ гээд тэгэхээр хотын дарга оруулж ирж байгаа бол Их Хуралд бас хүндэтгэлтэй хандах ёстой байх. Тэгээд би бас сая нэлээн харлаа ярилцлага, хэлэлцүүлгүүдийг. Тэгэхээр нөгөө Их Хурлын гишүүн байсан хүний хувьд бас энийгээ бас сайн мэдэж байгаа байлгүй дээ. Тэгэхээр нөгөө хотын даргынхаа байр сууриас илүү нөгөө мэргэжлийн байдлаар, тэгээд хотын даргынхаа түвшинд бас ингээд цаашаагаа Их Хурлын гишүүдтэйгээ харьцаж мэдээлэл өгч явах нь зүйтэй байх. Нэг ийм мэдрэмж төрөөд байна шүү.

Тэгээд 2 дахь нь болохоор энэ Баярсайхан гишүүн шиг сайхан яриад өгөөрэй гэдэг шиг хотын даргаа нэг

сайхан яриад өг дөө. Энэ нэг эдийн засгийн асуудлаар ингээд хотын асуудлыг шийднэ гэдгийг би бол дэмжээд байгаа юм. Тухайлбал нас урттай, хуучин ийм машинуудын импортын татварыг нь бол хязгаарлана гэдэг бол зөв өө зөв. Зөв л бодлого. Харин тэр нөгөө хотын төвийн татвар тавина гэж байгаад бол би бас эргэлзэж байгаа эдийн засагч хүний хувьд бол. Англид Лондонд бол congestion fee гэж бол байдаг. Тэр чинь тойрог замаар явдаг, манайд тэр нь байна уу, байхгүй байна уу, хэзээ вэ гэдэг асуудал гарч ирэх байх. Харин тэрний оронд нөгөө зогсоолуудыг төлбөртэй болгох асуудлыг бол яаралтай л хийх хэрэгтэй. Тэгээд зогсоол гэхэд л яамдын үүдэнд дарга нар нь машинаа тавиад л бөглөчихдөг. Тэгээд худалдааны төвүүд дэлгүүр гээд л тэгэхээр худалдагч нар нь машинаараа тавиад л бөглөчихдөг. Тэгээд 1 дүгээр эгнээг блокчлохдог нэг ийм байдлыг бол хязгаарлах хэрэгтэй шүү дээ. Тэгээд зах зээлийн системд нь оруулаад тэр parking fee-г нь зогсоолын төлбөрийг нь бол харин аваад, тэгээд торгодог механизм энэ зүйлийг бол энэ бол олон улсын бүх хотуудад байдаг зүйл. Яг ийм байдлаар явах нь бол зүйтэй байна. Зүгээр би нэг саналаа хэлж байгаа шүү.

Асуулт байна. Тэр нь юу вэ гээд тэгэхээр энэ хууль дотор чинь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг өөрчлөх тухай гээд. Тэгээд үүн дотор болохоор шууд гэрээ байгуулна. Шууд гэрээ байгуулахдаа 1 дүгээрт нийслэл хотын хот тохижилт, авто зам, халаалт, цэвэр, бохир усны шугам, үерийн далан сувгийн засвар, ачилгаа, хог хаягдалтай холбоотой бараа, ажил үйлчилгээг худалдан авах тохиолдолд шууд гэрээ байгуулна. Үгүй ээ энэ чинь Улаанбаатар хотын бүх ажлыг бүгдийг нь шууд гэрээгээр байгуулахаар ийм юм ороод ирлээ шүү дээ.

2 дахь нь 34.1.14 нийслэл хотод шаардлагатай машин техник, тоног төхөөрөмж, бараа материалыг

санхүүгийн түрээс лизингээр худалдан авах тохиолдолд шууд гэрээ байгуулна гээд. Би бас энийг ойлгохгүй байна л даа. Санхүүгийн хүн. Тэгээд санхүүгийн лизинг чинь бол урт хугацаагаар байдаг. Тэгээд та бол ингээд төсөв ингээд захиран зарцуулагч, төсөв чинь нэг жилээр байдаг. Гэтэл та ирээдүйн Засаг дарга нарын өмнөөс өнөөдөр шийдвэр гаргаад, тэгээд тоног төхөөрөмж авах гээд байна шүү дээ. Тэгээд тоног төхөөрөмж чинь тухайлбал автобус орно шүү дээ жишээ нь. Тэгэхээр энэ агуулгын хувьд, санхүүгийн техникийн хувьд бол энэ буруу болчихоод байна тийм. Өөрөөр хэлэх юм бол өр үйлдвэрлэдэг ийм л байдал руу орлоо шүү дээ. Одоо үе үеийн л Засгийн газрууд өр үйлдвэрлээд л, өрөө нэмээд л, дараагийн Засгийн газрууд нь ажил хийсэн болохын тулд бас өрөө нэмсээр байгаад л өнөөдрийн зовлон энэ шүү дээ. Дэлхийн түүхүүд бол энэ байдаг.

Гэтэл хотын дарга нар чинь ар араасаа дахиад л бөөн өр өрийн сүлжээнд ороод л тэгээд л яаж ийж байгаад сонгуульдаа бэлдэнэ гэж дахиж өр үүсгээд байдаг ийм өрийн чөтгөрийн тойрог руу хотыг оруулах ийм эрсдэл байна гэж харж байна. Энэ дээр бол Хотын дарга анхаарах хэрэгтэй. Тэгээд би нэг зүйлийг хэлчихмээр байгаа юм. Ер нь бол ингээд бүх зүйлийг шууд худалдан авалт хийх юм бол тэгвэл Худалдан авах ажиллагааны тухай хуулиа больчих л доо. 2000 онд би энэ хуулийг хийж байсан, хийлцэж байсан хүн нь, бүх юмыг нь орчуулж байсан, бичиг баримтыг нь. Тэгээд бүгдээрээ л цавчаа байсан шүү дээ. Бүгдээрээ шууд гэрээ байсан шүү дээ. Эрдэнэт дээр бүтэн жилийн.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Асуултад хариулъя. НЗД Нямбаатар хариулъя.

**Х.Нямбаатар:** Сая энэ хуулийн төслийн танилцуулга болон хууль санаачлагчийн илтгэлийг таны их дотнын найз Хэрэг эрхлэх газрын дарга танилцуулсан гэдгийг би бас та нөгөө

хоцорч орж ирсэн учраас анзаараагүй байх. Би ажлын хэсгийн гишүүний хувиар хариулт өгч байгаа. 2 дугаарт би ажлын хэсгийн гишүүний хувьд Улсын Их Хурлын гишүүдийн асууж байгаа асуултад хариулт өгөх тэр хүрээ хязгаараа би хуульд заасан тэр хүрээ хязгаарынхаа хүрээнд хариулна. Танаар бол би тэгж айхтар чиглүүлж заалгахгүй гэдгээ би хэлье. Би Их Хурлын гишүүдтэй хүндэтгэлтэй харьцана.

Зогсоол fee тэр бүсийн төлбөр юутай холбоотой юун дээр нийслэл зөвхөн эрхээ авъя л гэж байгаа юм. Нийслэл тэр таны хэлж байгаагаар замын тэр сангаа өргөжүүлсэн, зайлиггүй шаардлагатай гэж үзсэн тохиолдолд төлбөртэй бүс тогтоох эрхтэй байя л гэж байгаа юм. Тэрнээс биш энэ хууль батлагдаад маргааш төлбөртэй бүс тогтоох гэж байгаа зүйл ерөөсөө байхгүй. Та бас олон газраар явж байсан хүний хувьд их хотууд энэ том хотууд ерөөсөө ихэвчлэн хотын төвөө төлбөртэй бүс тогтоох замаар энэ түгжрэлтэйгээ тэмцдэг хамгийн 1 дүгээр арга хэрэгслийг авдаг. Энэ хуулийн төсөлд зогсоолын тэр төлбөр тогтоох бас журмууд нийслэл өөрөө энэ эрхээ авъя гэдгээр орж ирж байгаа.

Худалдан авалтын тухайд та энэ нөгөө нэг 2 хуулийн шилжилтийн юуг бас сайн ялгаж хараарай Доржханд гишүүнээ. Энэ шинэ баталсан Худалдан авах ажиллагааны хууль бол ирэх оны 1 дүгээр сарын 1-нээс эхэлж үйлчилж эхэлнэ. Бид нарын энэ хууль батлуулах гэж байгаа хууль хэрэв 12 сарын 1-нээс өмнө батлагдаж үйлчилж эхлэх юм бол бид нар нэн шаардлагатай байгаа нөгөө гараар давс цацдаг, гараар нөгөө хүрздэж бодис цацдаг, нөгөө эргэлт эргэх явцдаа нөгөө өнхрөөд унадаг тоос сорогч энэ тэрээ өөрчилье, богино хугацаанд бид нар хот тохижилтын газарт нэн шаардлагатай байгаа тоног төхөөрөмжүүдийг худалдаж авъя гээд ийм нэг ийм л нэг удаагийн үйлчлэлтэй хуулийг оруулж ирж байгаа. Олон удаагийн үйлчлэлтэй Худалдан авалтын

хууль бол зөвхөн инженерийн шугам сүлжээ задарсан тохиолдолд, цахилгаан шугам сүлжээ гэнэт тасарсан тохиолдолд, яаралтай энэ гамшиг осол тохиолдож далан суваг шуудуу сэтэрсэн тохиолдолд бид нар онцгой нөхцөл байдалд шууд худалдан авалт хийе гэдэг л ийм зүйл яаж байгаа. Та хэт өргөжүүлж ойлгож байгаа бол энэ дээр ажлын хэсэг дээр та бүхэн хэлэлцэх эсэх шийдэгдсэний дараа үүнийг хумьж, яг саяын миний хэлсэн утга агуулгаар зарчмын зөрүүтэй санал гаргаж болох байх гэж би бодож байна.

**Л.Мөнхбаатар:** Тогмидын Доржханд гишүүн тодруулж асууя.

**Т.Доржханд:** Би хэнтэй яаж найзлах, нөхөрлөх, юу ярих нь бол танд хамаагүй. 2 дугаарт би Их Хурлын гишүүний хувьд үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх бүрэн эрхтэй. Тэрэнд бол та нөлөөлөх боломжгүй. Би таныг хотын даргын хувиар асуудлаа ярь гэж байгаа болохоос биш Хууль зүйн сайд байсан юм шиг, Улсын Их Хурлын гишүүнээр олон сонгогдсон хүн шиг энд Их Хурлын танхимд орж ирээд ялангуяа сөрөг хүчний гишүүдэд хандаж байгаа хандлага чинь таалагдахгүй байна шүү Нямбаатараа нэг. Энийг би анхааруулж хэлж байгаа шүү.

2 дугаарт Худалдан авах ажиллагааны хууль чинь 3 л зүйл дээр шууд гэрээ байгуулдаг юм. Олон улсын жишиг нь тэр юм. 1 дүгээрт болохлоор форс мажор. Тэрийг чинь байгалийн гамшиг, онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд. 2 дугаарт бол үндэсний аюулгүй байдалтай холбоотой асуудал. Гуравт нь бол оюуны өмчийн патенттай тохиолдолд, бусад тохиолдол бол байдаггүй байхгүй юу. Одоо бүх зүйлийг шууд, шууд, шууд гэрээ гэсээр байгаад нууцалж байгаад цавчаа ногоон гээд л, тэгээд 18 их наядын оффтейк гэрээ гээд бөөн хулгай болоод байгаа биз дээ. Тэгээд Хууль зүйн сайд юм бол энэ хуулиа мэдэж

байгаа бол яг энэ хүрээн дээр л ажил.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Үг хэллээ. Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж асуултаа асууя. Доржханд, Нямбаатар 2 наад хэрүүлээ боль. Пүрэвдорж гишүүн асуултаа асууя. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуултаа асууя.

**Б.Пүрэвдорж:** Үгүй ээ, миний, би чинь ер нь цагтаа тааруулаад үг хэлдэг.

**Л.Мөнхбаатар:** Пүрэвдорж гишүүний цагийг эхлүүлээрэй, шинээр өгчих тийм.

**Б.Пүрэвдорж:** Туул голыг сувагчлах тухай асуудлыг Сумъяабазар дарга ярьж байсан. Тэгэхээр ер нь бол Улаанбаатар хотын нийт суурьшлын газрын хэмжээ бол 3500 га байдаг юм байна. Тэгээд энэ Туул голыг сувагчлах юм болбол 1500-аас 2 мянган га гарна гэж тооцоод, тэндээ барилгажуулна, одоо тэгээд тэрийг би яг барилгажуулах гэж байсан юм уу аль эсвэл газрыг нь зарах гэж байсан юм уу яг тэр талаар би мэдэхгүй л дээ. Тэгэхээр яг энэ асуудал дээр та ямар, энэ Туул голыг сувагчлах асуудлаар ямар бодолтой байдаг юм бэ?

2 дугаарт нь жилд нэг 17-гоос 17 мянга орчим га юу орон сууц ашиглалтад ордог юм байна. Тэр хэрээр тэр 17 мянган хашаа хорогдож байгаа юу? Тэр талаар, өөрөөр хэлбэл Улаанбаатар хотын иргэд чинь л тэр орон сууцанд чинь ихэвчлэн орж байгаа. Яагаад гэвэл хөдөө орон нутгаас орж ирж байгаа хүмүүсийг заавал байртай байна гэж яагаад, тэр хэсэг нь нэг хэсэгтээ орж байгаа байх. Тэгэхээр 17 мянган байр ашиглалтад орж байхад тэр хэрээр үгүй юм гэхэд тэдэн хувиар юу байдаг юм хашаа багасгах, багасаж байгаа тэр тооцоолол чинь юу байгаа юм бэ? Хамгийн гол нь хашаагаа л багасгах л, багасгах нь бидний хувьд хамгийн чухал байгаа шүү дээ.

3 дугаарт нь өнөөх алдартай ногоон автобус байна. Энэ ногоон автобусан дээр чинь хэдхэн тэр нэг компанийн нөхдүүд ганц, хоёр доод талын гар хөлийн үзүүрт зарагддаг нөхдүүд чинь саатуулчихаад байгаа. Тэгээд бусад хүмүүс нь үлдэх юм уу? Энэ дээр мэдээж очоод бичиг баримт энэ тэр бүх зүйлтэй нь танилцсан байх. Энэ дээр ямар хариуцлага тооцох юм бэ, ямар, ямар албан тушаалтнууд энд холбогдолтой юм, холбогдолтой юм бэ? Тэгээд нэг одоо ингээд л хар даа, ард иргэдийн дургүйцээд байгаа юм чинь ерөөсөө л янз янзын хулгай зэлгий маш их байна. Түүн дээр хариуцлага тооцож байгаа юм ерөөсөө байхгүй байна. Тэгээд 1 хэдэн чапакууд барьж байгаад, тэд нарыгаа явуулж ард нь томчууд нь үлддэг гэдэг ийм зүйлийг л маш их ярьж байгаа шүү дээ.

Тэгээд 3 дугаарт нь тэр юуны 4 дүгээрт нь тэр ногоон автобусаа хүлээж авах юм уу? Тэр ногоон автобус чинь анхнаасаа хүмүүсийн дургүйцлийг хүргэчихсэн, тэр автобусанд бараг хүмүүс үйлчлүүлээд нэг их явах ч үгүй байх. Тэгээд ч уулаасаа тэр маш их тийм хатуу евро2 гээд бүх болохгүй бүтэхгүй бүх юмыг нь хийсэн тийм л автобус гэсэн. Мордохын хазгай болсон автобус. Тэрнийгээ хүлээж авах юм уу авахгүй юм уу? Тэнд хэдэн төгрөг зарцуулсан юм бэ, тэр мөнгөө яаж олж авах юм бэ?

Тэгээд дээрээс нь 5 дахь асуулт нь шинэ автобусаа хэзээ оруулж байгаа юм бэ, хэдний дотор, яг хэдний дотор гэдэг энэ асуултад хариулт авъя.

**Л.Мөнхбаатар:** Пүрэвдорж гишүүн тодорхой хэдэн асуулт асуулаа. Энд НЗД Нямбаатар хариулъя. Ажлын хэсэг бас нэмж хариулж болно.

**Х.Нямбаатар:** Би хариулт өгье. Шинэ автобусны тендер 11 дүгээр сарын 23-ны өдөр нээгдэнэ, 30 хоногийн хугацаатай, олон улсын нээлттэй тендер зарлагдсан. Бид нар энэ ондоо багтаж гэрээ байгуулж нийлүүлэх ийм

боломжтой гэдэг ийм тооцоотой байгаа. Автобус үйлдвэрлэгчдийн хүчин чадлаас харахад өдөрт дунджаар 20-оос 100 автобус үйлдвэрлэдэг ийм хүчин чадалтай гэдэг ийм мэдээллүүдийг ялангуяа БНХАУ-ын автобусны үйлдвэрлэгчдийн ийм мэдээллүүдийг авсан байгаа. Нийлүүлэх тооны хувьд нэг үнэ өгч байгаа, үнийн саналаас шалтгаалж 650-аас 700 орчим шинэ автобус бид нар энэ гэрээний дагуу авна гэсэн ийм тооцоотой байгаа.

Энэ ногоон автобусыг бид нар хүлээж авахгүй гэдгээ хэлчихсэн. Ногоон автобустай холбоотой 130 тэрбум төгрөгийн урьдчилгаа төлбөр төлөгдсөнөөс одоогийн байдлаар үлдэгдэл 77 тэрбум төгрөгийн авлага, өглөг дээр л бид нар одоо АТГ шалгагдаж байгаа. Эрүүгийн хэрэг дээр Нийслэлийн нийтийн тээврийн газар иргэний нэхэмжлэгчээр оролцохоор бид хүсэлтээ өгсөн байгаа. 77 тэрбум төгрөгт Тэнүүн-Огоо компанийн мэдэлд байгаа автобусны 3 бааз байгаа байх тийм ээ, 3 бааз тоног төхөөрөмж бусад зүйл дээр бид нар үнэлгээ хийлгэх хүсэлтээ гаргасан байгаа. Ингээд эндээс хэдэн төгрөгийн үнэлгээ гарч, 77 тэрбум төгрөгт хэдэн төгрөгийг нь суутган тооцож, цаана нь үлдсэн хэдэн төгрөг үлдэх вэ гэдэг дээр шинжээчийн дүгнэлтийг хүлээж удахгүй нэг тоо гарна. Үлдсэн 318 тэрбум төгрөгөөс үлдсэн 200 арай хүрэхгүй 180-аад тэрбум төгрөгт нь бид нар 700 орчим автобусаа авна. Тэнүүн-Огоо компанийн нийлүүлсэн skywell цагаан цахилгаан автобусыг үндсэндээ хүлээгээд авчихсан байгаа. Одоо Тэнүүн-Огоо компанийн оруулж ирсэн 50 орчим ийм дунд оврын автобус дээр бид нар бас гаалийн бүрдүүлэлттэй холбоотой маргаантай асуудал байгаа учраас энэ маргааныг шийдэгдсэн тохиолдолд бид нар тодорхой үнэ дүйцүүлж хүлээж авна. Ингээд үндсэндээ Тэнүүн-Огоо компанитай бид нар тэр 77 тэрбум төгрөгийн асуудал дээр л шинжээчийн дүгнэлтээр тэр бааз байгууллагуудыг нь бүхэлд нь тоног төхөөрөмж техникийнх нь хувьд хүлээж

авахад ямар хэмжээний зөрөө гаргах вэ гэдгийг дараа нь танилцуулна.

Жилд дунджаар 17 мянган орон сууц ашиглалтад орж байгаагаас гэр хорооллын айл өрхүүдээс 40 орчим хувь нь энэ 17 мянган орон сууцын 40 орчим хувьд нь гэр хорооллын айл өрхүүд орж байгаа. Харамсалтай нь нөгөө хашаагаа ингээд яндан үйлдвэрлэхгүй байдлаар юу гэдэг юм өөр тохилог орон сууцууд солигдож байгаа тохиолдол бол их ховор байгаа. Тэгэхээр энэ удаагийн хуулиар ерөөсөө янданг дахиж үйлдвэрлэхгүйн тулд гэр хорооллын айл өрхүүдийг л газар чөлөөлөлтийг нь.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Яах юм бэ, нэмж хариулах юм уу? Гүйцээгээд хариулъя Нямбаатар.

**Х.Нямбаатар:** Энэ бид нар яг ингээд нөгөө нэг шууд орон сууц баригдсаны хэрээр гэр хорооллын хашаа яндан яг ингээд яг энэ хамааралтайгаар цөөрөхгүй байгаад дүгнэлт хийгээд л энэ удаагийн хуулийг оруулж ирж байгаа юм. Яг тэр гэр хорооллын бүсэд нь очоод таны газрыг байраар, байраар солино гэдэг л ийм газрыг байраар солино гэдэг л энэ зарчмыг энэ хууль дээр тусгаж оруулж ирж байгаа гэдгээ хэлье.

БНХАУ-ын ЗГ-ын хөнгөлөлттэй зээлээр нийтдээ Туул гол, Сэлбэ голыг тохижуулах ийм 60 сая ам.долларын төсөл хэрэгжиж эхлэхээр байгаа. Сая Сангийн яамнаас төсөл нь манайд шилжиж ирсэн. Энэ асуудал удахгүй би бас танилцуулъя гэж бодож байгаа. Таны ярьж байгаа тэр Туул голын сувагчлалын талаар бол хэн Хан-Уул хариулт өгөх байх. Зүгээр би түрүүн тэр лизингтэй холбоотой юман дээр хариулт өгье гэж бодож байгаа юм. Бид нар ер нь энэ хот нийтийн аж ахуйн тоног төхөөрөмжийг нэг дор бөөн мөнгө гаргаж худалдаж авна гэдэг бол тийм үр ашигтай тооцоолол биш. Тийм учраас худалдан авалтын нэг төрөл болгож уул уурхай юуны хот нийтийн аж ахуйн тоног

төхөөрөмжүүдийг бид нар лизингээр авдаг эрх зүйн орчноо л нэе гэж байгаа юм. Тэрнээс биш бид нар саяын ногоон автобус шиг бөөнөөр нь худалдан авалт хийх тухай энэ тэр ойлголтоос аль болох татгалзъя гэдэг л зүйлийг уг нь оруулж ирсэн юм. Тэгээд энийг цаашид хэлэлцүүлгийн явцад нэлээн тодорхой дэлгэрэнгүй тайлбарлана. Хан-Уул энэ Туул голын сувагчлалын талаар дэлгэрүүлээд хариулъя. 88 дугаар микрофоныг хурлын даргаа.

**Л.Мөнхбаатар:** Ажлын хэсгийн 88 дугаар микрофоныг өгье. Асуултад нэмж хариулъя.

**Д.Хан-Уул:** Хот байгуулалт хөгжлийн газар Хан-Уул байна. Энэ жил 2023 онд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн 63 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөө бол батлагдсан. Энэ дээр болбол хамгийн эрсдэлтэй хотын бол хамгийн эрсдэлтэй асуудал болбол энэ үерийн асуудал байгаа. Энэ асуудалтай холбоотой Туул, Сэлбэ гол дагуух далан сувгийг сайжруулах, шинэчлэх энэ мастер төлөвлөгөө шинэчлэгдэж нарийвчлагдаж батлагдаад, энэ жил болбол ажлын зураг төслийн даланжуулах ажлын, ажлын зураг төслүүд нь давхар хийгдээд явж байна. Туул голын дагуух газруудыг орон сууцжуулах энэ асуудал болбол батлагдаагүй, нарийвчилж зураг төсөл бол батлагдаагүй. 2040 оны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө дээр нарийвчлан судлагдаж танилцуулагдана.

**Л.Мөнхбаатар:** Тодруулах уу? Бөхчулууны Пүрэвдорж гишүүн тодруулж асууя.

**Б.Пүрэвдорж:** Тэгэхээр 17 мянган айлаас айлд жишээ нь орон сууц ашиглалтад орлоо гэхэд 8 мянга орчим яг энэ гэр хорооллоос ордог юм байна л даа. Гэтэл тэр 8 мянган хашаа буурахгүй байгаад байна шүү дээ. Тэгэхээр энэ тохиолдолд яах вэ гэхээр нэгэнт хашаа

буулгахгүй байгаа тохиолдолд тэр хавьцаа нь 200 айлыг нэгтгэсэн дэд бүтцүүдийг өөрөөр хэлбэл халуун дулаан өгдөг, бохирын асуудлыг шийдвэрлэсэн ийм 200 айлуудын нэг дэд бүтцийг нэг хийгээд үзээч нэг хороолол дээр. Нэг юу байдаг юм Баянхошуунд ч юм уу аль эсвэл Толгойт дээр ч юм уу. Тэгээд тэгж байж нөгөө яндангийнхаа асуудлуудыг бууруулахгүй болбол ерөнхий дэд бүтцийнх нь зүйл юу, хөрөнгө оруулалтыг нь хийчхээд л, тэндээсээ хашаа руугаа татаж авах асуудлыг.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Тодруулгад хариулах уу? НЗД Нямбаатар хариулъя.

**Х.Нямбаатар:** Пүрэвдорж гишүүний хэлж байгаа ерөөсөө л санаа энэ хуульд тусчхаад байгаа юм. Юу вэ гэхээр 6 дэд төвөө яг гэр хорооллын хамгийн их төвлөрсөн гэр хороолол дундаа 6 дэд төвөө байгуулъя. Энэ дэд төв нь инженерийн шугам сүлжээ, нийгмийн барилга байгууламж, зам бусад дэд бүтцийг бүхэлд нь шийдсэн АХБ-ны санхүүжилтээр хийгдэж байгаа юм. Энэ нэгэнт дэд бүтэц тавигдсан газрыг нь нийслэл өөрөө оролцож газрыг нь иүүд байраар солих ийм нөхцөлтэйгөөр л орон сууцжуулъя. Яг Пүрэвдорж гишүүний хэлж байгаа барилга баригдахын хэрээр яндан байхгүй болох ийм л төлөвлөлт рүү бид нар ингээд орж ирж байгаа юм. Өмнөх бид нарын алдаа болохоор нэг ийм 3, 4 айлын ч юм уу, 2, 3 айлын газар чөлөөлчхөөд түүн дээр нь нөгөө төлөвлөлт, барилгын компани өөрийнхөө ашиг орлогоо бодоод л өндөр байшин барьдаг, санхүүгийн боломждоо тааруулж газар чөлөөлдөг явдлыг нийслэл өмнөөс чинь ороод газрыг нь чөлөөлөөд, газрыг байраар солих энэ хөтөлбөрийг хэрэгжүүлж өгөөд, орон сууцын цогцолбор том хороолол барих газруудыг нийслэл өөртөө татаж авъя. Авсан газраа эргээд хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу барилгын компаниудад дуудлага худалдаагаар зарж, нийслэл өөрийнхөө гаргасан санхүүжилтээ эргэж олъё л гэдэг л ийм л

санхүүгийн схем бүхий хуулийн төслийг та бүхэнд танилцуулж байгаа юм.

**Л.Мөнхбаатар:** Улсын Их Хурлын гишүүн Даваажанцангийн Сарангэрэл асуултаа асууя.

**Д.Сарангэрэл:** Баярлалаа. 20, 30 жилийн турш ужгирсан хотын асуудлыг шийдвэрлэх хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох ийм л асуудлыг Нямбаатар сайд маань оруулж ирж байна. Би Нямбаатартай бас ЗГ-т хамтарч ажиллаж байсан. Асуудлыг том, жижиг гэхгүй барьж аваад ард нь гардаг бас нэг ийм дайчин сайн чанар бий л дээ. Тэр ч утгаараа энэ хотын хамгийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх гээд сая бас Пүрэвдорж гишүүн хэлж байна даа. Барагтай улс төрч айгаад барьж авдаггүй л асуудлуудыг барьж аваад л хийе, бүтээе гээд л ороод ирж байна. Тийм учраас дэмжиж байгаа. Бид нар энэ тулгамдсан асуудлуудаар олон статистик, судалгаа тооцоонууд ярьдаг л даа. Мэдэж байгаа тийм ээ энэ орон сууц, орон сууцжуулах асуудал явахгүй байна. Агаарын бохирдол, утаа, хөрсний бохирдол, нүхэн жорлон 145 мянга. Ингээд асуудлууд бол өчнөөнөөрөө бий. Энийг бүх талаас нь цогцоор нь шийдвэрлэх гээд ингээд ороод ирж байхад бол дэмжихгүй гэх хүн байхгүй байлгүй дээ. Би тэгж л бодох юм. 145 мянган нүхэн жорлон байна. Хөрсний бохирдлоос юу үүсэж байгааг бид нар мэднэ. Агаарын бохирдлын 80 хувийг гэр хороолол үүсгэж байна, эцсийн шийдэл нь орон сууцжуулах гээд 30 жил ярилаа шүү дээ. Тэгээд өнөөдөр шийдлийг нь Баянхошуунд эхний ээлжид 800 хүнийг орон сууцтай болгоё, дараа нь 5-аас 6 мянган айлыг орон сууцтай болгох гээд шийдвэрийг. Сэлбэ 12 мянган айлыг орон сууцжуулна гэж байна. Энэ манай Монголчуудын, Улаанбаатарчуудын, залуучуудын хүсэн хүлээж байгаа асуудал мөн шүү дээ. Тэгээд энийг шийдье гэж байна л даа. Тэгээд их чухал байна.

Түгжрэл бол тэдэн онд тэг зогсолт болно л гэж байна, тэг зогсолт хэдийнээ бий болчихсон. Намар бид нар санаж байгаа тийм ээ нэг бороо орсон, гаднын зочинтой өдөр бол тэг зогсолт болсон шүү дээ. Жилдээ 47 мянган тээврийн хэрэгсэл Улаанбаатар хотод нэмэгдэж байна гэж байна. Нийтдээ 1,2 сая тээврийн хэрэгсэл байгаа, 56 хувь нь Улаанбаатарт. 1,6 сая хүн нь Улаанбаатарт. Ингээд бид нар чинь бөөгнөрөөд ер нь наашаа ч үгүй, цаашаа ч үгүй маш хүнд асуудалд орчхоод байгаа юм. Энийг бол мэдээж хэрэг олон арга хэлбэрээр бол асуудлыг шийдэх нь тодорхой. Тэгээд энэ шийдлүүдээ хууль, эрх зүйн орчныг нь шийд гаргаад, ингээд шийдээд явъя гэдэг ийм саналыг оруулж ирж байгаа юм байна. Мэдээж хэрэг зарим гишүүдэд таалагдахгүй, нийцэхгүй зүйл байгаа л байх. Ажлын хэсэг байгуулагдана. 1, 2 дугаар хэлэлцүүлэг явна. Бид нар ярилцаад л асуудлын ард гарах ийм бололцоотой гэж ингэж бодож байгаа юм.

Асуух гэж байгаа зүйл юу вэ гэвэл бас энэ гишүүд ч яриад байна, иргэдийн зүгээс ч бас ярьж байгаа. Өмчийн харилцааны тухай асуудал гарна, газар чөлөөлөх. Энийг та бүхэн маань яаж шийдье гэж байгаа вэ? Яагаад гэвэл энэ чинь бас иргэн хүний өмчийн асуудал учраас их эмзэг асуудал. Үүнийг бол бас хүчээр шийдвэрлэх юм бол иргэдийн зүгээс эсэргүүцэлтэй тулгарна. Үүнийг их тийм зөв зохистой аль, аль тал талдаа ашигтай зөв байхаар яаж шийдэх гэж байгаа вэ? Энэ шийдлийг би 1 дүгээрт асуумаар байна.

2 дугаарт метроны тухай яриа нэлээн байна. Метрогоо хэзээ, яаж, хэрхэн байгуулах вэ? Энэ төлөвлөгөөнөөсөө бас танилцуулаач гэж.

3 дугаарт төлбөртэй бүсээ яаж тодорхойлох вэ? Энэ 27500 төгрөгийн асуудал бол би энийг бол Нямбаатар сайдын тайлбараас ойлгосон энэ чинь тэгээс эхлэх юм байна лээ шүү дээ шууд

27500 төгрөгийн асуудал биш юм байна лээ. Энийгээ бас хэрхэн яаж хийх гэж байгаа талаар бас олон нийтэд тайлбарлавал зөв байх гэж ингэж бодож байна.

4 дүгээрт энэ Яармагийн айлуудын асуудал олон жил болж байгаа юм. Гэр хорооллын газрыг дахин төлөвлөж орон сууцжуулна гэж хэлээд Яармагийн 4, 5, 6, 7, 8 гээд 5 хорооны айлын асуудлыг хүндрүүлчихсэн. Энэ Яармагийн энэ дахин төлөвлөлтийн асуудал та бүхний төлөвлөгөөнд хэрхэн яаж тусаж байгаа вэ гэдгийг энэ зүйлийг би бас асуухыг хүсэж байна.

Дээр нь энэ агаарын бохирдолтой холбоотой асуудлыг нэлээн тийм сайн тооцож байгаа юм байна гэж би ойлгож байгаа. Та бүхэн энэ хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэхээр зэрэг агаарын бохирдлоо 22 хувьтай, улмаар энэ түгжрэлийн асуудлаа 36 хувь.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Сарангэрэл гишүүний асуултад хариулъя. НЗД Нямбаатар хариулъя.

**Х.Нямбаатар:** Сүүлийнх нь асуултаас хариулъя. Яармагийн гэр хорооллыг орон сууцжуулах ажлын хүрээнд д Яармаг дэд төвийн ТЭЗҮ хийгдчихсэн байгаа юм байна Сарангэрэл гишүүнээ. Тэгээд бид нар АХБ-нд энэ Яармаг дэд төвийн санхүүжилтийг нэмэлт хэлэлцээр хийе гэдэг гэрээн дээрээ нэмэлт оруулж Яармаг дэд төвийг ADB-р санхүүжүүлбэ гэдэг хүсэлтээ явуулахад бэлэн байгаа. Тэгэхээр энэ дээр хоёулаа бас уулзаж байгаад, ярилцаад тэгээд ADB рүү ойрын үед бичгээ явуулъя. Тэгээд ADB Яармаг дэд төвийг дэмжбэ дэд төвийн санхүүжилтийг бид нар гаргахад бэлэн байна гэвэл бид нар ЗГ, Их Хурлаар оруулж байж ADB-тэй байгуулсан зээлийн хэлэлцээртээ өөрчлөлт оруулах ийм үе шаттай ажил хийх юм байна.

Метроны тухайд би нөгөө муу нуухаар сайн илчил гэдэг л үгээ л хэлж байгаа. Бид нарт яг өнөөдрийн байдлаар улс нийслэлийн төсөв дээр метро, тойрог хурдны зам барих ийм санхүүгийн эх үүсвэр байхгүй байгаа. Энэ жил нийслэл Улаанбаатар хот өөрийнхөө, ирэх жил төвлөрүүлэх төвлөрүүлсэн татварын орлогоосоо 230 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж өгөх үүрэгтэй. Тэгэхээр бид нар жил болгон улсын төсөвт төвлөрүүлж өгч байгаа энэ нийслэл өөрөө дангаараа метро барих гэдэг бол өнөөгийн санхүүгийн хувьд боломжгүй. Тэгэхээр бид нарт ямар потенциал байгаа вэ гэвэл Сумъяабазар дарга Уул уурхайн сайдаар ажиллаж байх үедээ одоогийн энэ Арева компанийн өрөмдөж байсан лицензийн талбай дээр нүүрсний хайгуул өрөмдлөг хийж байна гэдэг үндэслэлээр одоогийн энэ талбайг бас шилжүүлж авсан. Энэ Улаанбадрах сумын нутагт байгаа Цайдам тал гэдэг ийм нэртэй байришилд байгаа хүрэн нүүрсний ийм орд байгаа юм. Энэ хүрэн нүүрсний орд дээр Улаанбаатар корпораци өрөмдлөг хайгуулын ажил хийгээд 2 сарын дараа эхний өрөмдлөг хайгуулын тайлангийн дүн гарна. Энэ хугацаанд бид нар БНХАУ-ын ТӨК-удтай энэ хүрэн нүүрсний төсөл дээр хамтарч ажиллах, цаашлаад уул уурхайн бүтээгдэхүүнээр бид нар төлбөр төлөх нөхцөлтэйгөөр метро, тойрог хурдны замын ажлыг эхлүүлж гэдэг ийм төлөвлөлттэй ажиллаж байгаа. Энэ хүрээнд хэлэлцээр хийгдээд, цаашид энэ ажил явахаар хэлэлцээр амжилтад хүрсэн тохиолдолд энэ ондоо багтаж бид нар Улсын Их Хуралд энэхүү төслийг ийм нөхцөлтэйгөөр эдийн засгийн эргэлтэд оруулах зөвшөөрлөө Их Хурлаас авъя гэдэг ийм л дараалалтай байгаа. Энд ерөөсөө нууж хаах, засаглалыг нь бохирдуулах булингартуулах зүйл огт байхгүй гэдгээ хэлье.

Төлбөртэй бүс тогтоох эрхээ л авъя гэж байгаа. Бид нар бүх тэр төлбөртэй бүсүүдийн судалгаа хийгдэж байгаа. Бүсүүд тогтоогдсон тохиолдолд

үнэ төлбөргүй гадна талд нь зогсоолуудыг бий болгохоор ажиллаж байгаа.

**Л.Мөнхбаатар:** Тодруулж асуух уу? Сарангэрэл гишүүн тодруулж асууя.

**Д.Сарангэрэл:** Тэр газар чөлөөлөлт, өмчийн харилцааны асуудал нэлээн бас эмзэг асуудал учраас та бүхэн маань энэнийхээ шийдлийн талаар нэг надад хариулт өгөөрэй. Би 2 дугаарт бас хэлэх гэж байгаа зүйл Нямбаатар дарга болон багийнхан Их Хуралд их хүндэтгэлтэй хандаж энэ удаа бол их тийм өвөрмөц байдлаар хуулийн төслөө танилцуулж байна гэж бодож байгаа. Презентац бэлдчихсэн байна л даа Мөнхбаатар дарга, харамсалтай нь манай Их Хурал дээр энийгээ нэг дэлгэж тавиад тэрэн дээрээ очоод ингээд сайхан тайлбарлах ийм нөхцөл нь бүрдээгүй байна. Энийг ганцхан улс төрчдөд ойлгуулах биш Улаанбаатарчууд нийт иргэддээ энэ хуулиа ойлгомжтой байдлаар тайлбарлахын тулд самбар дээр бас энэ танилцуулгаа тайлбарлах ийм бололцоо үүсгэсэн бол их зүгээр байх байлаа гэж бодож байна. Ер нь хуулийн төслийг ийм танилцуулгатай оруулж ирж байсныг би лав санахгүй байна. Түүнээс гадна энэ хуулийн төслөөр бол энэ хэмжигдэхүйц үр дүн, цаг хугацаа, гарах үр дүнг нь тооцоолоод ороод ирсэн. Аливаа хуулийн төсөл бол бас эдийн засгийн үр ашгаа тооцсон байх ёстой. Утааг бол 22 хувиар бууруулна, түгжрэлийг 20.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Нөгөө хариулсны дараа нэмж авна, тодруулж болно. Сарангэрэл гишүүний тодруулгад хэн хариулах вэ? НЗД Нямбаатар хариулъя.

**Х.Нямбаатар:** Газар дээр Сарангэрэл гишүүнээ ийм 18 үндэслэлээр бид нар нийгмийн зайлиггүй хэрэгцээ шаардлага гэдгийг тодорхойлж байгаа юм. 1 дүгээрт дараах зориулалтаар нийгмийн зайлиггүй хэрэгцээ шаардлагын үүднээс газрыг чөлөөлнө гээд.



Боловсролын үйлчилгээ, эрүүл мэндийн үйлчилгээ, халамжийн үйлчилгээ, нийтийн номын сан, соёлын байгууллага, спортын байгууламж, эрчим хүч, дулаан хангамж, ус хангамж, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламж, харилцаа холбооны шугам сүлжээ, авто болон төмөр зам, гүүр, нүхэн гарц гарам, гамшигаас хамгаалах үйл ажиллагаа, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журмыг хамгаалах ажиллагаа, хог хаягдлыг нь зохистой хаях, хадгалах, устгах, тохижилт, цэцэрлэгжүүлэлт, явган зам, дугуйн зам, нийтийн хэрэгцээний авто зогсоол, нийтийн тээвэр, дүүжин тээвэр, гэр хорооллыг орон сууцжуулах гэсэн энэ тохиолдлуудад газар албадан чөлөөлөх шийдвэрийг гаргахад тухайн төсөл арга хэмжээний нөлөөлөлд өртөж байгаа газар өмчлөгч эзэмшигч этгээд улсын бүртгэлд бүртгэлтэй үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч иргэн хуулийн этгээдийн 65-аас доошгүй хувь нь нөхөн олговортойгоор газраа чөлөөлүүлж гэдгийг дэмжсэн тохиолдолд албадан чөлөөлөх ийм ажиллагаа явагдана л гэдэг. Энэ бол ер нь дэлхийн бусад улс орнуудад байдаг ийм газар нийгмийн зайлишгүй хэрэгцээ шаардлагаар чөлөөлүүлдэг энэ жишиг зохицуулалтыг оруулж ирж байгаа. Дээр нь Монгол Улсын Үндсэн хуулийн тэр 6.4-д заасан тэр үндэслэл, суурь эрх зүйн зохицуулалттай бас нийцэж байгаа гэдгийг хэлье.

**Л.Мөнхбаатар:** Дахиж тодруулах уу? Сарангэрэл гишүүн тодруулж асууя.

**Д.Сарангэрэл:** Тийм Мөнхбаатар даргаа энд зааланд бас өмчийн харилцааны асуудалд хүчээр хандах гэж байна гэсэн ийм ойлголтууд яваад байна шүү дээ. Тэгвэл энэ Үндсэн хуульд нийцсэн ямар тохиолдолд газар чөлөөлөлтийн асуудал хөндөгдөх вэ гэдгийг нь саяын танилцуулгаар ингээд бэлдээд ороод ирсэн. Тэгээд тэрийг нь яг олон нийтэд ийм харагдах боломжтой байдлаар тайлбарлах ийм нөхцөл бол Их Хуралд бүрдээгүй байгаа. Бид бол үүнийг бол анхаарах ёстой гэж ингэж бодож байна.

Би дахин хэлэхэд бол аливаа хуулийн төслийг бол олон нийтэд ойлгомжтой байх, хэмжих тийм хэмжүүртэй, цаг хугацааны хүчин зүйлийг нь тооцсон, гарах үр дүнтэй, эдийн засгийн үр ашгийг нь тооцож оруулж ирэх ёстой. Энэ бүгдийг бол хангасан ийм хуулийн төсөл би орж ирж байна гэж ингэж бодож байгаа юм. Жишээ авахад бол бид нар энэ хууль, эрх зүйн орчныг нь бүрдүүлээд өгчих юм бол нийслэлийн өмнө тулгамдаад байгаа түгжрэлийн асуудлыг 36 хувиар, агаарын бохирдлыг эхний ээлжид 20 хувиар, 22 хувиар бууруулах ийм тооцоо судалгаа хийгээд ингээд гаргаад ирсэн байна л даа. Тийм учраас бол би та бүхний өргөн барьсан нийслэлийн өмнө тулгамдаад байгаа 20, 30 жил уяжирсан.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Үг хэллээ. Сарангэрэл гишүүнээ ерөнхийдөө өнөөдрийн хуралдаан дээр Нямбаатар даргын үг хэлж байх үед пресентэйшн бол энэ дээр эдний бэлтгэсэн пресентэйшн бол явагдаж байгаа шүү. Тийм тэгж байгаа. Тийм. Иргэдэд бас нэлээн ойлгомжтой байх үүднээс энэ нөхцөлийг нь бас хангасан байгаа гэдгийг хэлье. Тогтохсүрэн. Ширнэнбаньдын Адьшаа гишүүн асуултаа асууя.

**Ш.Адьяа:** Өнөөдөр Монгол Улсад тулгамдаад байгаа Монголын хүн амын 50 хувь нь оршиж байдаг энэ 50, 60, 70 он сүүлийн 30 жилийн энэ хотын хамгийн муу муухай бүхэн нь хуримтлагдсан энэ цаг үед энэ асуудлыг шийдэхийн төлөө ийм хууль, эрх зүйн орчин, эдийн засгийн бодлогыг Нямбаатар сайд танилцуулж байгаа гэж ойлгож байгаа. Энэ асуудлыг нь энэ Улсын Их Хурал шийдэж өгөх ёстой, үүрэг хариуцлагыг нь үүрүүлэх ёстой. Нийслэлийн ард иргэд энэ 4 жилийн хугацаанд нийслэлд тулгамдсан асуудлыг энэ бүрэлдэхүүнээр шийднэ гэж шийдвэрээ гаргасан. Тэгэхээр энэ иргэд энийг ойлгох байх. Улсын Их Хурал ч гэсэн сүүлийн жилүүдэд нийслэлийн асуудал дээр онцгой анхаарч байгаа. Бат-Амгалан

гишүүнээр ахлуулсан Улсын Их Хурлын тур хороо байгуулагдсан. Түүнчлэн Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж өгсөн. Өнөөдөр Нямбаатар сайдад бас бид бас хүн ёсны хувьд жоохон хүндэтгэлтэй хандах ёстой гэж бодож байгаа. Сүүлийн энэ хотын дарга болсноос хойш энэ хүнийг чинь ер нь юу болгоод байгаа юм бас ингээд бас Монголчууд бас нэг нэгэндээ бас хүндэтгэлтэй хандаж, бас ажил хийе гэсэн ийм хүнийг бас энэ төрийн эрх барих дээд байгууллагын хэмжээнд дэмжих ёстой л гэж бодож байна.

Ингээд би энэ хуультай холбогдуулаад 2, 3 зүйлийг асууя. Энэ гаргасан шийдэл энэ хууль, эрх зүйн орчин энэ хотыг хөгжүүлэх төлөвлөгөө, хотыг орон сууцжуулах энэ төсөл хөтөлбөрүүдийг ойрын хугацаанд шийдэх ёстой, цаг хугацаа маш байгаа. Хэрвээ энэ сайн үр дүн гарвал Нямбаатар бол жинхэнэ эр хүн болно. Муу үр дүн гарвал худалч баатар болно шүү. Ийм учраас Улсын Их Хурал энэ оруулж ирсэн бичиг баримтыг нь яаралтай шийдэх ёстой гэж бодож байгаа, ийм байр суурьтай байгаа.

Ингээд 2, 3 асуулт асууя. Гэр хорооллыг орон сууцжуулах хөтөлбөрт хамруулна гэж байна. Энэ хамруулах юм байна. Гаднын ямар зээл тусламж авах юм бэ, дотоодын ямар эх үүсвэр байгаа юм бэ? Дээр нь өнөөдөр газар чөлөөлнө гэдэг аймшигтай асуудал байдаг юм шүү дээ. 100 айлын газар чөлөөлөхөд 5 айл чөлөөлөхгүй, өгөхгүй гээд 100 сая төгрөгийн үнэтэй үнэлгээтэй газрыг тэрбум төгрөгөөр нэхээд суувал энэ төсөл чинь гацвал яах юм бэ? Энийг ямар гарц гаргалгаа байна вэ?

Түгжрэлийг бууруулах асуудал шийдэхэд татварын бодлогоор дамжуулж шийдэл гаргадаг гаднын орнуудын туршилага байдаг тухай ярьж байгаа. Энэ шийдлийг ямархуу судалгаа байна вэ? Ингэж энэ татварын бодлогоор дамжуулж бүсчилсэн байдлаар энэ түгжрэлийг бууруулах энэ цогц арга

хэмжээ гаднын орнуудад байдаг. Парис, Женев гээд энэ хотуудад чинь байдаг юм байна лээ. Японы хотууд, Хятадын хотуудад байгаа шүү дээ. Энэ жишигийг хэрэгжүүлэхэд хэдий хэмжээний хөрөнгө мөнгө, цаг хугацаа байна. Энэ талаар нэг хариулт авъя.

Дээр нь энэ ухаалаг хот болох, энэ хиймэл оюун ухааныг ашиглаж хотын түгжрэлийг бууруулах энэ асуудал дээр ямар шийдэл гаргаж байна вэ гэдэг талаар бас нэг мэдээлэл авах ийм 3 асуудалд болбол би хариулт авъя гэж бодож байна.

**Л.Мөнхбаатар:** Асуултад хариулъя. НЗД бөгөөд Улаанбаатар хотын захирагч Нямбаатар хариулъя.

**Х.Нямбаатар:** Баярлалаа. Би Адышаа гишүүний асуултад хариулъя. Юун дээр хэрэгжиж байгаа Баянхошуу дэд төв дээр баригдаад эхэлчихсэн орон сууцны хороолол бол эхний 800 айлын орон сууц бол АХБ-ны 80 сая ам.долларын төслийн санхүүжилтээр баригдаж байгаа. Ирэх оны 4 дүгээр сард ашиглалтад орно. Энэ тохиолдолд бид нар цаашаа нийслэл өөрөө энэ орон сууцны гэр хорооллыг орон сууцжуулах дээр бодлогын жоохон өөрчлөлт гаргаж байгаа. Энийгээ хууль дээрээ тусгаж өгсөн. Өөрөөр хэлбэл эхний баригдсан 800 дээрээ шууд яг хажуугийнх нь гэр хорооллын айл өрхүүдийг хэлэлцээр хийсний үндсэн дээр ингээд шууд шилжүүлж, нөхөх олговор болгоод газрыг нь байраар солих байдлаар ингээд явъя. Энэ тохиолдолд 800 айлын орон сууц барих, 800 айлыг орон сууц руугаа шилжүүлээд оруулчихвал дахиад 5 мянган айлын орон сууц барих ийм газар чөлөөлөгдөнө гэдэг ийм концепцтой явж байгаа.

Одоо Сэлбэ дэд төв дээр баригдах түрүүн дэлгэц дээр та бүхэн харуулсан. 12 мянган айлын орон сууцыг бид нар ойролцоогоор нэг 600 орчим америк долларын урьдчилсан ийм зардал ТЭЗҮ-

ийг гаргаад ажиллаж байгаа. Одоо нарийвчилсан ТЭЗҮ рүүгээ орох гээд бид нар нийслэлийн төсвийн тодотгол дээр энэ ТЭЗҮ, барилгын төсөв, зургийн тендер зарлах гээд нээлттэй тендер зарлахаар бэлдэж байгаа. Энэ 600 орчим сая ам.долларын төсөвт өртөгтэй энэ төслийг хэрэгжүүлэх эхний санхүүжилт буюу 95 сая долларын америк долларын санхүүжилтийн эх үүсвэр өнөөдөр манай Сангийн яамны дансанд ороод ирчихсэн байгаа. Энэ бол Уур амьсгалын ногоон сангийн Ногоон орон сууц төслийг хэрэгжүүлэх ийм 95 сая долларын эх үүсвэр орчихсон байгаа. Бид нар дутагдаж байгаа 500 сая ам.долларын эх үүсвэрийг яаж гаргаж ирэхээр төлөвлөж байгаа вэ гэхээр бид нар нөгөө нийслэл дотоодод гаргах гэж байсан дотоод бондоосоо татгалзсан. Дотоод бонд бол 17,5 хувьтай, тэгээд зарцуулалт нь нөгөө сургууль, цэцэрлэг барих тэгээд нөгөө коксожсон нүүрсний 177 сая долларыг санхүүжүүлэх, цаашилаад нөгөө хот нийтийн аж ахуйн тоног төхөөрөмжийг шинээр авах гэх мэт ийм зориулалттай байсан бол бид нар энэ нэн шаардлагатай санхүүжилтээ урсгал зардлаа 23 ондоо 25 хувь хэмнэх замаар бид нар сургууль, цэцэрлэгийн барилгын энэ жилийн дутуу гүйцэтгэлийг санхүүжүүлэх, тоног төхөөрөмжийнхөө нөгөө хот нийтийн аж ахуйн цас цэвэрлэдэг, бодис цацдаг тоног төхөөрөмжүүдийнхээ шинэчлэлийг бас энэ ондоо багтааж худалдан авалт хийх энэ байдлаар шийдсэн.

Ирэх жил бид нар энэ том 12 мянган айлын орон сууцыг санхүүжүүлэхэд үндсэндээ ногоон зээл бонд гаргах ийм ажил эхэлчихсэн явж байгаа. Удахгүй ТЭЗҮ ирэх оны эхээр гарч ирсний дараа бид нар нөгөө бонд holder-уудтайгаа бид нар бас ийм private бонд, ногоон бонд гаргах.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Яах юм бэ, тодруулах юм уу та? Ширнэнбаньдын Адьшаа гишүүн тодруулж асууя.

**Ш.Адьяа:** Тэр нэг саяхан энэ Хятадын элчин сайдтай уулзсан ийм мэдээ байсан. Дээр нь энэ метроны асуудлыг, энэ түгжрэлийн асуудлыг бууруулахад бас Хятадын холбогдох ТӨК-уд бусад байгууллагуудтай хамтарч энэ төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх ийм бодлого байгаа гэж ойлгож байгаа. Энэ ямар шатдаа яваа вэ гэдгийг хариулт авъя. Дээр нь энэ түрүүн миний асуултад хариулт өгсөнгүй л дээ. Энэ түгжрэлийг бууруулах асуудал дээр энэ татварын бодлогоор дамжуулж шийддэг ийм шийдэл гаднын орнуудын туршилагын тухай нэг бас хариулт авмаар л байх юм.

**Л.Мөнхбаатар:** Тодруулгад хариулъя. НЗД Нямбаатар хариулъя.

**Х.Нямбаатар:** Түгжрэл дээр бол яах вэ ер нь бол ийм олон аргууд байдаг юм байна лээ. Жишээлбэл нөгөө нэг хотын түгжрэлийн татвараа шатахууных нь үнэ дээр нэмж авдаг ийм зохицуулалтууд байдаг юм байна лээ. Энэ бол нэлээн тийм нийтлэгдүү арга. Дээр нь нөгөө авто замуудаа төлбөртэй болгодог ийм арга байдаг. Энэнээс хамгийн энгийн арга буюу хамгийн эхний ээлжид хэрэглэдэг арга буюу төлбөртэй бүсийн зохицуулалтыг бид нар оруулж ирье гэж байгаа. Сингапур, Лондон, Стокхольм гээд хотууд энэ дэлгэц дээр гарч байгаа. Эдгээр улсууд бол энэ байдлаар түгжрэлээ 15-аас 30 хувь бууруулсан ийм туршилага байгаа учраас бид нар Их, Бага тойруугийнхаа аль нэг байдлаар төлбөртэй бүсээ тогтоох эрхээ л авъя гэж байгаа юм. Тэрнээс биш яг энэ хууль батлагдаад одоо төлбөртэй бүс тогтоох гэж байгаа зүйл биш гэдгийг хэлъя.

Саяхан ШХАБ-ын уулзалтын үеэр Монгол Улсын Ерөнхий сайд БНХАУ-ын Ерөнхий сайдтай уулзалт хийсэн. Уулзалтын ярианы гол нэг сэдэв бол Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулахад БНХАУ-ын ТӨК-удтай нийслэл Улаанбаатар хот хамтарч ажиллах боломж нөхцөлийн талаар ярилцсан. Энэ хүрээндээ уул

уурхайн бараа бүтээгдэхүүнээр энэ томоохон төсөл хөтөлбөрүүд, тэр дундаа тойрог хурдны зам, метроны төслүүдийг санхүүжүүлэх тал дээр хамтарч ажиллах боломж нөхцөлийг судлах чиглэлээр ийм яриа болж өнгөрсөн. Энэ хүрээнд бид нар БНХАУ-ын ТӨК-удтай энэ сардаа багтаж уулзалт хэлэлцээрүүд хийж эхлэхээр төлөвлөгөөтэй байгаа. Баянбогд төслийн хүрээнд энэ цайдам тал гэдэг юм байна лээ яг энэ газрынх нь нэр. Энэ хүрэн нүүрсний уурхайн хайгуулын ажил бол сая эхэлсэн. 2, 3 хоногийн өмнө эхэлсэн. Хайгуулын ажил бол энэ өвөлдөө өрөмдөөд энэ 1, 2 сар гэхэд хайгуулын ажлын дүнгүүд гаргаад, УУЯ-нд тайлагнахаар ийм төлөвлөгөөтэй байгаа. Бид нар хүрэн нүүрс гэдэг бол ер нь цаашдаа.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Ширнэнбаньдын Адьшаа гишүүн тодруулж асууя 1 минут.

**Ш.Адьшаа:** Тэр газар чөлөөлөх тухай асуудал байгаа юм. Энэ өмч хөрөнгийн асуудал гээд л зөндөө асуудал байна. Хэдэн жилийн өмнө би нэг бүүр нэг тодорхой жишээ мэдэх юм байгаа юм. Энэ БЗД-ийн нутаг дэвсгэр дээр энэ гэр хорооллын төсөл гээд 90, 90 хэдэн айлын хашааны асуудлыг шийдээд, 6 айл хашаагаа өгөхгүй энэ төсөл гацаад одоог хүртэл байж байгаа шүү дээ. Тэгээд энэ төсөл чинь гацвал ямар арга шийдэл байна вэ? Энэ дээр ямар бодолтой байна? Дээр нь энэ 177 тэрбум төгрөгийг энэ нөгөө нэг утаагүй түлшийг орлуулах бүтээгдэхүүн Хятадаас авна гээд тэр асуудал чинь хэвээрээ юм уу? Ер нь тэрнийг больсон гэдэг ийм мэдээлэл явж байсан. Энэ талаар нэг хариулт авъя.

**Л.Мөнхбаатар:** Тодруулгад нэмж хариулъя. Нямбаатар дарга хариулъя.

**Х.Нямбаатар:** БНХАУ-аас коксожсон нүүрс авах тухай ойлголт ингээд зогссон, авахгүй товчхондоо. Гэр хорооллыг дахин төлөвлөхөд ерөөсөө тулгамдаж байгаа энэ асуудал бол яг

цогцоор нь хороолол барихад газар чөлөөлөлтийн харилцаанд нийслэл, НЗД, Нийслэлийн орон сууцын корпорац, Нийслэлийн газрын алба яг ийм зохион байгуулалттайгаар орж ирж, айл өрхүүдийг хохироолгүй, хууль зөрчилгүй газар чөлөөлөлтийг хийхээс нөгөө гэр хорооллыг орон сууцжуулах ажил эхлэхээр байгаа юм. Тийм учраас би сая хэлсэн. Түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулахад саяын дурдсан 18 тохиолдолд тэр нөлөөлд өртсөн айлуудын 65-аас дээш хувь нь зөвшөөрсөн тохиолдолд нөхөх олговрыг нь өгөх нөхцөлтэйгөөр газрыг цогцоор нь чөлөөлөх энэ харилцааг л оруулж ирж байгаа юм. Түрүүн бас зарим гишүүд ярьж байна лээ. Нөгөө Газрын багц хуулиа энэ тэр хүлээвэл яасан юм бэ гээд. Газрын багц хууль бол нэлээн тийм асуудал дагуулсан хууль. Өмнө нь би бас үзэл баримтлалыг нь цуг батлалцаж байсан. Энэ Газрын багц хуулийг хүлээвэл ер нь энэ парламентын бүрэн эрхэд багтах уу үгүй юу л гэдэг асуудал байгаа юм.

Тэгэхээр агаарын бохирдол, энэ гэр хорооллыг орон сууцжуулах асуудал бол өдөр тутмаар цаг хэмжигдэж тоологдож байгаа харилцаа учраас бид энэ хууль батлагдсан тохиолдолд нийслэл маш өргөн фронтоор, өргөн бүрэлдэхүүнээр гэр хорооллын айл өрхүүдтэй хэлэлцээрийн ширээний ард сууна л гэдэг ийм л ажлыг төлөвлөж байгаа. Тэгээд айлуудад маш олон сонголтуудыг өгнө. Та шууд бэлэн байр авч болно, та шууд бэлэн мөнгө авч болно. Дээр нь та түрээсийн орон сууцад орж болно эсхүл түрээсийн орон сууцынхаа мөнгийг авч болно гэсэн ийм нөхцөлүүдийн аль нэг нөхцөл дээр нь тохирч байж бид нар цогцоор нь гэр хорооллыг чөлөөлж, цогцоор нь орон сууцжуулъя л гэдэг л ийм агуулгатай хуулийг оруулж ирсэн.

**Л.Мөнхбаатар:** Улсын Их Хурлын гишүүн Дамдинсүрэнгийн Өнөрболор асуултаа асууя.

**Д.Өнөрболор:** Энэ оруулж ирж байгаа хуулиар зохицуулагдаж байгаа энэ олон асуудлуудыг болбол нэг дор байр сууриа илэрхийлэхэд болбол нэлээн хугацаа болбол хүрэлцэхгүй юм байна. Тийм учраас нэг зүйл дээр болбол бас миний бие төвлөрөөд ер нь байр сууриа илэрхийлсэн нь дээр юм байна гэж бодож байна. Энэ танхимд нэлээдгүй цаг хугацаанд болбол бас Нямбаатар даргатай сууж бас Улсын Их Хурлын гишүүний хувиар бас олон асуудлыг бас шийдье хийчихье гэсэн ийм хандлагатай, бас ажил хэрэгч, хариуцлагатай хүн гэж бол би бас дотроо боддог. Энэ хотын дарга болоод ч гэсэн энэ олон жил бугширсан, түгжирсэн, авлигажсан энэ хуримтлагдсан асуудлуудыг шийдэхийг эрэлхийлж байгаа маш хурдтай бас энэ ажиллаж байгаа энэ санаачилгыг нь бас хүндэтгэж ажиллаж байна. Хүндэтгэж ойлгож байна.

Гэхдээ хот төлөвлөлт гэдэг болбол маш нарийн асуудал. Хот төлөвлөлтийн энэ замын, хөдөлгөөний түгжрэлтэй холбоотой асуудлын энэ шинэчлэлийг болбол хориг татвар 2-оос эхлэх юм болбол амжилтад хүрэхгүй Нямбаатар сайдаа. Энэ дээр та бас нэлээн анхааралтай хандах нь болбол зүйтэй байна. Таныг энэ Улаанбаатар хотын төлөвлөлт нийслэлчүүд иргэдэд гэр бүл, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, энэ ахмадууд гээд энэ хуулийн нөлөөлөл энэ сөрөг нөлөөлөл, тийм ээ хэрхэн тусах вэ гэдгийг та дахин нэг бодолцож, судалж үзээсэй гэж бол би бас хичээнгүйлэн хүсэж байгаа юм. Иргэн хүнд ер нь сонголт байх ёстой. Тэгээд ядаж энэ нийтийн тээвэр маань өөрөө чанартай, үйлчилгээтэй хүртээмжтэй байсан бол энэ хориглолтын заалт болох гол асуудал чинь болбол түгжрэл үүсээд байгаа ерөөсөө 1 шалтгааны л нэг нь ерөөсөө энэ нийтийн тээврээ хүртээмжтэй хөгжүүлээгүйгээс болоод байгаа асуудал л болоод байгаа шүү дээ. Тэгээд энэ оношоо зөв тогтоож тийм ээ түүндээ нийцсэн шийдвэр гаргах асуудал хамгийн чухал асуудал болоод байгаа юм.

Энэ Улаанбаатар хотын иргэдийн зорчих хөдөлгөөний энэ матриц боловсруулах би энэ судалгааг бас танилцаж үзлээ. Тэгээд энэ судалгаанаас харахаар Улаанбаатарчууд давхардсан тоогоор өдөрт ойролцоогоор 2,8 сая зорчилт хийдгээс автомашинаар 64 хувь, 24 хувь нь болбол нийтийн тээврээр 11, хувь нь болбол явган буюу дугуйгаар зорчдог юм байна. Тэгэхээр үндсэндээ энэ та бүгдийн тогтоогоод байгаа энэ хориглолтын бүс энэ гол бүсүүд дээр хүмүүсийн амьдрал өрнөөд байна. Хотын төв рүү ажилдаа ирэх зорчих зорчилтын гол бүсүүд нь 40 хувь байна. Сургууль, цэцэрлэг рүү чиглэсэн зорчилт 35 хувь байна. Төрийн болон нийгмийн үйлчилгээний зорчилт хөдөлгөөн болбол өнөөгийн нийслэлийн иргэдийн амьдралын яг энэ хэв маягийг одоо ингээд хэвшчихсэн тогтчихсон байж байгаа энэ хэв маяг маягийг задлах ийм нөхцөл байдал үүсчхээд байна л даа. Тэгээд энэ хуулийн үйлчлэл нь яг хэзээнээс хэрэгжиж эхлэх вэ? Нэн ялангуяа таны хэлж байгаагаар энэ ондоо багтаагаад энэ хуулийг батлаад, 1 сарын 1-нээс хэрэгжиж эхэлнэ гээд тэгэх юм бол энэ хөхөө өвлийн хүйтнээр улсууд тийм хаа байсан 300, 800 метрийн цаанаас алхаад хүүхдээ цэцэрлэгтээ хүргэж өгөөд, сургуульдаа хүргэж өгөөд тэгээд өөрсдөө ажилдаа яваад энэ болбол үндсэндээ болбол хүмүүсийн бухимдлыг болбол дээд цэгт нь хүргэнэ шүү.

Тэгээд энэ ер нь болбол хүмүүс энэ баяндаа машин унаад байгаа асуудал бол ерөөсөө ч биш юм л даа. Тэгээд нийтийн тээврийн асуудал ерөөсөө хүртээмжтэй, чанартай иргэдийн эрэлтэд яг нийцүүлсэн сонголттой ийм уян хатан шийдэлгүйгээс л болоод л ийм асуудал үүсээд байна гэдгийг болбол манай хотынхон болбол бас ойлгох нь чухал байгаад байна. Энэ ерөөсөө энэ аливаа зорчилтын ерөөсөө яг гол энэ бүсүүд чинь та бүгдийн энэ хориглолт татварын бүс гэж тодорхойлоод байгаа энэ цэгт чинь л өнөөдөр ерөөсөө гол амьдрал өрнөөд

байгаа учраас энэ дээр болбол бас ач холбогдол өгөх нь зүйтэй байна л даа. Уул нь энэ хот төлөвлөлт сайтай улс орнууд.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Асуултад хариулъя. НЗД Нямбаатар хариулъя.

**Х.Нямбаатар:** Би энэ хуулийн энэ өнөөдөр гишүүдийн асууж байгаа асуултад би бараг давхардсан тоогоор 15, 6 удаа энэ төлбөртэй бүсийг зөвхөн тогтоох эрхийг авах гэж байгаа. Хууль батлагдсанаар бүс тогтоохгүй, НИТХ нийтийн тээврээ сайжруулаад үе шаттай арга хэмжээ авсны дараа, зогсоолын менежментээ хийсний дараа, тойрог хурдны замаа эхлүүлсний дараа, метроны төслөө эхлүүлж чадвал түүний энэний дараа энэ төлбөртэй бүс тогтооно гээд байгаа шүү дээ Өнөрболор гишүүнээ. Та ингээд гуйвуулаад өвөл чи хөхөө өвлийн хүйтнээр бүс тогтоох гэж байна гэж ингэж гуйвуулдага болимоор байна. Би 15, 6 удаа өглөөнөөс хойш хариулж байгаа шүү дээ.

Яг таны хэлж байгаа наадхыг чинь би ерөөсөө энийг санаанаасаа зохиогоогүй. Нийслэл Улаанбаатар хотын бодлогын судалгааны хүрээлэн дээр сүүлийн 3 жил гаруй судалгаа тооцоолол хийгээд, тэр матриц боловсруулаад, хөдөлгөөний энэ зөрчилд эрчмийг бууруулах 1 дүгээр үе шат, 2 дугаар үе шат, 3 дугаар үе шатны арга хэмжээг авъя. Эдгээр арга хэмжээнүүдийг авах гэсэн чинь ийм, ийм хуулиуд гацаа саад болоод байна гэдэг л зүйлийг бид нар өнөөдөр ингэж оруулж ирж байгаа шүү дээ. Та яагаад ингэж айхтар гуйвуулж хэлж байгаа юм бэ? Хууль батлагдангуут чи 1 сарын 1-нээс хөхөө өвлийн хүйтэнд хүүхдээ тэврээд хотын төв рүү чи алхуулах гэж байна, хотынхон дахиж бодооч гэж та яагаад ингэж би маш олон удаа тайлбарлаж байгаа шүү дээ. Энэ эхний ээлжид бид нар энэ он дамжуулаад нийтийн тээврийнхээ шинэчлэлийг бүтэн хийнэ, программ хангамжийг нь шийднэ, хотын холбоос

тэр тээвэр зохицуулалтуудыг хийнэ, төлбөрийн системийг ойлгомжтой болгоно. Энэний дараа бид нар энэ холбоос замууд 1 дүгээр эгнээг өргөтгөх, замын 1 дүгээр эгнээнүүдийг нэмэх ажлуудыг дахиж хийнэ. Ингэснээр нийтийн тээврийн эрчим бүс, бүс дээр 15-аас 18 хувьтай нэмэгдэнэ. Ингэсний дараа бид нар зогсоолын менежментээ хийнэ гэсэн дандаа ийм логик дараалалтай явна. Тэрнээс одоо яг ингээд л өнөөдөр яах гэж байгаа зүйл биш шүү дээ.

2 дугаарт бид нар шууд бүс рүү орж ирэнгүүт л шууд төлбөр тогтоох тухай асуудал яригдаагүй. Шууд 27 мянган төгрөг гээд тогтоох тухай асуудал яригдаагүй. Тийм учраас та бүхэн ингээд бас Их Хурлын гишүүд энэ дээр бас нэг ийм энэ төсөл дээр сайн ажиллаад, та бүхэн энэ танилцуулгыг сайн үзээд, иргэдэд зөв ийм мэдээллийг өгөөч л гэдэг би та бүхнээс хичээнгүйлэн хүсэж байна. Нийтийн тээврийн парк шинэчлэл энэ он дамжаад хийгдэнэ.

**Л.Мөнхбаатар:** Тодруулах юм уу? Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүн тодруулж асууя.

**Д.Өнөрболор:** Тийм зөв, зөв. Ер нь болбол яг энэ урьдчилж авах энэ арга хэмжээнүүдээ л яг бүрэн ингээд авах хэрэгтэй. Өөрөөр хэлэх юм болбол энэ арга хэмжээнүүдийг үндсэндээ энэ нийтийн тээврийн энэ хүртээмжтэй, чанартай байдлыг, парк шинэчлэлийг үндсэндээ хийгээгүйгээр энэ хууль орж ирэх юм болбол иргэддээ болбол дэндүү харгис хандсан ийм л асуудал болох нь гэдгийг л би анх анхааруулж хэлж байгаа юм. Тэгэхээр энэ логик, эрэмбэ дарааллаа та бүгд маань болбол сайн мэргэжлийн түвшинд анхаарч хийх нь зүйтэй гэдэг асуудлыг ярьж байгаа юм.

Тэгээд тэрнээс гадна Нямбаатар даргад би бас нэг зүйлийг бас анхааруулж хэлэх маань юу гэж байна гэхээр энэ саяын энэ хаврын чуулганы төгсгөлд баяр наадмын уур амьсгалд орж байх үед тийм

ээ, олон нийтийн анхаарал энэ сарнисан үед хотод баригдах энэ бага оврын станцууд түүхий нүүрс түлэх ийм хууль батлагдсан байж байгаа юм. Тэгээд ААНОАТ-ын хуульд өөрчлөлт оруулсан. Энэ Чойжилсүрэн сайд болбол ерөөсөө бүүр би тайлбарлаад эсэргүүцээд ингээд одоо үнэхээр бараагүй. Тэгээд энэ хуулийн хэрэгжилтээр түүхий нүүрс хэрэглэхгүй байх .../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Ерөнхийдөө санал хэллээ. Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Лхагвын Мөнхбаатар, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан, Цэрэнпилийн Даваасүрэн нарын урилгаар Хөвсгөл аймгийн Рашаант сумын ЗДТГ-ын албан хаагчдын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүгддээ ажил хөдөлмөрийн өндөр амжилтыг хүсэн ерөөе. Манай Рашаант сумынхан маань Төрийн ордонтой, Улсын Их Хурлын үйл ажиллагаатай танилцаж байна. Хэлэлцүүлгийг үргэлжлүүлъя. ХЗБХ-ны дарга Дамдины Цогтбаатар асуултаа асууя.

**Д.Цогтбаатар:** Гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Надад нэг тодорхой 5 асуулт байна. Тэгэхээр ер нь бол Нямбаатар дарга нэлээн зоригтой шийдлүүд гаргаж урагшаа явж байна. Энэ яг энэ урам нь байгаа оргилж байгаа үед нь бол дэмжээд өгөх хэрэгтэй. Тэгээд 1 зүйлийг хэлмээр байна. Та бүгдэд таалагдсан шийдвэр угаасаа гаргах боломжгүй. Энэ их хуримтлагдсан асуудалтай газар бүгдэд таалагдсан шийдвэр гаргаж явна ч гэж байхгүй, олон хүнд муулуулж л таараа. Гэхдээ ажлаа та буцахгүй хийгээрэй.

Тэгээд асуултууд ийм байна. Энэ нөгөө бүсчилнэ гээд ярьж байгаа. Тэгэхээр манай СБД-ийн хувьд бол одоо ингээд цаашидаа энэ чинь төлбөр нэвтэрлээ гэж бодоход энэ бүсэд, дэлхийд байдаг л практик учраас энэ бол буруу зүйл биш. Гэхдээ яг тэр дүүрэгтээ амьдарч байгаа тэр төвдөө амьдарч

байгаа улсуудад чинь би зүгээр хэвлэлийн л мэдээлэлтэй байна, тодорхой хөнгөлөлт бас үзүүлнэ гэж байх шиг байсан. Тэр чинь яг бодитой зүйл үү? Хэрэв хөнгөлөлт үзүүлбэл ямар хэмжээний хөнгөлөлт үзүүлэх юм бэ? Нэг дэх асуулт.

2 дахь нь бол энэ барилга барих тал дээр манайхан аягүй их яриад байна. Энэ хотжилт ярихаар энийг л яриад байгаа юм. Нямбаатар сайдаа нэг юмыг эхлүүлээрэй. Хот гэдэг бол яг хоттой адилхан энэ зам барина гэдэг чинь бол өөрөө тусдаа хот. Өндөр, өндөр байшин шиг замууд барих хэрэгтэй. Аягүй олон барилгад орох мөнгийг бараг замд нь оруулж өгөх юм бол энэ түгжрэлийн асуудалд чинь бас хэрэгтэй байж магадгүй. Тэгэхээр энэ замын сүлжээгээ сайжруулах энэ өндөр замуудыг барих тал дээр та ямар төлөвлөгөө, бодолтой байгаа вэ?

3-д нь энэ Сэлбэ цогцолборыг бид нар уг нь овоо явж байгаа. Гэхдээ та энэ дээр бол цаашиа энийг бол нэлээн явуулна гэсэн асуудлууд ярьсан байна лээ. Тэгээд энийг бол яг бодитой ажил хэрэг болгоод зарим газраа ингээд очоод гагцхиаад байгаа энэ дээр та нэн тэргүүн анхаарч ажиллаж өгөөрэй гэж хүсмээр байна. Энэ талаар та одоо яг ямар асуудлууд байна вэ? Илүү урагшлуулах тал дээр юу бодож байгаагаа хэлээч?

4 дэх асуудал нь энэ Говьсайхан дарга энд сууж байна. Сэтгэл гаргаж нэг юман дээр ажилласан. 100 айлын олон жил хуримтлагдсан асуудлыг бол хөдөлгөсөн. Одоо тэнд барилга бариад эхэлсэн байгаа. Хөрөнгө мөнгө нь дутагдаад замдаа гацаад эхлэх вий дээ. Энэ дээр танайхан нэлээн сайн анхаараарай. Тэгээд энэ дээр тэр 100 айл дээр та ер нь цаашидаа ямар, ямар асуудлууд гарч болзошгүй байгаа, ямаршуу мэдээлэлтэй байгаа вэ? Энийг урагшлуулах тал дээр юу хийнэ гэж бодож байгаа вэ?

Тэгээд 5 дахь асуулт. Хотод бол дунд шатад танаас хараа хяналтаас чинь гадуур ер нь бол эрх мэдэл, хүнд суртлын систем чинь маш хүнд байгаа. Энэ чинь авлигын суурь нь. Тэгэхээр энэ дунд шатын авлига энэ эрсдэл дээр энийг буулгах тал дээр та юу хийж ажиллана, одоо ёстой Хууль зүйн сайд байсан хүний ур чадвар чинь энэ дээр гарна. Энэ хүнд суртлыг бууруулах тал дээр, энэ авлигын эрсдэлийг бууруулах тал дээр та юу хийж ажиллана гэж бодож байгаа вэ? Ингээд ийм 5 асуулт байна. Баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** 2 гишүүн асуулт асуусны дараа санал хураалт явагдана. Гишүүд танхимдаа орж ирээрэй. Асуултад хариулъя. НЗД Нямбаатар хариулъя.

**Х.Нямбаатар:** Би Цогтбаатар сайдын асуусан асуултад би хариулъя. Сүүлийнх нь сүүлээс нь эхэлчихье. Яах вэ авлига хүнд суртлыг арилгах тал дээр би эд нар очоод би нэг их удаагүй байгаа ч гэсэн бид хэд өмнө нь өмнөх Нийслэлийн Засаг даргын хийж байсан ажлыг үргэлжлүүлээд бид нар нөгөө бүтцийн шинжилгээ хийгээд дуусаж байна Цогтбаатар сайдаа. Чиг үүргийн шинжилгээ гээд бас судлаачдын бүрэлдэхүүнтэй хийгээд дуусаж байна. Одоо мандатын шинжилгээ гээд бас хийгээд дуусаж байгаа. Тэгээд бид нар ирэх жил НЗДТГ, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд орон тоогоо эдгээр шинжилгээнүүдийн үр дүнгийн дагуу 25 хувь эхний ээлжид бууруулна гэсэн төлөвлөгөөтэй ажиллаж байна. Ирэх жилийн төсвийг яг ингэж бичиж байна. Урсгал зардлаа 25 хувь хэмнэе, энэ мөнгөөрөө бид нар газар чөлөөлөлт бусад юмнуудыг хийе гэсэн байдалтай байж байна.

2 дугаарт авлигатай тэмцэх чиглэлээр яах вэ ажлаа хийгээгүй янз бүрийн алдаа гаргасан хүмүүсийг шалгуулах бичиг цааснууд өгч байна. Энэ бол шийдэл биш. Гол нь бид нар газрын албыг дүүргийн газрын албадуудыг газар

олгохоо болихоор энэ хуульд орж ирж байгаа юм нэмж. 2 дугаарт НЗД ерөөсөө зөвхөн дуудлага худалдаагаар л газар олгох зохицуулалтыг оруулж ирж байгаа юм. Төрийн худалдан авалттай холбоотой харилцаан дээр нөгөө тендерийн бичиг баримтыг боловсруулах яг ажлыг хувийн хэвшил буюу жишээлбэл мэргэжлийн холбоодод шилжүүлэхээр энэ хуульд орж ирж байгаа юм. Тусгай зөвшөөрлүүдийг ер нь цахимжуулах ажлуудыг эрчимжүүлъя. Тусгай зөвшөөрлийн тоог ер нь улам л буулгах чиглэлээр бас ажиллаж байгаа. Гэхдээ энд нэг тусгай зөвшөөрөл нэмэгдэж байгаа нь таксины үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй болгоё гэж байгаа юм. Тэгэхдээ тодорхой цаг хугацааны дараа.

Тэр бүсчлэлд байгаа иргэдийг бол 90 хувь хөнгөлөе гэж байгаа юм. Жишээлбэл бүсчлэлийг нэг удаагийн өдрийн зорчих зорчилт 5 мянган төгрөг байлаа гэж бодоход 90 хувь гэхээр 500 төгрөгийг тэр бүсэд амьдарч байгаа хүмүүс төлөх нь гэсэн л ийм л утга санаа гарч ирнэ. Энийг бол яах вэ тодорхой логик дараалалтай ажлууд хийгдсэний дараа энэ 24 оны төгсгөл рүү юу, 25 онд уу ямарваа нэгэн байдлаар нийслэлийн иргэдийн Хурал бүсчилж тогтоох эрхээ л авч байгаа юм. Авто тойрог хурдны зам барих чиглэлээр бид нар нэг би муу нуухаар сайн илчил гээд бас яриад байгаа. Нэг нийслэлд нэг хүрэн нүүрсний нэг лицензтэй талбай байгаа, одоо хайгуул хийгдэж байгаа. Та өөрөө мэдэж байгаа. Нөгөө дэлхийн дулаарлын эсрэг чиглэлээр хүрэн нүүрс бол цаашидаа ер нь хүндэрч байгаа. Тэгэхээр бид нар энэ богино хугацаанд метро тойрог хурдны замынхаа төслийг энэ төслөөрөө санхүүжүүлъя, энийг хэлэлцээр тохирвол 12 сард би эдийн засгийн эргэлтэд оруулж болно гэдэг тогтоолын төслөө ЗГ-т танилцуулж, ЗГ Их Хурал руу оруулж ирэх байх гэж бодож байна.

Таны хэлж байгаа Сэлбэ дэд төв, Сэлбэ сэргэлт 2-ыг бид эхний ээлжид



Сэлбэ дэд төвийн ажлыг ирэх барилгын сезонд эхлүүлбэ гэж байгаа юм. Дээр.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Говьсайхан дарга яах уу, нэмж хариулах уу? Хэн Нямбаатар дарга гүйцээгээд хариулчихъя.

**Х.Нямбаатар:** Тэгээд муу нуухаар сайн илчил л гээд л бид нар тэр хүрэн нүүрсээ л эдийн засгийн эргэлтэд оруулъя гэж байгаа юм. Хэрвээ энэ болох юм бол шууд л тэгээд л гэрээ хэлэлцээр байгуулна. Энэ эрхээ Их Хурлаас авна. Сэлбэ дэд төвийн ажил бол санхүүгийн схем нь их ойлгомжтой, 25 хувийнх нь санхүүжилт Уур амьсгалын өөрчлөлтийн сангаас ороод ирчихсэн. Үлдсэн 75 дээрээ ногоон бонд босгоё гэдэг бэлтгэл ажил хангагдаж байгаа. Энэ бараг босохоор байгаа. Ингэвэл энэ ажил ингээд бүтэн санхүүжилт босож ирж байгаа. Таны асуугаад байгаа Сэлбэ сэргэлт дээр бид нар орон нутаг өөрийнхөө дотоод эх үүсвэрийг дайчилъя. Энэ уулын амуудад байгаа нийслэлийн нутаг дэвсгэр дээр байгаа татвар огт төлдөггүй үл хөдлөх эд хөрөнгүүдийг бид нар тоолж, бүртгэж, үнэлж үл хөдлөхийн татвар авъя гэдэг бас хууль, эрх зүйн орчныг энэ дагасан хуулиар оруулж ирж байгаа гэдгийг хэлье. Мэдээж хэрэг олон хүний эрх ашиг хөндөгдөх байх. Би энэ бас олон эсэргүүцэлтэй ч тулах байх. Гэхдээ нийслэл өөрөө орлогын эх үүсвэрээ үл хөдлөхөөр л авна.

Ашиглалтын шаардлага хангахгүй байгаа 100 айлын байруудын нийт 300 өрхийн 1200 гаруй иргэд байсан. Одоо энийг бид нар ингээд дахин төлөвлөлтөд оруулах ажил НОСК эхлүүлээд 6 сард энэ барилгууд эхний барилгуудыг хүлээж авна гэсэн ийм тооцоотой байгаа. Дэд бүтэц нийтдээ 7,2 тэрбум төгрөг 23 онд бид нар 450 саяыг суулгасан. 24 онд үлдэгдэл эх үүсвэрийг нь суулгахаар ингээд ажиллаж байна. Таны асуултад бүрэн хариуллаа.

**Л.Мөнхбаатар:** Яах юм бэ, та тодруулах юм уу? 5 асуултад чинь бүрэн

хариулчихсан гээд байна шүү дээ. Улсын Их Хурлын гишүүн Гонгорын Дамдинням асуултаа асууя.

**Г.Дамдинням:** Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг бууруулах чиглэлээр хуулийн төсөл шинэ хотын дарга оруулж ирж байна. Тэгээд манай Нямбаатар сайд зоригтой хүн дээ тэгээд чадна гэж байгаа бол баталж өгөөд л явуулчих ёстой байх. Тэгээд 1 хэдэн асуулт байна. Яг үнэндээ бол Улаанбаатар хотын түгжрэл болбол энэ машинаасаа ч биш, олон барилгаасаа ч биш авлигаас л болоод байгаа шүү дээ. Би бол тэгж хардаг. Ялангуяа дунд, доод шатныхны авлигал болбол засаг замбараагаа алдсаны бэлгэ тэмдэг нь болбол би бүтэн сүүлийн 2 жил яриад явж байгаа Авлигал хороолол гэж олонд алдаршсан энэ байгууллага байна. Барилга байгууламж байна. Aqua garden буюу усан парк барина гэж анх газар аваад дараа нь орон сууцын зориулалттай болгож өөрчлүүлээд Усны тухай хууль, Төмөр замын тухай хууль зөрчөөд газар аваад, дараад нь техникийн нөхцөлүүд нь Улаанбаатар хотоос гараагүй байхад газраа ухаад сууриа цутгаад гаргаад ирсэн. Яг хуульгүй юм шиг, яг төргүй юм шиг загнаж байгаа.

Дараа нь Улаанбаатар хотын захиргаа харьяа яамнууд эрхийг нь цуцалсан, барилга эрхлэх зөвшөөрлийг нь болиулсан, барилгаа үргэлжлүүлж байгаа. Цахилгааныг нь тасалсан барилгаа үргэлжлүүлж байгаа. Тэгэхээр энэ хуулийг чинь бид нар батлаад өгөхөөр хэрэгжүүлж чадах юм уу даа та нар? Төр болбол энэ авлигачдаа толгой дээрээ залчихсаны бэлгэ тэмдэг болбол энэ авлигал хороолол харагдаж байгаа шүү дээ. Энийг хараад сууж байгаа олон, олон авлигал хорооллууд хүлээгээд сууж байгаа. Энэ баригдаад дуусах л юм болбол дараачийнх нь барьцаа л явна. Хүний хувийн өмч энэ тэр гээд янз янзын юм яригдаад байгаа юм. Төрөөс бүтэн зөвшөөрлөө аваагүй байж байж бариад

явчихсан байгаа энэ газарт зөвшөөрөөгүй байхад баригдчихсан бол буулгаж л таарна шүү дээ. Шүүх дээр НЗД-ын захирамж унасан гэж дуулдана лээ. Ямар арга хэмжээ авах вэ, хууль яаж мөрдүүлэх вэ? Энэ хууль дээрээ энэ бярттай хүчтэй нөхдүүд дайраад ингээд барьж чаддаг юм байж. Тэгвэл энэ дэд бүтцийнх нь зөвшөөрлүүдийг нь өгөхгүй цуцалж болдог эрхээ энэ хуулиараа оруулж болох уу? Цэвэр усаар битгий ханга, дулаанаар битгий ханга, бохиороор битгий ханга, авто замаар битгий ханга. Улаанбаатар хотын захиргаанаас өгсөн техникийн нөхцөлүүдийн гарын үсгүүдийн үр дүнгээр энэ ингээд явж байгаа байхгүй юу. Тэгэхээр хууль бус барилга газар дээр, хууль бус барилга бариад, хууль бусаар бяргаад ингээд төргүй юм шиг ард түмэнтэй нь цуг доромжлоод явж байгаа ийм газруудыг балгас болгоод орхидог, тэгээд өмчөө тэр хүн тэнд аваачаад хог болгоно л биз дээ. Тэгээд ашиглаж болдоггүй болгодог ийм эрх зүйн зохицуулалт энэ хуульдаа оруулж өгч байгаа юу? Энэ хэрэгтэй байна.

4 дүгээр асуулт болбол энэ барилгын чөлөө зөвшөөрлийг өгсөн танай хотын техникийн нөхцөл олгодог хүмүүсээ нэг бүрчлэн хууль хяналтын байгууллагад өгч хариуцлага тооцуулах тал дээр арга хэмжээ авч өгч чадах уу? Ийм 4 асуулт байна. Баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Хотын Говьсайхан дарга наашаа хүрээд ир ээ. Асуултад хариулъя НЗД Нямбаатар хариулъя.

**Х.Нямбаатар:** Би хариулъя. Одоо би энэ дэлгэц дээр ингээд яг одоогийн манай байгаа Их тойруугийн барилгажсан хэсгийг харуулж байгаа юм. Ингээд хотоос өгчихсөн шинээр барилга барих боломжтой зөвшөөрөл болон архитектур төлөвлөлтийн даалгавар өгчихсөн байгаа барилгуудыг улаанаар харуулна. Өөрөөр хэлбэл бид нар одоо энийг яг энд нь зогсоох уу эсхүл яг ийм улам илүү шигүү болгох уу гэдгээ л шийдэх

ёстой. 1 дүгээр эмнэлгийн хашаан дотор 20 давхар барилга барихаар барилгын ажил эхэлж байгаа шүү дээ. 1 дүгээр эмнэлэг өдөртөө хөдөө орон нутгаас 300-аас 500 өвчтөн ирдэг. Улаанбаатар хотоос хэдэн мянган иргэд ирж үйлчлүүлдэг. Одоо байгаа байдал нь маш хүндрэлтэй. Ямар ч машин эргэж тойрох боломжгүй дээр манай энэ өмнөх бас зөвшөөрөл өгдөг, газрыг шийддэг, барилга барих зөвшөөрөл өгсөн улсууд ийм л сэтгэлгүй барилгажилтын зөвшөөрөл өгсөн байгаа. Таны ярьж байгаа энэ *Agua garden*-тай холбоотой асуудал дээр НЗД-ын албадан буулгах захирамж гараад, Нийслэлийн захиргааны хэргийн шүүх дээр захиргааны актын хэрэгжилтийн биелэлтийг түр түдгэлзүүлчхээд явж байгаа. Ямар ч байсан би ажил аваад эхний ээлжид Шунхлай компанитай ойлголцоод нөгөө юуг Шунхлайгийн ШТС-ыг өнөөдөр ингээд чөлөөлөөд дуусаж байна. Одоо юу даланг нь өргөсгөх ажил эхэлж байна.

Маргаашаас бид нар *S outlet*-ийг өнөөдөр гарын үсэг бүх юмаа зурчихсан. *S outlet*-г чөлөөлөх ажлууд хийгдэж байна. Энэний дараа би нэлээн тохитойнхон *Agua garden*-гаа нөгөө хоёр 16 давхар билүү, 20 давхар байшинг буулгах энэ ажил руу орно гэдгээ би бас та бүхэнд хэлье. Мэдээж хэрэг хуулийн хүрээнд, шүүхийн шийдвэрийн дагуу хүний өмчлөх эрхэд халдах энэ процесс явагдах байх. Тэгээд энэ дээр бол та одоо цаг хугацааны асуудал байгаа. Та хэд бас зарим нь надаас их богино хугацаанд их олон зүйл шаардаж байна. Би яг НЗД-аар томилогдоод ажлын 17 өдөр л ажиллаж байна. Энэ хугацаанд бид нар хуулиа хийлээ, бүтцийнхээ шинжилгээг хийлээ. Энэ албадан чөлөөлөх ажлууд хийгдэж байна. Ер нь зөндөө ажлууд байна. Урт цагааныг ирэх 7 хоногт бас буулгаж, нийтийн эзэмшлийн талбай, ногоон байгууламж болгохоор иргэдээсээ санал асуулга асуудаг *Ulaanbaatar.mn* гэдэг ийм веб сайтыг ажиллуулж байна. Тэгэхээр ер нь бол таны хэлж байгаа энэ хүнд суртал, авлигатай тэмцэх чиглэлээр тодорхой

ахицуудыг би гаргасныхаа дараа ярья гэдэг бодолтой байна. Тэгээд хэдүүлээ хамтарч ажиллана гэдгээ хэлье. Баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Та тодруулах юм уу? Гонгорын Дамдинням гишүүн тодруулж асууя.

**Г.Дамдинням:** Нямбаатар сайдаа сая би нэг асуулт дээр бас тодорхой хариулт авчихмаар байгаа юм хотын даргаа. Энэ хууль зөрчөөд одоо таны энэ нөхцөл олгочихсон байгаа энэ сая харуулаа шүү дээ. Олон, олон авлигал хорооллуудын төлөвлөлт явж байгаа юм байна. Энэ дээр одоо энэ орж ирж байгаа хуулиар бид нар энэ цахилгаан, дулаан, тог, дэд бүтцийн энэ холболтуудаар нь хангахгүй байх эрх энэ хуулиар авч байгаа юу? Тэгээд та хуулийн сайд байсан хүн байна, тэгээд бас шударга ёсны төлөө бид нар бүгдээрээ тэмцээд л явна гээд амлацаагчигдсан, олон нийтдээ хэлээд сонгуульд ороод ирчихсэн хүмүүс, сонгогдоод ороод ирчихсэн хүмүүс. Хуулийг хэрэгжүүлж Улаанбаатар хотод газрын наймааны төгсгөл ирсэн шүү гэдэг энэ сигналыг өгч, энэ газрыг нэг буулгаарай. Төр байгаа шүү, ард түмэн хүчтэй шүү гэдгийг нэг харуулаарай л гэж хүсье дээ. Тийм.

**Л.Мөнхбаатар:** Үг хэллээ. Эрхэм гишүүн Дашидондогийн Ганбат асуултаа асууя. Санал хураалт явагдана гишүүд танхимдаа орж ирээрэй.

**Д.Ганбат:** Улсын нийслэл Улаанбаатар хотын талаар гэр хорооллыг барилгажуулах, хотын түгжрэлийг багасгах талаар хуулийг оруулж ирж байна. Бага ч атугай ингээд сайжирч л байвал бүгд дэмжихэд бэлэн байна. Улаанбаатар хот маань Монгол Улсын нийслэл 2 хүний нэг нь амьдарч байна Монгол хүний. Тэгээд нөхцөл байдал бол маш хүнд байгаа гэдгийг бүгдээрээ л ярьж байна, ойлгож байна. Улаанбаатар хотын сая 500 мянган хүн маань өнөөдөр яг л нэг харх шиг. Гэхдээ харх шиг

болохгүй л дээ, энэ чинь харх бол байгаа нөхцөл байдалдаа ингээд дасаад, ингээд амьдраад байдаг. Одоо бол энэ иргэд маань нөгөө Үндсэн хуульд заасан эрүүл, аюулгүй орчинд амьдрах энэ бүх юм бол зөрчигдсэн ийм байгаа. Утаа гэхэд өнөөдөр энэ танхимд ингээд л үнэртээд л байж байна. Тэгээд Нямбаатар сайд бол маш богино хугацаанд очиж ажиллах гэж байна. Тэгээд энэ хугацаанд яг энэ хуулийг хэрэгжүүлээд, батлуулаад, тэгээд үр дүн нь ямар байх вэ? Яг ямар асуудлыг шийдэж чадах вэ? Ер нь бид нар энэ тогтолцоондоо байна уу юундаа байна вэ? 2, 3 жилийн өмнө, жилийн өмнө Сумъяабазар гишүүнийг бас хотын дарга болоход нь тэгээд л зүйл бүрээр дэмжээд л бид нар явуулж байсан.

Дараа нь Түгжрэлийн сайдтай болсон. Тэгээд өнөөдөр үр дүн ямар байх вэ? Удахгүй Улаанбаатар хотын иргэд маань Монгол Улсын ард түмэн маань ингээд 8 жилийн ажилд, 4 жилийн ажилд ингээд дүн тавина. Нэг жилийн өмнө бид нар 420 тэрбум, 320 тэрбумыг бол шийдээд өгсөн. Энэ бол бага мөнгө биш. Гэтэл өнөөдрийн үр дүн ийм байгаа юм. Гэхдээ мэдээж хэрэг таныг энд буруутгаад ингээд байх юм алга. Таны хийсэн ганц нэг, ганц ч юу байх вэ бас сүүлийн үед ажлууд бий, бий. Тэр ураны төслийг бол хөдөлгөсөн энэ юмнууд байгаа. Гэхдээ бүх юманд хүн сайн байна гэж байхгүй. Ер нь таны баг ямар байна вэ? Өнөөдөр барилгажуулна гэхэд эрчим хүчний эх үүсвэр чинь хаана байна вэ? Өнөөдөр энэ түгжрэлийг багасгана гэхэд энэ замын нөхцөл байдал чинь ямар байна вэ? Энэ бүх юмандаа уялдуулж ингээж ажиллана л даа. Зүгээр нэг тушаал шийдвэр, хууль гаргаад ингэснээр бол асуудал шийдэгдэхгүй л дээ. Энэ бол аж ахуйн ажил. Би танд хэлмээр байгаа юм. Бусад улс орнууд энэ асуудлыг шийдэж байсан. Ганц манай Улаанбаатар ийм биш байсан. Гэхдээ өнөөдөр 21 дүгээр зуунд бас хамгийн дэлхий дээрх хамгийн муу муухай хот л бол Улаанбаатар болчихоод байна л даа. Бүх талаараа. Тэгээд энийг шийдэхийн тулд баг

хэрэгтэй. Энийг ишийдэж байсан туршилагатай ийм хүмүүсийг ажиллуулах ёстой.

Тийм учраас гадна, дотнын хүмүүсийг аваач, хөлслөөч, тийм бэлэн компаниудыг аваач. Тухайлбал Хөх хот асуудлаа ингээд ишийдчихсэн байна ойрхон. Энийг авчраад хуулбарлаад л тавьчихад цаг агаарын хувьд ч адилхан юм, угаасаа Монголчуудын байгуулсан ч хот юм. Улаанбаатар Хөх хот 2 адилхан. Тэгээд энэ тал дээр ажил хийж байгаа юмнууд байна уу гэсэн ийм асуулт байна. Юу, юу амжиж чадах вэ, юу, юу өөрчилж чадах вэ? Нэг их олон юм хийлгүй нэг л ажлыг ингээд сайн сайхан болгочоод ишийдчихээд ингэвэл бас хотын иргэд.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Ганбат гишүүний асуултад хариулъя. НЗД бөгөөд Улаанбаатар хотын захирагч.

**Н.Нямбаатар:** Би Ганбат гишүүний асуултад хариулъя. Ер нь бол Ганбат гишүүнээ энэ юу юм байна лээ China railway international group гэдэг компанийн тэр 6 дугаар товчоо гэдэг нь энэ төмөр замын метрог Хөх хотын метрог барьсан юм байна лээ. Бид нар энэ толгой компанийнх нь удирдлагуудтай бас Дэлгэрсайхан сайд уулзалт хийсэн. Өнөөдөр би бас ТӨК-удтай уулзалтууд хийсэн. Бид нар яг албан ёсоор хэлэлцээрийг 11 дүгээр сарын дундаас хойш хийе гээд бид нар төлөвлөчихсөн байгаа. Тэгээд ерөөсөө таны хэлж байгаа та бүгдийн очиж үздэг Хөх хотын тэр тойрог хурдны зам, Хөх хотын метроны энэ зураг төсвийг холболт хийж газар чөлөөлөлт хийх, түүний төсөвт өртгийг хэрхэн тооцох, төлбөрийн нөхцөлөө эргэн хэрхэн тооцох талаар бид нар ийм хэлэлцээрийн ажлууд хийхээр төлөвлөж байгаа гэдгээ хэлье.

Яг таны хэлсэнчлэн энэ Улаанбаатар хотод хот байгуулалт, архитектур, төлөвлөлт, зураг төслийн хүрээлэн, цаашилаад авто замын газар

гэдэг энэ салбаруудад бид нар гаднын нарийн мэргэжлийн туршилагатай ийм инженерүүдийг ажиллуулахаар энэ дагуулж өргөн барьж байгаа Төрийн албаны тухай хуульд ийм зохицуулалтыг өргөн барьж байгаа. Та бас энэ бодлогыг дэмжиж өгөөрэй гэдгийг хүсье. Яагаад гэвэл одоо манайд бас яг энэ чиглэлийн боловсон хүчнүүдийн дутагдалтай тал байна. Сайн инженер бас олон боловсон хүчнүүд маань хувийн сектор, гадаадад бас ингээд ажиллаад, яг энэ хот нийтийн аж ахуй, хот тохижилт, хот бүтээн байгуулалтын энэ салбаруудад нарийн мэргэжлийн өндөр технологи эзэмшсэн ийм хүмүүсийн дутагдалтай байдлыг нөхөх зорилгоор гадаад улсын иргэдийг багаар нь болон зөвлөхөөр авч ажиллуулах ийм эрх зүйн орчныг нээж оруулж ирж байгаа гэдгийг танд хэлье.

Юуны одоо эрчим хүчний нөөцийн хувьд бол энэ ондоо ерөнхийдөө ингээд тулсан чадлаараа явах юм байна. Ирэх онд бас Бөөрөлжүүт энэ тэр орж ирэх юм байна. Тэгээд бусад эх үүсвэрүүдийг бас нэмэх ийм чиглэлээр ЭХЯ тодорхой ажлууд хийж байгаа гэдгээ бас бидэнд хэлсэн. Дэд төвүүд дээр бол дэд бүтцийн асуудал, чадал, нөөцийн асуудал бол бүрэн ишийдэгдсэн юм байна. Ялангуяа бидний энэ жил эхлүүлээд явж байгаа, ирэх жил бүүр томоор нь эхлүүлэх гэж байгаа Баянхошуу дэд төв, Сэлбэ дэд төв 2 дээр бол дулааны эрчим дулааны болон цахилгаан эрчим хүчний, ус хангамжийн ариутгах татуургын нөөц хангалттай байгаа гэдгийг танд хэлье.

**Л.Мөнхбаатар:** Тодруулах юм уу? Дашидондогийн Ганбат гишүүн тодруулж асууя.

**Д.Ганбат:** Ингээд үе үеийн хотын дарга нар ингээд сонгогдсон танай манай энэ нам гэлтгүй ийм хүмүүсийн байдлаас болоод энэ Улаанбаатар хотын иргэд маш их хохирч байна. Эрүүл мэндээрээ, бүх талаараа ингээд хохирч байна. Тухайлбал энэ түлшээ юугаар ч барьцалдуулаад байдаг юм, энэ

хүүхдүүдийн чинь цусанд нь хар тугалга илрээд эхэллээ. Энэ хүмүүсийн уушгинд чинь өмнө дэлхий дээр байхгүй тийм вирус гарч ирж байна гэнэ. Энэ асуудал ингээд явчихсан ийм байдалтай байна. Тэгэхээр энэ буруутай этгээдүүдийг нь гаргаж ирээд нөхөн төлбөрийг нь өгөх үү, хохирлыг нь барагдуулах уу ийм юм байна уу байхгүй юу? Энэ хүмүүс бол өөрсдөө ямар ч буруугүй, татвар түрээсээ төлөөд Монгол Улсынхаа иргэнийхээ хамаг үүрэг.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Тодруулгад хариулъя. Нямбаатар дарга хариулъя.

**Х.Нямбаатар:** Ганбат гишүүн миний нөгөө нэг эрх хэмжээнээс арай бүр хальсан таны л Их Хурлын гишүүн та хэдийн л хэмжээнд шийдэх хариулах л хариулт байна гэж би бодож байна. Зүгээр миний одоо хариуцаж байгаа хуулиар хариуцаж байгаа чиг үүрэг бол мэдээж хэрэг энэ нийслэл Улаанбаатар хотын иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах энэ эрхийг хангахын төлөө л ажиллана. Яг үнэндээ өнөөдөр бас бодит байдлыг хэдүүлээ яривал энэ авто худалдааны төвүүд байгаа байршлууд ялангуяа Да хүрээ зах орчимд саяхан олон улсын байгууллагууд судалгаа хийсэн байна лээ. Тэнд хамгийн их нөгөө хүнд хортой элементүүд хамгийн ихээрээ байна гэж байгаа юм. Тэгэхээр бид нар энэ шийдвэрийн дагуу жишээ нь Да хүрээний энэ эзэдтэй уулзалт хийж, энэ Улаанбаатар хотоос авто худалдааны төвүүдийг гаргах чиглэлээр бас тодорхой ажлууд хийхээр дөнгөж ярьж эхэлчихсэн л явж байгаа. Би бас та хэд надад жоохон цаг хугацаа өгвөл энэ тулгамдаж байгаа асуудлуудаар бид нар нэг сардаа юм уу, 2 сардаа нэг удаа бид нар яг хийж хэрэгжүүлж байгаа ажлын талаар тайлангууд тавиад, та бүгдийн асуулга, асуултуудад хариулаад явахад бэлэн байна.

Ер нь бол бид нар энэ ийм агаарын бохирдлыг бууруулах, авто замын түгжрэлийг шийдэх чиглэлээр ийм цочмог

арга хэмжээ авъя л гэж энэ хууль төслүүдийг оруулж ирж байгаа юм. Тэгэхгүй яг ингээд урьдын уламжлалт аргаараа дугаар хязгаарладаг ч юм уу эсхүл юу гэдэг юм 1 дүгээр эгнээ гээд нэг ийм төсөл хөтөлбөр хэрэгжүүлээд байдаг. Араас нь ингээд өдөр тутамдаа автомашин орж ирээд л, жилд 50 мянган машин авто замд нийлүүлээд байгаа тохиолдолд ямар ч ийм арга хэмжээ аваад бид нар асуудал шийдэж чадахгүй. Жайкагийн судалгаагаар 30 онд 3,2км-т хүрнэ гэж байсан. Сүүлд хийсэн дотоодын судалгааны байгууллагын дүнгээр 2025 онд 3,2км-т хүрээд таг зогсоно гэдэг л ийм дүгнэлтэд хүрчхээд байгаа гэдгийг та бүхэн бодоорой.

**Л.Мөнхбаатар:** Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан 26 гишүүн асуулт асууж, хариулт авсан байна. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлэх гишүүн байна уу? Байхгүй байна. Баттөмөр гишүүн та юугаа товчлуураа дараарай. Баттөмөр гишүүнээр тасаллаа. Хэн юм бэ, Амарсайхан гишүүнийг нэмээд, 2 гишүүнээр тасаллаа. Баагаагийн Баттөмөр гишүүн асуултаа үг хэлье.

**Б.Баттөмөр:** Нийслэлд тулгамдсан энэ асуудлуудыг оруулж ирээд Улсын Их Хурлын түвшинд танилцуулаад хууль батлуулах гэж байгаа болбол зүйтэй. Энэ бол ажлын зөв эхлэл гэж ингэж ойлгож байна. Зүгээр засмаар янз бүрийн юмнууд, бодмоор юмнууд байх шиг байна л даа. Зүгээр ер нь том эрх ашиг гэж байдаг тийм ээ. Тэр үүднээсээ үзвэл газар чөлөөлөхтэй холбоотой асуудлууд болбол том эрх ашигаа бодож чөлөөлөх нь зүйтэй. Гэхдээ тэр Үндсэн хууль гээд янз бүрийн юмнуудтайгаа нийцүүлж энийгээ хийх нь зүйтэй гэж үзэж байгаа. Улаанбаатар хотын байдал үнэхээр төвөгтэй хүнд байгаа шүү дээ. Тэгээд РМ 2,5 гээд тэр үзүүлэлт болбол тэр хүхрийн хүчлийн хэмжээ бол ДЭМБ-ын зөвшөөрөгдсөн хэмжээнээс 27 дахин их байгаа шүү дээ. Хүхрийн хүчил. Тэгээд энэ болбол үнэхээр

аймшигтай, ямар ч цаг үед ер нь өөр газар ийм байдаг юм уу үгүй юм уу мэдэхгүй. Тэгээд энэ хамгийн гол нь энэ, энэ тэр зүйлийг л цогцоор нь л харж шийдэх л ийм шаардлагатай юм болов уу гэж ингээж харагдаад байна л даа.

Яах вэ энэ манай зарим гишүүд ч бүгд ярьж байгаа. Тэр bigdata хиймэл оюун ухаан гээд энэ замын хөдөлгөөний энийг чинь зохицуулдаг энэ рүүгээ шилжчихсэн. Энэ шинжлэх ухаан технологийн дэвшилүүдийг болбол их сайн ашиглах ёстой байх. Тэгээд орон сууц барьж яндангийн тоог цөөлөх, орон сууц барьж байгаль орчин энэ хөрс агаарын бохирдлыг бууруулна гэж байгаа юм. Эцсийн эцэст яах вэ зүгээр хааша байшингаа 70 хувь нь болбол сольё гэж байгаа, маш зөв сайн үзүүлэлт. Тэр байшинг барих компаниуд нь хаана байна вэ, тэр мөнгө нь хаана байна вэ? Өнөөдөр арилжааны банкнуудаас 18-аас 20 хувийн хүүтэй зээл аваад тэгээд байшин барина гэдэг чинь болбол байхгүй шүү дээ. Тэгээд энэ эх үүсвэр энэ тэрээ их сайн бодох ийм шаардлага болбол үүсэж байгаа юм.

Энэ бас нэг манайхны зарим улсууд шүүмжлээд байдаг тэр нэг нүүрсний уурхай хот эзэмших гэж байна гээд. Эзэмших хэрэгтэй, эзэмших хэрэгтэй шүү. Тэр хувьцаат компани болоод хөрөнгийн бирж дээр тэр хувьцааг нь гаргаад IPO нээлттэй компани болгоод тодорхой хувийг нь хот эзэмших ёстой шүү дээ. Америкт тийм байдаггүй, Англид тийм, Европт тийм байдаггүй л гээд байгаа юм. Бид тэрийг дуурайх албагүй шүү дээ. Монгол Улсын хөгжлийн чинь өөрийн онцлог, хөгжлийн загвар нь өөр шүү дээ. Тийм учраас Нямбаатар сайд энэ дээр бол буцах юм байхгүй шүү. Тэр уурхайг болбол ашиглах ёстой, хувьцаат компани болгох, ёстой, олон нийтийн хяналт хяналттай ийм болгох ийм шаардлагатай гэж ингээж байгаа юм.

Сая бас та нарын үгэнд тэр гаднын улсууд авч ирж туслуулна л гэж байгаа юм. Тэр Сингапурын Ерөнхий

сайдын хэлсэн үг байгаа шүү дээ. Энэ Англи, Франц гээд энэ колоничилсон улсууд колоничилсон улсууддаа энэ Үндсэн хууль, энэ хөгжлийн хууль, энэ сонгуулийн хуулийг нь энэ баталж өгсөн байдаг юм. Тэгээд хөгжссөн нэг ч улс байхгүй гэж. Сингапур яаж хөгжссөн гэхээр өөрийнхөө толгойгоор бид нар бүх зүйлээ хийдэг гэж. Тэр нарийн мэргэжлийн тэр юу гэдэг юм, зам гүүр ч байдаг юм уу, түгжрэлийн тийм хүмүүсийг авчирч зөвлүүлнэ үү гэхээс биш хотын хөгжлийг бол гаднынхнаар хийлгэнэ гэж бол байхгүй шүү дээ. Энийгээ та нар өөрснөө бодоорой гэдгийг би хэлэх гэж байгаа юм.

Ер нь тэгээд энэ манай хийгээд байгаа ажил бүгд нэг амь сүнсгүй байгаа байхгүй юу. Маш их ажил хийж байгаа. Маш их хурал зөвлөгөөн, ер нь тэгээд л зорилт хөтөлбөр замаа алдчихсан. Гаднынхан ч одоо зөндөө л бидэнд зөвлөж байна, тусалж байна. Ерөөсөө хийж байгаа ажил нэг амь сүнсгүй л байгаад байгаа юм. Энэ юунаас болж байна гэхээр ерөөсөө бид нарын хийж байгаа ажил эдийн засгаар баталгаажсаагүй. Хотыг барилгажуулна, дахин төлөвлөлт хийнэ гэвэл мөнгө хэрэгтэй. Тэр мөнгийг хаанаас яаж босгох юм бэ? Аливаа хийх гэж байгаа ажлынхаа хамгийн түрүүнд хийхдээ болбол санхүүжилтийн асуудлаа хамгийн түрүүнд бодлох ёстой. Энийгээ та нар бодож энэ хууль энэ тэрдээ тусгах нь зүйтэй гэж ингээж үзэж байгаа юм.

Ер нь бол түрүүн тэр хагархай цонхны онол гээд л ингээд л ярилаа шүү дээ. Бид бол дандаа асуудлын хойноос хөөцөлдөж байгаа шүү дээ. Урдаас бодоод, урдаас төлөвлөж хийх гээд тэгээд чаддаггүй юм гэхэд дагаж хөөцөлдмөөр байгаа юм. Асуудал үүсэнгүүт нь хамт тэрийг нь дагаад шийдээд, шийдээд явдаг. Нийслэлд болбол ингээд цаашидаа асар олон асуудал дахиад гарч ирнэ. Энийг дагаж биш, юу хойноос нь биш дагаж хөөцөлд, дагаж хөөцөлдөх нь зүйтэй гэж ингээж хэлэхийг хүсэж байгаа юм.

Тэгээд хамгийн сүүлд нь энэ нэг зүйл хэлэхэд энэ зах зээлийн нийгмийн хамгийн том сонирхол бол хувийн сонирхол. Иргэдийн хувийн сонирхлыг, ААН-ийн хувийн сонирхлыг Нийслэл хотыг хөгжүүлэх нийтийн эрх ашигтай яаж нийцүүлэх вэ гэдгийг бас бодмоор байгаа юм шүү дээ. Тийм ээ. Энийг бодох ёстой юм байгаа юм. Энэ болбол бас хөгжлийн том гарц шүү. Тэгээд сүүлд нь хэлэхэд энэ Нямбаатар сайд болбол залуу хүн бид нар дэмжих ёстой. Бид нарын дундаас очсон. Манлайлагч байх ёстой. Доод талын хүмүүс маань дандаа мэргэжлийн ийм хүмүүс байх ёстой шүү. Улаанбаатар хотын хөгжилд хүний хөгжил маш чухал.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** Монгол Улсын Шадар сайд Сайнбуянгийн Амарсайхан үг хэлье.

**С.Амарсайхан:** Хотын даргын оруулж ирж байгаа энэ түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх тухай хуулийн асуудлыг дэмжиж байгаа, зарчмын хувьд хэлэлцээд явах нь зүйтэй. Ер нь зүгээр өнөөдөр энэ Улаанбаатар хотод ч бай, улс орон даяар байгаа эмх цэгцгүй, эрэмбэ дараагүй асуудал болбол аливаа зүйлүүдийн болох болохгүйн хэм хэмжээс, улаан шугам болсон нөгөө стандарт гэдэг юмаа бид чинь амьдрал дээрээ хэрэгжүүлж баримтжуулж ирээгүй. Стандарт байгаа ч гэсэн түүндээ ач холбогдол өгдөггүй, шаарддаггүй. Өдөр тутмын амьдралын хэмнэл зуриллаа болгоогүй учраас энэ улс өнөөдөр эмх цэгцгүй, ундуй сундуй айл шиг болчихоод байгаа. Тэгэхээр энэ хууль батлагдсанаар бас нэлээн олон зүйлүүд цэгцдээ орох байх. Мэдээж нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар бүрэн эрхийн хүрээнд бас журамлаад цэгцлээд явах асуудлууд ч бас байгаа.

Зүгээр энэ дээр нэг хэд хэдэн зүйлүүд дээр бас нэг анхаарах зайлшгүй шаардлага байгаа юм болов уу гэж хараад байгаа юм. Миний сонссоноор өмнө нь энэ

А даалгавар авсан барилгын үйл ажиллагаагаа эхлүүлсэн 1500 гаруй ААН-үүдийн зөвшөөрөл цуцлагдсан шиг санагдаж байна. Одоо дахиад тэр хэмжээний аж ахуй нэгжүүдийн асуудал бас яригдах юм шиг байна. Тэгээд мэдээж нийтлэг эрх ашгийн хүрээнд цэгцэлж, стандартын дагуу энийг шийдвэрлэх нь зүйтэй. Гэхдээ тэрний цаана байгаа ААН-үүдийн эрх ашиг, тэгээд энэ улс оронд ажлын байр бий болгож байгаа, ард нь өчнөөн хөрөнгө мөнгө зараад зураг төслөө хийчихсэн, хөрөнгө оруулалт хийчихсэн, зарим нь насаараа шахуу ажиллаж ажиллаж нэг юм эхлүүлэх гэхээр одоо тэрийг нь өөрчлөх барих тухай асуудал яригдахаар иргэдэд эргээд хүнд тусна. Тийм учраас энэ асуудал дээрээ бас аль аль талаас нь нэлээн сайн нарийн тооцоо судалгаатай.

Тэгээд ялангуяа Нямбаатар даргын яриад байгаа тэр 12 мянган айлын орон сууцыг Сэлбэ, Баянхошуу дэд төв дээр барина гэдэг бол маш зөв. Бид өнгөрсөн хугацаанд хотынхоо төвд шахуу 2 ДЦС-тай. Тэгээд хотын төвөөсөө гадагшаа дэд бүтцээ ерөөсөө бодож тооцож хийгээгүй учраас энэ дэд бүтцээ дагаад энэ төвлөрөл бий болоод байгаа гэдэг асуудлыг ерөөсөө бас тэр болгон ярилгүй ирсэн. Өнөөдөр ч гэсэн мөн ялгаагүй. Яг л хотынхоо төвд шаваад байгаагийн үндсэн шалтгаан болбол хаана дулаан, цахилгаан байна, бохир, цэвэр байна тэнд л хүмүүс хөрөнгө оруулж байгаа шүү дээ. Өөр газар очоод оруулъя гэхээр дэд бүтэц нь байдаггүй. Өөр газар очоод хийе гэхээр нөхцөл нь бүрддэггүй. Тэгэхээр энэ хотын төвөөс гадагшаа орон сууц барьж байгаа, энэ гэр хорооллыг барилгажуулах ажлуудад хөрөнгө оруулж байгаа ААН-үүддээ бас татвар хураамжийн дэмжлэг тусалцаа үзүүлэх, хөрөнгө оруулалтыг нь хөхиүлэн дэмжиж баталгаажуулах асуудал дээр бас энэ хуулийн хүрээнд зарим зүйл заалтууд дээр анхаарах бас зүйлүүд харагдаж байна шүү гэдгийг хэлье. Тэгээд саяын ярьсан энэ стандартын асуудал

дээр хотын дарга бас нэлээн сайн анхаарч ажиллана биз.

**Л.Мөнхбаатар:** Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн, хошууч генерал Цэдэвийн Сэргэлэнгийн урилгаар Нийгмийн аюулаас хамгаалах яамны Цэргийн дээд сургуулийн 1989 оны команд ба улс төрийн ангийн төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ Улсын Их Хурлын нэрийн өмнөөс болон Улсын Их Хурлын гишүүн Цэдэвийн Сэргэлэнгийн нэрийн өмнөөс улсын хил хамгаалалтад албанд хамтран зүтгэж явсан Сэргэлэн генералын онжавууд та бүгдэд ажил амьдралын хамгийн сайн сайхан бүгдийн дээдийг хүсэн ерөөе. Манай Сэргэлэн генералын онжавууд Улсын Их Хурлын үйл ажиллагаатай танилцаж байна.

Гишүүд үг хэлж дууслаа. Байнгын хорооны саналаар, Байнгын хорооны саналаар Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Авто тээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийслэл хотын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд

нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил хянан, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Авто замын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүд болон Засгийн газарт чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураая. Санал хураалт. 73,2 хувиар санал дэмжигдлээ.

Төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр ТББХ-нд шилжүүлээ.

15.04 цаг

**Хоёр.Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэл /Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалах, оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны талаар/**

Дараагийнхаа асуудалд оръё. Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээллийг хэлэлцэнэ. Хөгжлийн



бэрхиээлтэй, хөгжлийн бэрхиээлтэй хүний эрхийг хангах, хамгаалах тогтолцоог нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны талаар мэдээлэл сонсоно. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Хүрэлбаатарын Булгантуяа мэдээлэл хийнэ. Таныг индэрт урьж байна.

**Х.Булгантуяа:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улс 2008 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн бэрхиээлтэй хүний эрхийн тухай конвенцод нэгдэж, Улсын Их Хурлаас 2016 онд Хөгжлийн бэрхиээлтэй хүний эрхийн тухай хуулийг баталснаар хөгжлийн бэрхиээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжих, нийгмийн хамгааллыг сайжруулах, тэдний онцлог, чадварт нь тохирсон ажлын байраар хангах, үйлчилгээг сайжруулах чиглэлээр холбогдох салбаруудын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр цөөнгүй арга хэмжээг аваад байна. Монгол Улс нийт 115100 орчим хөгжлийн бэрхиээлтэй хүн байгаагийн 40 хувь нь төрөлхийн, 60 хувь нь олдмол шалтгаантай байна. Мөн 0-18 насны 11,8 мянган хөгжлийн бэрхиээлтэй хүүхэд байна.

Хөгжлийн бэрхиээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд хийж хэрэгжүүлсэн томоохон арга хэмжээнүүдээс онцлон та бүхэнд танилцуулъя. 1 дүгээрт хууль, эрх зүйн орчныг сайжруулах хүрээнд хөгжлийн бэрхиээлтэй иргэдийг хангах, оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн хууль, эрх зүйн орчныг сайжруулах хүрээнд холбогдох салбаруудын хуулиудыг шинэчлэлийг бид нар хийгээд байна. Тухайлбал Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлан хэрэгжүүлж байна. Тус хуульд хөдөлмөрийн харилцаанд хүний хөгжлийн бэрхиээлээр нь ялгаварлахгүй байх НҮБ-

ын хүний эрхийн хорооноос ирсэн зөвлөмжийн дагуу хөгжлийн бэрхиээлтэй хүний ажлын цагийн холбогдуулсан байдлыг хорогдуулсан байдлыг устгах, ажил олгогч нь ажлын байрны тохируулгыг бүрдүүлж өгөх, хөгжлийн бэрхиээлтэй хүн ажиллах боломжтой ажлын байрны жагсаалтыг баталж байсан хүний эрхийн зөрчилтэй заалтыг хасах, хөгжлийн бэрхиээлтэй иргэн болон хөгжлийн бэрхиээлтэй хүүхэдтэй эцэг, эхийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг тэргүүн ээлжид худалдан авах, зайнаас ажиллах боломж нөхцөлөөр хангах зэрэг зарчмын чухам чухал өөрчлөлтүүдийг тусгаж чадсан. Эдгээр бараа бүтээгдэхүүнийг худалдан авалт хийсэн ажил олгогчийг хөгжлийн бэрхиээлтэй хүн ажиллуулаагүй орон тоо тутамд ноогдох төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх журмыг ЗГ-ын 2022 оны 253 дугаар тогтоолоор батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгын төслийг энэ оны 7 дугаар сард Улсын Их Хурлаар баталж, 2024 оны 1 дүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхлэх гэж байна. Тус хуульд байнгын асаргаатай хүүхдээ асарч, асарны улмаас хөдөлмөр эрхэлж чадахгүй байгаа эцэг эсхүл эхийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг төрөөс 100 хувь хариуцахаар зохицуулалтыг тусгаж, 2024 оны төсвийн төсөлд төсвийг тусган тусгасан байгаа.

Боловсролын багц хуулийн шинэчилсэн найруулгыг энэ оны 7 дугаар сард Улсын Их Хурал хэлэлцэн баталсан. Тус хуульд хөгжлийн бэрхиээлтэй суралцагчийн сурах эрхийг баталгаажуулж, боловсролын зарчим тэгш, хүртээмжтэй, ялгаварлан гадуурхахгүй, нээлттэй байна гэж тодорхойлоод бүх дагалдах хуульд уг зарчмыг баримтлах бөгөөд багш бэлтгэх сургалтын хөтөлбөрт хөгжлийн бэрхиээлтэй хүүхдэд багшлах арга зүйн ур чадварын багш мэргэжлээр суралцаж байгаа бүх оюутан, багш эзэмших бүх

түвшиний боловсролын сургалтын хөтөлбөр агуулгыг ялгаатай хэрэгцээтэй суралцагчийн онцлогт тохируулахаар тусгасан. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд тэгш хамран сургах боловсрол гэсэн бие даасан бүлгийг оруулж, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, сурах бичиг, хэрэглэгдэхүүн, үнэлгээ, багшийн арга зүй, сургалтын орчин, санхүүжилт, эцэг эхийн оролцоо, хамтын ажиллагааг бүхэлд нь тусгасан, тусгаж хуульд оруулж өглөө. Түүнчлэн боловсролын бүх шатын сургалтын байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудын суралцах онцлогийг харгалзан сургалтын хөтөлбөртөө тохируулга хийхээр тусгаж, багш бүр ялгаатай хэрэгцээтэй хүүхэдтэй ажиллах, тэднийг сургаж хөгжүүлэх арга зүйн ур чадвар эзэмшсэн байхыг онцгойлон авч үзсэн байгаа.

Төрийн албанд 2022 онд нийт байдлаар 4864 хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллаж байгаагаас 0,5 хувь нь удирдах албанд, 57,5 хувь нь гүйцэтгэх албанд, 37,1 хувь нь туслах албанд ажиллаж байна. Үүнээс 87 хувь нь төрийн үйлчилгээний албан тушаалд ажиллаж байна. Энэ нь төрийн захиргааны албан тушаалд хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллах боломж, нөхцөл хангалтгүй байгааг илтгэх нэг үзүүлэлт юм. Иймд хөгжлийн бэрхшээлтэй иргэн төрийн захиргааны албан тушаалд ажиллах боломж нөхцөлийг нэмэгдүүлэх зорилгоор төрийн албан тушаалд тавигдах тусгай шаардлагыг хөгжлийн бэрхшээлтэй хүний хувьд 2 дахин бууруулсан зохицуулалтыг Төрийн албаны тухай хуульд нэмэлтээр тусган 2023 оны 7 дугаар сард Улсын Их Хурлаар мөн батлуулаад байна.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын даргаар хөгжлийн бэрхшээлтэй хүн удирдах эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлж, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал

эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргаар Төрийн албаны тухай хуулиар хөгжлийн бэрхшээлтэй иргэний хувьд тавигдах ажилласан жилийн тусгай шаардлагыг хангасан эсхүл өндөр мэргэжилтэй хөгжлийн бэрхшээлтэй хүнийг томилж болох зохицуулалтыг нэмж тусган батлуулаад байна. Төрийн албаны шалгалт өгөх болзол журамд хөгжлийн бэрхшээлтэй хүний талаар зохицуулалт байхгүй байсныг өөрчилж, шалгалт авах байрыг хүртээмжтэй болгох, төрийн албаны нөөцөөс хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нэн тэргүүнд нөхөх зарчмыг баримтлах, шалгалт өгөх нөхцөл боломжийг мөн бүрдүүлээд байгаа.

БХБЯ-наас Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 2022 онд Улсын Их Хуралд өргөн барьсан. Хуулийн төсөлд хот байгуулалтын үйл ажиллагаанд нийтийн эрх ашгийг эрхэмлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх болон олон нийтийн оролцоо, оролцогч этгээдийн эрх тэгш байдлыг хангах, хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн дэд бүтэц, нийтээр ашиглах барилга байгууламжид саадгүй хүрэх нөхцөлийг бүрдүүлэх дэд бүтцийн хэрэгцээг хангах нь хот байгуулалтын баримт бичигт тавигдах үндсэн шаардлага болох, гадна тохижилтын ажил, барилга байгууламжийн орц, гарцыг хөгжлийн бэрхшээлтэй болон хөдөлгөөний хязгаарлалттай хүний хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хүртээмжтэй орчныг бүрдүүлэн төлөвлөсөн байх, хөгжлийн бэрхшээлтэй хүний саадгүй хүрч үйлчлүүлэх нөхцөлийг хангаагүй хот төлөвлөлт инженерийн болон нийгмийн дэд бүтцийг барьж байгуулах, аливаа төсөл, барилгажилтын шийдэл, зураг төсөлд зөвшөөрөл олгохгүй байх, хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй орчны талаарх мэдээлэлд тусгах зэрэг хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангахад чиглэсэн чухал зохицуулалтуудыг тусгасан.

Энэ хүрээнд бид 2024 оноос ялангуяа улсын төсвөөс хэрэгжиж байгаа сургууль, цэцэрлэг, эмнэлэг гэх мэтчилэн иргэдийн нэн шаардлагатай дэд бүтцийн жишиг зургуудыг хөгжлийн бэрхшээлтэй иргэнд нийцүүлэн шинэчлэх ажлыг хийх гэж байна. Орон нутаг, Орон сууцын ашиглалтын тухай хуулийн төслийг эцэслэн боловсруулж Монгол Улсын ЗГ-аас Улсын Их Хуралд өргөн барихаар бэлтгэл ажлыг бас хангаж байгаа. Хуулийн төсөлд орон сууцын барилгад хөгжлийн бэрхшээлтэй иргэд зорчих хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн хангасан, хүртээмжийг сайжруулсан орчныг бүрдүүлэх зохицуулалтуудыг тусгасан. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн маань хувьд хамгийн чухал асуудал нь нийгэм өөрөө хөгжлийн бэрхшээлтэй, дэд бүтэц хөгжлийн бэрхшээлтэй, барилга байгууламж, нийтийн тээвэр хөгжлийн бэрхшээлтэй байх нь нэн чухам тулгамдаад байгаа асуудлууд юм.

Боловсрол, шинжлэх ухаанаас ухааны яамнаас Монгол дохионы хэлний тухай анхдагч хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн болон үйл ажиллагааны төлөвлөгөө, шаардагдах төсвийг Боловсрол, шинжлэх ухааны сайдын тушаалаар баталсан бөгөөд хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулж байна. Авто замын тухай хуульд хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан тээврийн хэрэгслийг авто зам замын байгууламж ашигласны төлбөрөөс чөлөөлнө гэж тусган баталсан. Үүнийг нийслэл Улаанбаатар хотын түгжрэлийг бууруулах хуулийг хэлэлцэж байгаа энэ цаг үед бас бид тусган ажиллах ёстой. Ийнхүү Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2023 оны 5 дугаар сард Улсын Их Хурлаар баталсан. Холбогдох журмуудад мөн журмын төслүүдэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчилгээ үзүүлэх асуудлыг тусгахаар бид ажлын хэсэгт орон бас ажиллаж байна.

Бүтэц тогтолцоог бэхжүүлэх хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажлынхаа тухай товч танилцуулъя. Монгол Улсын ЗГ-аас хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах, оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн бүтэц тогтолцоог бэхжүүлэхэд анхаарч ажиллаж байна. Тухайлбал Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны бүтцэд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн хэлтэс чиг үүргийнхээ хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах асуудлыг төрийн бодлого шийдвэрт тусган ажиллаж байна. ЗГ-ын 2016 оны 136 дугаар тогтоолоор хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар дундын үйл ажиллагааг улсын хэмжээнд уялдуулан зохицуулах, хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий Үндэсний зөвлөлийг байгуулан ажиллуулж байна. Үндэсний зөвлөл нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж, бүх яамны ТНБД-аар ахлуулсан дэд зөвлөл, аймаг, нийслэл, дүүрэгт Засаг даргаар ахлуулсан салбар зөвлөлүүдийн үйл ажиллагааны тайланг хэлэлцэн зөвлөмж чиглэл өгч ажиллаж байна. Эдгээр зөвлөлүүд нь оны эхэнд тухайн жилд хийж хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, жилийн эцэст тайлагнадаг тогтолцоо бий болж болсон бас ийм амжилт байна.

Тус зөвлөлүүд нь холбогдох төрийн байгууллагуудаас гадна хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа ТББ-ын төлөөллийг оруулж, бодлого төлөвлөлт хэрэгжилтэд тэдний оролцоог ханган ажиллаж байна. ЗГ-ын 2022 оны 350 дугаар тогтоолоор Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталж, зөвлөлийг Монгол Улсын сайд, ЗГ-ын Хэрэг эрхлэхийн дарга ахалж байна. Зөвлөлийн ээлжит хурлаар байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэн хүн, ахмад настныг асарч байгаа иргэнд олгох тэтгэмж, хөгжлийн бэрхшээлтэй

иргэний халамжийн тэтгэврийн хэмжээг тус тус нэмэгдүүлэх асуудлыг хэлэлцэн ЗГ-ын хуралдаанд танилцуулж шийдвэрлүүлсэн болно.

Мөн 0-16 насны хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тогтоох, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамруулах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссыг 21 аймаг, 9 дүүрэгт байгуулан ажиллаж байна. Хууль болон конвенцыг хэрэгжүүлэхэд салбар дундын уялдааг хангах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн ерөнхий газрыг 2018 онд Улсын Их Хурал, ЗГ-ын шийдвэрээр байгуулсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд эрүүл мэнд, нийгмийн сэргээн засалтын цогц үйлчилгээ үзүүлэх, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвийг ЗГ-ын 2019 оны 125 дугаар тогтоолоор байгуулсан. Тус төв нь хүүхдийн хөгжлийн хоцрогдол, бэрхшээлийн эрт илрүүлэх, оношлох, сэргээн засах, хоёрдогч хөгжлийн бэрхшээлээс урьдчилан сэргийлэх, олон нийтийн оролцоонд түшиглэн хөгжүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг нийгмийн харилцаанд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцоход нь дэмжлэг үзүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдэд зориулсан сургалт, нөлөөлөл, хөгжлийн арга хэмжээг зохион байгуулахаас гадна өдөрт 250 хүүхдийг хэвтэн эмчлүүлэх, өдрөөр сэргээн засах үйлчилгээнд хамруулах боломжтой 8 давхар эмнэлгийг барьж байгуулаад ашиглалтад оруулаад байна.

Түүнчлэн хөдөө орон нутаг, алслагдсан дүүргээс ирсэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг 14-21 хоног хэвтүүлэн, нарийн мэргэжлийн болон орчин үеийн шинжилгээ оношилгоо,

хөдөлгөөн засал, хөдөлмөр засал, хэл засал, усан ба физик эмчилгээ зэрэг сэргээн засах тусламж үйлчилгээ үзүүлж, тохирох туслах хэрэгсэл, протез, ортопедийн үйлдвэрлэл, засвар үйлчилгээг мөн үзүүлж байгаа.

АХБ-ны зээлийн санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төслийн хүрээнд Дархан-Уул, Дорнод, Дундговь, Ховд, Хөвсгөл аймгуудад Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг 9 дүгээр сард нээж үйл ажиллагааг нь бүрэн эхлүүлээд байна. Эдгээр төвүүд нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, насанд хүрэгчдэд эрүүл мэнд, нийгмийн сэргээн засах цогц тусламж үйлчилгээг тухайн орон нутагт нь үзүүлж, гэр бүл асран хамгаалагчдад чиглэсэн олон үйлчилгээг хүргэж, салбар дундын уялдаа холбоог хангаж ажиллах юм. Эдгээр төвүүдийг аймаг орон нутгууд ахмад настанд ч гэсэн чиглэсэн байдлаар ашиглах боломжтой гэдгийг бас онцолж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх чиглэлээр БШУЯ, ХНХЯ, ЭМЯ, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, тэдний эцэг эх болон төрийн бус байгууллагуудын төлөөлөлтэй хамтарсан салбар дундын уулзалтыг яамнууд ээлжлэн зохион байгуулж хэвшсэн байж байгаа. Энэ хүрээнд яригдсан асуудлуудыг шийдвэрлэхээр Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэхээр боловсруулаад байна. Хамгийн сүүлийн энэ уулзалтыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам зохион байгуулаад байгаа. Дараагийн уулзалтыг ЭМЯ зохион байгуулахаар 3 сайд нар ээлжлэн яам яаман дээрээ зохион байгуулдаг уламжлал тогтоод байгаа.

ЗГ-аас 2016-аас 2020 онд Жайка байгууллагатай хамтран хэрэгжүүлсэн Улаанбаатар хот дахь хөгжлийн бэрхиээлтэй иргэдийн нийгмийн оролцоог нэмэгдүүлэх төслийн хүрээнд Хөгжлийн бэрхиээл ба тэгш байдал сургалтыг үндэсний хэмжээнд зохион байгуулах, хөгжлийн бэрхиээлтэй сурагч, багш нарыг бэлтгэн, хандлага ойлголт нэмэгдүүлэх, сургалтын тогтолцоог бий болголоо. Энэ хүрээнд 2023 оны байдлаар 500 гаруй удаагийн сургалтаар 40 мянга гаруй төрийн болон хувийн хэвшлийн ажилтан, албан хаагч, ерөнхий боловсролын болон их дээд сургуулийн оюутан сурагчдыг хамруулж, сургалтад хамрагдсан байгууллагууд гадна болон дотоод орчноо хүртээмжтэй болгоход анхаарч ажиллаж байна. Сургалтыг зөвхөн хөгжлийн бэрхиээлтэй хүн өөрөө заадаг учир үүгээр дамжуулан хөгжлийн бэрхиээлтэй залуусыг чадавхжуулан тэдний нийгмийн оролцоог бас бид нэмэгдүүлж байгаа юм.

Хөгжлийн бэрхиээлтэй хүний сурч боловсрох эрхийг хангах талаар. 2022, 22-оос 23 оны хичээлийн жилд нийт хөгжлийн бэрхиээлтэй хүүхэд нийт хүүхдийн 64 хүүхдийн хөгжлийн бэрхиээлтэй хүүхдийн 64 хувийг буюу 8228 суралцагчийг бүх шатын боловсролын үйлчилгээнд хамруулж байна. Боловсролын түвшинээр авч үзвэл СӨБ-д 1498, ерөнхий боловсролд 5673, мэргэжлийн боловсролд 643, дээд боловсролд 414 суралцагч суралцаж байна. Боловсролын багц хуулийн шинэчлэлийн хүрээнд ялгаатай хэрэгцээтэй суралцагчдын боловсрол эзэмших асуудлаар сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд тэгш хамруулан сургах боловсрол бүлгийг тусгайлан оруулж өгсөн байж байгаа, гэсэн сургалтын, сургалтын байгууллагын суралцагчийн ялгаатай хэрэгцээ ур чадварын түвшинд харгалзан сургалтын хөтөлбөрт тохируулга хийх гэсэн зохицуулалтыг тусган батлуулсан.

Дээд боловсролын тухай хуульд тусгай хэрэгцээ шаардлагатай суралцагчийг дэмжих хөтөлбөр баталж, шаардагдах орчин нөхцөл бүрдүүлэх талаар бас тусгасан байгаа. Тэгш хамран сургах боловсролын бодлогын хураангуйг боловсруулж, тэгш хамран сургах боловсролын 9 үндсэн шинж чанарын хүрээнд хийсэн шинжилгээний үр дүнд бодлогын 20 зөвлөмжийг бас гаргасан. Тэгш хамран сургах боловсролын талаар баримтлах чиглэлийг Боловсрол шинжлэх ухааны сайдын тушаалаар батлан 13 чиглэлийн 44 ажлыг 2022-оос 24 онд хэрэгжилтийг ханган ажиллахаар төлөвлөж байна, ажиллаж байна.

БШУЯ-наас тэгш хамран сургах боловсролын чиглэлээр Жайка ОУБ-ын Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах, АХБ-ны буцалтгүй тусламжаар хэрэгжиж байгаа Тэгш хамруулах боловсролыг дэмжих, Дэлхийн боловсролын түншлэл ОУБ-ын санхүүжилтээр Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих төслүүдийг бид мөн хэрэгжүүлж байна. Эдгээр төслүүдийн хүрээнд нийт 3 тэрбум орчим төгрөгийн санхүүжилтээр 26 сургалтын байгууллагын хүртээмжтэй орчныг сайжруулж, хүүхэд хөгжлийн танхимыг шинээр тохижуулаад байна. Хөгжлийн бэрхиээлтэй хүүхэд суралцдаг 2 цэцэрлэг, 6 сургуульд улсын төсвөөр 800 сая төгрөгийн санхүүжилтээр тохирох хэрэглэгдэхүүнийг нэмэгдүүлэх, хүртээмжтэй орчныг бас сайжруулах ажлыг хийлээ.

21 аймаг, 9 дүүргийн боловсролд хамрагдалтын дэмжих зөвлөл, Боловсрол шинжлэх ухааны газрын холбогдох мэргэжилтэн, 2900 багш, ажилтан, эцэг эхэд чиглэсэн сургалт нөлөөллийн аяныг бид бас хийгээд байна. Мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын салбарт Монголын хараагүйчүүдийн үндэсний төвийн дэргэдэх МСҮТ-д

хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамруулан сургах зорилгоор 250 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг саяхан БШУЯ-наас шийдсэн. Мөн дээд боловсрол ЗГ-ын тогтоолоор дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх журмын дагуу суралцагчдад төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгийг 2023 оны эхний хагас жилд дараах байдлаар олгосон. Үүнд хөгжлийн бэрхшээлтэй бакалавр, магистр, докторын хөтөлбөрт сурч байгаа 473 суралцагчид 843,9 сая төгрөг, бакалаврын хөтөлбөрт суралцаж байгаа эцэг эх нь хоёулаа хөгжлийн бэрхшээлтэй 282 суралцагчид 544,4 сая төгрөг, бакалаврын хөтөлбөрт суралцаж байгаа хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан гишүүнтэй өрхийн 1382 суралцагчид 2,6 тэрбум төгрөг, төрийн өмчийн их дээд сургуульд хөдөлгөөн засалч, хөдөлмөр засалч мэргэжлээр суралцаж байгаа 73 суралцагчид 99,9 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг тус тус олгоод байна.

Их, дээд сургуульд элсэх шалгалтын талаар. Хөгжлийн бэрхшээлтэй шалгуулагч ЭЕШ өгөхөд зориулсан тусгай өрөө бэлтгэх, шалгалтын цагийг уртасгах, шалгалтын даалгаврыг брайлаар, том форматаар хэвлэх, дохионы хэлмэрч, туслах багш ажиллуулах зэрэг дэмжлэг үзүүлдэг. Сүүлийн үед хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ЭЕШ өгөх тоо нэмэгдэж байна. Тухайлбал 2020 онд 13 шалгуулагч бүртгүүлж, бүртгүүлж байсан бол 2021 онд 22 шалгуулагч бүртгүүлж, 2022 онд 31 шалгуулагч бүртгүүлж 31 хүн, 2023 онд 33 шалгалт шалгуулагч бүртгүүлж 29 буюу 2020-оос 23 онд ЭЕШ-д нийтдээ 99 хөгжлийн бэрхшээлтэй хүн бүр бүртгүүлж, 92 нь шалгалтаа өгсөн байна.

Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр заалтын хэрэгжилтийг хангах зорилгоор боловсролын салбарт ажиллаж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн судалгааг шинэчлэн гаргалаа. Судалгаагаар сургуулийн өмнөх болон

ЕБС, их, дээд сургууль, коллеж, шинжлэх ухааны байгууллагад 2261 хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллаж байгаа нь үзэж эргэлт, ЕБС, дээд боловсролын байгууллагын нийт 102829 ажиллагсдын 2,1 хувийг бүрдүүлж байгаа юм.

Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаар. Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд нэмэлт эмнэлгийн урт хугацааны тусламж үйлчилгээг шинээр тусгасан. Урт хугацааны тусламж үйлчилгээний эрх зүйн орчин боловсронгуй болсноор хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тусламж үйлчилгээний тасралтгүй байдал бүрэн хангагдах боломж бүрдсэн. Эрүүл мэндийн сайдын тушаалаар баталсан Жирэмсэн, төрөх, төрсний дараах үед үзүүлэх тусламж үйлчилгээний журамд үйлчлэх хүрээний хөгжлийн бэрхшээлтэй жирэмсэн эмэгтэйчүүд, хөдөлмөрийн чадвар түр алдалттай нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн судалгааг гаргаж, гэр бүл төлөвлөлтийн тусламж үйлчилгээг үзүүлнэ гэсэн заалтуудыг онцлон тусгаж өгсөн.

Эрүүл мэндийн салбарт эрүүл мэндийн байгууллагын үйлчилгээний соёлтой холбоотой стандартыг хэрэгжүүлэхээр эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага стандартыг анх удаа батлуулсан. Уг стандартад хөгжлийн бэрхшээлтэй үйлчлүүлэгчтэй хэрхэн харилцах, эрүүл мэндийн байгууллагын гадна болон дотоод орчинд тавигдах шаардлагад хөгжлийн бэрхшээлтэй хүнд ээлтэй орчин бүрдүүлэх, хэвтэн эмчлүүлэх тасагт хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй өрөөг нэгээс доошгүй зориулалтын тоног, зориулалтын тоноглол бүхий ариун цэврийн өрөөг төлөвлөх зэрэг 20 орчим тусгайлсан заалтыг тусгасан. Харамсалтай нь ялангуяа дээхэн үед баригдсан манай дүүрэг, өрхийн эрүүл мэндийн барилга байгууламжууд маань хөгжлийн

бэрхиээлтэй иргэд орж үйлчлүүлэхэд их хэцүү. Ихэнхдээ үүд хаалгаар нь орлоо гэхэд цаашаагаа лифт дээшээ бусад тасгуудаар үйлчлүүлэхэд ийм чиглэлийн стандартыг бас хангаагүй баригдсан байдаг.

Нярайн шарлалтын үеийн оношилгоо эмчилгээний эмнэл зүйн зааврыг боловсруулж, Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлан хэрэглэгчдийг ханган ажиллаж байна. Энэ хүрээнд нярайн дутуу төрөлтийг бууруулах, дутуу нярайд үзүүлэх эмнэлгийн тусламжийг сайжруулах, нярайн амь насыг аврах, амьсгалын дистресс хам шинжийн шинжилгээнд хэрэглэх сурфактант эмчилгээг шинээр нэвтрүүлсэн. Бүгд Найрамдах Турк улс, Энэтхэг улс, Япон улсын мэдрэлийн мэс заслын чиглэлээр ажилладаг эмнэлгийн эмч нарын багуудтай хамтран 11 тархины саатай хүүхдэд ризотомид мэс засал хийж, сэргээн засах, хөдөлгөөн засах эмчилгээнүүдийн үр дүнг бас хянаж байна. Цаашид хагалгаанд орох 210 гаруй хүүхэд үзлэг хийж хагалгаа төлөвлөсөн ба Улсын гуравдугаар төв эмнэлэг хүүхдийн тархины саагийн шалтгаант булчин чангарлын үеийн нугасны мэдрэлийн арын ёзоорыг сонгомлоор таслах ризотомид мэс заслын эмчилгээг өөрийн эх оронд бүрэн нутагшуулахаар бас ажиллаж байна. Хөгжлийн бэрхиээлтэй 1200 гаруй хүүхдэд мэдрэл, дотор, чих, хамар, хоолой, нүд, шүд, сэтгэцийн эмч, хэл засал, сэргээн засалч эмч, удам зүйч, мэдрэлийн мэс заслын төрөлжсөн мэргэжлийн эмч нарын хамтарсан үзлэгийг зохион байгуулж, хөгжлийн бэрхиээлтэй хүүхдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг ойртуулах, өвдөхөөс нь өмнө урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанууд хэрэгжүүлэн бид бас ажиллаж байна.

ДЭМБ-ын санхүүжилтээр тусгай хэрэгцээ шаардлагатай эмэгтэйчүүдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх, тэднийг эсэн мэнд амаржуулахад зориулсан өндөр намыг нь

тохируулж болдог төрөхийн орыг нийслэлийн амаржих газруудад төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг болон 21 аймгийн амаржих газруудад хүлээлгэн өгөөд байна.

Хүүхдийн хөгжлийн хоцрогдол бэрхиээлийн эрсдэлийг илрүүлэх Монгол хүүхдийн хөгжлийг үнэлэх түргэвчилсэн үнэлгээг үнэлгээний асуумжийг эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтэрт тусган шинэчилж Эрүүл мэндийн сайдын тушаалаар баталсан бөгөөд энэ эрүүл мэндийн байгууллагууд төдийгүй эцэг эх, асран хамгаалагч нар гэр бүлийн түвшинд хөгжлийн хоцрогдол, бэрхиээлийн эрсдэлтэй хүүхдийг эрт илрүүлэх, оношлох, улмаар тэдэнд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээг цаг алдалгүй үзүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Хөгжлийн бэрхиээлтэй хүүхдүүдийн эцэг эхчүүд, төрийн бус байгууллагуудтай хийсэн уулзалт дээр ялангуяа эрт илрүүлэхийг аль болохоор эрт хийх тусам хүүхдүүдэд үзүүлэх тусламж үйлчилгээ сайжрах ийм олон улсын туршилагыг бид нар нэвтрүүлэх хэрэгтэй байна гэдгийг онцлон хэлж байсан. Шинэ төрсөн нярай бүрийг 4 төрлийн скрининг шинжилгээнд хамруулах ажлыг бид хэрэгжүүлж байна. Нярайн эсрэг скрининг шинжилгээ нь эмнэл зүйн шинж илрээгүй байхад оношилж, эрт эмчилгээнд хамруулснаар оюуны хомсдол, өсөлтийн хоцрогдол, хөгжлийн бэрхиээл эндэгдлээс сэргийлэх боломжтой юм. Мөн төрөлхийн хөгжлийн гажгийг эрт илрүүлэх зорилгоор улсын хэмжээнд ургийн төрөлхийн зүрхний гажиг, хромосомын шинжилгээ хийж байна. Ингэснээр ургийн хөгжлийн ямар нэгэн гажгийн эрсдэлийн улмаас хөгжлийн бэрхиээлтэй хүүхэд төрөх магадлалыг бууруулах бас боломжтой юм.

ЭМД-ын үндсэн зарчмын дагуу эмзэг бүлгийн иргэдийг санхүүгийн эрсдэлээс хамгаалах зорилгоор ЭМД-ын

шимтгэлийг нь төрөөс хариуцдаг даатгуулагчийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зардлын төлбөрийг даатгалын сангаас 100 хувь хариуцаж эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд иргэний хариуцан төлөх хамтын төлбөрөөс бүрэн чөлөөлсөн. 2021 онд 39 тэрбум, 2022 онд 47 тэрбум төгрөгийг тус тус хамтын төлбөрөөс чөлөөлж, эмзэг бүлгийн иргэдийг санхүүгийн эрсдэлээс хамгаалсан.

Тархины саажилт уналт таталтын эсрэг эмийн хангамжийг тасралтгүй байдлыг хангах хүрээнд 0-18 насны хүүхдэд хэрэглэх уналт таталтын эсрэг 10 нэрийн эмийг 2 жилийн хугацаатайгаар өнчин эмийн бүртгэлд бүртгэж 21 эмд импортын нэг удаагийн лиценз олгосон. Монгол Улсын бүртгэлтэй болон нэг удаагийн импортын лицензээр импортолсон нийт олон улсын нэршлээр 53, худалдааны нэршлээр 93 нэрийн уналт таталтын эсрэг эмийн 30-аас дээш хоногийн нөөцтэй 16 нэрийн эм байгаа бол 30-аас цөөн хоногийн нөөцтэй 7 нэр төрлийн эм байна. ЭМЯ-наас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эмчилгээнд хэрэглэгдэх эм эмийн хэрэгслийн чиглэлээр гол баримталж байгаа бодлогын хувьд эм бүртгэлийн үйл ажиллагааг шуурхай зохион байгуулах, эмийн худалдааны үнэд тухай бүрд хяналт хийх, эмийн хэрэгцээг тооцоод, хэрэгцээг тооцоолон олон нийтийг үнэн зөв мэдээллээр хангах, нэн шаардлагатай цөөн, цөөн тоогоор хэрэглэгдэх эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийн асуудлыг шийдвэрлэхэд онцгой анхааран ажиллаж байна. Нийслэлийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй 1200 гаруй хүүхдэд мэдрэл, дотор, чих, хамар, хоолой, нүд, шүд, сэтгэцийн эмч хэл засаж, сэргээн засалч эмч, удам зүйч, мэдрэлийн мэс заслын төрөлжссөн мэргэжлийн эмч нарын хамтарсан багийн ажил хяналтыг, хяналт үйлчилгээг бид нар өмнө нь урьдчилан сэргийлэх үйл ажиллагаануудыг бид нар хэрэгжүүлэн ажиллаж байна.

Даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтооход баримтлах өвчний жагсаалт, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацааг шинэчлэн бид нар шинэчлэн боловсруулж Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны хамтарсан тушаалаар батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. ЭМЯ-ны харьяа нийт 42 эрүүл мэндийн байгууллагад 6,8 мянган эмч, эмнэлгийн мэргэжилтэн ажиллаж байгаагаас 230 ажилтан буюу 3,5 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн байна. Хөгжлийн бэрхшээлтэй ажилтан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхэдтэй эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийн цалинг шатлал ахиулах, сар бүр нэмэгдэл олгох үйл ажиллагаануудыг шат дараатай хэрэгжүүлэн бас ажиллаж байна.

Эрүүл мэндийг дэмжих сангийн санхүүжилтээр Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоонд 21 аймаг, 9 дүүргийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд бэлгийн цогц боловсролыг хүртээмжтэй хүргэх чадавх олгох сургалтыг үе шаттайгаар зохион байгуулсан. ЮНЕСКО-оос гаргасан бэлгийн боловсролын арга зүйн удирдамжийн чиглэл болгож хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст бэлгийн цогц боловсрол олгох сургагч багшийг багц гарын авлагыг боловсруулан багц нөөц хэрэглэгдэхүүний хамт бас түгээсэн байж байгаа. Цаашид хүүхдийн тархины саагийн шалтгаант булчин чангарлын үеийн нугасны мэдрэлийн эмчилгээ болон чөмөг шилжүүлэн суулгах хагалгааг өөрийн орондоо бүрэн нутагшуулах, эрүүл мэндийн салбарт эрүүл мэндийн байгууллагын үйлчилгээний соёлтой холбоотой эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага стандартыг хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ээлтэй, тэднийг дэмжсэн орчныг бүрэн цогцоор хөгжүүлэх, хэрэгжүүлэх, эрүүл мэндийн байгууллагын дотор, гадна орчныг хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ээлтэй болгох шаардлага хэрэгцээ бидэнд байна.



Хөгжлийн бэрхиээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийн талаар. Хөгжлийн бэрхиээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжихтэй холбоотой хууль, эрх зүйн орчин Хөдөлмөрийн тухай, Хөгжлийн бэрхиээлтэй хүний эрхийн тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулиуд тэдгээрийг дагаж гарсан дүрэм журам, журмаар зохицуулагддаг байгаа. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад хөгжлийн бэрхиээлтэй иргэн ажиллуулаагүй ажлын байрны төлбөрийн хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулан тогтоох болон хөгжлийн бэрхиээлтэй иргэдийн хөдөлмөрлөх эрхтэй холбоотой бусад шинэ зохицуулалтыг тусган хэрэгжилтийг ханган бас ажиллаж байна. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2021 онд хийсэн судалгаагаар улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа нийгмийн даатгалын санд бүртгэлтэй 25-аас дээш ажилтантай 6500, 6500 байгууллагаас судалгаанд хамрагдсан 3200 байгууллага 9600 орчим хөгжлийн бэрхиээлтэй иргэн ажиллуулахаас 7200 гаруй иргэн ажиллуулж байгаа нь хуулийн хэрэгжилт ААНБ-д 61 хувь, төрийн байгууллагад 59 хувьтай хэрэгжиж байгааг харуулж байна.

Тийм ч учраас бид Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулж, хөгжлийн бэрхиээлтэй иргэд төрийн албанд ажиллах боломж бололцоог бас нээж өгсөн. Энэ нь хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай байгааг бидэнд харуулж байгаа юм. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хөдөлмөрийн хяналтын чиг үүрэг шилжиж ирсэнтэй холбоотойгоор өмчийн хэлбэр харгалзахгүйгээр бүх ААН байгууллагуудад хяналт шалгалт хийх боломжтой болсон нь хуулийн хэрэгжилтийг хангахад, эрчимжүүлэхэд бас эерэг нөлөө үзүүлж байгаа. Түүнчлэн хөгжлийн бэрхиээлтэй хүн ажиллуулаагүйн төлбөрийн орлогыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлж хөгжлийн бэрхиээлтэй

иргэдийн ТББ бизнес хийхийг дэмжих, хөдөлмөр эрхлэхийг дэмжих чиглэлээр бид нар бас зарцуулж байна. Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйл өмнө хүчин төгөлдөр байсан хуулийн 111 дүгээр зүйлийн хэрэгжилтийг хангах хүрээнд хөгжлийн бэрхиээлтэй хүнийг ажиллуулаагүйн төлбөрөөс Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд 2016 онд 349,5 сая төгрөг төвлөрүүлж байсан бол энэ хэмжээ жил бүр өсөж 2021 онд 11,5 тэрбум төгрөг, харин 2022 хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулан тогтоосны дагуу 4,7 тэрбум төгрөг, энэ оны 3 дугаар улирлын байдлаар 2,8 тэрбум төгрөгийг тус тус төвлөрүүлсэн. Хөгжлийн бэрхиээлтэй хүнийг ажиллуулаагүйн төлбөрийн орлогыг дараа оны Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсөвт хөгжлийн бэрхиээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зориулалтаар тусгадаг бөгөөд өмнөх оны орлогоос илүү хэмжээний хөрөнгийг тухайн жил бүр тусган холбогдох үйл ажиллагаанд зарцуулж байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүжилтээр хөгжлийн бэрхиээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлж байгаа бөгөөд 2022 онд 9,5 тэрбум төгрөгийг зарцуулсан 1,2 мянга гаруй ажлын байр, 2023 оны 3 дугаар улирлын байдлаар 7 мянга, 7,5 тэрбум төгрөг зарцуулж 2,4 мянга гаруй иргэнийг хамруулан 900 орчим ажлын байрыг бий болгоод байна. Япон улсын буцалтгүй тусламжаар Жайка байгууллагатай хамтран Хөгжлийн бэрхиээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тогтолцоог бэхжүүлэх төслийг 2021 оноос эхлүүлэн хэрэгжүүлж байна. Энэ төслийн хүрээнд хөгжлийн бэрхиээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төлөвлөгөөг боловсруулж, хүний нөөцийг хөгжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжин ажилладаг байгууллага хоорондын сүлжээтэй болох, ажлын байрны тохируулгат орчин нөхцөлийг бүрдүүлэх

талаар ААНБ байгууллагад зөвлөгөө өгдөг, ажлын байранд дадлагажигчийн тогтолцоо бас бүрдүүлэхэд чиглэн ажиллаж байна. Төслийн хүрээнд 2021 онд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар ажлын байрны дадлагажуулагч буюу job coach ажил мэргэжлийг үндэсний ажил мэргэжлийн ангилал, тодорхойлолтод жагсаалтад оруулж, ажлын байрны дадлагажуулагчийн үйл ажиллагааны удирдамжийг батлан загвар төслийг бид бас хэрэгжүүлж байна.

Хөгжлийн бэрхиээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын үйлчилгээний талаар. Ахмад настан, хөгжлийн бэрхиээлтэй хүн, хагас бүтэн өнчин хүүхэд, өрх толгойлсон эх, эцэг болон нийгмийн халамжийн дэмжлэг тусалцаа зайлиггүй шаардлагатай иргэдээс төрөөс нийт 72 нэр төрлийн нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж, тусламж, хөнгөлөлтийн үйлчилгээг хүргэж байна. Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхиээлтэй хүүхэд, иргэн, ахмад настныг асарч байгаа иргэнд олгох тэтгэмжийн хэмжээ 2018 онд 84 мянган төгрөг байсныг 123,1 мянган төгрөг болгож нэмэгдүүлсэн байсан. Үүнийг 2023 оны 7 дугаар сарын 1-нээс 275 мянган төгрөг болгож нэмэгдүүлсэн. Ирэх онд бас мөн инфляцтай уялдуулж нэмэгдүүлэхээр улсын төсөвт өргөн бариад байна. 9 дүгээр сарын байдлаар байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхиээлтэй иргэнийг асарч байгаа 14,7 мянга гаруй иргэнд 16,7 тэрбум төгрөгийг олгосон байна. Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхиээлтэй хүүхдийг асарч байгаа 12,9 мянга гаруй иргэн байгаа. Эдгээр иргэдэд 18400 төгрөг олгож байна. Байнгын асаргааны тэтгэмж том хүн асарч байгаа, хүүхэд асарч байгаа нь ялгаатай байсан. Үүнийг ижил тэгш болгож 2-оос 3 дахин нэмэгдүүлж 275 мянган төгрөг болгон 7 дугаар сарын 1-нээс олгож эхлээд байгаа юм.

Хөгжлийн бэрхиээлтэй иргэнд олгож байсан 188 мянган төгрөгийн тэтгэмжийн хэмжээг цар тахлын нөхцөл байдалтай уялдуулан 2020 онд 288 мянган төгрөг болгон нэмэгдүүлсэн бол 2023 оны 7 дугаар сарын сараас эхлэн 325 мянган төгрөг болгон нэмэгдүүлж мөн 9 дүгээр сарын байдлаар хөгжлийн бэрхиээлтэй 36,9 мянган иргэнд 86,6 тэрбум төгрөгийг олгоод байна. Хөгжлийн бэрхиээлтэй хүний эрхийн тухай хуульд хуулийн хүрээнд хөгжлийн бэрхиээлтэй хүнд үзүүлсэн тусламж хөнгөлөлтөд 2022 оны байдлаар 48,5 мянган иргэн хамрагдаж 10,1 тэрбум төгрөгийн төгрөгийг зарцуулсан байна. Нийгмийн даатгалын багц хуулийн хүрээнд тэтгэврийн даатгалын сангаас 2022 оны жилийн эцсийн байдлаар 62,2 мянган хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагчид 316,1 тэрбум, 23 оны 9 дүгээр сарын байдлаар 63,1 мянган тэтгэвэр авагчид 249 тэрбум төгрөгийн тэтгэврийг тус тус олгоод байна. Мөн тэтгэмжийн даатгалын сангаас 2022 оны жилийн эцсийн байдлаар 162,3 мянган хөдөлмөрийн чадвар түр алдсаны даатгуулагчид 27,4 тэрбум төгрөг, 2023 оны 9 дүгээр сарын байдлаар 104 мянган даатгуулагчид 22,6 тэрбум төгрөгийг тэтгэмж тус тус олгосон байна.

Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас 2022 онд 3,6 мянга, 3600 хөдөлмөрийн чадвар алдсан, алдсаны тэтгэвэр авагчид 27,5 тэрбум төгрөг мөн сангаас 1200 даатгуулагчид 1,3 тэрбум төгрөг, төгрөгийн тэтгэмж төлбөр, 2 мянган гаруй даатгуулагчид 1,1 тэрбум төгрөгийн сувиллын зардлыг тус тус олгосон бол 2023 оны 9 дүгээр сарын байдлаар 3500 хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагчид 22,6 тэрбум төгрөгийг мөн тус сангаас 1100 даатгуулагчид 1,3 тэрбум төгрөгийн тэтгэмж, 1200 даатгуулагчид 0,7 тэрбум төгрөгийн сувиллын зардлыг бас тус тус гаргаад байна.

Дүгнэж хэлбэл манай улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэн бүр нийгмийн даатгалын болон халамжийн сангаас тэтгэвэр авч байгаа бөгөөд цаашид нийгмийн халамжийн үйлчилгээний нэр төрлийг оновчтой болгон багцалж хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгох мөнгөн дүнг нэмэгдүүлэх нь зүйтэй юм. ОУБ-ын зүгээс Монгол Улсыг ялангуяа хүртээмжтэй нийгмийг бий болгоход хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэн болгон нийгмийн халамж хамгаалалд хамрагдаж байгаа нь сайшаалтай. Харин хүртээмжтэй байгаа ч гэсэндээ үүний дүнгийн нэмэгдлийг бид нар уялдаа холбоотой зохицуулалт илүү сайтай байх дээр анхаарах ёстой гэж бас зөвлөж байгаа юм.

Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмийн харилцаанд саад бэрхшээлгүй оролцоход чиглэсэн дэд бүтэц болон мэдээллийн хүртээмжийг сайжруулах. БХБ-ын сайдын тушаалаар барилга байгууламжийн норм, нормативын баримт бичиг, барилга байгууламжид хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүртээмжийг төлөвлөхийг баталж мөрдөн ажиллаж байна. Мөн БХБ-ын сайдын тушаалаар барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрмийг шинэчлэн боловсруулахаар ажиллаж байна. БХБ-ын сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан тушаалаар хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг төрөөс орон сууцаар хангахад дэмжлэг үзүүлэх хөтөлбөрийг саяхан баталсан. Энэхүү хөтөлбөр хэрэгжсэнээр түрээсийн орон сууцанд хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй өрхийн хамрагдах хувь хэмжээг нэмэгдүүлэх, орон нутгийн өмчийн орон сууцнаас тэргүүн ээлжид орон байргүй хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй өрхийг хөлслүүлэх эзэмшүүлэх, төлбөрийн уян хатан хөнгөлөлттэй нөхцөлөөр худалдан авах боломжийг бүрдүүлэхээр тусгасан байгаа. Энэ ташрамд тус хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийг

бас та бүхнийг дэмжихийг Улсын Их Хурал дээр хүсэж байна.

ЗТХЯ-наас явган хүний зам талбайн төлөвлөлт, төсөвлөлт болон техникийн шаардлагыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоотойгоор боловсруулж батлуулахдаа зам замын байгууламжид үнэлгээ хийх шалгах хуудсыг тусгаж дэд бүтцийн хүртээмжийн үнэлгээ хийх албан ёсны баримт бичигтэй болсон. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зүгээс хараагүй иргэнд зориулсан зам тавилаа гэхэд дунд нь гэрэлтүүлэг тавьчихдаг, зам юу тавилаа гэхэд өгсөх зам тавилаа гэхэд хаалгыг нь тохиромжтойгоор хийж чаддаггүй гэх мэтчилэн стандарт алдагдсан байдаг талаар маш их ярьдаг, шүүмжлэлтэй ханддаг. 2016-аас 18 онд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ТББ, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Жайка байгууллага, холбогдох төрийн байгууллагууд хамтран түүвэрлэн сонгосон автобусны зогсоол, явган хүний зам, нийтийн тээвэр, төрийн захиргааны үйлчилгээ, төрийн захиргаа, үйлчилгээний байгууллагуудын болон хувийн хэвшлийн барилга байгууламж, Хөшигийн хөндийн шинэ нисэх онгоцны буудал, түүнчлэн нийслэлийн хэмжээнд олон нийтийн зориулалттай 27 барилга байгууламжид нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын 30 гаруй байгууллагын үйлчилгээний хүртээмжид тус тус үнэлгээ хийсэн.

2022 онд Сүхбаатар, ЧД-ийн замд, замын байгууламж, нийтийн тээврийн үнэлгээний саадгүй байдал хүртээмж, Төрийн ордон, бүх яам, НЗДТГ, төвийн 6 дүүргийн ЗДТГ барилга байгууламж болон мэдээллийн технологи харилцаа холбооны үйлчилгээний саадгүй байдал хүртээмжид 3 чиглэлээр үнэлгээ хийсэн. Саадгүй байдал, хүртээмжийн үнэлгээг барилга, байгууламж, авто зам, замын байгууламж, нийтийн тээвэр болон мэдээллийн технологи, харилцаа

холбооны чиглэлээр үнэлгээ хийж зөвлөмжийн дагуу засаж сайжруулах арга хэмжээ авснаар үнэлгээ хийсэн газар нутагт Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, улмаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, нийгмийн харилцаанд саадгүй оролцох боломж нөхцөлийг бид нар нэмэгдүүлэх зайлиггүй шаардлага байна. Төрийн үйлчилгээг хүртээмжтэй болгох зорилгоор И-Монголиа, И-даатгал, И-халамж, e-job цахим системийг нэвтрүүлж, сонсголгүй иргэдэд төрийн үйлчилгээг саадгүй хүргэх зорилгоор зайнаас туслан зөвлөх төвийг байгуулан ажиллуулж байна.

Тухайлбал И-Монголиа системээс цахимаар лавлагаа тодорхойлолт авах боломжийг бүрдүүлснээр 2023 онд хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолголт, хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоосон шийдвэрийн лавлагааг 11 мянган хүн цахимаар авсан байна. Түүнчлэн ЗГ-ын хуралдааны мэдээлэл зарим төрийн байгууллагууд нэвтрүүлгүүдээ дохионы хэлтэйгээр тогтмол бэлтгэн хүргэдэг болоод байна. Мөн улсын их баяр наадмын нээлтийг дохионы орчуулгатайгаар олон нийтэд хүргэдэг болсон зэрэг мэдээлэл сурталчилгааны ажил сайжирч байна.

Жайка байгууллагатай хамтран хэрэгжүүлсэн Улаанбаатар хот дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог нэмэгдүүлэх төслийн хүрээнд Монгол Улсад анх удаа төр, ТББ хамтран харааны бэрхшээлтэй иргэдийн мэдээллийн хүртээмжийг 9, сонсголгүй иргэдэд иргэдийн мэдээллийн хүртээмжийг 7 шалгуур үзүүлэлтээр үнэлж тодорхой дүгнэлт зөвлөмжийг өгсөн. Дүгнэлтэд үндэслэн олон нийтийн телевизэд дохионы орчуулга болон үсгэн тайлбар оруулах олон улсын стандарт И702-ыг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангаж, веб сайтын болон IP телевизийн хүртээмжийг хангах олон улсын зөвлөмжийг Харилцаа холбооны

зохицуулах холбооноос баталсан. Мэдээллийн хүртээмжийг сайжруулах хүрээнд Ковид 19 цар тахлын үед 2020 онд теле хичээл, төрийн байгууллагаас цар тахлын тухай мэдээлэл зөвлөмж болон Улсын Их Хурлын сонгуулийн сурталчилгаа, сонгогчдын боловсролд зориулсан нэвтрүүлгүүдийг дохионы хэлмэрчтэй хүргэсэн нь хүртээмжтэй телевизийн тоо, нэвтрүүлгийн хувь өмнөх оноос өндөр болсон. Харин 2022 онд нийт 35 телевизээр мэдээ мэдээлэл, хүүхэд танин мэдэхүйн нэвтрүүлгийг дохионы хэлтэй нэвтрүүлсэн бол 2023 оны байдлаар нийт 42 телевизээр нийт хөтөлбөрийн 3,79 хувь нь дохионы хэлтэй харин 16 телевизийн хөтөлбөрүүдийн 1,2 хувь нь хадмал тайлбартай байна. Тэгэхээр энэ чиглэлд бид нар бас нэлээдгүй хийх ажил зайлиггүй байна.

Бүрэн хараагүй болон харааны бэрхшээлтэй иргэд нийгмийн харилцаанд бусад хүмүүсийн нэгэн адил тэгш оролцох, бусад хүмүүс харааны бэрхшээлтэй иргэдтэй брайл үсгээр дамжуулан харилцах, бие биедээ туслах, харилцан суралцах боломжийг бүрдүүлэх, мэдээллийн хүртээмжийг сайжруулахад чиглэсэн Монгол брайл бичгийн стандартыг батлан хэрэгжүүлж байна. АХБ-ны зээлийн санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хангах үйлчилгээг сайжруулах төслийн хүрээнд мэдээллийн хүртээмжийг сайжруулах зорилгоор харааны бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн Монгол хэлний бичвэрийг ярианд хөрвүүлэх программ хангамжийг хөгжүүлж, туршилтын ажлыг бид бас эхлүүлээд байна. Энэхүү программ хангамж нэвтэрснээр цахим үйлчилгээ, нийтийн тээвэр, ресторан зоогийн газар, банк зэрэг бусад үйлчилгээний байгууллагууд бүрэн ашиглаж, харааны бэрхшээлтэй иргэд үйлчилгээний хүртээмж сайжирч нийгмийн харилцаанд тэгш оролцох боломж бас бүрдэнэ. Мөн төслийн хүрээнд Монгол дохионы хэлмэрч бэлтгэх сургалтын хөтөлбөрийг боловсруулан

дохионы хэлний хэлмэрч орчуулгыг Сэргээн засалт, сургалт үйлдвэрлэлийн төв дээр бэлтгэж байна. Цаашид мэдээллийн хүртээмжийг сайжруулах чиглэхээр онцгой анхаарч ажиллах бид нар зайлишгүй шаардлагатай байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний бие даан амьдрах эрхийг хангах хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүний бие даан амьдрахад дэмжлэг үзүүлэх үйлчилгээний журмыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар батлан хэрэгжүүлж байна. Түүнчлэн 2017-гоос 2020 оны хүрээнд олон улсын тэмцээн уралдаанд оролцон амжилт үзүүлсэн ч урамшууллаа авч чадаагүй байсан 43 тамирчинд олгох 268 гаруй сая төгрөгийг олгохтой холбоотой асуудлыг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, Хөдөлмөр халамжийн ерөнхий газраас тамирчдын мөнгөн урамшууллыг олгох ажлыг зохион байгуулсан болно. Цаашид хөгжлийн бэрхшээлтэй тамирчдын урамшууллын асуудлыг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль болон ЗГ-ын 2018 оны Журам шинэчлэн батлах тухай 173 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулж, тус зардлыг бүхэлд нь Биеийн тамир спортыг дэмжих сангаас олгох зохицуулалтыг тусгахаар төлөвлөж байна.

Биеийн тамир, спортын улсын хороо, Монголын тусгай олимпын хороо, Паралимпын хороо, Дифлимпын хороо гэсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг биеийн тамир спортоор хичээллүүлэх, хичээллүүлэх, олон улсын уралдаан тэмцээнд оролцуулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-тай 2021-ээс 2023 онд хамтран ажиллах санамж бичиг байгуулж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд залуучуудыг биеийн тамир спортоор хичээллүүлэх, хөгжүүлэх, олон улсын тив, дэлхийн хэмжээний уралдаан тэмцээнд оролцоход дэмжлэг үзүүлэх, тамирчдын гаргасан амжилтыг олон нийтэд түгээх алдаршуулах зэрэг арга хэмжээг бид хийж хэрэгжүүлэх хэрэгтэй. Саяхан болсон Азийн паралимпын тэмцээнээс бас

манай Монголын тамирчид 8 медальтай бас ирсэн ийм сайхан амжилттай байгаа. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд олон улсын уралдаан тэмцээнд оролцох зардлыг Хүүхдийн төлөө сангаас гаргах зохицуулалт бол бий болсон.

Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хамт олон түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээний стандартыг батлуулж хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүнд тэгш хүртээмжтэй үзүүлэхэд байгууллагад тавигдах нийтлэг шаардлагыг тогтоож өгсөн. Нийслэл нийслэлийн Чингэлтэй дүүргийн 149 дүгээр сургуультай хамтран багш, ажилчдад эцэг эхчүүдийн хүүхдийн эрх хамгаалал, хөгжлийн бэрхшээлийн талаар ойлголт хандлагыг дээшлүүлэх, зөвлөгөө өгөх ажлыг бид бас зохион байгуулсан. Ийнхүү хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд ээлтэй сургуулийн загвар төслийг бид бас хэрэгжүүлж бусад сургуулиудад хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Хүүхдийн хөгжлийн цогц үйлчилгээний төвүүдийг байгуулж, санхүүжилтийг төрөөс олгуулах саналын дагуу манай яамнаас Хүүхэд хамгааллын тухай хууль болон Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 2018-аас 23 онд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн үүсгэн байгуулсан 20 гаруй төрийн бус байгууллагуудтай 700 гаруй сая төгрөгийн гэрээ байгуулан хамтран ажилласан. Цаашид хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд хөгжлийн цогц дэмжлэг үйлчилгээ үзүүлэхэд салбар дундын уялдаа холбоог хангаж, санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэхэд бүх талаар хамтран ажиллах хэрэгтэй байна.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Засгийн газраас хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах чиглэлээр хөгжлийн бэрхшээлийн талаарх олон нийтийн хандлага, ойлголтыг нэмэгдүүлэх, хүртээмжтэй орчныг бүрдүүлэх замаар тэдний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, бие даан амьдрах боломжийг бүрдүүлэх, бүрдүүлэхэд анхаарч ажиллах хэрэгтэй байна. Гэсэн хэдий ч бидэнд илүү сайжруулах, төрийн бодлогын түвшинд анхаарах асуудлууд бас цөөнгүй байна. Нийгмийн ойлголтыг, хандлагыг ч гэсэн нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагатай байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зүгээс бид өөрчлөгдөх биш, нийгэм өөрчлөгдөж, биднийг хүлээн зөвшөөрдөг, биднийг дэмждэг, хамтран амьдардаг ийм нийгмийг бий болгоход анхаарах хэрэгтэй байна гэдгийг бас хэлдэг. Иймд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, нийгмийн бүхий л харилцаанд ямар нэг алагчлалгүйгээр оролцуулах нөхцөл боломжийг бүрдүүлэхэд ойрын үед дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Нэгд.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль хэрэгжиж эхэлснээр 5 жилийн дараа хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэх, хуулийн давхардал үнэлэхэд хуулийн давхардал 24,4 хувь, зөрчил 35,5 хувь, хийдэл 13,3 хувь тус тус эзэлж байна. Нийт давхардлын 61 хувь нь нийгмийн халамж, 34 хувь нь боловсрол, 5 хувь нь бусад харилцаатай холбоотой байна. Иймд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд тэдний үндсэн эрхийг баталгаажуулж, хамгаалах, хариуцах этгээдийн чиг үүргийг нарийвчлан тодорхойлох зэрэг процедуруудыг бусад салбар хуулиудаар зохицуулах байдлаар тус хуульд шинэчилсэн найруулга хийх шаардлагатай гэсэн дүгнэлт гарсан. Тиймээс тус хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж байгаа бөгөөд нэр томъёог Монгол Улсын нэгдсэн нэгдэн орсон олон улсын гэрээ конвенцод нийцүүлэх, хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг ойлголт нэмэгдүүлэх, сургалтын

тогтолцоог тодорхой болгох, бие даан амьдрах эрхийг хэрэгжүүлэх үүднээс дэмжих үйлчилгээг илүү тодорхой болгож, ажлын байрны дадлагажуулагчийн тогтолцоог бүрдүүлэх зэрэг асуудлыг шинээр тусгасан. Хуулийн төсөл боловсруулах явцад төр болон ТББ-ын төлөөлд 9 удаа хэлэлцүүлэн санал авсан бөгөөд ирсэн саналуудыг ЗГ-ын хуралдаанд хэлэлцүүлэхээр яамнуудаас санал аваад авахаар аван бэлтгэж байна.

Хоёрт Саадгүй байдал, хүртээмжийн тухай анхдагч хуулийн төслийг боловсруулан ЗГ-ын хуралдаанд хэлэлцүүлэхээр бэлтгэж байна. Тус хуулиар нийтийн тээврийн хүртээмж, барилга байгууламж, авто зам, замын байгууламжийн хүртээмж, тээврийн хүртээмж, хүртээмж, мэдээлэл, харилцаа холбооны хүртээмж, үйлчилгээний хүртээмжийн асуудлыг зохицуулна. Хууль батлагдсанаар орон сууц, олон нийтийн барилга, байгууламж, нийтийн тээвэр, мэдээлэл, харилцаа холбооны технологийн болон үйлчилгээний хүртээмжийг сайжруулж, олон улсын түгээмэл загварт нийцүүлэн иргэд нийгмийн харилцаанд оролцоход дэд бүтэц, мэдээлэл үйлчилгээний хүрээнд тохиолдож буй саад бэрхшээлийг арилгаж, хөгжлийн бэрхшээлтэй иргэд нийгмийн харилцаанд оролцох, сурч боловсрох, хөдөлмөрлөх эрх боломж нэмэгдэх юм. Хуулийн төслийг төрийн болон төрийн бус байгууллагуудад 8 удаа хэлэлцэж хэлэлцүүлж, тэдний саналыг тусган Улсын Их Хуралд өргөн барихаар бэлтгэл ажлыг Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу анхаараад ажиллаж байна.

**Л.Мөнхбаатар:** Булгантуяа сайд цагаа бариарай. Нийтдээ 25 минутад багтаах ёстой байгаа.

**Х.Булгантуяа:** ЗГ-аас тэтгэврийг хүн амын амьжиргааны доод түвшин, инфляцын түвшинтэй уялдуулан жил бүр нэмэгдүүлэх чиглэлийг баримталж байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам энэ Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж байгаа бөгөөд уг хуулийн төсөлд нийгмийн халамжийн тэтгэврийг хүн амын амьжиргааны доод түвшин, хэрэглээний үнийн өсөлттэй уялдуулан жил бүр тогтоохоор тусгасан байгаа. Мөн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ зэргийг харгалзан ялгаатай байхаар бид бас тусгаж байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, хөдөлмөр хөтөлбөр төслийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг нарийвчлан тусгаж, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангаж байна. Гэр бүлийн тухай хуульд мөн зохицуулалтуудыг оруулан өнөөдөр ХЗДХ-ийн сайд өргөн бариад байна. 2020-оос 22-оос 23 оны хооронд өргөн хүрээнд хэлэлцүүлэг хийсэн. Ялангуяа хуулиар эрх ашиг нь хөндөгдөх хэсэг, өрх толгойлсон эцэг, эх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, гэр бүлийн гишүүний эрх ашгийг нэн тэргүүнд авч үзэхээр хуулийн зохицуулалтуудыг тусгаж өгсөн байж байгаа.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бие даан амьдрах, нөхөн сэргээх үйлчилгээний тухай хуулийн төслийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудтай хамтран боловсруулж байна. Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд холбогдох журмын дагуу сонгон шалгаруулалт орж байгаа ААН байгууллагуудад тавигдах шаардлага хөгжлийн бэрхшээлтэй хүн нийгмийн харилцаанд саад бэрхшээлгүй оролцоход чиглэсэн стандартуудыг заавал дагаж мөрдсөн байх. Хөдөлмөрийн тухай хуулийн 25 ба дээш ажилтантай байгууллага нийт ажилтны 4-өөс

доошгүй хувьд хөгжлийн бэрхшээлтэй ажилтан ажиллуулах заалтыг заавал хэрэгжүүлсэн байх тухай зохицуулалтыг нэмж тусган бид бас тусган батлуулна. Ирэх онд нийслэлд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлт хөгжлийн нэгдсэн төв, Архангай, Дорноговь, Завхан, Өвөрхангай, Өмнөговь аймгууд болон БЗД-т Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг цаашид бид барьж байгуулахаар төлөвлөж байна. Нийслэл Улаанбаатар хотын хүрээнд ийм төвийг бүсчлэн дор хаяж 4, цаашилбал дүүрэг болгонд нэг нэгийг барьж байгуулах хэрэгцээ шаардлага байна гэж үзэж байна.

Швейцарын Холбооны Улсын Женев хотноо 2023 оны 8 дугаар сард болсон Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хорооны 658, 659 дүгээр хуралдаанд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайдаар ахлуулсан холбогдох яамдын төлөөллийг хамруулсан Ажлын хэсэг ЗГ-ын 2 болон 3 дахь тайлан илтгэлийг хэлэлцүүлсэн. Хороо тайланг хэлэлцээд эцсийн дүгнэлтээ тайлагнах удирдамжийн дагуу бэлтгэгдсэн Монгол Улсын нэгдсэн тайланг сайшааж, олон талт, олон салбар бүрийг хамарсан ЗГ-ын холбогдох яамдын төлөөлөл оролцсон үр дүнтэй хэлэлцүүлэг болсныг өндрөөр үнэлж байгаа тухай дурдаж, цаашид анхаарах асуудлуудын талаар 70 гаруй зөвлөмж ирүүлсэн. Хорооноос ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэхэд чиглэсэн дунд хугацааны төлөвлөгөөг холбогдох яамд болон төрийн бус байгууллагуудтай хамтран боловсруулж хэлэлцүүлэн ЗГ-ын Хэрэг эрхлэхийн дарга бөгөөд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах зөвлөлийн даргаар батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллах болно.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудаас ирүүлсэн шаардлагуудтай холбоотой холбогдох уулзалтуудыг хийж, салбар дундын ажлын хэсгийг байгуулж, төлөвлөгөө батлан ажиллаж байна.

Эрхэм Улсын Их Хурлын гишүүд, Их Хурлын дарга аа, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал бол бас бүх нийтийн асуудал. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал хамардаггүй салбар гэж байдаггүй. Тийм учраас нийгэм хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ээлтэй болох дээр бид нийгмийн хандлагыг өөрчлөх, нийгмийг хүртээмжтэй болгох дээр та бүхнийг бас бодлогын дэмжлэг үзүүлж хамтран ажиллахыг хүсье.

**Л.Мөнхбаатар:** Булгантуяа сайдад баярлалаа. Мэдээлэлтэй холбогдуулан цөөнхийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн Амгалангийн Адъяасүрэн үг хэлнэ. Таныг индэрт урьж байна.

**А.Адъяасүрэн:** Монгол Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалах, оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны талаарх Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээллийг сонслоо. Улсын Их Хурлаас 2016 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг баталснаас хойш хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах, тэдний нийгмийн оролцоог дэмжих, нийгмийн хамгааллыг сайжруулах эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын багц хууль, Боловсролын багц хууль болон бусад цөөнгүй хуульд нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулж, шинэчлэн баталсан билээ.

Гэвч Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрх, НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенцуудын заалтууд болон дээрх хуулиудын хэрэгжилт хангалтгүй байгаагийн үр дагаврыг хөгжлийн бэрхшээлтэй иргэд эдэлж байгааг та бид өдөр тутамдаа харж байна. Нэн

тэргүүнд Үндсэн хуульд заагдсан амьд явах, хөдөлмөрлөх эрх зөрчигдөж байгаа талаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах төрийн бус байгууллагууд байнга анхааруулсаар ирсэн. Өнөөдөр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сар бүр авдаг тэтгэвэр 325 мянган төгрөг, тэднийг байнга асарч байгаа иргэнд олгох тэтгэмжийн хэмжээ 275 мянган төгрөг байна. Гэтэл хүнсний бараа бүтээгдэхүүний үнэ 2-оос 3 дахин нэмэгдсэн энэ үед хүнсний наад захын хэрэгцээг хангаж чадахгүй, шаардлагатай эм тариагаа авч хүрэлцэхгүй, өмсөх зүүхээ танахаас авхуулаад тухайн айлын амьдрал маш хүнд эмзэг буюу шууд хэлэхэд ядуурлын түвшинд очиж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд зөвхөн тэтгэмж авч амьдрах гэхээсээ илүү өөрийн нөөц боломжийн хэмжээнд тохирсон хөдөлмөр эрхлэх хүсэл сонирхол их байдаг ч тэднийг ажилд авахгүй, ажлын байраар хангагдах боломжгүй байгаа нь хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаагийн илрэл. Өнөөдөр хөдөлмөрийн насны 90 мянга орчим хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зөвхөн 13 мянга гаруй нь хөдөлмөр эрхэлж байгаа нь маш хангалтгүй үзүүлэлт юм. Хөдөлмөрийн тухай хуулийн өмчийн төрөл хэлбэрээс үл хамаарч 25 ба түүнээс дээш ажилтантай ААНБ нийт ажлын байрныхаа 4-өөс 4 хувиас доошгүй орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулна гэдэг заалт яагаад хэрэгжихгүй байна вэ? Засгийн газар Санаачлан төрийн бүх байгууллагад хуулийн энэ заалтыг хэрэгжүүлж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажиллуулах хувийн хэвшлийн байгууллагад татварын урамшуулал хөнгөлөлт үзүүлэх замаар энэ хуулийг хэрэгжүүлэх боломж байна уу гэвэл байна. Зөвхөн халамжлуулах биш бүтээх, сэтгэх хийх хүсэл эрмэлзэлтэй олон мянган хөгжлийн бэрхшээлтэй иргэдээ төрийн бодлогоор үр дүнтэй дэмжин ажиллаач гэж шаардмаар байна.



Манай улсын хөгжлийн бэрхшээлтэй өдөр тутамдаа тулгарч байгаа томоохон бэрхшээл нь хүртээмжийн асуудал юм. Өөрөөр хэлэх юм бол жил болгон олон арваараа ашиглалтад орж байгаа орон сууцны барилга, сургууль, цэцэрлэг, үйлчилгээний газрууд, зам, зогсоол худалдан авч байгаа тээврийн хэрэгслүүд нь энэ стандарт шаардлага хангаагүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд улам бүүр бэрхшээл үүсгэж, хүндрэл учруулж, хөгжлийн бэрхшээлтэй иргэн нийгмийн амьдралд бие даан оролцох, бие даан оролцох боломжийг хязгаарлаж байна. Энэ бүх асуудлыг зохицуулсан стандарт, хуулийн зохицуулалт байсаар байтал хэрэгжихгүй байгаагийн шалтгаан нь албан тушаалтнуудын хүнд суртал, ажилдаа хойрго, авлигын шинжтэй үйлдлүүд сүүлийн 8 жил эрх барьсан МАН хүсэхгүй, хэрэгжүүлэхгүй, хянахгүй, шаардахгүй, дүр эсгэж үйлдлээр биш амаар ажлаа хийдгийн тод жишээ, тод илрэл юм. Энэ мэтээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хуулиар тогтоосон эрх зөрчигдөж, тэдний хөдөлмөрлөх, сурч боловсрох, нийгмийн харилцаанд эрх тэгш оролцох эрх хангагдахгүй байгаа нь төрийн байгууллага үүргээ хангалтгүй биелүүлж байна гэж дүгнэхээр байна.

Мөн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгон үйл ажил явуулах эрх зүйн орчныг тодорхой болгох хэрэгтэй. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх, тэдний үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэхэд дэмжлэг үзүүлэх, төсвийн хөрөнгөөр хийх худалдан авалтад тэргүүн ээлжид хамруулах зэрэг ажлууд хийгдэхгүй байна. Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй хүний талаар зөв ойлголтыг нийгэмд төлөвшүүлэхэд чиглэсэн бодлого, хэвлэл мэдээллийн хэрэгслийн сурталчилгаа сургалт ч үгүйлэгдсээр удлаа.

Сүүлийн жилүүдэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийг дэмжих чиглэлээр улсын төсвөөс олгох хөрөнгө оруулалт багассаар 2023 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хамгаалах ерөнхий газрын багцад нэг ч төгрөг суусангүй. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд санд төвлөрүүлэх орлого 2021 онд 11,5 тэрбум төгрөг байсан бол 2022 онд 4,7 тэрбум төгрөг, 2023 оны эхний 3 дугаар улирлын байдлаар 2,8 тэрбум төгрөг болж буурснаас гадна тус сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан мэдээлэл сонсогдох болсоор удаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдээ нийгмээс тусгаарлах бус харин ч ажлын байраар хангах, өрхийн үйлдвэрлэлд нь тэргүүн ээлжид дэмжлэг үзүүлэх, сургах, олон нийтэд түшиглэн хөгжүүлэх замаар тухайн хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг, тэдний гэр бүлийг дэмжих нь цаашилаад төрийн зүгээс дундаж давхаргыг нэмэгдүүлэхэд чухал алхам болох юм.

Одоогоос 4 жилийн өмнө буюу 2019 оны улсын төсөвт 3 аймагт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төвийн барилгын хөрөнгийг тусган хэрэгжүүлж эхэлсэн хэдий ч түүнээс хойш нэг ч төв нэмж баригдсангүй. Гэтэл улсын төсвийн орлого, зарлага хэдэн их наядоор шаардлагагүй хөрөнгө оруулалт, хөшөө дурсгалд олон тэрбум төгрөгийг зарцуулж байгаа нь хүнээ гэсэн сэтгэл дутмаг байгаагийн илрэл юм. Иймд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангахтай холбоотой хууль тогтоомж, дүрэм журмын биелэлтэд ЗГ-ын зүгээс онцгойлон хяналт тавьж, зохион байгуулалтын оновчтой шийдлүүдийг гарган шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэж ажиллах нь зүйтэй гэж сөрөг хүчний бүлгийн зүгээс үзэж байна.

Өнөө цагт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төрөлхийн болон олдмол шалтгааны судалгааг хийж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах нь чухал асуудлын нэг болоод байна. Цус ойртолт,

ургийн гажиг үүсэхээс сэргийлэх, оюуны хүний бэрхиээлийн шалтгаануудыг бууруулах арга хэмжээнүүдийг авах бусад улс орнуудын туршлагыг судлах ажиллагаа ямар түвшинд явж байгаа нь дэндүү бүрхэг байгааг онцлон тэмдэглэмээр байна. Хөгжлийн бэрхиээлтэй хүний таатай, аюулгүй орчинд амьдрах, сурч боловсрох, шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцох, улс төрийн эрхээ эдлэхэд саад болж байгаа үйлдэл эс үйлдэхүйг Монгол Улсын нэгдэн орсон НҮБ-ын конвенцод ч, Хөгжлийн бэрхиээлтэй хүний эрхийн тухай хуульд ч ялгаварлан гадуурхалт гэж заасан байгааг бид мартаж болохгүй.

Түүнчлэн хөгжлийн бэрхиээлтэй гэх хөгжлийн бэрхиээлтэй иргэн гэх хуулийн нэршил зөв үү, хөгжлийн бэрхиээлтэй иргэн хэмээн тодотгож байгаа аргачлал дэлхийн улс орнуудын жишигтэй нийцэж байна уу гэдгийг ч бас бодолцох цаг болжээ. Монгол Улсын ЗГ-ын зүгээс хөгжлийн бэрхиээлтэй иргэдэд чиглэсэн үйл ажиллагаа, хууль, хэрэгжилт хангалтгүй байгаа байдал тэднийг тэтгэмжийн мөнгөөр амьдрах, ядуу амьдрах нөхцөл рүү түлхэж байгааг анхааралдаа авч, төрийн зөв, үр дүнтэй бодлогоо хэрэгжүүлж, хөгжлийн бэрхиээлтэй иргэдийн эдлэх эрх тэгш хүртээмжтэй, нийгмийн харилцаанд оролцох нөхцөлийг сайжруулах, ажлаа хийхгүй байгаа албан тушаалтнуудыг хууль хэрэгжүүлэхийг шаардах, зөрчлүүдийг арилгах чиглэлээр Улсын Их Хурал дахь АН-ын бүлэг эрх баригчдад шаардлага тавьж, анхаарал хандуулж ажиллах болно гэдгийг энэ таширамд дурдъя. Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Л.Мөнхбаатар:** Адъяасүрэн гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Хүрэлбаатарын Булгантуяа, БХБ-ын сайд Цэрэнпилийн Даваасүрэн, Эрүүл мэндийн сайд Содномын Чинзориг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны ТНБД Энхтуяагийн Ганхүү, БШУЯ-ны ТНБД

Лхагвын Цэдэвсүрэн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Амарсайханы Хишигбаяр, тус яамны Хүн амын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Сандагийн Тунгалагтамир, тус яамны Нийгмийн халамжийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах дарга Болдын Ундрал, тус яамны Хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг дэмжих хэлтсийн дарга Борын Алтантулга, Хөгжлийн бэрхиээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Цэрэнсодномын Нямсүрэн, БХБЯ-ны Барилга инженерийн дэд бүтцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Доржпаламын Гантулга, ЭМЯ-ны Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газрын дарга Аюурзаны Өнөржаргал, БШУЯ-ны Тэгш хамран сургах боловсролын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Гомбодоржийн Саранхүү, байгаа юу? Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албаны дарга Лхамтогмидын Нямгэрэл, СЭМҮТ-ийн захирал Ванчиндоржийн Баярмаа нар оролцож байна.

Мэдээлэлтэй холбогдуулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд болон ажлын хэсгийн гишүүдээс асуулт асууж, үг хэлэх цөөнхийн бүлгийн гишүүд байна уу? Цөөнхийн бүлгээс зөвхөн асууна. Алга байна. Улсын Их Хурлын зөвхөн цөөнхөөс асууна, дэгээрээ тийм юм байгаа. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 109.11-д заасны дагуу Parliament цахим хэлэлцүүлгийн платформ дээр байршуулсан Ерөнхий сайдын мэдээлэлтэй холбогдуулан иргэдээс ирсэн саналуудыг ЗГ-ын гишүүнээс асууна. Улсын Их Хурал дахь МАН-ын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн Бадарчийн Жаргалмаа асуулт асууя. Асуулт, хариулт 20 минут үргэлжилнэ. Асуултаа асууя.

**Б.Жаргалмаа:** Та бүхнийхээ өдрийн амгаланг айлтгая. Иргэдээс маш олон санал ирсэн байна. Тэгээд би Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд болон бусад ажлын хэсгийнхнээс миний асуултад ямар нэгэн удиртгалгүйгээр шууд хариулаарай гэж хүсье. Иргэн Нандинжаргалаас НӨАТ-ын буцаан олголтыг 5 хувь болгох юм бол хөгжлийн бэрхиээлтэй иргэний амьдралд бага ч гэсэн тус болох болов уу гэсэн байна. Асуултынхаа хариултыг авчхаад дараагийнхаа асуултыг асуугаад явчихъя. Нэгэнт асуулт байгаа учраас хариулаад, хариулаад явчих тэгэх үү? Булгантуяа сайд.

**Х.Булгантуяа:** НӨАТ-ын буцаан олголтын талаар хуулийн дагуу Сангийн сайд эрхлэх асуудлын хүрээнд байгаа учраас мэдээж энэ буцаан олголт нэмэгдвэл хөгжлийн бэрхиээлтэй иргэдийн хувьд бол энэ бас л амьдралд нь нэмэртэй л байгаа. Тэгэхээр би Нандинжаргал иргэнээс ирсэн саналыг бол дэмжиж байна.

**Б.Жаргалмаа:** Иргэн Мөнгөншагай, Долгорсүрэн, Содбаяр нараас хөдөлмөрийн чадвараа 70-аас дээш хувь алдсан хүний эм тариа, асаргааны мөнгийг заавал өгөх ёстой тэд өөрсдөө ажиллах боломжгүй байдаг бөгөөд ар гэрт нь хүндрэл их гардаг. Энэ талаар ямар ажил хийгдэж байна вэ гэсэн асуултыг ирүүлсэн байна.

**Х.Булгантуяа:** Байнгын асаргаа шаардлагатай иргэдийн хувьд эм тарианы санхүүжилтийг бас олгодог байж байгаа. Мөн байнгын хөгжлийн бэрхиээлтэй иргэдийн хувьд хөгжлийн бэрхиээлтэй иргэн өөрөө хүмүүс үүнийг бас их юу яадаг, өөрөө авч байгаа болохоороо 325 мянга, байнгын асаргаа шаардлагатай бол байнгын асаргааны асаргаа үзүүлж байгаа иргэнд нь олгож байгаа голцуу эцэг эхчүүд байдаг энэ нь 275 мянган төгрөг. Мөн эмийн эм, эм тарианы бас нэмэгдлүүдийг бас олгож байгаа.

**Б.Жаргалмаа:** Энэ 70 хувь хөгжлийн.../үг тасрав/

**Л.Мөнхбаатар:** Ажлын хэсгийн гишүүдээс бас нэмж хариулахаар болбол та нар микрофоноос шууд дараад хариулж болно шүү. Нэр, албан тушаалаа хэлээд тийм ээ.

**Х.Булгантуяа:** За, тэгээд тохируулга нь хийчихсэн үү.

**Б.Жаргалмаа:** Энэ Содбаяр бас ингэж асуусан байна л даа 70 хувь алдсан хүмүүстээ олгож болдоггүй юм уу? СХД хүн ам, ихтэй хөгжлийн бэрхиээлтэй иргэн ихтэй байгаа нь үнэн. Гэхдээ өгөх ёстой юм бол өгч болдоггүй юм уу гэж асуусан байна.

**Х.Булгантуяа:** Хишигбаяр дарга харуулах уу? Шууд дараад юу яачих, шууд дараад хариулчих.

**Б.Жаргалмаа:** Дараад явчих.

**Х.Булгантуяа:** Одоо асаж байна наад микрофон нь.

**Л.Мөнхбаатар:** Хэд байна вэ микрофон чинь? 84 дүгээр микрофоныг өгье, микрофоныг ер нь нээчих. Ажлын хэсгийн гишүүд албан тушаал, нэрээ хэлээд асуултад хариулаад, шууд хариулаад явж болно шүү. Жаргалмаа гишүүний асуултад. Ажлын хэсгийн 84 дүгээр микрофоныг өг дөө.

**Б.Ундрал:** Хөгжлийн бэрхиээлтэй иргэдийн асаргааны асуудлыг болбол Амьжиргаа дэмжих зөвлөл тогтоодог байгаа. Аймаг, дүүргүүд дээр улсын хэмжээнд 2 мянга гаруй амьжиргаа дэмжих зөвлөл ажилладаг. Байнгын асаргааг болбол хөгжлийн бэрхиээлтэй иргэдийн хувь хэмжээгээр ерөөсөө огтхон ч тодорхойлдоггүй байгаа. 70 хувь, 60 хувь, 90 хувьд гэхгүй. Гагцхүү өвчин гэмтлийн жагсаалтын дагуу комиссын хурал ороод тухайн шийдвэр гараад

ингээд явдаг байгаа. Иргэний энэ хүсэлтийг бид нар шалгаад эргээд иргэнд нь хариу өгье.

**Б.Жаргалмаа:** Иргэн Энхнямаас хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүүхдийг гадаад, дотоодын коллеж, их дээд сургуульд хөнгөлөлттэй болон үнэ төлбөргүй сурах боломжоор хангаж өгнө үү. 2 дугаар асуулт хүнд суртал, авлигаас хол байлгах, мөн хэрэггүй олон бичиг цааснаас чөлөөлж өгнө үү. Энэ асуудал дээр хуульд дорвитой заалт оруулах хэрэгтэй байна гэсэн байна.

**Х.Булгантуяа:** Боловсролын яамны ТНБД хариулах уу? Их дээд сургуулийн, коллежийн сургалтын төлбөрийн асуудлаар.

**Л.Мөнхбаатар:** Хэд байна вэ, ажлын хэсгийн 80 дугаар микрофоныг өгье.

**Л.Цэдэвсүрэн:** Иргэний асуултад хариулъя. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүүхдийг гадаад дотоодын сургуульд суралцуулахад бид нар эхний ээлжид дотооддоо ЗГ-ын 2022 оны 346 дугаар тогтоолоор баталсан журмын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй бакалавр, магистр, докторын хөтөлбөрт суралцаж байгаа оюутнуудад тэтгэлэг өгч байгаа. Мөн эцэг эх нь хоёулаа хөгжлийн бэрхшээлтэй бакалаврын хөтөлбөрт суралцаж байгаа оюутнуудад тэтгэлэг тэтгэмжүүд өгч байна. Хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан гишүүнтэй өрхийн бакалаврын хөтөлбөрт суралцаж байгаа хүүхдүүдэд бас мөнгө өгч байгаа. Тэгээд төрийн өмчийн их дээд сургуульд хөдөлгөөн засалч, хөдөлмөр засалч мэргэжлээр суралцаж байгаа оюутнуудад ингээд санхүүгийн дэмжлэгүүдийг тус тус өгөөд явж байгаа. Түрүүн Булгантуяа сайдын илтгэлд бол тодорхой тоон баримтууд хэлсэн учраас энэ энийг бол давтах боломжгүй гэж бодъё, шаардлагагүй гэж үзлээ.

Ер нь цаашид ямар арга хэмжээ авах гэж байгаа вэ гэхээр гадаад улсад, ялангуяа Унгар, Франц, Польш, ОХУ, Вьетнам зэрэг улсуудад энэ бид нар ЗГ хоорондын хамтын ажиллагааны хүрээнд тусгай хэрэгцээт боловсролын мэргэжилтэн бэлтгэх чиглэлээр гэрээ хэлэлцээрүүдээ бол шинэчлээд явж байгаа. Тийм учраас энэ ажлыг бол цааши нь үргэлжлүүлээд хийнэ. Мэдээж боловсролын салбарт хүүхдүүдэд үйлчилгээ үзүүлэхэд ямарваа нэгэн хүнд суртал, авлигаас хол байлгах, бүх л бодит арга хэмжээнүүдийг авч байгаа. Хэрэггүй олон цааснаас салгах гэдгийг нэг л сайн ойлгосонгүй. Энэ хэрвээ багштай холбоотой асуудал үүсэж байгаа бол багшийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор бид нар үйл ажиллагааны цахим шилжилтүүдийг нэлээн сайн хийж байгаа гэдгийг бас иргэндээ хэлэх гэсэн юм.

**Х.Булгантуяа:** Хүнд сурталтай холбоотойгоор сая Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбар дээр ЗГ-ын Хэрэг эрхлэхээс процессын дахин инженерчлэлийг хийсэн. Үүний үр дүнг бид нар бас хэвлэл мэдээлэл олон нийтэд танилцуулсан. Ер нь бол үнэн. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд гэлтгүй жирийн иргэдээс ч гэсэндээ олон бичиг цаас шаарддаг. Нэг үйлчилгээ авах гэж бараг 6 шат дамжлага дамждаг энэ бүх юуг бид нар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбар дээр хүнд сурталыг бууруулах, шат дамжлагыг багасгах энэ ажлыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбар ЗГ-ын яамнуудаас хамгийн түрүүлж хийхээр төлөвлөөд байгаа.

**Б.Жаргалмаа:** Иргэн Батмөнх, Баасанхүү, Сүнжидмаа, Эрдэнэ-Очир нар нэг зүйлийг асуусан байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний бүртгэлийг жил бүр сунгуулдаг группийг гэсэн үг байна тийм ээ, жил бүр сунгуулдаг байх хэрэгтэй юм уу? Ихэнх нь эрхтэн дутуу байхад заавал 1-ээс 2 жилийн дараа дахин хурлаар орж байж сунгадаг эсвэл хасдаг. Тэглээ гээд

хөл, гар хуруу ургахгүй. Энэ заалтыг бүх насаар нь болгож болдоггүй юм уу гэсэн утга бүхий асуултыг иргэд асуусан байна. Саяын иргэд.

**Х.Булгантуяа:** ЭМЯ хариулах уу? Дугаараа хэл, микрофоныхоо.

**Л.Мөнхбаатар:** Дугаараа өгөөрэй. Ажлын хэсгийн 87 дугаар микрофоныг өгье.

**А.Өнөржаргал:** Ер нь хэдийгээр хөгжлийн бэрхшээлтэй иргэн гээд ингээд нэг хуруугүй тэр нь хэзээ ч дахиж ургахгүй энэ тэр гээд ингээд энэ асуудлуудаар ингээд яриа гардаг ч гэсэн эрүүл мэндийн байгууллага бол заавал ч үгүй энэ иргэнд дараагийн өөр өвчин энэ энэтэй холбоотойгоор үүсэх эрсдэлийг нь заавал ч үгүй тооцоолж, заавал ч үгүй хянадаг. Жишээлбэл нэг нүдний ийм бэрхшээлтэй байгаад ингэх юм бол тэр хүнд заавал ч үгүй симпатик үрэвсэл буюу нөгөө нүдэнд нь заавал ч үгүй нөлөөлөл ингэж үүсдэг учраас тэрэнд нь сөрөг нөлөө үүсэх вий гэдгээс эрүүл мэндийн салбар эмч нар бол заавал ч үгүй энэ хүнээ хянаж байж энэ эмнэлэг магадлалын комиссоор ингээд оруулдаг юм. Тэгэхээр энэ дээр болбол яах вэ тодорхой хэмжээгээр бид нар энэ комиссын хурлын хуралд бол шинэ хурлынхаа энэ журмыг ингээд шинэчилж байгаа. Тэгэхдээ энэ дээр бас тодорхой хэмжээний criteria тавьж, энэ хүмүүсийн энэ тавьж байгаа асуудлыг бас бид нар авч үзэж, авч үзнэ.

**Л.Мөнхбаатар:** Ажлын хэсгийн гишүүд асуултад хариулахдаа нэр, албан тушаалаа хэлээрэй. Яагаад гэвэл Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан бүтэн протоколтой явдаг. Хэний асуултад хэн хариулж байгаа нь их тодорхой байх учиртай. Асуултаа үргэлжлүүлье.

**Б.Жаргалмаа:** Иргэн Ууганбаяр хөдөлмөрийн чадвар 50-аас 60 хувь алдсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдээ энгийн сургуульд явуулах болоход эмч нар

асаргааны болон эм тарианы мөнгийг хасдаг асуудлыг болиулах хэрэгтэй байна. 2 хүүхдийн тохиолдлыг би дурдаж болно шүү гэсэн байна.

**Х.Булгантуяа:** Жаргалмаа гишүүний, Ууганбаяр иргэний асуултад хариулъя. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд тэгш хамран сургахаар энгийн сургуульд суралцаж байгаа тохиолдолд асаргааны тэтгэмж хасах хууль, эрх зүйн орчин байхгүй. Энэ тэгэхээр асаргааны мөнгийг бол эмч хасах ч эрх байхгүй. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс нь шийдвэр гаргахдаа аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн төрөлжсөн мэргэжлийн багийн дүгнэлтийг үндэслэж тухайн хүүхдийг хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тогтоодог. Салбар комиссын хурлаар орохдоо оношоо тодорхойлуулж төрөлжсөн мэргэжлийн багаар заавал дүгнэлт гаргуулсан байх ёстой.

Тэгээд ер нь бол ялангуяа энэ групп тогтоох эмнэлэг, магадлангийн комисс, энэ тэрийн процессуудыг ер нь их хөнгөвчлөхгүй бол энэ дээр их алдаа, бухимдал иргэдээс маш их гарч байгаа асуудлууд бол байгаа. Хоёрхон минутын хуралд орох гэж бараг бүтэн сарын ажил болдог. Хэдэн мянган км явдаг. Дээрээс нь нэмээд хөдөлмөр хамгааллын салбар маань зөвхөн харьяаллаараа үйлчилдэг. Тэгэхээр Улаанбаатар Архангайн иргэн Улаанбаатар хотод байлаа гэхэд группээ гэж ярьдаг, группээ сунгуулахад заавал буцаж Архангай руу очихгүйгээр Улаанбаатар хотын хаана нэг харьяа манай салбар дээр нийгмийн даатгал дээр очоод сунгуулах энэ хууль, эрх зүйн орчинг, журмыг бид нар бас шинэчилсэн байгаа. Одоо удахгүй ХЗДХЯ-ан дээр бүртгүүлээд, ингээд дагаж мөрдөхөд боломжтой болж байгаа.

**Б.Жаргалмаа:** Яалт ч үгүй энэ асуудал бол хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд маш хүндрэлтэй тусдаг учраас энэ асуудлыг яаравчлан шийдэх ёстой

байх. Иргэн Батмөнх 2 асуулт ирүүлсэн байна. Хөгжлийн бэрхиээлтэй хүний сурч боловсрох эрхийг хангах талаар ерөнхий боловсролын сургууль, их дээд сургууль, цэцэрлэгийн орчин буюу дэд бүтцийн асуудлыг ямар шат дараатайгаар шийдэж, боловсролд тэгш хамруулах бодлогыг хэрэгжүүлж байна вэ? Өнөөдөр тулгамдаж байгаа гол асуудлын нэг нь хөгжлийн бэрхиээлтэй иргэдийн саадгүй байдал, тэгш хүртээмжийн үнэлгээг барилга байгууламж, авто зам, замын байгууламжийн асуудлыг нэн яаралтай шийдэхийн тулд бодитой юу хийж хэрэгжүүлж байна вэ гэсэн байна. Уг нь түрүүн сайдын ер нь мэдээлэлд байсан тийм ээ. Сайд товч хариулчих. Товчхон хариулаарай.

**Х.Булгантуяа:** 80 номер, Боловсрол, шинжлэх ухааны ТНБД.

**Л.Цэдэвсүрэн:** Батмөнх иргэний асуултад хариулъя. Цэдэвсүрэн БШУЯ-ны ТНБД. Хөгжлийн бэрхиээлтэй хүний сурч боловсрох эрхийг хангах хамгийн гол зүйл маань бол эрх зүйн орчныг боловсронгуй болгох байсан. Бид нар энэ оны 7 сард Боловсролын ерөнхий хууль болон бусад хуулиудаа шинэчилж батлуулахдаа хөгжлийн бэрхиээлтэй суралцагчийн сурах эрхийг баталгаажуулж, боловсролын зарчим болон тэгш хүртээмжтэй, ялгаварлан гадуурхахгүй байх, нээлттэй байх чиглэлийг бол тусгаж өгөөд энийгээ бол хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Хөгжлийн бэрхиээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулахад хувьсах зардлын бүтцийг бол шинэчилсэн. Хувьсах зардлын бүтцийг шинэчлэхдээ өмчийн бүх хэлбэрийн цэцэрлэг, ЕБС-ийн сургуульд хөгжлийн бэрхиээлтэй хүүхэд ингээд суралцах тохиолдолд тухайн хүүхдэд ногдох хувьсах зардлыг 3 дахин нэмэгдүүлж олгодог. Үүнийгээ бол хэрэгжүүлээд явж байна. 2 дахь нэг гол агуулга юу байдаг вэ гэхээр хөгжлийн бэрхиээлтэй хүүхдүүдтэй ажиллах

багшийг бэлтгэх асуудал. Боловсролын их сургууль дээр энэ багш бэлтгэх хөтөлбөр, агуулгууд бүгд шинэчлэгдээд багш нарыг бэлтгээд явж байна. Хамгийн гол зүйл нь ЕБС болон энгийн цэцэрлэгт ажиллаж байгаа багш нарыг хөгжлийн бэрхиээлтэй хүүхэдтэй ажиллах боломж нөхцөл, тэд нарыг тийм заах арга, ур чадварт сургах нь хамгийн чухал байдаг. Өнөөдрийн байдлаар энгийн хэв шинжийн 811 багш цэцэрлэгийн, ерөнхий боловсролын 925 багш ингээд хөгжлийн бэрхиээлтэй хүүхдүүдтэй ажиллаад явж байна. Энэ багш нарыгаа дэмжих зорилгоор бид нар 10 хувийн нэмэгдэл бол бас олгоод явж байгаа. Мэдээж.../үг тасрав/

**Б.Жаргалмаа:** Уучлаарай, баярлалаа. Иргэн Сарантуяагаас 8 асуулт ирүүлсэн байна. Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйл заалтын хэрэгжилт чинь хэр байгаа вэ? Энэ зөвхөн санг бүрдүүлэх биш хөдөлмөрийн чадвараа алдсан иргэдийг хөгжлийн бэрхиээлтэй иргэдийг ажлын байраар хангахад чиглэгдсэн байдаг. Гэтэл энэ заалтын хэрэгжилт ямар хэмжээнд байна вэ гэсэн асуулт байна. Би өөрийнхөө асуултыг нэмчихье. ЗГ-ын яам, агентлагууд яг энэ Хөдөлмөрийн тухай хуулийн 144-ийг хэр хэрэгжүүлж байгаа вэ? Тоон мэдээлэл авъя.

**Х.Булгантуяа:** Тунгалагтамир дарга хариулах уу? Юугаа өргөөрэй тоогоо.

**Л.Мөнхбаатар:** Хэд вэ? Микрофон 83 уу? Ажлын хэсгийн 83 дугаар микрофоныг өгье.

**С.Тунгалагтамир:** Тунгалагтамир Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга. Хөдөлмөрийн тухай хуулийн 144-ийн хэрэгжилт өмнө бол өмнөх хуулийн хэрэгжилтийг хангаж байх үед бол ЗГ-ын 2019 оны 111 дүгээр тогтоолоор хөгжлийн бэрхиээлтэй хүн

ажиллуулаагүй ажлын байрны төлбөрийг болбол тогтоосон. Энэ дээр болбол тухайн ААНБ-ын дундаж цалингаар ингээд тогтоосон байсан учраас санд төвлөрөх мөнгөн хөрөнгө болбол илүү өндөр болбол болж орж ирсэн. ЗГ-ын тогтоолоор энэ төлбөрийг тогтоогоод байхаар бас нөгөө нэг маш олон удаа ингээд өөрчлөгдөөд дээшээ доошоо савлаад байдаг байсан учраас яг хуульд бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний сарын хэмжээгээр тооцож, нэг хүний ажиллуулаагүй ажлын байрны төлбөрийг төлдөг байхаар зохицуулалт тусгаад, тэгснээр болбол түрүүний бас яригдаад байгаа хөгжлийн бэрхиээлтэй энэ санд төвлөрч байгаа мөнгөн хөрөнгө багасаж байна гэсэн асуудал бол гарч ирж байгаа. 11,1 гэдэг юм уу, 11 тэрбум төгрөгийн хувьд болбол яг энэ санд төвлөрсөн хөрөнгөөс гадна дээрээс нь улсын төсвөөс мөнгө нэмж, мөнгө хөрөнгө нэмж төвлөрүүлээд Хөгжлийн бэрхиээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг болбол санхүүжүүлж хэрэгжүүлдэг байж байгаа юм.

ЗГ-ын байгууллагуудын хувьд бол бид бас тодорхой судалгаануудыг болбол авч байгаа. Энэ дээр тухайлбал нийтдээ бүх яамнууд дээр байгаа нийт хөгжлийн бэрхиээлтэй иргэдийн тоо, нийт ажилтан юу салбаруудын нийт ажилтны тоо бол хорь, хорин, хоёр зуун жаран юу 36053 ажилтан байгаа. Эндээс ажиллавал зохих орон тоо 9441 гээд. Эндээс хөгжлийн бэрхиээлтэй ажилтны тоо болбол 4,1 мянга буюу 4200 орчим байна. Энэ нэг 51 орчим хувийг болбол яг хуулийн хэрэгжилтээр яг бүх салбарын хувьд болбол хангаж байгаа төрийн байгууллагууд дээр. Яамдын хувьд болбол 1600 орчим ажилтан ажил юу албан хаагчтайгаас ажиллавал зохих орон тоо нь үндсэндээ 62. Эндээс бол хөгжлийн бэрхиээлтэй ажилтны тоо 25, 30 орчим байгаа гээд. Тэгэхээр энэ дээр 36, 7 хувийн яг энэ хуулийн хэрэгжилт бол хангагдаад ажиллаж байгаа. Энэ дээр бол бас тодорхой салбарууд дээр бага гэдэг юм уу тодорхой салбарууд дээр юу, тодорхой

яамнууд дээр, яамнууд дээр бас огт ажиллуулахгүй байгаа ийм асуудлууд бас байгаа. Энэ дээр бид нар бас улирал тутамдаа яг бас яамнууд руу яг энэ чиглэлээр холбогдох бичиг явуулдаг. Мөн тоонуудыг нь жил, хагас жилээр болбол авч нэгтгэдэг байгаа.

**Х.Булгантуяа:** Үүнтэй холбоотойгоор Жаргалмаа гишүүний асуултад тодруулахад ер нь бол хувийн хэвшилд төрийн байгууллагуудаас энэ хуулийн хэрэгжилт сайн байгаа. Төрийн байгууллагууд дээр түрүүний хэлсэнчлэн яаман дээр 30 гаруйхан хувьтай байна гэдэг бол хөгжлийн бэрхиээлтэй иргэдийн хувьд төрийн үйлчилгээний албан тушаал дээр харьцангуй гайгүй. Төрийн захиргааны албан тушаал дээр бол тэнцэж ороход хэцүү байгаад байсан учраас өнгөрсөн жил гэж байхад төрийн захиргааны албан тушаал дээр шалгалт өгсөн хөгжлийн бэрхиээлтэй иргэд бараг 2, 3-хан байсан. Тэгэхээр бид нар үүнтэй холбоотойгоор сая 7 дугаар сард Төрийн албаны тухай хууль дээрээс нь нэмээд Хөгжлийн бэрхиээлтэй иргэдийн хууль ингээд холбогдох хуулиудад өөрчлөлт оруулж, хөгжлийн бэрхиээлтэй иргэн төрийн захиргааны албан тушаалд ажиллах, ахиж дэвших энэ процессыг нь, шалгуурыг нь 2 дахин багасгаж өгсөн байж байгаа.

**Б.Жаргалмаа:** Баярлалаа. Тэгээд иргэдийн ирүүлсэн асуулт ийм байна. Одончимэг гээд иргэн нөгөө зарим асуултууд түрүүн нөгөөдөх сайдын илтгэлд дурдчихсан учраас би асуусангүй өнгөрөөчихлөө уучлаарай. Одончимэг гишүүн нэг асуулт ирүүлсэн байна. Яг хөгжлийн бэрхиээлтэй хүн төрөөс авдаг хөнгөлөлтөө бүрэн авдаггүй, энд хэрхэн хяналт тавьж, шалгаж байна вэ гэсэн асуулт байна. Энэ дээр товч хариулаач.

**Х.Булгантуяа:** Тунгалагтамир дарга хариулах уу 80 номер тийм ээ.

**Л.Мөнхбаатар:** 83 ажлын хэсгийн 83 дугаар микрофоныг өгье.

**С.Тунгалагтамир:** Тунгалагтамир Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга. Хөгжлийн бэрхиээлтэй хүмүүсийн хувьд болбол Хөгжлийн бэрхиээлтэй хүний эрхийн тухай хуульд заасан нийгмийн халамжийн сангаас олгох хөнгөлөлт тусламжид хамрагдах шалгуур, болзол нөхцөлөө хангасан, хүсэлт гаргасан иргэн үйлчилгээнд хамрах, хамрагдах бол бүрэн боломжтой байгаа. Тэгээд тухайлбал протез ортопед тусгай хэрэгсэл, рашаан сувиллын үйлчилгээ болоод нарийн мэргэжлийн эмч эмнэлгийн байгууллагын дүгнэлтэд үндэслээд болбол яг энэ үйлчилгээнд болбол хамрагддаг байж байгаа.

Харин нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хувьд бол тэтгэвэр, тэтгэмж авах эрх үүссэн сараас бол хүсэлтээ гаргаад И-халамж болоод И-Монгол цахим системд дансаа холбуулаад иргэн бүр одоо сар, улирал, одоо хагас жил, жил гээд ингээд давтамжит хугацаагаар болбол тухайн тэтгэвэр, тэтгэмж, тусламж үйлчилгээнд болбол шууд бүрэн хамрагдах ийм боломжтой байгаа. Халамжийн үйлчилгээнд хамрагдах хүсэлтэй иргэдийн тухайд бол сум, хороо, аймаг, нийслэл, дүүргийн бол халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, халамжийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас эсвэл халамжийн үйлчилгээний байгууллагуудын цахим хуудсаар дамжуулаад мэдээлэл авах бүрэн боломжтой байгаа. Яг энэ хяналт тавьдаг асуудлын хувьд болбол манай нийгмийн халамжийн бүх шатны байгууллагууд бол хяналт тавьж ажиллаж байгаа.

**Б.Жаргалмаа:** Надад нөгөө цаг бага үлдсэн учраас би иргэн Баярсайханаас ирүүлсэн 3 асуултыг товчлоод асуугаадахъя. Хөгжлийн бэрхиээлтэй хүүхэд хөгжүүлэх төв 16-

аас 20 ажиллаж байна. Тэдэнд ямар нэгэн санхүүжилт байдаггүй олон жил тэтгэвэрт хандаж байгаа гэсэн ийм мэдээлэл байна. Энэ хүүхэд, Хөгжлийн бэрхиээлтэй хүүхэд хөгжүүлэх төвийн санхүүжилтийн асуудлыг хэрхэн яаж шийдвэрлэдэг юм бэ? Нөгөө талаар хөгжлийн бэрхиээлтэй хүүхэд 18 нас хүртлээ улсын асрамжид байгаа байхчаад, 18 нас хүрчхээд хаачихаа мэдэхгүй ийм нөхцөл байдалд байна. Энийг яаж шийдвэрлэх юм бэ гэдэг нэг ийм асуулт байна.

Би бас өөрийнхөө асуултыг тавьчихмаар байна. Ер нь ургийн гажиг илрүүлэх 4 төв ажиллуулна гэж байсан. Эх хүүхдийн эрүүл мэндийн төв, АШУИС дээр ингээд 2 төв ажиллаж байгаа. Нөгөө 4 төв байгуулах асуудлыг хэрхэн яаж шийдвэрлэж байгаа юм бэ? Энэ дээр ямар нэгэн төсөв хөрөнгө байна уу? Ургийн гажгаа бид нар ургийн явцад нь илрүүлчих юм бол бас хөгжлийн бэрхиээлтэй иргэдийн асуудал бас тодорхой хэмжээнд шийдэгдэнэ. Өнөөдөр протез ортопедийн үйлдвэр маань байргүй хэвээрээ байгаа шүү дээ. Мэргэжилтэн бэлтгэх тал дээр, үүнийг байртай болгох тал дээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хэрхэн хандаж байна вэ? Ер нь салбар дундын санхүүжилтээр шийдвэрлэдэг болж байгаа хөгжлийн бэрхиээлтэй хүүхдүүдийн асуудлаа. Бид нар Боловсролын хуульд энэ асуудлыг шийдвэрлүүлсэн. Тэгвэл яг салбар дундын зохицуулалтаа бид нар хийж чадсан уу? Бид хугацаа алдахгүйгээр хүүхдүүддээ энэ чиглэлийн халамж үйлчилгээгээ үзүүлэх ёстой, сургалтын байгууллагад хамруулах ёстой. Энэ асуудал ер нь хэрхэн яаж шийдвэрлэгдэж байна вэ?

Өнгөрсөн ер нь 9 дүгээр сард ДЭМБ-ын Ерөнхийлөгчтэй уулзах үеэр Монгол Улсын хөгжлийн бэрхиээлтэй иргэдийнхээ талаар авч хэрэгжүүлж байгаа бодлого үйл ажиллагаа хууль, эрх зүйн орчин дээр бол хангалттай сайн гэсэн үнэлгээг өгч байсан. Тэгвэл ер нь ЗГ дээрээ яг амьдралд хэрэгжих тал дээр энэ



асуудал ер нь удаашралтай байна гэдэг шүүмжлэлийг бас иргэд ч гэсэн хэлж байна. Энэ дээр ер нь ямар, ямар үйл ажиллагааг зохион байгуулах гэж байна вэ? Өнөөдөр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төвийнхөө удирдлагыг хүртэл бид нар тийм ээ томилж чадаагүй байгаа. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийнхөө газрынхаа даргыг ч гэсэн бид нар бас тийм ээ томилж чадаагүй байгаа. Яг энэ асуудал дээр хөгжлийн бэрхшээлтэй иргэд маань өөрсдөө иргэддээ чиглэсэн үйл ажиллагааг явуулах тэр боломжийг нь нээх үүднээс хөгжлийн бэрхшээлтэй иргэдээр ийм байгууллагуудаа удирдуулъя гэсэн ийм шийдвэр гаргасан боловч өнөөдрийг хүртэл шийдвэрлэж чадаагүй байгаа ийм асуудал байна. Ер нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд маань өнөөдөр зөвхөн хөгжлийн бэрхшээлээсээ шалтгаалан ажил хөдөлмөр эрхлэх маш их сонирхолтой байгаа. Тэгвэл энэ асуудал дээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам яг ямар арга хэмжээ авч байгаа юм бэ гэдэг зүйлийг би тодруулъя. Ингээд иргэдийнхээ асуулт болон өөрийнхөө асуултын хариулыг даргаа авах боломжийг олгож өгнө үү. 20 минут маань дуусчихлаа.

**Х.Булгантуяа:** Би нэг юун дээр нь товчхон хариулчихъя. Асрамжийн газруудад 18 нас хүрсэн бага насны ч гэсэндээ 18 нас хүрээгүй 0-10 насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд бас их байдаг. Эдгээр хүүхдүүд 18 нас хүрээд хүүхдийн асрамжийн төв учраас энд үргэлжлүүлэн байлгаад байх хэцүү байдаг. Яг авдаг, үргэлжлүүлэн асардаг эрүүл мэндийн.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** 20 минутад багтааж асуулт хариулт явах дэгтэй. Тэгээд цаг болсон байна. Улсын Их Хурал дахь АН-ын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн Наянтайн Ганибал ЗГ-ын гишүүнээс болон ажлын хэсгээс асуулт асууна. Наянтайн Ганибал гишүүний микрофоныг өгье.

**Н.Ганибал:** Өнөөдөр бид бүхэн бас ер нь хөгжлийн бэрхшээлтэй гэдэг нэр томъёо дээрээсээ эхэлье гэсэн энэ асуудлыг бас тодорхой хүмүүс санал тавьсан, асуулт асуусан байгаа. Тэгэхээр өнөөдрийн саяын Булгантуяа сайдын мэдээлэл дотор ингээд 3 янзын нэр томъёо гарч ирлээ. Нэгд нь болохоороо Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамныхан маань бол яах вэ хөгжлийн бэрхшээлтэй иргэд гэдэг албан ёсны нэр томъёогоо ашиглаж байх шиг байна. Манай Боловсролын яамныхан болохоор тусгай хэрэгцээт иргэд гэдэг нэр томъёоллыг их хэрэглэж байна түлхүү, мэдээллийнх нь өгсөн дарааллаар нь харахаар тэгж харагдаж байна. 3-д нь ялгаатай хэрэгцээт гэдэг нэр томъёо бас хэрэглэлээ. Дээр нь бид нар бас нөгөө бас олон жил бас ашиглаад одоо харин арай гайгүй болчихоод байгаа л даа. Группийн асуудал дээр бол тахир дутуугийн групп гэдэг нэр томъёолол бол олон жил ашиглагдсан тийм ээ. Тэгэхээр энэ болгон маань өнөөдөр бид нарын юуг харуулаад байна вэ гэхээрээ бид нар өнөөдөр энэ хөгжлийн бэрхшээлтэй иргэддээ төр засгийн нэгдсэн бодлого ЗГ-ын нэгдсэн бодлого харагдахгүй байна. Энд асуудалдаа хандаж байгаа нэр томъёоноосоо эхлээд энэ иргэддээ ээлтэй ийм төр болж чадаж байна уу үгүй юү гэдэг энэ асуудал гарч ирж байгаа юм. Тэгэхээр энэ дээр цаашид яг алийг нь ашиглах юм бэ? Олон улсын нэр томъёо хэрэглэж байгаа энэ асуудал дээрээ аль хэрэгцээг нь ашиглах юм бэ, ялгаатай хэрэгцээт гэдэг юм уу? Ер нь зүгээр олон улсын жишигээр бол тэр өндөр хөгжссөн, хүний эрх дээдэлсэн улс орнуудын хувьд бол тэр тусгай хэрэгцээт гэдэг нэр томъёолол бас ашиглагддаг юм байна лээ.

Тэгэхээр энэ дээрээ та бүхэн бас нэгдсэн байр сууриа яам яамныхаа зүгээс бас илэрхийлээч. Тэгээд ер нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам маань энэ дээрээ тогтсон нэр томъёо яг алийг нь ашиглах юм бэ цаашид, тэрэн дээрээ бас саналаа хэлээч? Тэгээд ер нь зүгээр нэг бид нарын бас нэг муу, нэг юу байгаа шүү

дээ дурсамж, муу нэг жишиг байгаа. Тэр нөгөө Хөдөлмөр, нийгмийн хамгааллынхаа сайдыг улныхан гэдэг нэр томъёоллыг ашигласнаараа бүүр сайдаа өөрчилж огцруулж байсан ийм гашуун туршлага байгаа. Тэгэхээр энэ дээр хэдүүлээ бас хүндээ ээлтэй, хүнийхээ эрхийг дээдэлсэн, ер нь нэр томъёолоо алийг нь ашиглавал дээр юм бэ? Хөгжлийн бэрхшээлтэй гэдэг томъёолол бол тухайн хүнийг хөгжихгүй, ямар нэгэн тийм хөгжил байхгүй болсон гэдэг тийм нэр томъёолол болоод байна гэдэг саналыг бас манай сая Адъяасүрэн гишүүн маань бас сая дүгнэлтдээ санал болгоод бас ярилаа. Тэгээд энэ асуултдаа хариулт аваадахъя.

**Х.Булгантуяа:** Микрофон нь асаагүй.

**Л.Мөнхбаатар:** Булгантуяа сайдын микрофон өгье.

**Х.Булгантуяа:** Ганибал гишүүний асуултад хариулъя. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үндэсний хороон дээр эрхийг хамгаалах үндэсний хороон дээр бас энэ асуудлыг ярьсан юм. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зүгээс бол нэр томъёо яах вэ бид нар луу чиглэсэн харин зүгээр үйл ажиллагаа, үйлчилгээг л сайжруулаад өгөөч, хүртээмжийг л нэмэгдүүлээд өгөөч. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд гэдэг дээр гэдэг нэр томъёо дээрээ бид нар нэг их эмзэглэхээсээ илүүтэйгээр хөгжлийн бэрхшээлтэй гэж бид нарыг мэдсээр байж дахин, дахин групп тогтоолгох гэж байна гээд л явуулдаг. Нийгэм нь өөрөө хүртээмжгүй байгаа байдал дээр бид нар харин анхаарах ёстой юм гэж үзэж байгаа. Манай эрүүл мэндийн салбарынхан үүн дээр тусгай хэрэгцээт энэ тэр гээд энэ талаар нэмэлт эрүүл мэндийн чиглэлээр нэмэлт хариултауд өгөх болов уу гэж бодож байна.

Одоогийн манай нийгмийн даатгалын сая бид нар 23 оны 7 дугаар сард Нийгмийн даатгалын багц хуулийг батлууллаа. Тэгэхэд энэ хууль дээр бол энэ

өмнөх хууль дээр тахир дутуугийн тэтгэвэр гэж гэдэг юу бол байсан. Одоогийн хууль дээр бол байгаа. 24 оны 1 дүгээр сарын 1-нээс хэрэгжих шинэ хуульд бол бид нар энийг хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр гэж болгож нэр томъёог нь бол бас бид нар, дээрээс нь нэмээд нөгөө *people disability* гээд яг хөгжлийн бэрхшээлтэй иргэн гэдэг талаас нь бол энэ нэр томъёог нь бол шинэчилсэн. Манай Нийгмийн даатгалын багц болбол сая 23 оны 7 дугаар сард батлагдахад шинэ хууль батлагдсантай холбоотойгоор хүчингүй болгосон хуулиуд дотор БНМАУ-ын гэсэн хууль хүртэл байсан. Тэгэхээр энэ нэр томъёо дээр бол зарим нэг хуулиуд дээр бол ийм хуучин нэр томъёотой, хүний эрхийн жоохон мэдрэмжгүй нэр томъёотой зүйлүүд бол байсан. Тэгээд энийг бол шинэчилсэн. Эрүүл мэндийн салбарынхнаас яг тэр нөгөө тусгай хэрэгцээт, онцгой хэрэгцээт гэдэг талаас нь тайлбарлах уу? 37 номер.

**Л.Мөнхбаатар:** Ажлын хэсгийн 87 юу? 87 дугаар микрофоныг өгье.

**А.Өнөржаргал:** Өнөржаргал Эрүүл мэндийн яам. Манайх Эрүүл мэндийн тухай хуульдаа нэмэлт, өөрчлөлт оруулах оруулахаар ажиллаад, тэгээд тахир дутуу гэсэн энэ нэр томъёо Эрүүл мэндийн тухай хуульд явсныг нь өөрчилж хөдөлмөрийн чадвараа алдсан гэдэг ийм нэр томъёогоор явж байгаа. Ер нь бол цаашидаа бол хөдөлмөрийн чадвар түр алдсан, хөдөлмөрийн чадвар алдсан гээд ингээд энэ ч чиглэлдээ болбол эрүүл мэндийн салбарт хэрэгжиж байгаа бодлогодоо бол бас ингэж оруулж байгаа. Ер нь болбол бас яг хөгжлийн бэрхшээлтэй иргэн гэсэн яг энэ иргэний эрхийн тухай хууль гэдэг нэр томъёогоороо бол цаашидаа бас энэ бүх бодлогын баримт бичигтээ энэ нэмэлтүүдийг хийгээд явна.

**Х.Булгантуяа:** Боловсролын Төрийн нарийн тусгай хэрэгцээт боловсролын тухай нэмэлт мэдээлэл өгөх үү? 80.

**Л.Мөнхбаатар:** Ажлын хэсгийн 80 дугаар микрофоныг өгье.

**Л.Цэдэвсүрэн:** Ганибал гишүүний асуултад хариулъя. Ер нь яах вэ Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль өөрөө суурь хууль. Манай Боловсролын багц хууль өөрөө салбарын хууль. Тэгэхээр бид нар энэ өнөөдөр энэ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын мэдээлэлд оруулсан үг, үсэг бол яг энэ одоо хүчин төгөлдөр мөрдөгдөөд явж байгаа хуулийн үг, үсгүүд бол явж байгаа. Сая 23 оны 7 сард батлагдсан Боловсролын багц хууль дээрээ бид нар тэгш хамран сургах боловсрол гэдэг нэр томъёог ер нь аваад, энийгээ бол бүхэл тусгайлсан бүлэг болгоод энэ чиглэлээрээ ажиллаж байгаа. Яагаад ийм нэр томъёог авчав гэхээр ер нь Монгол Улсын ЗГ Боловсролын яамнаас Сонгол иргэдийн, Монгол хүүхдүүдийн боловсролд тэгш хамруулах, тэднийг ялгаатай байдлыг нь хэтэрхий зааглах ийм бодлого бол баримтлахгүй байгаа. Тийм учраас тэгш хамран сургах боловсрол гэдэг бүлгийг бол бий болгоод батлуулаад, ингээд хэрэгжилтийг нь зохион байгуулаад явж байна. Магадгүй ЭМЯ болон бусад холбогдох мэргэжлийн байгууллагуудаас хуулийг шинэчлээд батлагдахад энэ нэр томъёо бол нэгдсэн нэг зохицуулалтад орно гэж бодож байна.

**Н.Ганибал:** Тэгээд ер нь зүгээр хэдүүлээ бас аль болох бас хүний эрхээ дээдэлсэн, тэр хүн, энэрэнгүй тэр нэр томъёоллоо хэдүүлээ ашиглаад нэгдсэн байдлаар ашиглаад явах нь нөгөө тэр нэрнээсээ эхлээд бүх юм анхаарлаа хандуулах нь илүү төрийн анхаарал хандуулах нь илүү л дээ. Тэгээд ер нь нэг ийм асуудлууд байгаад байгаа юм. Түрүүн сая Жаргалмаа гишүүн бас асуултдаа асуусан. Иргэдийн ер нь асуусан асуултын бараг 30 хувьд нь байна лээ л дээ. Энэ төрөлхийн болон эдгэшигүй ойлгомжтой өвчтэй хүмүүсийн группийг сунгах асуудал нь жил болгон бол группэд оруулж, дахин хэлэлцүүлээд байгаа энэ

асуудлууд буруу. Энэ угаасаа буруу гэдгийг нь бүх энэ асуудалд хандсан иргэд хэлээд байгаа юм. Тэгэхээр энэ дээр юу гэдэг юм нөгөө нэг нүд нь болохгүй бол нөгөө нүдийг нь шалгаж байгаа гээд буруу хариулаад байна л даа. Тийм боломж гэж байхгүй шүү дээ. Хүн гэдэг чинь өөрөө өөрийнхөө өвчнийг тодорхойлоод, би одоо болохоо байлаа, ийм учраас энэ группэд хэлэлцүүлэгт оръё л гэж байгаа болохоос ямар та бүхэн группээр дамжуулж хүнийг хүнд эрүүл мэндийн үзлэг хийж байгаа гэдэг ойлголт чинь маш буруу шүү. Энэ дээрээ та бүхэн шинэ гарах журам дээрээ ингээд хатуу шийдээрэй. Энэ дээр энэ асуудалтай чинь болоод бас манай Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбооноос тодорхой бас асуулга юуг Булгантуяа сайд, ЗГ-т тавьсан шүү дээ. Тэгэхээр та бүхэн энийг хүлээж аваад, шийдээд өгөөрэй гэж бас манай бүлгийн зүгээс түрүүн дүгнэлтдээ албан ёсоор оруулчихсан байгаа.

2 дахь асуудал нь ер нь зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй гэдэг энэ нэр томъёолол нь өөрөө халамж авч байгаа асуудал биш, зөвхөн халамжийн асуудал биш шүү гэдгийг манай бас тавьсан асуудал тавьсан иргэдийн ихэнх нь тавьсан байна лээ. Энд бид нарыг хөгжүүлэх бидэнд тэр боломжийг олгох асуудлуудаа илүү тавьж өгөөч. Энэ асуудал дээр олон асуудлуудыг өнөөдөр шийдсэн гэж сая Булгантуяа сайдын мэдээлэл дотор байна л даа. Хуулийн хувьд зохицуулалт хийчихсэн. Өнөөдөр төсөв хэлэлцэж байгаа энэ үед яг энэ асуудлууд дээрээ бодитой ямар нэмэгдлүүдийг бий болгов, төсөвт яаж суув? Жишээлбэл танай яаман дээр хүртэл жишээ ярьж байна лээ л дээ. Өнөөдөр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам нь хүртэл тухайн иргэн ороход зориулалтын шат байдаггүй, зориулалтын довжоон дээгүүр гарах ийм боломжууд зам талбайнууд нь болдоггүй. Манай Төрийн ордон гэхэд Ромын пап ламыг ирэхэд л энэ боломжоороо хангагдсан шүү дээ. Өнөөдөр 30 жил, сүүлийн 30 жил бид нар бол ямар нэгэн

боломжийг бас нээгээгүй явсан юм байна гэдэг нь батлагдсан. Тэгэхээр энэ дээр бодитой хийгдэж байгаа ямар асуудлууд байна вэ?

Тэр спорт, аялал жуулчлалын, спортын нөгөө сайдын яаман дээр хороон дээр нь очихоор нөгөө хөгжлийн бэрхшээлтэй тамирчид маань дасгалжуулагч нар бас бодлогын хүмүүстэй уулзах боломж бас байдаггүй гэж байгаа юм. Тэгэхээр энэ дээр та бүхэн маань энэ жилийн төсөв дээр яг ямар ажлууд хийгдэх бол гэсэн асуулт байна.

**Х.Булгантуяа:** Ганибал гишүүний асуултад хариулъя. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төвийг сая бид нар 5 аймагт ашиглалтад оруулсан. Яг ийм жишиг төвийг энэ жишиг зургийг, жишиг төвийг ямар үйлчилгээ авах хэрэгцээ шаардлага байгааг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төрийн бус байгууллагуудтай, иргэдтэй нь хамтран бид нар энэ зураг төсвийг хийсэн. Яг ийм төвийг ахиад бид нар 4 нэмж барьж байгуулахаар улсын төсөвт суугаад явж байна. Зарим манай Дорноговь аймаг, Өмнөговь аймаг гэхэд орон нутаг өөрсдийнхөө төсвөөр үүнийг хийх гэж байна. Ахиад Завхан аймагт, Архангай аймагт нэг баригдаж байна. Ингээд Улаанбаатар хотод гээд нэмээд барьж байгуулах гэж байна. Мөн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сургалтын төвийг бид энэ 11 дүгээр хороололд бас барих баригдаад энэ ажил нь явж байна, 70 хувийн гүйцэтгэлтэй байгаа. Энэ 23 онд, 24 оны хавар ашиглалтад орохоор байгаа.

Сая Улсын Их Хурлын дарга Занданшатарын Солонгост хийсэн айлчлалаар мөн Солонгосын талаас хөнгөлөлттэй зээлээр хөгжлийн бэрхшээлтэй иргэд мөн урт хугацааны сэргээн засах ийм эмнэлгийг Монгол Улсад барьж байгуулахаар болсон байж байгаа. Үүнд бас спортын чиглэлийн эмнэлэг бас нөгөө адилхан хүнд гэмтэл болдог учраас ийм сэргээн засах чиглэлийн эмнэлгийг

Монгол Улсад бас барьж байгуулахаар болсон байгаа. Мөн бид спортын чиглэлийн нэлээн томоохон төвийг барьж байгуулахаар болж байгаа. Энэ нь ганцхан хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд гэлтгүй Монгол Улсын хэмжээнд томоохон хэмжээний олимпын бэлтгэлийг хангах ийм том спортын комплексыг, энэ нь бас хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй байдлаар барьж байгуулахаар төлөвлөж байна. Ер нь таны хэлж байгаа бас үнэн. Яг үнэнийг хэлэхэд бид нар одоо ингээд л хүүхдийн эрхийн асуудлыг ярьж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлыг ярьж байна. Монголын өнөөдөр гудамж талбай, дээрээс нь нэмээд иргэдийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хамгийн их үйлчилгээ авдаг барилга байгууламжууд хамгийн хүртээмж муутай юм байна лээ. Бараг манай бүх яамнуудаас бодвол манай ЭМЯ, манайх, Боловсролын яам энэ хэдэн яамд дээр хөгжлийн бэрхшээлтэй иргэд хамгийн их очиж үйлчилгээ авч байгаа.

Тэгэхээр барилга байгууламжууд нь ЭМЯ, манай яам 2 бол хамгийн хуучин барилгатай. Тэнд лифт ЭМЯ-нд бол бараг, огт байхгүй. Тэгэхээр тэрнээс үүдний жижүүрээс дээшээгээ явж чадахгүй гэсэн үг. Манай ер нь хөдөлмөр халамжийн хэлтсүүд, нийгмийн даатгалууд, гэр бүл, хүүхэд хөгжлийн хэлтсүүд бүгдээрээ адилхан. Аймаг дээр ч адилхан, дүүрэг дээр ч адилхан. Дүүргийн ЭМТ-үүд бас бүгдээрээ адилхан дандаа дээр үед баригдсан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байдлаар огт баригдаагүй. Одоо үүнийг шинэчилж сайжруулахын тулд дараагийн энэ барилгад нэлээн их хэмжээний засвар үйлчилгээ орох ёстой юм байна лээ. Тийм учраас сая 5 төвийн нээлтийг хийхэд Монгол Улсын Ерөнхий сайдаас цаашид Монгол Улсын төсвөөр баригдаж байгаа ялангуяа үйлчилгээний чиглэлийн барилга байгууламжуудыг жишиг зургийг шинэчилж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй болгох нь зүйтэй гэж үзсэн. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд

ээлтэй байна гэвэл ахмад настан ч ээлтэй байна, хүүхдүүдэд ч ээлтэй байна гэсэн үг. Энэ бол төсвийн хувьд тэгэхдээ нэмэгдэнэ. Яг ийм чиглэлийн сургууль энэ тэр бол бараг төсөвт өртөг нь 20-оос 30 хувиар бараг нэмэгдэж орж ирэх байх.

Тэгэхдээ бид нар өнөөдөр томоохон дүүргүүд жишээлбэл хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн ганцхан цэцэрлэгтэй. Манай БЗД ганцхан цэцэрлэгтэй. Тэгээд тэр нь Сансарын тэнд байдаг 10 дугаар цэцэрлэг. Энд өнөөдөр Шар хаднаас, Хонхороос, Гачууртаас хүмүүс хүүхдээ зөөж авчирч ирж хамрагдуулна гэдэг бол маш хэцүү. Тийм ч учраас СӨБ-ын хамрагдалт бол бас харьцангуй бага байдаг. ЕБС-д ч гэсэндээ хамрагдахад уг нь аль болохоор хүний эрхийн тухай хуулиараа ч гэсэндээ хамгийн ойрхон сургуульдаа хамрагдмаар байдаг. Гэтэл сургуульд нь орох, гарах гарц ч байхгүй, орлоо хүртээмжтэй бие засах газар ч байхгүй, орлоо шаардлагатай техник тоног төхөөрөмж ч байхгүй. Одоо дэлхий даяараа хөгжлийн бэрхшээл гэдгийг манай бараг л одоогийн нөхцөлөөр бол ингээд л 1 нүд нь хараагүй гэвэл 50 хувийн чадвар алдсан, 2 нүд нь хараагүй гэвэл 100 хувь чадвар алдсан гэж л үнэлэх гээд байдаг. Гэтэл дэлхий даяараа техник тоног төхөөрөмж хөгжсөн энэ цаг үед хөгжлийн бэрхшээлтэй хүн ч гэсэндээ хаанаас ч, ямар ч байдлаар ажил хөдөлмөр эрхлэх боломжтой болсон. Ингээд компьютер техник тоног төхөөрөмжийн чадавх, чадвараар гэрээрээ ч ажил хийж болно, ирээд ч ажил хийж болдог баймаар байна.

Гэтэл таны хэлж байгаагаар салбарынх нь яам нь хүртэл л үнэнийг хэлэхэд бол бас хэцүү. Манай зарим өнөөдөр өрөө тасалгаануудаар бол орох бол ямар ч боломж байхгүй, лифт ч байхгүй. Яг бид нар манай хөгжлийн бэрхшээлтэй асуудал хариуцсан манай газар бол нэг давхарт яг үүдтэйгээ хамгийн ойрхон байрладаг. Тэгэхдээ хуучны барилга учраас бас их амаргүй. Ер нь манай барилга байгууламжийн

стандартууд ийм л байгаа юм байна лээ. Тэгэхээр бид нар энэ стандартуудыг шинэчлэх, зураг төсвийг шинэчлэх дээр бас Ганибал гишүүнийг үүн дээр төсөв санхүүжилтийг ер нь бас шахаж ажиллаасай гэж хүсэж байна.

**Н.Ганибал:** Ер нь тэгээд асуудлуудаа бүгдээрээ ойлгосон бас одоо яах вэ энэ Булгантуяа сайд маань бас орж ирээд олон асуудлууд дээр хууль, эрх зүйн хувьд Их Хурлын гишүүнийхээ хувьд бол маш олон асуудлуудыг шийдсэн л дээ. Тэрийг бүгдээрээ харж байгаа. Одоо бид нарын хувьд бол яг нөгөө бодит хуулиа хэрэгжүүлэх, дээрээс нь бид нарын тэр нэг жоохон хүний эрхийн мэдрэмжтэй, энэрэнгүй үйлдлүүдийг хийх нь бол ЗГ, төрийн болон хувийн хэвшлийнхэн бүгдээрээ л энэ дээр хамтарч ажиллах зайлиггүй шаардлагатай харагдаад байгаа юм.

Батсуурь гишүүн бид 2-ын хувьд бол яг орон нутаг дахь албан ёсны бие төлөөлөгч маань бол Сүхбаатар аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбооны тэргүүн байдаг. Тэгэхээр би манай Сүхбаатар аймгийн жишээ л дээ зүгээр тэнд хүмүүс маань бол ямар нэгэн байдлаар би группийн групп авдаг хөгжлийн бэрхшээлтэй иргэн гэж өөрсдийгөө ханддаггүй. Жишээ болгоод хэлэхэд харааны бэрхшээлтэй иргэд маань нийлээд бас бариа заслын томоохон үйл ажиллагааг явуулдаг. Өнөөдөр Сүхбаатар аймагтаа бол нэлээн алдартай ийм бариа заслын үйлчилгээг явуулдаг. Дээрээс нь ер нь иргэдийг бас төрийн болон хувийн хэвшилдээ нөгөө 25 орон тооны 1-д нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажиллуулах гэдэг энэ асуудал дээр манай тэр бие төлөөлөгч маань, холбооны тэргүүн маань бол маш байгууллагуудыг шахаж ажилладаг л даа. Энэний үр дүнд бол Сүхбаатар аймагт бол бас тодорхой хэмжээнд нөгөө хөгжлийн бэрхшээлтэй иргэд маань бол хөдөлмөр эрхлэх тийм хүсэл эрмэлзэл илүү төрсөн байдаг. Тэгэхээр энэ бол Монгол Улсын хэмжээнд бас яг энэ асуудлуудыг

илүү түлхүү тавих, ер нь зүгээр тэргэнцэртэй хүн гэдэг чинь бол хөдөлмөрийн 100 хувийн чадвартай хүн шүү дээ. Зөвхөн тухайн нэг цэгээс нөгөө цэгт очих энэ асуудалд нь ямар нэгэн боломж байх юм бол тэр хүн бол 100 хувийн гүйцэтгэлтэйгээр эрүүл хүнтэй яг адилхан ажил хөдөлмөр гүйцэтгэх чадамжтай гэсэн үг. Тэгэхээр энэ болгон дээр бид нар энэ өнцгөөс нь харах, харж асуудалд хандах нь л бид нарын цаашид хөгжлийн бэрхшээлтэй гээд байгаа иргэдээ хамгийн нийгмийн зөв харилцаанд оруулах, дээрээс нь төрийн хамгийн том халамж бол тэнд байгаа л гэж ойлгож байгаа.

Тэгэхээр түрүүний асуудал дээр эргээд хэлэхэд тэр группийн асуудал дээр маш их хэл ам дагуулдаг. Аймаг, орон нутаг сумд маш их. Энэ дээр та бүхэн ЭМЯ маань нэг нэгдсэн бодлогоо гаргаад, листээ гаргаад, энэ хүмүүс бол эргэж эдгэшигүй учраас энэ дээр бол юу гэдэг юм тэр группийн асуудал байна. 2-т нь жил болгоны групп дээр өмнөх жил нь группт орчихсон мөртөө дараагийн жилд нь хасагдчихдаг. Нөгөө өвчний жагсаалт гээд гаргачихсан байдаг ЭМЯ. Энэ нь өөрчлөгдөөд байдаг юм уу нэг эсвэл нэг тодорхой тоонд бариулаад байх шиг байгаа юм. Ийм тооны хүнийг л группт оруулна гэнгүүт нөгөө тоондоо баригдсан хүмүүс чинь цаана нь ирээд хүлээлт үүсдэг, түүнийгээ дагаад хүнд суртал бий болдог, авлигал бий болдог. Энэ бол бүх нийтээрээ мэдэж байгаа асуудал. Тэгэхээр энэ асуудал дээр манай ЭМЯ-ныхан бас тодорхой ахиц шийдэл гаргаасай гэж хүсэж байна.

2-т нь энэ 115 мянган хөгжлийн бэрхшээлтэй иргэн бол 3 сая хүн дотроо бол тийм өндөр тоо биш шүү. Дэлхийн улс орнуудын дундаж бол нийт хүн амын 10 хувь гэж байдаг юм байна лээ. Гэхдээ тэнд үзүүлж байгаа төрийн үйлчилгээ нь хангалттай байдаг юм байна лээ. Өнөөдрийн бид нарын өгч байгаа 325 мянган төгрөг, 225 мянган төгрөг гэдэг бол зүгээр л тэр хүмүүсийг амьжиргааны

хамгийн доод түвшинд байлгах гэсэн энэ л мөнгөн дүн байгаа шүү дээ. Тэгэхээр энэ дээрээ та бүхэн маань бас Булгантуяа сайд маань бас илүү бас анхаарч, энэ асуудалд миний түрүүний хэлдэг энэ хүмүүстээ амьдрах нийгмийн харилцаанд орох энэ боломжийг нь л түлхүү олгож өгөх юм бол бид нарын хамгийн том дэвшил болно гэдгийг бас санал болгож хэлье. Тэгээд ер нь зүгээр хараагүй байлаа гээд бусад эрхтэн илүү хөгждөг, түрүүний бариа засал гэдэг шиг өнөөдрийн үүрэн телефоны маш олон операторууд бий болчихлоо. Үүнд лавлах операторууд хийгээд, түүндээ хариулт хийгээд явах энэ боломж бүрэн хангагдаад эхэлчихлээ. Нийгэм өөрөө хөгжихөд дагаад тэр хүмүүст бас боломж нэмэгддэг гэдгийг бас хэлье.

**Х.Булгантуяа:** Ганибал гишүүндээ баярлалаа. Яг үнэхээр үнэн. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зүгээс ч гэсэндээ бид нийгмийн нэг эд эс болоод ажил хөдөлмөр эрхлээд, аж амьдралаа сайжруулаад, улс эх орныхоо хөгжилд ч гэсэн хувь нэмэр оруулаад, үр хүүхдүүдээ сайхан өсгөөд ингээд явахыг хүсэж байна. Гэтэл харамсалтай нь Монголын нийгэм гэрээсээ гараад л хараагүй хүн битгий хэл ахмад настай хүн ч гэсэн бүдрээд уначихаар ийм зам харгуйтай, нийтийн тээвэр нь хүртээмж муутай, ажилд ороод очихоор оффисуудад нь орж гарч чаддаггүй. Монголд бараг л үнэнийг хэлэхэд хамгийн хүртээмжтэй барилга байгууламж хамгийн үнэтэй Шангрила, Централ Тауэр 2 л юм байна лээ ерөөсөө. Тэгэхээр яг үүн шиг бид нар энэ барилга байгууламжуудаа чанар стандартыг нь сайжруулахаас авхуулаад, ядаж хувийн хэвшлийг шахахтай нэгэн зэрэгцээд төр өөрөө үүн дээр манлайлах ёстой юм. Тэгэхээр бид нар энэ жишиг зургуудыг ирэх жилээс сайжруулаад, Боловсролын хууль дээр тэгш хүртээмжтэй байна гэж тунхгийн шинж чанартай юм шиг ийм хуультай байдаг. Гэтэл үүдээр нь орж чадахгүй байгаа хүүхэд яаж тэнд очиж боловсролын үйлчилгээ авах юм. Арай гэж үүдээр нь орлоо гэхэд хамгийн ойрхон бие

засах газартаа орж чадахгүй байхад өнөөдөр тэр хүүхдийг яаж.../минут дуусав/

**Л.Мөнхбаатар:** АН-ыг төлөөлж Наянтайн Ганибал гишүүн асуулт асууж, хариултаа авлаа. Үдээс хойших нэгдсэн хуралдаанаар Ерөнхий сайдын мэдээллийг сонслоо. Гишүүд, ажлын хэсэгт баярлалаа.

16.42 цаг

Их Хуралд өргөн мэдүүлсэн төслүүдийг танилцуулъя. Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогыг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Засгийн газар 2023 оны 10 дугаар сарын 23-ны өдөр өргөн мэдүүлсэн, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хэлэлцэнэ. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Засгийн газар 2023 оны 10 дугаар сарын 24-ний өдөр өргөн мэдүүлсэн, Төсвийн байнгын хороо

хэлэлцэнэ. Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Засгийн газар 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдөр өргөн мэдүүлсэн, Төрийн байгуулалтын байнгын хороо хэлэлцэнэ.

Баталсан хуулийн эцсийн найруулгыг сонсьё. Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Эцсийн найруулга сонссонд тооцлоо.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул чуулганы нэгдсэн хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ, ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ Д.УЯНГА